

Экадешид

Мацаг барихуйн

учир шалтгаан хийгээд

түүний ач тус

**Х А Р И Б У Р Х А Н Ы Ө Д Ө Р
Э К А Д А Ш И**

Пурануудын хэсгүүдийн орчуулга

БХАКТИВЕДАНТЫН ИНСТИТУТ

Бомбей Сан-Франциско Тирупати

ГАРЧИГ

Төгс төгөлдөр номын багш.....
Энэ номын тухай.....
Оршил.....
Экадашийг хэрхэн баримтлах вэ?.....
Сута Госвамийн айлтгал.....
Утпанна экадаши.....
Мокшада экадаши.....
Шапхала экадаши.....
Путрада экадаши.....
Шат-тила экадаши.....
Жая экадаши.....
Вижая экадаши.....
Амалаки экадаши.....
Папамочани экадаши.....
Камада экадаши.....
Варутхини экадаши.....
Мохини экадаши.....
Апара экадаши.....
Ниржала экадаши.....
Йогини экадаши.....
Падма экадаши.....
Камика экадаши.....
Путрада (Павитропани) экадаши.....
Ажа экадаши.....
Паривартини экадаши.....
Индира экадаши.....
Пашанкуша экадаши.....
Рама экадаши.....
Харибодхини экадаши.....
Падмини экадаши.....
Парама экадаши.....

“Материаллаг оршнолын далайд живэгсдэд зориулагдсан таван завь байдаг:

Бурхан Вишну, Бхагавад Гита, Шримати Туласи-деви, үнээ болон экадаши.”

Гаруда Пурана

“Надад бүх ургамлуудаас хамгийн эрхэм нь *туласи*, бүх саруудаас хамгийн эрхэм нь Картика, ариун мөргөлийн бүх газруудаас хамгийн эрхэм нь Миний хайртай Дварака, мөн бүх өдрүүдээс хамгийн эрхэм нь экадаши байдаг.”

Падма Пурана, Утгара Кханда

“Тэнцвэрээ алдсан *доши* нь мацаг барих үед тэнцвэрт байдалд орж, хоол боловсруулах гал дүрэлзэн, бие махбодь болон ухаан хэвийн байдалдаа ордог.

Түүнээс гадна бие махбодь хөнгөрөн хоол ундны эрүүл дуршилтай болж, ухаан санаа болон хоол боловсруулах үйл ажиллагаа сайжирч, мөн эрч хүч, чадалтай болдог.”

Аюрведа, Аштангахридаям 1.8

“Мэдрэхүйн болон үйл хөдлөлийн эрхтэнгүүдийн цэвэр ариун байдал, зөв цэвэршилт, биеийн хөнгөн шингэн байдал, хоолны эрүүл дуршил, өлсөж цангах байдал цаг хугацаандаа илрэх, хоолойн болон зүрхний хэсгийн цэвэр ариун байдал, мөн тэрчлэн бие махбодийн чөлөөтэй байдал, нойронд сэргэг байх болон залхуугаас ангид байх- энэ бүхэн мацгийн авчрах ач тус билээ.”

Аюрведа, Ситрастханам 14.17

“Би бие махбодь болон сүнсээ хянан удирдахын тулд мацаг барьдаг. Мацаг нь надад зорилгодоо хүрэх шийдвэр төгс байдал болон эрч хүчийг өгдөг.”

М.К. Ганди

ТӨГС ТӨГӨЛДӨР НОМЫН БАГШ

Бурханы адислалт А.Ч. Бхактиведанта Свами Прабхупада 1896 онд Калькутта хотод (Энэтхэг) Кришнаг ухамсарласан чин бишрэлтэнгийн гэр бүлд төрсөн. Бүр хүүхэд ахуй цагаас нь л түүнд Бурханы цэвэр чин бишрэлтэнгийн шинж тэмдгүүд илэрч байлаа. Бага байхаасаа *киртанд* оролцдог байлаа. Сургуульд суралцангаа Кришнын ухамсартай холбоотой бүхэнд оролцож байв. Эцэг Гоур Мохан Де нь түүнд эрхэм дээд бурханлаг хүмүүжлийг олгосон.

Өөрийн номын багш Шрила Бхактисиддханта Госвамитай (1874-1937) Шрила Прабхупада анх эхлээд 1922 онд Калькутта хотод учирсан. “Брахма Гаудия” багш шавийн барилдлагааны хэлхээ сүлжээний нэгэн үе нь болох Шрила Бхактисиддханта Сарасвати нь Кришнын ухамсарын гүн ухаанд бүрэн нэвтэрхий бөгөөд Энэтхэгт 64 Гаудия матх-г үндэслэгч байлаа. Анхны учралаараа л Шрила Прабхупада номын багшаасаа дэлхий даяар бурханлаг хувьсгал хийх урам зоригийг өдөөн бадруулсан номлол сургаалыг хүртсэн. Шрила Бхактисиддханта Сарасвати: “Чи бол боловсролтой залуу хүн. Бурхан Чайтанья Махапрабхугийн захиа сургаалыг дэлхий даяар чи яагаад номлож болохгүй гэж?” хэмээн хэлсэн. Ведийг баримтлагчид нь өнө эртийн цагаас Бурхан Кришнад Бурханы Дээд Бодьгал байдлаар бишрэл хүндэтгэлээ илэрхийлж байгаа ч жинхэнэ ведийн гүн ухаан болох трансценденталь бүтээлүүд нь Энэтхэг орны хилийн чанадад танигдаж мэдэгдээгүй байлаа. Номын багшийнхаа сургаал зааврыг даган биелүүлснээр Шрила Прабхупада Бурхан Кришнагаас Өөрөөс нь эхлэлээ авсан номлол сургаалыг уламжлуулан дамжуулахад хамгийн чухал үе хэсэг нь болсон.

1944 онд Шрила Прабхупада Кришнын ухамсарын трансценденталь шинжлэх ухааныг тайлбарлан таниулах англи хэл дээр хэвлэгдэн гарах “Бурханы зүг буцахуй” нэртэй сэтгүүлийг үндэслэсэн. Тэр хэний ч туслалцаагүйгээр өөрөө бичиж, хянаж, засварлаж, өөрийн мөнгөөр хэвлэн Энэтхэгийн хойд хэсгийн нутгуудаар тарааж байлаа.

Дараагийн жилийн туршид Шрила Прабхупада зүүдэндээ, Шрила Бхактисиддханта Сарасвати түүнд гэр бүлийн амьдралаа орхиж амьдралын дээд, бурханлаг хэлбэр болох огоорохуйн хэвшил буюу *санньясид* орохыг хэрхэн зааж сургахыг нэг бус удаа үзсэн. Кришнад маш эрхэм ариун дагшин газар орон болох Вриндаванад энэхүү зүүдийг зүүдлэх үедээ тэрээр энэхүү дуудлагыг дагахаар шийдсэн.

1959 оны 9 дүгээр сард, Матхура хотод Шрила Прабхупада огоорохуйн сахилыг сахих ам өчгийг өгч, А.Ч. Бхактиведанта Свами нэрийг хүртсэн. *Санньяси* болсноор Шрила Прабхупада номын багшийнхаа захиа даалгаврыг хамгийн сайн байдлаар биелүүлж чадах болсон. Гэсэн ч үүний тулд түүнд ведийн гүн ухааны англи хэл дээр хэвлэгдэн гарсан номууд болон барууны ертөнц АНУ-г зориход санхүүгийн дэмжлэг тусламж шаардлагатай байлаа.

Тэгээд Шрила Прабхупада Кришнын өршөөл нигүүлсэлд бүрнээ даатган, Шримад Бхагаватамыг дэлгэрэнгүй тайлбартайгаар англи хэл дээр орчуулан гаргах аугаа их санаагаа хэрэгжүүлэн биелүүлэх үйлдээ орсон. Утга зохиолын бүтээл туурвилын Бурханы хувилгаан дүр Шрила Кришна-Двайпаяна Вьясадевагийн бүтээж туурвисан бурханлаг нэвтэрхий толь Шримад Бхагаватамыг “Ведийн зохиол бүтээлийн өрөм, цөцгий” гэж үргэлж нэрлэдэг. Учир нь, тэнд Бурханы Бодьгалын болон Түүний трансценденталь зугаа наадмуудын талаар өгүүлсэн байдаг билээ. Шрила Прабхупада өөрөө бичиж, хянан засварлаж, эхний гурван ботийг хэвлэн гаргах санхүүгийн эх үүсвэрийг цуглуулсан. Тэрээр эхний ботийг дуусгаад нэг хувийг тэр үеийн Энэтхэгийн ерөнхий сайд байсан Лала Бахадур Шастрад бэлэглэсэн. Тэр Шрила Прабхупадын шинжлэх ухааны ажлыг өндрөөр үнэлсэн билээ.

1965 онд барууны ертөнцийг зорихтой холбогдсон Шрила Прабхупадын түүхэн үйл эхэлсэн. “Скиндия Стимшип” компани ачааны “Жаладута” хөлгөөр зорчих үнэгүй тийзийг өгсөн ба 1965 оны найм дугаар сард Шрила Прабхупада өөртөө Шримад Бхагаватамын хэдэн ботиудыг хийсэн хайрцаг, хос *каратал* болон нийтдээ 40 Энэтхэг рупи (ойролцоогоор 7 орчим доллар)-тойгоор Энэтхэг орныг орхисон.

Дөчин хоног үргэлжилсэн аялал ер бусын хүнд хэцүү байлаа. Хэдэн өдөр дараалан далайн догшин ширүүн шуурга “Жаладута” хөлгийг сэгсчиж байсан бөгөөд Шрила Прабхупада далайн өвчний хажуугаар зүрхний маш хүчтэй дутагдалд орсон. Зүрхний дутагдал хоёр шөнө дараалан үргэлжилсэн бөгөөд 69 настай түүний хувь тавилан муугаар төгсөж болох байлаа. Гэсэн ч гурав дахь шөнө нь Прабхупадын зүүдэнд Бурхан Кришна Өөрөө морилон ирж түүнийг Өөрийн ивээл хамгаалалдаа авсан. Зүрхний өвчин тэр дороо л зүгээр болсон.

Эцсийн эцэст, 1965 оны 9 сарын 17-нд “Жаладута” хөлөг Бостоны боомтод орж ирэх үед Шрила Прабхупада: “Ай эрхэм Бурхан Кришна минь ээ, Та энэхүү ямар ч тусгүй сүнсэнд ийм л өршөөл ивээлтэйгээр хандаж байна. Гэсэн ч, намайг Та яах гэж гэж ийш нь илгээснийг би мэдэхгүй байна. Одоо Та надтай хүссэн бүхнээ хийж болно. Кришнын ухамсарын илгээмжийг барууны ертөнцийн хүмүүст би хэрхэн яаж хүргэх билээ? Би бол золгүй, чадваргүй бөгөөд хамгийн доод түвшинд унасан нэгэн билээ. Ийм учраас тэдэнд хандахын тулд би Таны адислалыг эрж байна. Учир нь, үүнийг хийх хүч надад байхгүй билээ.” гэж бичсэн байдаг.

Ийнхүү, хэдэн ном болон өчүүхэн бага хэмжээний мөнгөтэйгөөр Шрила Прабхупада дэлхийн хамгийн том хотуудын нэгэн болох Нью-Йоркт ирлээ. 1965-66 оны өвлийн хүйтнийг гэтлэн өнгөрүүлэх үедээ Шримад Бхагаватамын цөөн хэдэн хувиа бүгдийг нь сониуч зантай америкчуудад худалдсан. Тэгээд юу ч үгүй болсон байсан ч бичих үйлээ цааш нь үргэлжлүүлсээр байлаа. Хэсэг хугацаа өнгөрсөний дараагаар Манхеттены Доод Ийст Сайдын хоёр дугаар Авеньюгийн 26-д жижиг агуулах болон өрөөг хөлслөн авч тэндээ нүүн орсон. Тэр үеэс, бурханлаг үнэний хойгоос эрэлхийлэгч залуусын дунд Харе Кришна мантраг бахдан дуулах иогийн онцгой аргыг номлогч энэтхэг *свадийн* тухай сураг мэдээ тархаж эхэлсэн байлаа.

1966 оны 7 дугаар сард Шрила Прабхупада Кришнын Ухамсарын Олон Улсын Нийгэмлэгийг албан ёсоор бүртгүүлсэн ба удалгүй өөрийн анхны шавь нарын хамтаар олон нийтийн дунд Харе Кришна мантраг бахдан дуулах арга хэмжээг Вашингтон сквер паркт зохион байгуулсан. Түүний том биш агуулахын өрөө нь Доод Ийст Сайдынхны анхаарлыг татаж эхэлсэн. Мах идэх, гэр бүлээс гадуур бэлгийн харьцаанд орох, аз сорьсон тоглоом тоглох болон мансууруулах бодис хэрэглэхийг хатуу чанд хорьсон байсан ч түүнд олон биш ч гэсэн чармайлттай дагалдагчид татагдан цуварч байлаа.

Цаг хугацааны явцад Шрила Прабхупада Сан-Франциско, Монреаль, Бостон, Лос-Анжелес болон Буффалод бурханлаг төвүүдээ нээсэн. Тэр хөдөө аж ахуйн хамтлаг “Шинэ Вриндавана”-г баруун Виржинид үндэслэн байгуулсан бөгөөд хүүхдүүдийг *гурукулын* зарчмаар сурган хүмүүжүүлэх ведийн системийг барууны ертөнцөд нэвтрүүлсэн. Түүнээс гадна Шрила Прабхупада баруун Бенгаль дахь Шри Чайтанья-чандродая мандир, Вриндаванад Кришна-Баларамын сүм болон зочид буудал, Бомбейд боловсролын төв болон сүрлэг сайхан, том сүм зэрэг цөөнгүй тооны олон улсын том төвүүдийг Энэтхэг оронд барьж байгуулах ажлыг санаачлан хэрэгжүүлсэн. Шрила Прабхупадаг 1977 онд энэ ертөнцийг орхихын өмнө түүний үндэслэн байгуулсан Харе Кришна хөдөлгөөн дэлхий даяар түгэн дэлгэрч Америк, Европ, Африк, Ази болон Австралийн том хотуудад төвтэй болсон.

Байнгад хийх аяллын (12 жилд дэлхийг 14 удаа тойрсон) хажуугаар Шрила Прабхупада Кришнын ухамсарын шинжлэх ухааны талаар бичих үйлээ хэзээ ч орхиж байгаагүй үргэлжлүүлсээр байсан. Тэрээр 80 гаруй боть ном туурвисан бөгөөд одоо дэлхийн 80 орчим хэл дээр орчуулагдан олон зуун саяар хэвлэгдэн гарсан. Эдгээр номуудын тоонд: анх айлдсан төрх байдлаараа байгаа Бхагавад Гита (1968), Бурхан Чайтаньягийн номлол (1968), Кришна-Бурханы Дээд Бодьгал (1968), Чин бишрэлийн рашаан (1970), Шри Чайтанья Чаритамрита-гийн 17 боть (1973-1975) болон Шримад Бхагаватамын 30 боть (1962-1977) ордог. Шрила Прабхупада хаана ч байсан үргэлж л ариун гэгээн ведийн судруудыг тайлбарлах болон орчуулах ажлаа үргэлжлүүлэн, шавь нараа хүмүүжүүлэн, өөрийн үндэслэн байгуулсан хөдөлгөөнөө улам бэхжүүлж байлаа.

Шрила Прабхупада насан өндөр (69-өөс 81 насандаа) болсон байсан ч Бүхний Дээд Бурхан Кришнад хэлбэрэлт гуйвалтгүй итгэх итгэл бишрэл болон өөрийн хүчин чармайлт дээрээ тулгуурлан энэхүү ойлгож ухаарахын аргагүй гавъяаг бүтээсэн. Энд дурьдсан бүхэн нь түүний трансценденталь амжилт бүтээлийн зөвхөн зарим хэсэг нь билээ. Түүний бүрэн намтар түүхийг Сатсварупа даса Госвами “Шрила Прабхупада лиламрита” гэдэг номдоо бичсэн билээ.

Шрила Прабхупада зөвхөн бурханлаг номлогч биш, тэр бол хүмүүст Кришнын ухамсарын цэвэр ариун зам мөрийг заан хүртээж, тэднийг Бурханы оронд хөтлөн хүргүүлэхээр Бурхан Кришнагийн сонгосон аугаа их гэгээн байсан гэдэг нь бүрэн тодорхой. Иймээс Шрила Прабхупадын үзүүлсэн хамгийн чухал ач тус, хувь нэмэр бол академийн боловсролын нийгэмд ч тэдний эх сурвалж байдал, гүн гүнзгий утга болон тов тодорхой нь өндөр үнэлэгддэг түүний бүтээж туурвисан номууд билээ. Тэдгээр номуудыг олон олон коллеж, сургуулиудад үндсэн сурах бичиг байдлаар ашигладаг. Шрила Прабхупадын номуудыг хэвлэхээр 1972 онд анх байгуулагдсан Бхактиведанта Бук Траст нь одоо энэтхэгийн шашны болон гүн ухааныг түгээн дэлгэрүүлдэг дэлхийн хамгийн том хэвлэлийн газар болон өргөжсөн. Төгс төгөлдөр номын багшийн сургаал номлол нь зовлон шаналал болон бялангач зан ноёрхсон энэ дэлхийн хүн бүрийг авран Бурханы зүгт, буцаад гэрлүүгээ эргэн харих замыг нь зааж өгдөг учраас Шрила Прабхупадын номууд нь бүх хүн төрөлхтөнд ач тусаа хүртээх чадвартай болой.

ЭНЭ НОМЫН ТУХАЙ

Бурханы, утга зохиолын бүтээл туурвилын хувилгаан дүр болох Шрила Вьясадевагийн туурвисан янз бүрийн Пурануудын хэсгүүдийн орчуулгаас бүрдэх энэ ном нь Шрила Прабхупадын номуудад нэмэлт болох юм. Шрила Сута Госвами Наимишаранья ойд хуран цугларсан 88000 гэгээдэд хандан сургаал айлдсан. Эдгээр гэгээдийг тэргүүлж байсан Шаунака, Сута Госвамигаас нүгэлт үйлүүдийн бүхий л үр дагавруудаас хэрхэн яаж ангижрахыг асуусан. Нүглээс чөлөөлөгдөн ангижралгүйгээр цэвэр чин бишрэлийн албанд зүтгэх аргагүй юм.

Бурхан Кришна Бхагавад Гитагийн (7.28)-д айлдахдаа: *йешам тванта-гатам папам жананам пуньякарманам... бхажанте мам дрдха-вратах* буюу “Өнгөрсөн болоод одоогийн амьдралдаа ариун шудрага үйл үйлдэн байх хийгээд бүхий л нүгэл нь бүрнээ устан үгүй болсон байх хүмүүс нь хий хуурмагийн хоёрдмол байдлын эрхшээл нөлөөнөөс ангижрах бөгөөд Миний албанд шийдвэр төгс зүтгэн байдаг.”

Шаунакагийн асуултанд хариулангаа Сута Госвами урьдын цагт болсон янз бүрийн түүхэн үйл явдлууд болон яриа хөөрөөнөөс хүүрнэсэн. Энэхүү хүүрнэлүүдэд өгүүлэх экадашид нарийн чанд баримтлах дүрэм журмууд нь *карма-канда-д* хамаарагдах судруудын хэсэг гэж хэн нэгэн нь бодож болох юм. Гэсэн ч эдгээр дүрэм журмууд нь бүрнээ ариусахыг эрмэлзэн чармайж байгаа чин бишрэлтэнд тус болох нь эргэлзээгүй. Хэрвээ Пурануудад өгүүлсэн түүхүүд нь хамгийн цэвэр ариун нь биш байсан бол Бурхан Кришна, Аржуна, Юдхистхира, Брахма бурхан, Нарада Муни, Сута Госвами болон Шаунака Риши нар тэднийг ийнхүү бүрэн төгс байдлаар тодорхойлон өгүүлэхэд өөрсдийн үнэт цаг заваа зориулахгүй байхсан билээ. Мөн, утга зохиолын бүтээл туурвилын Бурханы хувилгаан дүр Шри Двайпаяна Вьяса тэдгээрийн талаар цэвэр ариуны гунад орших хүмүүст зориулагдсан Пурануудад бичихгүй л байсан. Тийм учраас, бурханлаг хөгжил дэвшилд хүрэхээр тэмүүлж байгаа хүн эдгээр сургаалыг чин зүрхнээсээ бүрнээ хүлээж авах ёстой билээ. Тэдгээр нь бидний бурханлаг өсөлт хөгжилтийн төлөө л зориулагдсан.

Шри Чайтанья Махапрабхугийн айлдсанчлан, Кришны ухамсарын бүх үйл явц нь *вайрагья-видье* буюу огоорохуй болон танин мэдэхүй дээр үндэслэгдсэн байдаг. Экадашийг нарийн чанд баримтлах нь чин бишрэлтэнг өөрийгөө ариусгах чадвартай болгохын дээр түүний Кришнаг хайрлах хайрыг нэмэгдүүлдэг огоорохуйн эх сурвалж үйл явц, арга зам юм. Шрила Прабхупада "Чин бишрэлийн рашаан" номдоо "Брахма-вайварта" Пуранаас иш татан бичсэнчлэн, экадашийн өдөр мацаг барьж байгаа хүн нүгэлт үйлийнхээ бүхий л хэлбэрийн үр дагавруудаас чөлөөлөгдөн ангижирч зөв шудрага амьдралдаа ахиц дэвшил гаргадаг. Зүгээр л нэг мацаг барих биш, Говинда, Кришнаг хайрлах хайраа болон итгэл бишрэлээ нэмэгдүүлэх явдал бол үндсэн зарчим нь байдаг юм. Экадашид мацаг барихын жинхэнэ утга учир нь бие махбодийн хэрэглээг аль болох хамгийн бага хэмжээнд байлгаж, цаг хугацааг Бурханы чин бишрэлийн алба үйлэнд зүтгэх, Түүнийг магтан дуулахад зориулах явдал юм. Мацаг барьж буй өдрөө Говиндагийн зугаа наадмыг дурсан санах, Түүний ариун гэгээн нэр алдруудыг байнгад сонсох нь хамгийн чухал. Экадашид ийм байдлаар, Кришнад аугаа их чин бишрэлтэйгээр мацаг барих хэрэгтэй. Харин материаллаг бодлогын үүднээс биш. Нарада Муни Вьясадевад хэлснийг Шримад Бхагаватамын нэг дүгээр дуулалд өгүүлсэнчлэн, амьдралын олон олон хэлбэр төрөлд тоо томшгүй олон удаа төрөн энэхүү орчлонгийн дээд болон доод гаригуудын системээр хэрэн тэнүүчилснээр ч хүрэх аргагүй тэр л зүйлийг хүртэхийг тэмүүлэх ёстой. Энэ зорилго бол бурханлаг тэнгэр дэх Кришна Бурханы оронд биднийг буцааж хүргэх Кришнын цэвэр ухамсар билээ. Иймээс соёл иргэншил бүхий хүний амьдралын хэлбэрийн аугаа их ач тусыг ашиглаж байгаа хэн бүхэн Кришнын цэвэр чин бишрэл дүүрэн бялхах албаны зам мөрөөр замнаж болох бөгөөд тэгснээр тэр үхэл, өвчлөл болон хөгшрөлт, төрөлтийн хүрднээс ангижран салж Бурханы зүгт, буцаад гэрлүүгээ эргэж харина. Шри Экадашийг зөв баримтлах нь цэвэр чин бишрэлийн зүтгэлийн алба үйлийг бэхжүүлэн батжуулдаг ба экадашийн өдөр мацаг барихын энэхүү баярт хэн бүхэн оролцож болно.

ОРШИЛ

Бхагавад Гитагийн (15.7)-д Бурханы Дээд Бодьгал, Шри Кришнагийн айлдсанчлан, энэхүү материаллаг ертөнцөд тэмцэлдэн байгаа амьд оршнолууд нь дээдийн дээд бурханлаг Бүрэн Бүтэний салшгүй өчүүхэн жижиг хэсгүүд, бурханлаг очнууд байдаг. Аливаа нэгэн хэсгийн жам ёсны үүрэг нь бүрэн

бүтэндээ зүтгэх явдал байдаг учраас амьд оршнолын жам ёсны үүрэг нь Бурхан Кришнад үйлчлэн зүтгэх явдал мөн. Гэсэн ч материаллаг мөн чанартай холбогдсоноос болж энэхүү үүрэг функци нь мунхагаар бүрхэгдэн хучигдсан амьд оршнол нь өөрийгөө бие махбодь болон ухаантайгаа адилтган, Кришнын албанд зүтгэхийн оронд материаллаг мөн чанарыг ноёрхохыг оролдож байдаг. Өөрийгөө материтай ийнхүү хуурмаг, буруугаар адилтган үзэх үзэл буюу хуурамч эго гэж нэрлэгддэг энэхүү бузардалт нь хүний амсаж эдлэх бүхий л зовлон шаналалын эх булаг болдог. Гэсэн ч бохирдсон усыг шүүн цэвэршүүлж болдог шиг хуурамч эгогийн бузарт өртөж нэрвэгдсэн амьд оршнолыг Кришнын ухамсарын трансценденталь арга үйлүүдээр ариусгаж болдог. Энэ үйл явцын үндсэн хэсгүүдийн нэг нь экадашид мацаг барих явдал юм.

Экадаши бол *санатана дхарма* буюу өөрөөр хэлбэл Кришнын ухамсарыг дагах хүний байнга тогтмол баримталдаг, тэвчил наманчлалын өдөр юм. “Эка” гэдэг нь “нэг”, “даша” гэдэг үгийн эм хүйс болох “даши” нь арав гэсэн утгыг илэрхийлдэг. Экадаши- энэ бол бүтэн сарны болон шинэ сарны дараа, сард хоёр удаа тохиодог арваннэг дэх өдөр юм. Эдгээр онцгой өдрүүдэд чин бишрэлтэнгүүд нь хоол хүнсэндээ будаа тариа болон буурцагт ургамлын зүйлс хэрэглэхийг цээрлэн тэвчдэг ба Бурханы Дээд Бодьгал Шри Кришнын чин бишрэлийн алба үйлдээ илүү их хүч гарган зүтгэдэг.

Экадаши дахь мацаг нь зөвхөн хөгжил дэвшилд хүрсэн *брахмачари* болон *санньяси* нарт зориулагдсан юм биш. Чин үнэнээсээ тэмүүлж байгаа ямар ч сүнсэнд мацгийн эдгээр ариун гэгээн өдрүүд нь үхэл төрөлтийн хүрднээс энэхүү амьдралдаа л ангижрахад нь тусалдаг. Экадаши нь хүнд энэхүү материаллаг ертөнцөд мэдрэхүйн хий хуурмаг таашаал ханамж эдлэхийг болин зогсооход туслан, огоорохуйн жинхэнэ амтыг мэдрүүлж өгдөг. Шримад Бхагаватамын (3.7.22)-ын тайлбарт Шрила Прабхупадын бичсэнчлэн, Кришнын ухамсар дахь огоорохуй нь дур булаан татах хий хуурмаг ямар ч зүйлд алдагдан гажихааргүй тийм хүчтэй. Чин бишрэлийн зүтгэлийг бүрэн *тапасьяд* буюу тэвчилтэйгээр үйлдэх хэрэгтэй. Шинэ сарны болон тэргэл сарны дараахь арваннэг дэх өдрүүдэд тохиодог экадашийн хоёр өдөр, мөн Бурхан Кришна, Бурхан Рама болон Чайтанья Махапрабху нарын морилон илэрч тодорсон өдрүүдэд мацаг барих хэрэгтэй.

Энэ дэлхийд хүмүүсийн хоёр төрөл байдаг. Эхний төрлийн хүмүүсийн ухамсар нь бурханлаг, тэд ведийн судруудын дагуу амьдралаа зохиож байдаг бол нөгөөдүүл нь буюу материалист хүмүүс нь бүрэн харанхуй мунхаг бөгөөд судруудад заасныг үл дагаж мөрдөцгөөдөг. Гэсэн ч Бурхан Кришна бүх сүнснүүдийг Өөрийн хүүхдүүд гэж үздэг. Бүгдэд өршөөл нигүүлслээ хайрлаж байдгийн хувьд Тэр энэ дэлхий ертөнцийн хүн бүрийг бурханлаг хөгжил дэвшилд хүрээсэй гэсэн үүднээс экадашийн өдрүүдийг баримтлах зэрэг ариусгах үйл явц, арга замуудыг тогтоож өгсөн билээ. Өөрийгөө даатгасан сүнснүүд болох Кришнын чин бишрэлтэнгүүд нь энэхүү мацгийг Кришнын өршөөл нигүүлслийг хүртэх, *майагийн* хавчлага даралтаас ангижрах болон Бурханы зүгт буцаж харин Кришнад мөнхөд үйлчлэн зүтгэх гэж л барьдаг. Харин харанхуй мунхаг хүмүүс нь мөн л Бурхан Кришнын хайрладаг материаллаг ач тус, үр шимийг хүртэх гэж энэхүү өршөөл ивээлтэй таатай сайхан боломжийг ашиглаж болдог. Экадашид ингэж байнга тогтмол мацаг барьснаар мөн материалистууд ч бүрэн ангижралд хүрч болно. Экадаши ийм л аугаа хүчтэй байдаг болой.

Гэхдээ экадаши дахь мацгийн бүрэн ач тусыг хүртэхийн тулд энэхүү номд өгүүлэх дүрэм журам болон зохицуулах зарчмуудыг дагаж мөрдөх шаардлагатай. Хэрвээ дүрэм журмыг зөв дагаж мөрдөн, экадашийг Кришнын бүрэн ухамсарт баримтлах аваас энэ нь уналтанд өртсөн сүнснийг ч Бурханы хайртай албатын жам ёсны байр сууринд нь дээшлүүлэн хүргэнэ. Иймээс ч

экадашийг “бүх боломжуудын шилдэг нь” гэж нэрлэдэг. Экадашид мацаг барихын гайхамшигт үр шим, ач тусыг амтлах саналыг хүн бүрт зориулан дэвшүүлж байна.

Мацгийн өдөр хүн биеийн хүчний хүнд хүчир ажил хийхээс аль болох зайлсхийн зөвхөн Бурхан Кришнын чин бишрэлийн алба үйлэнд зүтгэх хэрэгтэй. 1971 оны 7 сарын 9-нд Шрила Прабхупадагаас Жадурани деви дасад бичсэн захидал үүнийг баталдаг. “Яагаад зөвхөн 25 тойрог гэж? Таны боломж дахиад хир байна, тэр хэмжээгээрээ л олон удаа давтан хэлэх хэрэгтэй. Үнэн хэрэгтээ экадаши нь өөр ямар ч үйл үйлдэлгүй, зөвхөн мацаг барих болон Бурханы ариун гэгээн нэр алдруудыг бахдан дуулж, давтан хэлэх гэсэн үг юм. Хэрвээ хойшлуулшгүй яаралтай ажил үгүй бол экадашид өөр үйл үйлдэхийг ийнхүү зогсоон больж болно.”

Экадашийн чухлыг Чайтанья Чаритамритад (Ади-лила,15.9-20) Бурхан Чайтанья болон Түүний эх Шачи- деви нарын яриагаар тайлбарласан байдаг: Нэгэн удаа Шри Чайтанья Махапрабху эхийнхээ хөлд сөхрөөд Өөрийн нь гуйлтыг биелүүлж соёрхохыг гуйсан. Эх нь: “Хайрт хүү минь, би Чиний хүссэн бүхнийг чинь өгдөг шүү дээ.” гэж хариулсан. Тэгэхэд нь Бурхан: “Ай ээж минь ээ, Та экадашийн өдөр үр тариа битий идээрэй.” гэж айлддаг. Тайлбарт нь Шрила Прабхупада: “Шри Чайтанья Махапрабху бүр хүүхэд ахуйгаасаа л экадашийн өдөр мацаг барихуйн дүрэм журмыг баримталсан. Шрила Жива Госвами “Бхактисандарбха”-д экадашид үр тариа идэж байгаа хүн өөрийн эх, эцэг, ах дүү нар, номын багшийг хөнөөгч болдог ба тэр Вайкунтхийн гаригуудад дээшлэн хүрсэн байсан ч дахин доош унадаг гэсэн ишлэлийг Сканда Пуранагаас татсан.” гэж бичсэн байдаг билээ.

Экадашийн өдөр Бурхан Вишнуд зориулан үр тариа болон *далыг* оролцуулан янз бүрийн идээ зоогийг бэлтгэж болно. Гэхдээ вайшнавууд нь экадашид *вишну-прасадамыг* ч амсаж болдоггүй журамтай байдаг. Вайшнавууд нь Вишну Бурханд өргөөгүй хоол хүнсийг хэрэглэдэггүй боловч экадашид тэд Бурхан Вишнугийн *махапрасадамыг* ч амсах ёсгүй. Энэ *прасадамыг* дараагийн өдөр нь хүртэхээр хадгалж болно. Экадашийн өдөрт, Бурхан Вишнуд өргөсөн байсан ч үр тарианы ямар ч төрөл хэлбэрийг идэхийг хатуу хориглодог.

Барууны ч тэр, мөн аюрведийн анагаах ухаан ч тэр эрүүл мэндээ хамгаалж, сайжруулахын тулд мацаг барих хэрэгтэй гэж зөвлөдөг. Орчин үеийн биологичид ч тэр, мөн эрт цагийн мэргэд ч тэр мацаг нь хүнийг бие махбодийн болон ухааны хувьд хөгжүүлдэг гэж үздэг. Иймээс, экадаши дахь мацаг нь олон янзын өвчин эмгэг тусахаас урьдчилан сэргийлж, туссан өвчнийг анагаадаг нь гайхалтай зүйл биш. Шримад Бхагаватамын (1.17.38, тайлбар)-т Шрила Прабхупада: “Төр засаг мөрийтэй тоглоом, архидалт согтуурал, садар самуун явдал болон хууран мэхлэлийн бүх хэлбэрүүдийг шийдвэртэйгээр таслан зогсоох ёстой. Нийгмийн ёс суртахууны ялзрал, доголдлыг зогсоохыг хүсэж байгаа төр засаг нь шашны зарим зарчмуудыг номлон дэлгэрүүлснээр зорьсондоо хүрч болно. Заавал мацаг барих өдрийг сар бүр доод зах нь хоёр байхаар тогтоох хэрэгтэй. Эдийн засгийн байр сууринаас аваад үзсэн ч, нэг сард мацаг барих ийм хоёр өдөр нь улсад хүнсний бүтээгдэхүүнийг тонн тоннор нь хэмнэх боломж олгохоос гадна иргэдийн эрүүл мэндийн байдлыг бүхэлд нь сайжруулах билээ.” гэж бичсэн байдаг.

Энэ номоос уншигч та экадашийг баримтлан байгаа хүн тэнгэрийн гаригуудад дээшлэн хүрдэгийг мэдэх болно. Гэхдээ үүнийг өөрийн зорилгоо гэж үзэх хэрэггүй. Энэ номонд дурьдагдсан бодьгалуудын олон нь экадашид санаандгүйгээр мацаг барьсан, тэд дүрэм журмуудыг дагаж мөрдөөгүй, тэдний зүрх мунхагт нэрвэгдэж автсан байсан. Тэд экадашийг баримталж байгаагаа мэдээгүй болон зүрх нь материаллаг хүслээр дүүрсэн байсан ч материаллаг ач тус, үр шимийн төлөө тусгайлан зориудаар, санаатайгаар мацаг барьж буй

хүмүүсийн адилаар өөрсдийн зорилгодоо хүрсэн. Гэхдээ, Бурханд учир шалтгаангүйгээр, хольцоогүй цэвэр чин бишрэлээр зүтгэхийг тэмүүлэн, ийм санаа бодолтойгоор мацаг барьж байгаа, Кришнын ухамсарт оршин байгаа чин бишрэлтэнгүүд нь Бурхан Кришнын залрах дээдийн дээд орон Голока Вриндаванад үнэхээрийн дээшлэн хүрдэг билээ. Экадаши дахь мацаг нь хүнийг Бурханы зүг буцан харих замдаа хөгжил дэвшил гаргахад нь маш их тус болдог.

ЭКАДАШИЙГ ХЭРХЭН БАРИМТЛАХ ВЭ?

Ер нь мацаг барина гэж *ачамана* болон *чаранамрита* (зөвхөн 3 дуслыг) уухыг зөвшөөрөн, хоол ундыг бүрэн цээрлэн тэвчихийг хэлдэг: Хэрвээ хүн хоол ундгүйгээр тэсэн байж чадахгүй бол юм ууж, үр тариа болон буурцагт ургамлын зүйлс үл орсон хоолыг үдээс хойш нэг удаа идэж болно. Энэ хоолыг *накта* буюу оройн хоол гэж нэрлэдэг бөгөөд үндэс үрт ургамлууд (манжингаас бусад), жимс, ус, сүүн бүтээгдэхүүн, самар, сахар болон ногооноос (мөөгнөөс бусад) бүрддэг. Экадашид нэгээс олон удаа идэж уухгүй байхыг хичээх хэрэгтэй. Бурхан Кришнагийн Аржунад хандан айлдсанчлан, экадашид бүтэн мацаг барьж байгаа хүн түүний ач тус, үр шимийг бүрэн, харин *накта-аар* хязгаарлаж байгаа хүн хагасыг нь хүртдэг. Кришнын ухамсарын хөдөлгөөний чин бишрэлтэн бүрийн хувьд хамгийн гол чухал үүрэг бол мэдээжийн хэрэг номлол сурталчилгаа байдаг бөгөөд экадашид бүтэн мацаг барих нь энэ үүргээ биелүүлэхэд нь саад тотгор учруулж байвал мацгийг бүтэн барихгүй байж болно. Харин чин бишрэлтэн нь өөрийн үүргийг үргэлжлүүлэн биелүүлэхийн зэрэгцээ бүтэн мацгийг дүрэм журмаар нь барих чадвартай байх аваас тэр тэдгээрийг хамтат нь хийх хэрэгтэй.

Экадашид мацаг барихуйн үндсэн дүрэм журам нь үр тариа болон буурцагт ургамлыг хоол хүнсэндээ хэрэглэхээс хатуу зайлсхийх явдал байдаг. Мөн тэрчлэн, өдөр унтах, биедээ тос түрхэх, бетелийн самар зажлах, сарын тэмдэг нь ирсэн байх эмэгтэй болон нохойгоор хооллогч-чандала, архичид, нэхмэлчин, юм угаагч эрэгтэйд хүрэх, шүргэх, үс сахлаа авах, хүрэл савнаас хоол унд идэж ууж болдоггүй. Экадашид хоол идэж байгаа хүн үр тариа болон буурцагт ургамлын зэрэгцээ шпинат, бал, баклажан, асафетида, далайн давс (өөр бусад төрлийн давс бол болно) орсон хоол хүнсийг болон бусдын гэрт хоол унд идэж уухаас зайлсхийх хэрэгтэй. Энэхүү ариун гэгээн өдөр зөвхөн өвчтэй хүн л эмийг хэрэглэж болно.

Орчин цаг үед ведийн хуанлийг *Чайтра* эсвэл *Вишну* (3-4 дүгээр) сараас эхлэн тоолдог боловч эрт дээр цаг үед *Маргаширша* эсвэл *Кешава* (11-12 дүгээр) сараас эхлэн тоолдог байсан. Энэ бол маш тааламжтай цаг үе буюу сар байдаг билээ. Бурхан Кришна Бхагавад Гитагийн (10.35)-д: “Саруудын дундаас бол Би 11 болон 12 дугаар сар.” гэж айлдсан байдаг. Экадашид мацаг барихаар зэхэж байгаа хүнийг чухамхүү энэ сараас л эхлэхийг зөвлөдөг. Сар бүрт экадашийн хоёр өдөр: нэг нь шинэ сарны хоёр долоо хоног буюу сарын гэрэлтэй хагас, харин нөгөө нь хуучин сарны хоёр долоо хоног буюу сарын харанхуй хагаст тохиодог. Эдгээр хоёр экадаши нь бурханлаг хөгжил дэвшилд үзүүлэх үйлчлэл нөлөөллийн хувьд адил хүчтэй байдаг.

Чин бишрэлтэн нь мацаг барьж эхлэхийн өмнө энэхүү эхлэн орж буй зорилгоо хатуу чанд даган баримтлах шийдвэртээ бат итгэлтэй байх ёстой. Дараа нь тэр Бүхний Дээд Бурханы, хоёр дахиа төрсөн номч мэргэнийг олж учран түүнээс экадашид мацаг барихуйн ариун гэгээн үйлд суралцах хэрэгтэй. Хүнд өвчтэй эсвэл нас өндөр болсоны улмаас мацаг барьж огт чадахгүй байгаа хүн бурханлаг зам мөрдөө өндөр хөгжил дэвшилд хүрсэн сүнсэнд экадашийн өдөр ямар нэгэн зүйл өргөх хэрэгтэй. Вайшнавуудын хувьд үүнтэй адилтгахуйц заавар журам нь бол экадашийн өдөрт Кришнын ухамсарыг түгээн

дэлгэрүүлэхэд онцгой хүчин чармайлт гаргах ёстой явдал юм. Энэ бол аугаа эрхэм нандин зүйл болой. Бас өөр нэгэн чухал заавар журам бол экадашийн өдөр бүрийн тухай унших болон сонсох явдал байдаг. Бурхан Кришна, энэхүү үйл явдал нь мацгийн үр дүнд хүрэхэд тус болдог гэж зөвлөн айлдсан.

Хэрвээ экадашид санаандгүйгээр мацаг барилгүй өнгөрүүлсэн бол түүнийг экадашийн дараа өдөр, *двадашид* барин *трайодашид* буюу гурав дахь өдөр нь тайлж болно. Ведийн судруудад өгүүлсэнчлэн, Бурханы Дээд Бодьгалын залран байх оронд хүрэхийг үнэхээрийн эрмэлзэн тэмүүлж байгаа хүн экадашийг мартаж өнгөрүүлсэн байх аваас тэр түүнийг *двадашид* барьж болно. Учир нь экадаши нь дараагийн өдөртөө сунан үргэлжилдэг билээ.

Сарын гэрэлтэй хагасын экадашийн үед *ом кешавайа намах* болон биедээ *тилаки* тавихдаа Бурханы чин бишрэлтэнгүүдийн байнгад давтан хэлж байдаг бусад мантрануудыг хэлж, Бурхан Вишнугийн ариун гэгээн арванхоёр нэрийг бясалгах хэрэгтэй. Сарын харанхуй хагаст тохиох экадашийн үед чин бишрэлтэн Бүхний Дээд Бурханы дөрөвдэгч хувилгаан дүр болон тэдгээрийн дараагийн бүрэн хэсгүүдийн ариун гэгээн арванзургаан нэр алдруудыг төвлөрөн бясалгах ёстой. Чин бишрэлтэн нь *ом санкаршанайа намах, говиндайа намах* гэх зэргээр бахдан дуудах ёстой. (Чайтанья Чаритамрита, Мадхья-пила, 20.195-197-г үз).

Экадаши бүрт Бурханы Дээд Бодьгал, Шри Кришнаг Түүний зохих бүрэн хувилгаан дүрээр бясалгах хэрэгтэй. Мөн *шаструудад* тодорхойлон өгүүлсэн байдаг Бурханы янз бүрийн дүрүүдийн *муртиг* бясалгаж болно.

Хэрвээ астрономын экадаши нь сарны арав дахь өдөр, *дашитай* давхцаж байвал энэ өдрийг бузартсан гэж үздэг учраас мацаг барьдаггүй. Харин экадаши нь *двадаши* буюу арванхоёр дахь өдөртэй давхцаж байвал түүнийг цэвэр ариун гэж үздэг ба *махадвадаши* гэж нэрлэн түүнийг баримталдаг. Ведийн уламжлалд *махадвадашийг* экадашитай адилд үздэг.

Экадашийг дүрэм журмын дагуу нарийн чанд баримталсаны дараагаар *двадашид* мацгаа тайлдаг. Мацаг тайлах цаг хугацаа нь нар мандсан үеэс хойшхи хагас цагаас хоёр цагийн хооронд таардаг.

Сударт зааснаар бол таван нас хүрсэн л бол хүн бүр экадашид мацаг барих ёстой байдаг. Нийгмийн болоод бурханлаг хөгжлийн бүх дөрвөн анги шатанд хамрагдагсад нь Шри Кришнын залран байгаа дээдийн дээд оронд дээшлэн хүрэхийн тулд экадашийг чин зүрхнээсээ, нарийн чанд баримтлахыг *ачарья* нар зөвлөсөн байдаг. Гэхдээ нөхөртэй эмэгтэйчүүдэд: “Нөхөртэйгөө амьдарч байгаа эхнэр хүн мацаг барих зөвшөөрлийг нөхрөөсөө авах ёстой. Үүнийг үл хайхрах аваас тэрээр нөхрийнхөө амьдралыг богиносгох ба түүнийг там руу илгээж байгаа хэрэг болно.” гэж сургасан байдаг. Иймээс нөхөрт гарсан эмэгтэй хүн экадашид мацаг барихын тулд эр нөхрөөсөө зөвшөөрөл авах ёстой.

Экадашийн өглөө чин бишрэлтэн нь Бурханы Дээд Бодьгал, Шри Кришна эсвэл Шри Рамагийн *муртийн* өмнө очин *сахасра-ширша пурушах* гэсэн үгүүдээр эхэлдэг *Пуруша-сукта* залбирлыг хэлэх ёстой. Цааш нь, чин бишрэлтэн Бурханд гүн хүндэтгэл бишрэлээ илэрхийлэн:

Ом дамодарайа намах гэж хэлэн Түүний бадамлянхуа өлмийг
Ом мадхавайа намах гэж хэлэн Түүний хөлийг
Ом камапатайе намах гэж хэлэн Түүний нууц хэсгийг
Ом ваманайа намах гэж хэлэн Түүний гуяыг
Ом падманабхайа намах гэж хэлэн Түүний хүйсийг
Ом вишвамуртайе намах гэж хэлэн Түүний хэвлийг
Ом гьянагамайа намах гэж хэлэн Түүний зүрхийг
Ом шрикантхайа намах гэж хэлэн Түүний хүзүүг
Ом сахасрабахаве намах гэж хэлэн Түүний мутрыг
Ом парамайогине намах гэж хэлэн Түүний бадамлянхуа мэлмийг

Ом уругайаи намах гэж хэлэн Түүний магнайг
Ом нараке шаварайа намах гэж хэлэн Түүний хамрыг
Ом сарвакамадайа намах гэж хэлэн Түүний үсийг
Ом сахасраширшайа намах гэж хэлэн Түүний тэргүүнийг

бясалгах ёстой.

Үнэхээрийн чин бишрэлтэй хүн Бурханд гүн хүндэтгэл бишрэлээ илэрхийлэн, Бурханы Дээд Бодьгал, Шри Кришнын үзэсгэлэн гоо төгөлдөр бурханлаг дүрийг ингэж бясалгах ёстой. Чин бишрэлтэн нь хөгжмийн янз бүрийн зэмсгүүд дээр тоглон эсвэл эрхин дээр, хайр чин бишрэл дүүрэн, тайван амгалан байж Бурханы ариун гэгээн нэр алдрууд Харе Кришна, Харе Кришна, Кришна Кришна, Харе Харе/Харе Рама, Харе Рама, Рама Рама, Харе Харе-г магтан дуулж, давтан хэлэх хэрэгтэй. Хэрвээ боломжтой бол унталгүй сэрүүн байж бүхий л шөнийн туршид Бурханыг магтан алдаршуулах хэрэгтэй.

Двадашид чин бишрэлтэн нь эхлээд угаал үйлдэн бие махбодио цэвэрлэн, махамантраг давтан хэлж зүрхээ ариусгах хэрэгтэй. Дараа нь Бурханыг цэнгүүлэхийн тулд тансаг сайхан идээ зоог бэлтгэн түүнийгээ аугаа их чин бишрэлтэйгээр чин зүрхнээсээ залбиран Түүнд өргөх ёстой. Идээ зоогоо бусад чин бишрэлтэнгүүд болон брахмануудад түгээн мөн өөрөө хүртэн мацгаа тайлж болно.

СУТА ГОСВАМИЙН АЙЛТГАЛ

Сута Госвами өгүүлсэн нь: “Жилд 12 сар байдаг, сар бүрт 2 экадаши тохиодог. Иймээс жилд 24 экадаши байдаг, харин өндөр жилд (ведийн тооллоор) дахин хоёр экадаши нэмэгддэг. Ай аугаа гэгээд минь ээ, эдгээр өршөөл ивээлт өдрүүдийг намайг хэрхэн нэрлэхийг та бүхэн сонсоцгооно уу: Утпанна, Мокшада, Шапхала, Путрада, Шат-тила, Жая, Вижая, Амалаки, Папамочани, Камада, Варутхини, Мохини, Апара, Ниржала, Йогини, Падма (Девашаяни), Камика, Путрада (Павитропани), Ажа, Паривартини, Индира, Пашанкуша, Рама болон Харибодхини (Девоттхани). Өндөр (ведийн тооллоор) жилийн нэмэлт хоёр экадашийг Падмини ба Парамма гэж нэрлэдэг.

Ай гэгээд минь ээ, эдгээр экадашуудын тухай сонсож байгаа хүн л тэдгээрийг хэрхэн яаж зөв баримталдгийг мэдэж хүртэх билээ. Экадаши бүр нь түүнийг нарийн чанд баримтлах хэн бүхэнд онцгой ач тусыг хайрлан хүртээдэг.

Бие махбодийн хувьд экадашид мацаг барьж үл чадах хүн эдгээр өдрүүдийн аугаа гайхамшгийн тухай сонсох болон тэдгээрийн нэрийг давтан хэлэх хэрэгтэй. Ингэснээрээ тэр экадашийг бүрэн баримталж байгаа хүний хүрдэг зорилгод хүрдэг билээ.

УТПАННА ЭКАДАШИ

Сута Госвами айлдсан нь: Ай номч мэргэн брахманууд минь ээ, олон жилийн өмнө Бурханы Дээд Бодьгал, Шри Кришна Шри Экадашийн өршөөл ивээлт таатай сайхан шинж чанаруудыг тайлбарлаж, энэ ариун гэгээн өдөр нэг бүрт хэрхэн мацаг барих дүрэм журам, зааврыг тогтоож өгсөн билээ. Ай шилдэг брахманууд минь ээ, экадашийн өдөр барих энэхүү ариун гэгээн мацгийн гарал үүсэл болон алдар цууны талаар сонсож байгаа хэн бүхэн энэ материаллаг ертөнц дэх өөрийн оршнолоо төгсгөл болгонгоо Бурхан Вишнугийн орон тийш шууд одох болно.

Притхын хүү Аржуна Бурханаас асуусан нь: Ай Жанардана минь ээ, экадашийн өдөр бүтэн мацаг барих эсвэл зөвхөн орой (*накта*) эсвэл үдэд хоол

идэх аваас ямар ач тустай байх вэ? Мөн тэрчлэн экадашийн өөр өөр өдрүүдэд ямар журмаар мацаг барьдаг вэ? Энэ бүхний талаар надад айлдан соёрхоно уу.

Бүхний Дээд Бурхан Кришна айлдсан нь: Ай Аржуна минь ээ, шинээр эхэлж байгаа хүн өвөл эхлэх үед *Маргаширша* (11-12) сарын харанхуй хагас дахь экадашид мацаг барьж эхлэх хэрэгтэй. Экадашийн өмнөх өдөр *дашид* шүдээ маш сайн цэвэрлэх хэрэгтэй. Дараа нь *дашийн* 8 дахь хэсэгт, нар жаргах үед оройн хоолоо идэх хэрэгтэй. Дараагийн өдөр нь чин бишрэлтэн дүрэм журам болон зааврын дагуу мацаг барих ёстой. Үд дундын үед голд, нууранд эсвэл том биш цөөрөмд угаалыг зөв үйлдэх ёстой. Голд угаал үйлдэх нь цэвэршин ариусахад хамгийн сайн байдаг. Дараа нь нууранд, эцэст нь цөөрөмд угаал үйлдэх ордог. Хэрвээ гол ч, нуур ч эсвэл цөөрөм ч байхгүй бол булаг шандын усаар угааж болно.

Чин бишрэлтэн газар эхийн нэр алдрыг агуулсан залбирал хэлэх хэрэгтэй. “*Ай Ашвакранте, ай Патхакранте, ай Вишнукранте, ай Васундхаре, ай Мриттике*, ай Газар ээж минь ээ, Бүхний Дээд Бурханы ариун гэгээн оронд дээшлэн хүрч очуулахын тулд өнгөрсөн амьдралуудадаа миний хураасан бүх нүглийг арилган зайлуулж хайрлаач. Ийнхүү залбирангаа чин бишрэлтэн өөрийн биедээ нялцгай шавар эсвэл шороо түрхэх хэрэгтэй.

Мацаг барьж буй өдрөө чин бишрэлтэн нь өөрийн нь шашин номын үүрэгт хамааралгүй хүмүүс, нохойгоор хооллогчид, хулгайчид болон бялангач хүмүүстэй ярьж харьцахын хэрэггүй. Мөн хагас бурхад, ведийн сургаал хийгээд брахмануудыг доромжлогчид, сүм хийдийг сүйтгэн бусниулагчид болон дээрэмчин тонуулчид, хов жив хөөцөлдөгчид болон унтахад хориотой эмэгтэйчүүдтэй унтагч¹ зэрэг ёс журамгүй, завхай зайдан хүмүүстэй ярилцахаас зайлсхийх хэрэгтэй. Экадашийн хугацаанд иймэрхүү хүмүүстэй ярилцах, тэр ч бүү хэл тэднийг харах аваас нар өөд шууд харан өөрийгөө ариусгах хэрэгтэй.

Угаал үйлдсэнийхээ дараагаар чин бишрэлтэн Бурхан Говиндад хамгийн сайн идээ зоог, цэцэг болон өөр бусад зүйлсийг хүндэтгэлтэйгээр өргөх ёстой. Чин бишрэлийн цэвэр ухамсарт оршингоо тэр Бурханд зул өргөх ёстой. Өдөр унталгүй байхын зэрэгцээ бэлгийн харьцаанд орохыг бүрэн цээрлэн тэвчих хэрэгтэй. Юм ч идэлгүй, ус ч уулгүйгээр шөнийн туршид Бурханы алдар цууг баяр хөөртэйгөөр магтан дуулж, Түүнийг цэнгүүлэхийн тулд хөгжмийн зэмсэг дээр тоглох хэрэгтэй. Шөнийг ийнхүү унталгүйгээр цэвэр ариун ухамсарт өнгөрөөсний дараагаар чин бишрэлтэн нь зохистой брахманд өглөг тарааж басамжлан алдасхийснийг өршөөхийг түүнээс мөргөн гуйж, хүлцэнгүй байдалтайгаар хүндэтгэл үзүүлэх ёстой. Сарын харанхуй хагаст тохиох экадашийг сарын гэрэлтэй хагаст тохиох экадаштай адилаар авч үзэх хэрэгтэй. Ай хаан минь ээ, экадашийн энэ хоёр төрлийн хооронд ялгаа хийх хэрэггүй.

Харин одоо экадашийг ийнхүү баримтлах хүний хүртэх үр дүн, ач тусын талаар тодорхойлон айлдахыг сонсоно уу. Бурхан, Шанкхасура демоныг дарж устгасан газар болох Шанкходдехара мөргөлийн ариун газарт угаал үйлдсэний ач тусыг ч тэр, Гададхара Бурханыг шууд бясалгаснаар хүртэх ач тусыг ч тэр экадашид мацаг барьснаар хүртэх 16 шагналтай зүйрлэх аргагүй. Тэргэл сартай анхны өдөр тарааж байгаа өглөг нь жирийн өргөлөөс зуун мянга дахин илүү их ач тустай байдаг гэж ярьдаг. Ай баялагт хүрэгч минь ээ, *санкранти* (өдөр шөнө тэнцэх) өдөр өгсөн өглөг бусад үед өгсөн өглөгөөс дөрвөн зуун мянга дахин их ач тусыг хайрладаг. Гэхдээ, экадашийн өдөр зүгээр л мацаг барьсан хүн энэ бүх ач тус, үр дүнд хүрдэг, мөн тэрчлэн нар эсвэл сар хиртэх үед Курукшетрад ирсэн шиг тийм үр шим, ач тусыг хүртдэг. Түүнээс гадна экадашид мацаг барьж байгаа чин бишрэлт сүнс нь *ашвамедха-ягья* (мориор өргөл өргөх) үйлдэхээс нэг зуу дахин их ач тусыг хүртдэг. Экадашид төгс

байдлаар нэг удаа ч гэсэн мацаг барьсан хүн мянган гуйлгачинг жаран мянган жилийн туршид өдөр бүр хооллосонтой адил гавьяаг хүртдэг. Экадашийг нэг удаа зөв баримталсан хүн Ведийг судалж байгаа брахманд нэг мянган үнээ бэлэг болгон өгсөнөөс арав дахин илүү ач тусыг хүртдэг.

Нэг брахмачариг хооллож байгаа хүн хэдэн арван брахмануудыг өөрийн гэртээ дайлж байгаа хүнээс арав дахин илүүгээр үнэлэгддэг. Гэсэн ч, газрыг шаардлагатай хүнд болон зөв шудрага брахманд бэлэглэж байгаа хүн брахмачариг хооллож байгаа хүнээс нэг мянга дахин илүүг хүртдэг. Харин энэ ач тусаас нэг мянга дахин илүүг цэвэр ариун бүсгүйг залуу, боловсролтой, журамтай эрд гаргаж байгаа хүн хүртдэг. Үр хүүхдүүдээ бурханлаг зам мөрөөр ямар нэгэн сайшаал шагнал хүлээлгүйгээр зөв хүмүүжүүлсний ач тусын өршөөл ивээл түүнээс арав дахин илүү байдаг. Гэхдээ өлсгөлөн хүнд талх өгөх² нь үүнээс арав дахин илүү сайн байдаг. Шаардлагатай хүнд өглөг өгөх нь бүхнээс илүү гэдэг нь эргэлзээгүй хэрэг. Үүнээс илүү өргөл гэж байдаггүй. Ай Кунтийн хүү минь ээ, хүн энэрэл нигүүлслийн улмаас талх тараах аваас тэнгэрийн гаригууд дээрх хагас бурхад болон бүхий л өвөг дээдэс нь маш ханамжтай болдог. Гэвч экадашид бүрэн хэмжээгээр мацаг барьсны ач тусыг хэмжихийн аргагүй. Куру удмынхны шилдэг нь болох Аржуна минь ээ, энэ ач тусын хүчийг хагас бурхад хүртэл үнэлж цэгнэж чадахааргүй байдаг. Экадашийн өдөр нэг удаа *накта* идэх хүн энэ ач тусын хагасыг нь хүртдэг.

Хари Бурханы өдөр үр тариа болон буурцагт ургамал идэлгүйгээр үд дундад нэг удаа эсвэл мөн үр тариа болон буурцагт ургамал идэлгүйгээр орой нэг удаа хооллох эсвэл огтхон ч хоол идэлгүйгээр бүтэн мацаг барих хэрэгтэй. Ариун мөргөлийн газруудад очих, өглөг тараах, галан тахилга үйлдэх зэрэг нь экадаши бий болохоос өмнө л ач холбогдолтой байсан билээ. Иймээс, материаллаг зовлон шаналалаас салан ангижрахыг эрмэлзэж байгаа хэн бүхэн экадашийг баримтлах хэрэгтэй. Экадашид дунгаас ус уух, амьтан тэр бүү хэл гахай, загасыг ч алах, үр тариа болон буурцагт ургамал идэж болохгүй. Ай Аржуна минь ээ, Би чиний хүссэнээр мацаг барихуйн бүхий л аргуудаас хамгийн шилдэг сайныг нь тодорхойлон айлдлаа.

Дараа нь Аржуна асуусан нь: Ай Бурхан минь ээ, ведийн мянган тахилга өргөл ч экадашийн мацагтай үл тэнцэнэ гэж Та айлдлаа. Яаж ийм юм байж болох юм бэ? Экадаши нь яахаараа ингэж бусад өдрүүдээс илүү чухал ач холбогдолтой болсон юм бэ?

Бурхан Кришна хариу айлдсан нь: Би чамд экадаши нь бусад бүх өдрүүдээс яагаад ингэж хамгийн их ариусгадаг болох талаар тайлбарлая. Эртийн нэгэн цагт, *Сатья югад*, Мура нэртэй онцгой аймшигт демон амьдардаг байжээ. Цаг үргэлж уур хилэн нь бадарч явдаг тэр бүх хагас бурхдад аймшиг төрүүлж байлаа. Тэр ч бүү хэл, тэр тэнгэрийн хаан Индра, нарны бурхан Вивисван, найман Васу³, Брахма бурхан, салхины бурхан Вайя, галын бурхан Агниг хүртэл ялан дийлсэн байлаа. Аймшигт хүч чадлаараа тэр бүгдийг өөрийн эрхшээлд оруулсан байв.

Тэгээд Индра бурхан Шива бурханд хүрч очоод: “Бид бүгд өөрсдийн гаригуудаас доош хөөгдлөө, одоо бид газар дэлхий дээр гунигтайгаар хэрэн тэнүүлчилж явна. Ай бурхан минь ээ, энэ их гай зовлонгоос бид яаж ангижрах билээ? Хагас бурхад биднийг чухам юу хүлээж байна вэ?” гэж асуужээ.

Шива бурхан: “Ай хагас бурхдын шилдэг нь минь ээ, Гарудагаа хөлөглөн морилдог Бурхан Вишну дээр очиж бараалха. Тэр бол бүхий л орчлонгуудын захирагч Жаганнатха, мөн тэднийг авран хамгаалагч билээ. Тэр Өөрт нь бишрэн даатгах бүх сүнснүүдийг хамгаалан Өөрийн аврал ивээлдээ авдаг.” гэж хариулсан.

Бурхан Кришна цааш нь үргэлжлүүлэн айлдсан нь: Ай баялгийг эзлэгч Аржуна минь ээ, Шива бурханы энэ үгүүдийг сонсоод Индра бурхан бүхий л хагас бурхдын хамтаар бүх сүнснүүдийг авран хамгаалагч, орчлонгийн Бурхан

Жаганнатха Бурхан амран байгаа тэр газар луу явцгаасан. Усны мандал дээр нойрсон байгаа Бурханыг харцгаагаад хагас бурхад алгаа хавсарцгаан Индраг даган дараахь залбирлыг айлтгацгаасан:

Ай Бурханы Дээд Бодьгал минь ээ, Бид Таны өмнө өвдөг сөгдөн мөргөж байна. Ай бурхдын Бурхан минь ээ, ай хагас бурхдаар алдаршуулан магтуулагч минь ээ, ай демонуудын дайсан минь ээ, ай бадамлянхуа мэлмийт Бурхан минь ээ, ай Мадхусудана (Мадху демоныг даран хөнөөгч) минь ээ, биднийгээ хамгаалж аврал ивээлдээ авч хайрлаач. Муру демоноос айж зугатсан бид Танаас аврал өмгөөлөл эрэхээр ирлээ. Ай Жаганнатха минь ээ, Та бол бүхнийг бүтээгч билээ. Та бол бүхий л орчлонгийн эх болоод эцэг нь билээ. Та бол бүгдийг бүтээж, тогтоон барьж, устган сүйрүүлдэг билээ. Та бол бүх хагас бурхдад дээдийн дээд тус дэм хайрлагч, зөвхөн Та л тэдэнд амар тайвныг хүртээж чадах билээ. Зөвхөн Та л газарт, тэнгэрт болон бүх нийтэд ачтай тустай, ивээл хайрлагч байдаг билээ. Та бол гурван ертөнцийг тогтоон баригч Шива, Брахма, Вишну билээ. Та бол нарны, сарны, галын бурхан билээ. Та бол ариусгагч тос, тахилга өргөл, ариун гал, мантра, зан үйл, ариун гэгээнтэн болоод жала-ын намуухан давталт билээ. Та бол өргөл болгон өргөгч тэр зүйл бөгөөд мөн тэдгээрийн үр дүнг таашаан болгоогч Бурханы Дээд Бодьгал билээ. Энэ гурван ертөнцөд хөдлөх болоод үл хөдлөх юу ч байсан Танаас хамааралгүйгээр оршин тогтнох боломжгүй билээ. Ай Бүхний Дээд Бурхан, бурхдын Бурхан минь ээ, Та бол Танд өөрийгөө даатгагч бүхний хамгаалагч билээ. Хагас бурхад бид демонуудад дийлдэн тэнгэрийн орноосоо түлхэгдэн унагаагдлаа. Ай Бурхан минь ээ, өөрсдийн байр сууриа алдсан бид одоо газар дэлхий дээр л хэсүүчлэн тэнэж явна.

Бурхан Кришна мөн цааш нь үргэлжлүүлэн айлдсан нь: Индра болон бусад хагас бурхдын айлтгалыг сонсоод Бурханы Дээд Бодьгал, Шри Вишну хариу айлдсан нь: Ямар демон нь ингэж бүх хагас бурхдыг ялан дийлэхээр хий хуурмагийн аугаа их чадалтай байдаг байнаа? Ямар нэртэй, хаана байдаг демон бэ? Тэр хаанаас ийм их хүч чадал хийгээд өмгөөлөл хамгаалалтай болсон хэрэг вэ? Индра минь юунаас ч айлгүйгээр бүгдийг нь Надад айлтга.

Индра бурхан айлтгасан нь: Ай Бурханы Дээд Бодьгал минь ээ, Ай Өөрийн цэвэр чин бишрэлтэнгүүдийн зүрхэнд төрсөн айдсыг дарагч минь ээ, ай Өөрийн чин бишрэлт албатуудад өршөөл нигүүлслээ хайрлагч минь ээ, урьд нэгэн цагт брахмануудын удамд Надижанга нэртэй нэгэн хүчирхэг демон байсан билээ. Тэр онцгой аюултай, догшин хэрцгий байсан бөгөөд хагас бурхдыг түлхэн унагаахад өөрийгөө бүхэлд нь зориулсан нэгэн байлаа. Тэрээр гутамшигт булай бүхнээрээ зартай Мура хэмээх хүүтэй байсан.

Мурагийн захирдаг хамгийн том орон нь Чандравати байв. Тэндээс л онцгой аюулт, хүчирхэг демон бүхий л орчлонг эзлэн түрэмгийлж бүх хагас бурхдыг тэнгэрийн орноос нь хөөн зайлуулсан. Тэр тэнгэрийн хаан Индра, галын бурхан Агни, эрлэгийн эзэн Яма, салхины бурхан Вай, мөн Шива бурхан-Иша, сарны бурхан Сома, зүг чигийн бурхан Найррити, усны бурхан Паши-Варунагийн үүрэг ролийг өөртөө авсан. Түүнээс гадна тэр нарны бурхан болон гэрэл цацруулж эхэлсэн, мөн тэр өөрийгөө үүлээр тархаан өргөтгөж байна. Хагас бурхад түүнийг ялж дийлж чадахгүй байна. Ай Вишну Бурхан минь ээ, энэ демоныг хөнөөн дарж, хагас бурхдад ялалтыг хайрлаач.

Индрагийн энэ айлтгалыг сонсоод Бурхан Жанардана маш ихээр уурсан хилэгнэж: “Ай хүчирхэг хагас бурхад минь ээ, одоо бүгдээрээ Мурагийн эзэмшил Чандравати руу морилцгооё.” гэж айлдав. Ингээд Хари Бурхан тэргүүтэй бүх хагас бурхад Чандравати тийш зүглэцгээв.

Хагас бурхдын айсууг хараад демонуудын толгойлогч Мура чангаар тачигнатал инээв. Мөн туяаран гялалзах бриллиантан зэвсэг барьцгаасан өөр бусад тоо томшгүй олон демонууд түүний ийн хөхрөхийг дэмжицгээж байв. Шүдээ хүртэл зэвсэглэсэн демонууд хагас бурхад руу довтлон дайрахад тэд

тулааны талбарыг орхин арван зүгтээ зугатацгаалаа. Тулааны талбар дээр мэдрэхүйн Эзэн, Бүхний Дээд Бурхан Хришикешаг догшин хэрцгий демонууд хараад Түүний зүгт бүхий л зэвсгээ хэрэглэн дайрцагалаа. Сэлэм, хүрд болон бороохой шийдэм барьцгаан Бурханы зүгт дайрмагцаа л тэд бүгд Түүний хорт хурц суманд нэвт хатгуулж байлаа. Олон зуун демонууд Бурханы мутарт ийнхүү хөнөөгдсөн.

Тулааны төгсгөлд демонуудын толгойлогч Мура Бурхантай тулалдсан. Мура нь Бүхний Дээд Бурхан Хришикешагийн хэрэглэсэн аливаа зэвсэг бүрийг аюул хөнөөлгүй болгох тийм ид шидийн хүчийг агуулсан байлаа. Ямар ч зэвсгийн цохилтыг тэр демон цэцэг хүрж буй мэтээр хүлээн авч байв. Демоныг зэвсгийн хүчээр дарж чадаагүй Бурхан түүнтэй төмөр муна мэт нүцгэн мутраараа тулалдаж эхэлсэн. Бурхан Муратай тэнгэрийн тооллоор мянган жилийн туршид тулалдаад ядран⁴ Бадарикашрам тийш чиглэн одсон.

Орчлонгийн Эзэн, бүхий л иогчдоос хамгийн аугаа нь болох Бурхан Иогешвара тэнд очоод Химавати гэж нэрлэгддэг хамгийн сайхан агуйг эрж олсон. Энэ агуй нь хэмжээгээрээ ойролцоогоор 96 миль бөгөөд түүн рүү ордог зөвхөн ганц л орц ам байв.

Ай Дхананжая, баялгийг эзлэгч минь ээ, ядарсан Би түүн рүү жаахан унтаж амрах гэж орсон. Энэ аугаа нүсэр тулаанд Би маш ихээр ядарсан байлаа. Намайг мөрдсөөр агуйд орж ирсэн демон, Намайг унтаж байхыг хараад, тэр: “Олон демонуудыг минь хөнөөсөн энэ Хариг би өнөөдөр устгана.” гэж дотроо занан бодсон. Хорон муу санаат Мураг ийнхүү өөрийн төлөвлөгөөг бодож боловсруулж байхад Миний биеэс гялбам туяа цацруулан залуу бүсгүй гарч ирсэн. Мура гартаа олон тооны зэр зэвсэг гялалзуулан байгаа түүнийг хараад өөртэй нь тулалдах гэж байна гэдгийг ойлгосон. Энэхүү эмэгтэй түүнийг тулаанд дуудсан, Мура түүнтэй тулалдаж эхэлсэн бөгөөд тэр эмэгтэй тулалдахдаа түүнээс дутуугүй гэдгийг мэдээд гайхсан. Демонуудын толгойлогч, надтай тулалдаж байгаа аянгын цохилт шиг энэ уур хилэнтэй, айхтар бүсгүйг хэн бүтээгээ вэ? гэж бахдан хашгирсан. Тэр ингэж хэлэнгээ тулалдаанаа үргэлжлүүлэв.

Тун удалгүй гэрэлтэн туяарах охин тэнгэр Мурагийн бүхий л зэр зэвсгийг нь хэмх цохихын хамт түүний байлдааны тэргийг жагсаалаас гаргалаа. Демон түүний эсрэг нүцгэн гараараа дайрахад уурлаж хилэгнэсэн тэр эмэгтэй түүний толгойг тасар цавчин хаяв. Толгойгоо тастуулсан демон газарт хөсөр унаж эрлэгийн эзэн Ямаражагийн эзэмшил буюу Бурханы дайснууд айдас хүйдэс болон аюул ослоос өөрсдийгөө нууж далдлах, газрын доор орших Паталад хүргэгдсэн.

Бүхний Дээд Бурхан сэрээд толгойгүйгээ болсон демон болон Өөрийн нь өмнө алгаа хавсран мөргөн байгаа бүсгүйг харсан. Тэрээр нүүрэндээ гайхашрал тодруулан: “Энэхүү хорсолт демоныг хэн хөнөөгөө вэ? Тэр бүхий л хагас бурхад, *гандхарвануудыг*, тэр ч бүү хэл Индраг түүний бараа бологч дагуулууд *марутуудын* хамт, мөн тэрчлэн доод гаригуудыг захирагч *нагуудыг* (могойнууд) хүртэл хялбархан ялсан билээ. Тэр ч бүү хэл тэр тулаанд Намайг ялж энэ агуйд орж нуугдахаас өөр аргагүй байдалд оруулсан шүү дээ. Энэ агуйд жаахан унтаж амрахаар тулааны талбараас зугатан одсон Намайг хэн ингэж ивээж хамгаалсан хэрэг вэ?” гэж бахдан айлдсан.

Бүсгүй хариу айлтгасан нь: “Таны трансценденталь биеэс гарсан би энэ демоныг устгасан билээ. Ай Бурхан Хари минь ээ, Таныг нойрсож байхыг тэр хараад мэдээж хэрэг хөнөөхийг хүссэн. Гурван ертөнцийн өргөс болсон түүний санаа зорилгыг ойлгоод би энэ хорон санаат үл бүтэх этгээдийг хөнөөн бүх хагас бурхдыг айдас хүйдэснээс ангижрууллаа. Би бол Таны *маха-шакти*, дайснуудын чинь зүрхэнд айдас хүйдэс хуруулах Таны аугаа дотоод эрчим бөлгөө. Бүхий л гурван ертөнцийг авран хамгаалахын төлөө орчлон даяар аюул, зовлон таригч энэхүү демоныг би устгасан бөлгөө. Ай Бурхан минь ээ,

энэ демоныг үхсэн байхыг хараад яагаад гайхаж байгаагаа айлдаж хайрлана уу?”

Бүхний Дээд Бурхан айлдсан нь: “Ай нүгэл үгүй минь ээ, чамайг демонуудын энэ хааныг хөнөөсөнд Би маш ханамжтай байна. Чи хагас бурхдад аз жаргал, цэцэглэн мандалт болон бүхий л ач тусыг хайрлан хүртээжээ. Гурван ертөнц дэх бүх хагас бурхдад ач тус хүргэсэн чамд Би маш их хангалуун байна. Ай ач тустан минь ээ, чи Надаас өөрийн хүсэж байгаа бүхнээ гуйж болно. Би чамд бүгдийг хүртээх болно гэдэгт эргэлзэх хэрэггүй.”

Бүсгүй хариу айлтгасан нь: “Ай Бурхан минь ээ, Та надад ханамжтай байгаа хийгээд намайг шагнахыг болгоож байгаа бол энэ өдөрт мацаг барих хэн бүхнийг хамгийн том аюулт нүглээс нь ч ариусгах хүчийг надад хайрлан соёрхоно уу. Будаа тариа болон буурцагт ургамал үл оролцуулан зөвхөн нэг удаа үд дунд эсвэл орой хооллох хэн бүхэн энэ мацгийн ач тусын хагасыг нь хүртдэг байхыг би хүсэж байна. Өөрийн мэдрэхүйгээ эзэмдэн захирч миний илэрч тодорсон өдөр бүтэн мацаг нарийн чанд барьж байгаа хэн бүхэн энэ ертөнцөд цэнгэл жаргалын бүхий л төрлийг эдлээд Бурхан Вишнугийн оронд нэг миллиард *кальпын*⁵ туршид байхаар буцан очиг. Ай бурхан минь ээ, Таны өршөөл нигүүлслээр ийм адислалыг хүртэхийг би хүсэж байна. Ай Жанардана Бурхан минь ээ, бүтэн мацаг баригчид болон мөн орой эсвэл үдэд зөвхөн нэг удаа хооллох хэн бүхэнд бурханлаг ухамсар, эд баялаг мөн эцэст нь ангижралыг хайрлан соёрхох ажаам уу.”

Бүхний Дээд Бурхан айлдсан нь: Ай эмэгтэйчүүдийн дундаас хамгийн эрхэм хүндэтгэлт минь ээ, Тиймээ, чиний хүссэнээр болог. Энэ ертөнцөд Миний бүх чин бишрэлтэнгүүд чиний илэрч тодорсон өдөр мацаг барин гурван ертөнц даяар үүгээрээ алдаршин дуурсах бөгөөд эцэстээ Надад хүрч ирэн Миний залрах оронд байх болно. Миний трансценденталь эрчим-чи хомсдон байх сарны арваннэг дэх өдөр илэрч тодорсон учраас чамайг Экадаши гэж нэрлэцгээх болно. Хэрвээ хэн нэгэн хүн экадаши өдөр мацаг барих аваас Би түүний бүхий л нүглийг шатаан устгах бөгөөд түүнд Өөрийн трансценденталь оронд дээшлэн ирэх соёрхлыг хүртээнэ.

Надад тэргэл болон шинэ сарны дараахь өдрүүд: *тритья* (гурав дарь өдөр), *аштами* (найм дахь өдөр), *навами* (ес дэх өдөр), *чатурдаши* (арвандөрөв дэх өдөр) илүү эрхэм бөгөөд, ялангуяа *экадаши* (арваннэг дэх өдөр)⁶ онцгой эрхэм байдаг. Экадашид мацаг барихын ач тус нь бусад бүх мацгууд, ариун мөргөлийн газраар аялах болон брахмануудад өглөг тарааснаар хүрэх үр дүнгээс ч даван илүү гардаг. Би чамд ийм байдаг гэж үнэнийг айлдаж байна.

Бүхний Дээд Бурхан бүсгүйд адислалаа хайрлан хүртээмэгцээ л харагдахаа болив. Тэр цагаас эхлэн экадашийн өдөр орчлонгийн хамгийн өршөөл ивээлтэй, хамгийн алдар цуутай өдөр болсон. Ай Аржуна минь ээ, хэрвээ хүн экадашийг нарийн чанд баримтлах аваас Би түүний бүхий л дайснуудыг хөнөөн, түүнд дээдийн дээд оронд дээшлэн хүрэх соёрхлыг хайрлан хүртээх болно. Энэ аугаа өдөр оноож зөвлөсөн аргуудын⁷ алиныг нь ч баримталсан байх хэн бүхний бурханлаг төгс төгөлдөржилтийн зам мөр дээрх бүхий л саад тотгорыг Би арилган зайлуулах ба түүнд амьдралын төгс төгөлдрийг хайрлан хүртээх нь ямар ч эргэлзээгүй билээ.

Ай Притхын хүү минь ээ, экадашийн гарал үүслийн талаар Би чамд ийнхүү тодорхой айлдлаа. Ганц энэ өдөр л бүх нүглийг устган зайлуулдаг билээ. Бүх нүглээсээ ариусан салахад ивээл өршөөлтэй, хамгийн таатай өдөр бол энэ өдөр гэдэг нь эргэлзээгүй. Энэхүү өдөр нь энэ орчлонгийн хэн бүхний ач тусын тулд бий болсон бөгөөд түүнийг баримтлагч нь бүхий л төгс төгөлдөрийг хүртдэг болой. Шинэ (нэмэгдэн байгаа) сарны болон хуучин (хомсдон байгаа) сарны экадашуудын хооронд ялгаа хийхийн хэрэггүй, хоюуланг нь баримтлах хэрэгтэй шүү Притхын хүү минь. Экадашийн өдөр мацаг барьж буй хэн бүхэн

эдгээр экадашуудыг адил гэж үзэх хэрэгтэй. Учир нь тэдгээр нь тэр л *титтхи* (сарны хоног)-т болдог бөгөөд тэднийг *маха-двадашигаас*⁸ ялгаатай гэж үзэх хэрэггүй.

Экадашид бүтэн мацаг барьж байгаа болон оноогдсон журам дүрэм, заавруудыг даган баримталж байгаа хэн бүхэн Гарудагаа хөлөглөн морилж байдаг Бурхан Вишнугийн залран байгаа оронд дээшлэн хүрч очдог. Гаруда хөлөгт Бурхан Вишнуг бишрэн шүтэх хэн бүхний алдар бадраг! Бурхан Вишнуд бишрэн зүтгэдэг хийгээд экадашийн аугаа гайхамшгийг байнгад хүртэн байгаа хэн бүхний алдар бадраг! Экадашид юу ч идэхгүйгээр ам өчиг тавьсан хийгээд дараагийн өдөр нь хооллож байгаа хүн мориор тахилга өргөл үйлдсэнтэй адил ач тусыг хүртдэг. Үүнд эргэлзэх хэрэггүй.

Экадашийн дараагийн өдөр *двадашид*: “Ай Пундарикакша, ай бадамлянхуа мэлмийт минь ээ, Та намайг хоол идэхийг болгоон намайг хамгаалан соёрхоно уу.” гэж залбиран гуйх хэрэгтэй. Цэцэн мэргэн чин бишрэлтэн ийнхүү залбираад Бурханы бадамлянхуа өлмийд цэцэг болон ус өргөн, найман үет мантраг⁹ гурвантаа давтан хэлээд өргөж буй зоогийг нь таалан болгоохыг Бурханаас гуйх ёстой. Хэрвээ чин бишрэлтэн мацгийн үр шим, ач тусыг хүртэхийг хүсэж байгаа бол Бурханы бадамлянхуа өлмийд өргөсөн ариун савнаас авсан уснаас ууж хүртэх хэрэгтэй.

Двадашид: өдөр унтах, өөр айлд хооллох, нэгээс илүү удаа хооллох, *урад-дал* идэх, биедээ тос түрхэх зэргээс зайлсхийх хэрэгтэй. Чин бишрэлтэн нь *двадашид* дээрх 8 үйлдлийг цээрлэн тэвчих хэрэгтэй. Хэрвээ энэ өдөр түүнд хүний хүрээнээс хасагдагчидтай ярих хэрэг гарах аваас *туласийн* навч эсвэл *амалакийн* жимс идэн өөрийгөө ариусгах хэрэгтэй. Ай хаадын дундах шилдэг нь минь ээ, экадашийн өдрийн үд дундаас *двадашийн* өглөөний үүр цайх хүртэл угаал үйлдэх, Бурханд мөргөх, өглөг тараах болон галан тахилга үйлдэх зэргийг оролцуулаад чин бишрэлийн алба үйлэндээ зүтгэх хэрэгтэй. Харин хэн нэгэн нь нөхцөл байдлыг даван гарах хүчин мөхсдөж, *двадашид* мацгаа бүх журам дүрмийн дагуу тайлж чадахгүй байх аваас ус ууснаар л мацгаа зогсоон тайлж болох бөгөөд дараа нь юм идэж болно.

Байж болох бүхий л ач тусыг хүртээн соёрхох, Бурханы тухай яриа хөөрөөг цэвэр чин бишрэлтэнгийн амнаас өдөр шөнөгүй сонсож байгаа Бурхан Вишнугийн чин бишрэлтэн Бурханы залран байх оронд дээшлэн хүрч тэнд арван сая *кальпын* туршид байх болно. Тэр ч бүү хэл, экадашийн аугаа гайхамшгийн талаар ядаж ганц өгүүлбэр ч гэсэн сонссон байх хэн бүхэн брахманыг хөнөөсөн¹⁰ шиг тийм аймшигт нүглийн үр дагавраас ч ариусдаг. Үүнд ямар ч эргэлзээ байхгүй. Экадашийн өдөр мацаг барихаас илүү сайн, Бурхан Вишнуд хүндэтгэл үзүүлэх арга хэзээ ч бий болохгүй.

Утпанна экадаши буюу Маргаширша-кришна экадашийн яруу алдрын тухай Бхавитья-уттара Пуранаас авсан хүүрнэл ийнхүү өндөрлөлөө.

Тайлбар:

1.Ведийн соёл иргэншлийн хуулийн дагуу бол охинтойгоо, эхтэйгээ, эгчтэйгээ, бэргэн болон бусад эмэгтэй төрөл төрөгсөдтэйгөө бэлгийн харьцаанд орохыг хориглодог.

2.Махабхарата-д: *аннадау жаладаш чайва атураш ча чикитсаках/тривидхам сваргам айати вина йагвена бхаратах* буюу Ай Бхарата минь ээ, гачигдал, дутагдал, хэрэгцээтэй хүмүүст идэх талх, уух ус өгөх, анагаах эмийн эсвэл эмнэлгийн тусламж үзүүлэх хэн бүхэн ямар нэгэн тахилга өргөл үйлдэлгүйгээр тэнгэрийн оронд дээшлэн хүрдэг гэж өгүүлсэн байдаг.

3.Амара-коша нь найман Васугийн нэрийг: Дхара, Дхрува, Сома, Аха, Анила, Нала, Пратьюша болон Прабхава гэж нэрлэсэн байдаг.

4. Бүхний Дээд Бурханд айх эсвэл ядрах гэж байдаггүй нь мэдээж хэрэг билээ. Энэ бол Түүний бурханлаг зугаа наадмын хэсэг байдаг бөгөөд үүний ачаар л экадаши- охин тэнгэр илэрч тодорсон билээ.

5. Брахма бурханы 12 цагаас бүрддэг нэг *кальпа* нь 4 320 000 000 жил үргэлжилдэг. Иймээс Бурхан Кришна Бхагавад Гитагийн (8.21)-д: "...нэгэнт хүрсэн л бол тэндээс хүн хэзээ ч буцаж ирдэггүй орон бол Миний залрах дээдийн дээд орон билээ." гэж айлдсан байдаг. Иймээс Бурхан Вишнугийн залрах оронд нэг миллиард *кальпын* туршид чин бишрэлийн алба үйлэнд зүтгэх чин бишрэлтэн тэнд мөнхөд үлдэх болно гэж ойлгох хэрэгтэй.

6. *Тритья*. Мацаг барих ёстой *тритья* гэдэг өдөр байдаг. Энэ өдөр нь *Вайсакха* эсвэл *Мадхусудана* (4-5) сарын гэрэлтэй хагаст тохиодог. Энэ өдөр Бүхний Дээд Брахманд мөргөн далайн усанд угаал үйлддэг.

Аштами. Энэ өдрүүдэд шөнө дунд, үд дунд эсвэл нар шингэх хүртэл мацаг барьдаг ба *Кришна Жанмаштами*, *Радхаштами* болон *гопаштами* зэрэг өдрүүд багтдаг.

Навами нь өөртөө *Рама навами* болон *Акшая навами* агуулдаг.

Чатурдаши. Мацгийн энэ өдрүүдэд *Нрисимха чатурдаши*, *Ананта чатурдаши* болон *Шива чатурдаши* багтдаг.

Экадаши. Мацаг барьдаг бүх өдрүүдээс *экадаши* нь Бурхан Кришнад нэн эрхэм байдаг. Мацаг барьдаг олон тооны өдрүүдэд бүгдэд нь мацаг барьж үл чадах хэн бүхэн зөвхөн *экадашийг* л баримталснаар тэдний нэг бүрийн ач тусыг хүртдэг.

7. Экадашийг баримтлах гурван аргын талаар зөвлөсөн байдаг. Үүнд: бүтэн мацаг, зөвхөн орой эсвэл зөвхөн өдөр л нэг удаа хооллох. Үндсэн дүрэм журам нь буурцагт ургамал болон үр тарианы бүтээгдэхүүнийг хоол хүнсэндээ оруулж хэрэглэхийг бүрэн цээрлэх явдал юм.

8. Заримдаа, одон орны ойлголтоос болж экадашийг дараагийн өдөрт нь буюу *двадашид* баримталдаг. Энэ *махадвадашийг* нэн тааламжтай сайн өдөр гэж үздэг.

9. Найман үет мантра: *ом намo нарайанайа*.

10. Утпанна экадашийн аугаа гайхамшгийн талаар сонссон, брахманыг хөнөөсөн хүн үйлдсэн энэ нүглийнхээ үр дагавраас ч ангижирдаг. Гэхдээ брахманыг хөнөөчихөд энэ экадашийн тухай сонссоноор л ял шийтгэлээс мултран зайлж болох юм гэж бодох нь байж болшгүй хэрэг. Ийм санаатайгаар зориудаар нүгэлт үйл үйлдсэн хүнд тэр нүгэлт үр дагавраас мултран зайлах ямар ч арга зам байддаггүй.

МОКШАДА ЭКАДАШИ

Юдхиштира Махаража айлтгасан нь: Ай бүгдийн эзэн Вишну минь ээ, ай гурван ертөнцийн бахархал, ай орчлонгийн Бурхан, ай ертөнцийг бүтээгч, ай хамгийн ахмад, ай бүх оршнолуудын хамгийн шилдэг нь минь ээ, Таны өмнө би бишрэл хүндэтгэлтэйгээр мөргөө.

Ай бурхдын Бурхан минь ээ, бүхий л амьд оршнолуудын ач тусын тулд миний асуултуудад хариу айлдаж соёрхоно уу. Бүх нүглийг арилган зайлуулах, *Маргаширша* сарын гэрэлтэй хагаст тохиодог экадашийг юу гэж нэрлэдэг вэ? Түүнийг хэрхэн зөв баримтлах вэ? Энэ өдөр ямар Бурханд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн залбиран мөргөх вэ? Ай Бурхан минь ээ, надад энэ бүхний талаар бүрэн дүүрэн хариу айлдан соёрхоно уу?

Бурхан Кришна айлдсан нь: Ай Юдхиштира минь ээ, чи маш их өршөөл ивээлтэй сайхан асуулт асуулаа. Энэ нь чамд алдар хүндийг авчрах болно. Би чамд урд нь, *Маргаширша* сарын харанхуй хагаст тохиодог үнэлж баршгүй ач тустай Утпанна *маха-двадашийн*¹ буюу Мура демоныг хөнөөхөөр Экадаши деви Миний биеэс илэрч тодрон гарсан, гурван ертөнц дэх амьд болоод амьд бус

бүхэнд ач тус авчрагч өдрийн тухай өгүүлсэн шигээ одоо *Маргаширша* сарын гэрэлтэй хагас дахь экадашийн талаар айлдья. Энэ экадаши нь жинхэнэ чин бишрэлтэнг бүхий л нүгэлт үр дагавруудаас нь ариусгадаг болон түүнд ангижралыг хайрладаг учраас Мокшада гэж алдаршсан. Энэ өдөр Дамодара Бурханд мөргөдөг. Түүнд зориулан *туласи манжари* (*туласийн* цэцгийн цоморлиг), цэцэг болон зул өргөж, хүж уугиулахын зэрэгцээ анхаарлаа бүрэн төвлөрүүлэн мөргөх хэрэгтэй.

Ай хаадын хамгийн шилдэг нь минь ээ, Намайг цааш нь сонс. Би чамд энэхүү экадашийн тухай эртний, ивээл өршөөлөө хайрласан нэгэн түүхийг айлдья. Түүнийг зүгээр сонссоноор л хүн тахилга үйлдэн мориор өргөл өргөсөнтэй адил ач тусыг хүртдэг. Энэхүү хүртэн буй ач тусын тусламжтайгаар, тамд унасан байх өвөг дээдэс, эхчүүд, хөвгүүдээ болон бусад төрөл төрөгсөдөө авран чөлөөлж, тэдэнд диваажинд хүрч очих боломжийг хүртээдэг. Иймээс, ай хаан минь ээ, энэ хүүрнэлийг анхааралтай сонс.

Энэ явдал *вайшнав*-чин бишрэлтэнгүүдийн алдаршуулан магтдаг гайхамшигт Чампаконагари хотод болсон. Ариун гэгээн хаадын шилдэг нь болох Вайкханаса Махаража түүнийг захирдаг байсан ба тэрээр албат иргэддээ өөрийн охид хөвгүүд шигээр ханддаг байв. Энэхүү хотын брахманууд нь ведийн мэдлэгийн дөрвөн төрөлд маш нэвтэрхий сайн байлаа. Энэхүү зөв шудрага хаан нэгэн шөнө зүүдэндээ тамын гаригуудад тамлагдан тарчлан зовж байгаа өөрийн эцгээ үзжээ. Хаан маш ихээр гашуудан гуньж, удаанаар уйлсан. Дараа өглөө нь Вайкханаса Махаража өөрийн урьд шөнийн зүүдний талаар хоёр дахиа төрсөн брахмануудад өгүүлсэн.

“Ай брахманууд минь ээ,” гэж эхэлсэнээ хаан цааш үргэлжлүүлэн өгүүлсэн нь: Би урьд шөнө зүүдэндээ, тамд тарчлан зовж байгаа эцгээ харлаа. Тэр “Ай хүү минь ээ, намайг тамын зовлонгоос ангижруулж авраач.” гэж хашгирч байсан. Би тавгүй байдалд ороод байна, энэ гайхамшигт улс гүрэн ч миний хувьд тэсвэрлэхүйеэ бэрх боллоо. Тэр ч бүү хэл миний хүлэг морьд, заанууд болон байлдааны тэрэгнүүд хүртэл надад сайхан санагдахгүй байна, мөн миний аугаа их баялаг, сан хөмрөг ч намайг огтхон ч баясгахгүй байна. Ай брахмануудын дундахь шилдгүүд минь ээ, эцгээ тамд хэрхэн зовж тарчилж байгааг харснаас хойш бүх юм, тэр ч бүү хэл эхнэр хөвгүүд минь хүртэл миний хувьд зовлон гунигийн эх үүсвэр боллоо. Ай брахманууд минь ээ, түүний зовлон шаналалыг хөнгөвчлөхийн тулд би яах ёстой вэ? Юу хийх вэ? Хаашаа явах вэ? Миний бие гаслан зовлонгийн галд шатаж байна. Эцгээ тарчлал зовлонгоос чөлөөлөх болон өвөг дээдсээ ангижралд хүргэхийн тулд би ямар өглөг тараах, ямар байдлаар мацаг барих, ямар тэвчил наманчлал эсвэл ямар гүн бясалгалыг үйлдэх хэрэгтэйг надад хэлж өгөөч. Ай брахмануудын шилдгүүд минь ээ, эцэг нь тамын гаригуудад тарчлан зовж байх юм бол хүү нь хичнээн хүчирхэг байгаад ч ямар утга байх билээ дээ. Чухамдаа ийм хүүгийн амьдрал ямар ч тусгүй, огт дэмий зүйл юм.

Хоёр дахиа төрсөн брахманууд хариулсан нь: Ай хаантан минь ээ, эндээс холгүй уулын ойд нэгэн *ашрам* байдаг. Тэнд аугаа гэгээн Парвата Муни суудаг. Та түүн дээр л оч. Тэр хэн бүхний өнгөрсөн, одоо болон ирээдүйг мэддэг. Тэр таныг энэхүү гаслан зовлонгоос салахад туслах нь лав.

Гаслан зовлонд автсан хаан брахмануудын зөвлөгөөг сонсоод тэр дороо бэлтгэлээ базааж алдар цуутай гэгээнтэн Парвата Мунигийн *ашрамд* очихоор замд гарсан. Ашрам гайхмаар том байсан ба тэнд дөрвөн Ведийн² ариун гэгээн дууллуудыг дуулахын төгс төгөлдөрт хүрсэн олон номч мэргэд амьдарч байлаа. Ариун гэгээн *ашрамд* ирээд хаан үл төрсөн, бүтээгч Брахма бурхан мэргэдийн дунд суугаа мэт байх Парвати Муниг харсан.

Вайкханаса Махаража *мунид* эхлээд өвдөг сөгдөн мөргөснөө дараа нь бүр түүний өмнө сунаж мөргөн гүн хүлцэнгүйгээр бишрэл хүндэтгэлээ илэрхийлсэн. Тэгээд, хааныг босож суусны дараагаар Парвати Муни түүний өргөн уудам улс

гүрэн, хаант төрийн түшиг тулгуур долоон баганын³ амар мэнд болоод элбэг дэлбэг байгаа эсэхийн талаар асуусан. Муни, мөн түүний улс гүрэн нь элдэв гай зовлонгоос ангид уу, албат иргэд нь амгалан тайван, аз жаргалтай амьдарч байна уу гэж асуусан. Хаан хариу болгон: “Ай алдар цуутай мэргэн минь ээ, Таны өршөөлөөр миний хаант төрийн долоон түшиг тулгуур бүгд амар мэнд болоод элбэг дэлбэг байгаа билээ. Гэхдээ саяхнаас нэгэн гаслантай сураг мэдээ намайг зовоох болоод, ай брахман минь ээ, тэгээд л би зөвлөгөө авахаар таныг зорин ирлээ.” гэж хэлэв.

Бүхий л гэгээнтэн мэргэдийн шилдэг нь болох Парвати Муни нүдээ анин, хааны өнгөрсөн, одоо болон ирээдүйг бясалгав. Хэсэг хугацааны дараагаар тэрээр нүдээ нээснээ дараахь зүйлийг өгүүллээ: “Чиний эцэг маш хүнд нүгэл үйлдсэний улмаас тамд зовон тарчилж байгаа юм байна. Ямар учир шалтгаанаас болж тэгж зовж тарчилж байна вэ? гэдгийг нь ч оллоо. Тэр өнгөрсөн амьдралдаа, эхнэрээ сарын тэмдэг нь ирсэн үед түүнтэй бэлгийн харьцаанд орсноос болж ингэж зовон тарчлах болжээ. Эхнэр нь түүнийг болиулахыг оролдож: “Ай эр нөхөр минь ээ, болио ч дээ. Сарын тэмдэг ирсэн үед намайг ингэж бүү зовоогооч.” гэж хэлсэн боловч тэрээр эхнэрээ амар тайван орхилгүй өөрийн хүслийг хангасан байна. Энэхүү хүнд бэрх нүглийн улмаас чиний эцэг чинь тамд унажээ.”

Тэгээд Вайкханаса хаан: Ай мэргэдийн дундах хамгийн аугаа нь минь ээ, ямар мацаг барьснаар эсвэл өргөл өргөснөөр би өөрийн эрхэм хүндтэй эцгээ тамын зовлонгоос ангижруулж болох вэ? Бүрмөсөн ангижралд хүргэх түүний зам мөрт нь тотгор болоод байгаа энэхүү нүглийн тээг саадыг би хэрхэн арилган зайлуулж болохыг та надад хэлж өгөөч.” гэж өгүүлэв.

Парвати Муни хариулсан нь: *Маргаширша* сарын гэрэлтэй хагаст Мокшада гэж нэрлэгддэг экадаши тохиодог. Хэрвээ чи энэхүү ариун гэгээн өдөр дүрэм журмыг маш нарийн чанд баримтлан бүтэн мацаг барьж өнгөрөөн, хүртсэн ач тусаа өөрийн зовж тарчилж байгаа эцэгтээ өгөх аваас тэр зовлон шаналалаасаа салан хагацаж, шууд ангижрах болно.

Үүнийг сонсоод Вайкханаса Махаража гэгээнтэнд чин зүрхнээсээ талархаад ордон руугаа буцсан. Ай Юдхитхира минь ээ, *Маргаширша* сарын гэрэлтэй хагас болоход Вайкханаса Махаража өөрийн хатан, хүүхдүүд болон бусад төрөл төрөгсдийн хамтаар экадашийн өдөр мацгийг төгс төгөлдөр байдлаар барьсан. Тэрээр мацаг барьснаар хүртсэн ач тусаа өөрийн эцэгтээ хүлцэнгүйгээр дамжуулсан. Түүнийг энэ бүхнийг хиймэгц тэнгэрээс гайхамшигтай сайхан цэцгүүд асгаран унаж мялаав. Хагас бурхдын элчүүд түүний эцгийг магтан тэнгэрийн оронд хүргэхээр дагалдан одоцгоосон. Хүүгийнхээ хажуугаар өнгөрөхдөө эцэг нь: “Хайрт хүү минь ээ, чиний бүх юм сайн сайхан болтугай.” гэж хэлсэн. Ингээд тэр тэнгэрийн оронд хүрч очжээ⁴.

Ай Пандугийн хүү минь ээ, ариун гэгээн Мокшада экадашийг заасан дүрэм журмын дагуу нарийн чанд баримтлах хэн бүхэн бие махбодио орхисны дараагаар бүрэн төгс ангижралд хүрдэг. Ай Юдхитхира минь ээ, *Маргаширша* сарын гэрэлтэй буюу шинэ сарны хоёр долоо хоногт тохиох энэ экадашиас мацаг барих илүү сайн өдөр гэж үгүй билээ. Энэ өдөр бол болор мэт цэвэр тунгалаг бөгөөд нүгэлгүй юм. Бүхий л хүслийг биелүүлэгч үнэт эрдэнийн чулуу *чинтамани* мэт энэ экадашид чин зүрхнээсээ мацаг барьж байгаа хэн бүхэн үнэлж барахын аргагүй онцгой ач тусыг хүртдэг. Энэ өдөр тэнгэрийн гаригуудад, мөн түүгээр ч барахгүй төгс төгөлдөр ангижралд хүрэхийг ч болгоон соёрхдог бөлгөө.

Мокшада экадаши буюу Маргаширша-шукла экадашийн яруу алдрын тухай Брахмананда Пуранаас авсан хүүрнэл ийнхүү өндөрлөлөө.

Тайлбар:

1.Хэрвээ *экадаши двадашид* тохиох аваас чин бишрэлтэнгүүд түүнийг *экадаши* гэж нэрлэдэг.

2.Дөрвөн Вед: Сама, Яжур, Риг болон Атхарва.

3.Хаант төрийн гол 7 түшиг тулгуур баганууд: хаан өөрөө, түүний зөвлөхүүд, хөрөнгө сан хөмрөг, цэрэг арми, холбоотнууд, брахманууд болон түүний хаант улсад үйлдэж буй тахилга өргөлүүд, албат иргэдийн хэрэгцээ.

4.Нас барсан эцгээ тамын гаригаас мултлан гаргахын төлөө мацаг барьж байгаа бол энэхүү мацгийг барьснаар хүртсэн ач тус нь эцгийг нь тамаас ангижруулан тэнгэрийн гаригуудад дээшлэн хүрч очихыг болгоодог. Тэнд хүрч очоод тэрээр Вишнугийн буюу Кришнын чин бишрэлийн алба үйлэнд зүтгэснээр Бурханы зүгт буцаж очиж болно. Харин экадашийг өөрийн бурханлаг хөгжлийн төлөө баримталж буй хүн өөрөө Бурханы зүгт буцан очих бөгөөд энэхүү материаллаг ертөнцөд хэзээ ч буцаж үл ирнэ.

ШАПХАЛА ЭКАДАШИ

Юдхиштира Махаража асуусан нь: Ай Кришна минь ээ, *Пауша* (12-1) сарын харанхуй хагаст тохиодог экадашийг юу гэж нэрлэдэг вэ? Түүнийг яаж баримтлах ёстой вэ? Энэ өдөр ямар Бурханд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн мөргөдөг вэ? Ай Жанардана минь ээ, энэ тухай надад айлдаж хайрлана уу.

Бүхний Дээд Бурхан айлдсан нь: Ай хаадын дундахь шилдэг нь минь ээ, чи энэ талаар сонсохыг хүсэж байгаа болохоор Би чамд Пауша-Кришна экадашийн яруу алдрын тухай бүрэн, тодорхойлон айлдъя. Янз бүрийн тахилга өргөл үйлдэж байсан ч, Миний чин бишрэлтэнгүүд экадашийн өдөр мацаг барьж байгаа шигээр Миний таашаалд тэгж нийцэж, Намайг баясган цэнгүүлдэггүй билээ. Ийм учраас Хари Бурханы өдөр, экадашид чадлынхаа хирээр мацаг барих хэрэгтэй.

Ай Юдхиштира минь ээ, *двадашид* тохиодог Пауша-Кришна экадашийн яруу алдрын талаар маш анхааралтай сонс. Би урьд өмнө тайлбарласанчлан, янз бүрийн экадашуудын хооронд ялгаа хийх хэрэггүй. Ай хаан минь ээ, бүхий л хүн төрөлхтөний ач тусын тулд мөн Шапхала экадаши гэж нэрлэгддэг Пауша-Кришна экадашийг хэрхэн баримталдаг арга замын талаар одоо Би чамд тодорхойлон айлдъя. Нараяна Бурхан энэ экадашийн удирдан залагч шүтээн Бурхан нь байдаг учраас энэ өдөр Түүнд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн мөргөх хэрэгтэй бөгөөд мацаг барих талаар урьд өмнө тодорхойлсон аргуудыг баримтлах хэрэгтэй.

Могойнуудын дундаас хамгийн шилдэг нь Шеша-нага, жигүүртнүүдийн дундаас- Гаруда, тахилга өргөлүүдээс- Ашвамедха-ягья, харин голуудаас Ганга эх, бурхдаас Вишну Бурхан хамгийн аугаа нь, хоёр дахиа төрөгсдөөс хамгийн шилдэг нь брахманууд байдаг бол бүхий л өдрүүдээс хамгийн эрхэм сайн нь экадаши мөн болой. Ай Бхаратын удамд төрсөн хаадын шилдэг нь минь ээ, экадашийг нарийн чанд баримтлах хэн бүхэн Надад маш эрхэм байдаг бөгөөд Би түүнд янз бүрээр тусладаг нь эргэлзээгүй хэрэг. Шапхала экадашийг хэрхэн баримталдаг талаар одоо сонс.

Шапхала экадашид Миний чин бишрэлтэнгүүд Надад газар орон, цаг хугацаа болон нөхцөл байдалдаа харгалзуулан шинэ жимс өргөн бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн мөргөх ёстой бөгөөд Намайг бүгдэд ач тусаа хайрлагч Дээдийн Дээд Бодьгал дүрээр бясалгах хэрэгтэй. Тэд Надад жамбир, гранат, бетель, наргилын самар, гуава, самар, гвоздика, манго болон анхилуун үнэртэй янз бүрийн амтлагч ногоонуудыг өргөх хэрэгтэй. Шапхала экадашид зул өргөх нь онцгой өршөөл ивээлтэй байдаг учир Надад зориулан хүж уугиулан шар тосоор зул өргөх нь маш сайн. Чин бишрэлтэн нь бүхий л шөнийн туршид унталгүй сэрүүн байхыг чармайх хэрэгтэй.

Мацаг барих болон бүхий л шөнийн туршид унталгүй сэрүүн байх нь ямар ач тустай болох талаар анхаарлаа сулруулалгүйгээр сонс. Ай хаадын дундах шилдэг нь минь ээ, тахилга өргөл үйлдсэн эсвэл ариун мөргөлийн газраар аялж явснаар хүртэх ямар ч ач тус Шапхала экадашид мацаг барьсаны ач тустай эн тэнцэх болон давж илүү гардаггүй. Ялангуяа бүхий л шөнийн туршид унталгүй сэрүүн байх аваас энэ мацаг нь чин бишрэлтэнд 5000 жилийн туршид тэвчил наманчлал үйлдсэнтэй адил үр дүн ач тусыг хүртээдэг.

Ай хаадын дундах арслан минь ээ, одоо энэ экадашийн алдар цуутай түүхийг сонс. Энэ явдал ариун гэгээн хаан Махишматагийн захирдаг Чампавати хотод болсон. Махишмата хаан дөрвөн хүүтэй байлаа. Тэдгээрийн хамгийн ахмад нь буюу ууган хүү нь болох Лумпака мөрийтэй тоглоомоор тоглон, бусдын эхнэрүүдтэй эр эмийн харьцаа холбоотой байхыг хориглож цээрлэснийг үл хайхрахын зэрэгцээ янхнуудтай байнгад явалдаж, өөрөөр хэлбэл хамгийн нүгэлтэй үйлүүдэд автсан байлаа. Ийнхүү буруу, муу үйлтэй орооцолдон зууралдсаар тэр өөрийн эцэг Махишмата хааны хөрөнгө баялгийг сүйтгэн үрэн таран хийж байв. Түүний зэрэгцээ Лумпака хагас бурхад болон брахмануудыг байнгад шүүмжлэн, вайшнавчуудыг өдөр бүр л харааж муучилдаг байв. Эцсийн эцэст Махишмата хаан өөрийн хүүгийн хорт муу зан авирыг ойлгож мэдээд түүнийг ой руу хөөжээ. Лумпакагийн нүгэл төрөл төрөгсөд нь түүнийг хааны уур хилэнгээс хамгаалж чадахааргүй тийм их байлаа.

Хөөгдсөндөө тэвдэж мэгдсэн Лумпака: “Хаан эцэг минь намайг хөөлөө, төрөл төрөгсөд минь ч намайг өмгөөлж хамгаалсангүй. Одоо тэгэхээр яах вэ? юу хийх вэ?” гэж бодсон. Ингээд тэр мөн л нүгэлт төлөвлөгөө боловсруулж эхэлсэн: “Харанхуй болохоор хот руу нэвтрэн орж тэндхийн оршин суугчдыг дээрэмдэнэ. Өдөр нь ойд байж байгаад шөнө нь хот руу буцан очиж байх болно.” Тэр ийнхүү бодсоор ойн харанхуй гүн рүү орсон. Тэр махан хоолтон байсан учир өдөр нь амьтан алж, харин шөнө нь хотын оршин суугчдын үнэ цэнэтэй зүйлсийг нь хулгайдаг байв. Хотын иргэд түүнийг тэд хэд хэдэн удаа барьсан боловч хаан эцгээс нь айсны улмаас суллан тавьжээ.

Лумпакаг ийнхүү зохисгүй, нүгэлт үйлүүдээ үйлдэж байх явцад Шапхала экадашийн тохиох цаг ойртож байлаа. Экадашийн өмнөх шөнө ихэд хүйтэн болсон хийгээд хөнжил нь маш нимгэн байсан учраас тэр даарснаасаа болж бүхий л шөнийн туршид нойргүй хоносон. Хүйтнээс болж тэр зөвхөн нойргүй хоноод зогсоогүй хөлдөж үхэхээ шахсан. Өглөө болж нар мандсан ч түүний шүд нь дагжин чичирснээс болж тачигнан ухаангүй шахуу болсон байсан бөгөөд экадашийн энэ өдрийн өглөөний туршид бээрсэн байдлаасаа гарч чадахгүй л байлаа.

Лумпакагийн оромж нь Бурхан Васудевад маш эрхэм байдаг баньян модны доор байрлаж байв. Олон хүмүүс энэ модонд ойн бүхий л ургамлуудын бурхан байдлаар мөргөдөг байсан. Шапхала экадашийн үд болох үед нүгэлт Лумпака арай чарай босон баньян модны доороос үлгэн салан гарлаа. Тэгээд тэр ой дундуур өлсөж цангаснаасаа болж зовж шаналсаар хазгар доголлон хүн адил алхам тутамдаа бүдчин, итгэлтэй бус, удаанаар явж байлаа. Лумпака энэ өдөр нэг ч амьтан алж чадахааргүйгээр ядарч сульдсан байв. Өлсөж туйлдсан тэр газарт унасан жимсүүдийг түүж эхэллээ. Түүнийг баньян модны дэргэд буцаж ирэхэд нар хэдийнээ жаргажээ. Түүсэн жимсээ өөрийнхөө хажууд газар тавиад Лумпака: “Надад ямар хэцүү зовлонтой байна вэ? Би одоо яах вэ? Хайрт эцэг минь ээ, надтай юу болох нь энэ вэ? Ай Хари Бурхан минь ээ, надад өршөөл нигүүлслээ хайрлаач. Та энэ жимснүүдийг таалан болгоогооч.” гэж гаслан гиншиж байлаа. Тэр шөнийг дахиад л нойргүй өнгөрөөв. Гэсэн ч Лумпакагийн ийнхүү ойн жимс өргөсөн нь Бурханы Дээд Бодьгал, Мадхусуданагийн таалалд нийцэж түүний өргөсөн жимсүүдийг таалан болгоосон. Ийнхүү Лумпака өөрийн хүсэл зорилгоос ангид гадуур санаандгүйгээр, экадашийг бүтэн мацаг барьж

өнгөрөөсөн бөгөөд энэ нь түүнд хаан төрөө ямар нэгэн саад бэрхшээлгүйгээр дахин авахыг болгоон соёрхсон хэрэг болсон.

Ай Юдхиштира минь ээ, Махишмата хааны хүүгийн хүртсэн ач тусын соёо зүрхэнд нь дөнгөж цухуйж эхэлмэгц түүнд юу болсныг сонс доо. Дараагийн өдөр нь тэнгэрт хурц наран мандах үед Лумпакын өмнө гайхамшигтай сайхан морь бий болон гарч ирсэн. Тэр мөчид цэлмэг тэнгэрээс: Лумпака, Энэ морь чинийх. Түүнийг унаад гэртээ хурдан эргэж харь! Ай Махишмата хааны хүү минь ээ, Бурхан Васудевагийн өршөөл нигүүлслээр болон чиний баримталсан Шапхала экадашийн ач тусаар хаант төр чинь чамд ямар ч саадгүйгээр эргэн ирэх болно. Энэ бол ивээл өршөөлөө хайрласан энэхүү өдөр чиний барьсан мацгийн хүртээж байгаа адислал юм. Одоо эцэгтээ буцаж очин өөрийн байх ёстой байр сууриа эзэл." гэж хэлэх дуу гарсан. Энэхүү бурханлаг үгүүдийг сонсоод Лумпака мориндоо үсрэн мордоод Чампавати хотын зүг довтолголоо.

Шапхала экадашийг баримталсны ач тусаар л Лумпака өөрийн ухаанаа Бурханы Дээд Бодьгал, Хари-гийн бадамлянхуа өлмийд автуулж чадсан. Өөрөөр хэлбэл, тэр Миний цэвэр чин бишрэлтэн болсон. Лумпака Махишмата хаан эцэгтээ хүлцэнгүй даруу байдлаар хүндэтгэлээ илэрхийлсэн бөгөөд хан хүүгийн үүрэг, байр сууриа эзэлсэн. Вайшнавын чимэглэл болон *тилактай* хүүгээ хараад Махишмата хаан хаант төрөө түүнд итгэн даалгасан бөгөөд Лумпака олон олон жилийн туршид улс гүрнээ ямар ч хүндрэл бэрхшээлгүйгээр захирсан. Экадаши болох бүрт тэрээр Бүхний Дээд Бурханд машид чин бишрэлтэйгээр мөргөдөг байлаа. Шри Кришнын өршөөл нигүүлслээр тэр гайхамшигтай сайхан эхнэр хүүхэдтэй болсон.

Нас ахихын цагтаа тэр хаант төрөө өөрийн эцгээс түүнийг хэрхэн уламжлан авч байсан шигээ өөрийн хүүдээ шилжүүлсэн бөгөөд харин тэр өөрөө ухаан болон мэдрэхүйгээ эзэмдэж захиран Бүхний Дээд Бурханд зүтгэхээр ой руу явсан. Бүхий л материаллаг хүслээсээ ангижирснаар бие махбодио орхисон тэр Бурханы зүгт, буцаад гэр лүүгээ харьснаар Бурхан Кришнын бадамлянхуа өлмийд өөрийн жам ёсны байр сууриа эзэлсэн.

Ай Юдхиштира минь ээ, Надад Лумпакын нэгэн адил хандах хэн бүхэн харамсал болон түгшүүр зовиураас бүрэн салж ангижирна. Энэхүү аугаа Шапхала экадашийг зөв (тэрч бүү хэл Лумпака шиг ойлгож ухааралгүй, санамсаргүйгээр) баримтлах хэн бүхний яруу алдар энэ ертөнц даяар цуурайтах болно. Тэр үхлээс бүрмөсөн ангижирч Вайкунтхын гаригууд тийш буцан очих болно. Үүнд эргэлзэхийн хэрэг огт байхгүй. Түүнээс гадна Шапхала экадашийн алдар цууны тухай зүгээр л сонссон хэн бүхэн *Ражасуя-ягья* үйлдсэнтэй адил шагнал, ач тусыг хүртэх бөгөөд дараагийн төрөлдөө хамгийн наад зах нь гэхэд л тэнгэрийн гаригуудад төрөх болно.

Шапхала экадаши буюу Пауша-Кришна экадашийн яруу алдрын тухай Бхавишья-уттара Пуранаас авсан хүүрнэл ийнхүү өндөрлөлөө.

ПУТРАДА ЭКАДАШИ

Юдхиштира Махаража айлтгасан нь: Ай Бурхан минь ээ, Та надад *Пауша* (12-1) сарын харанхуй хагаст тохиодог өршөөл ивээлт Шапхала экадашийн яруу алдрыг гайхамшигтай сайхнаар тодорхойлон айлдан соёрхлоо. Харин одоо Та надад энэ сарын гэрэлтэй хагасын экадашийн талаар айлдаж соёрхоно уу. Түүнийг юу гэж нэрлэдэг вэ? Энэ өдөр ямар шүтээнд мөргөн бишрэл хүндэтгэлээ илэрхийлэх ёстой вэ? Ай Пурушоттама минь ээ, ай Хришикеша минь ээ, энэ өдөр Таныг хэрхэн цэнгүүлж болохыг надад мөн айлдана уу.

Бурхан Кришна айлдсан нь: Ай хаан минь ээ, Би бүх хүмүүсийн ач тусын төлөө Пауша-шукла экадашид мацгийг хэрхэн яаж барьдаг талаар чамд

айлдъя. Би урьд өмнө айлдсанчлан, экадашид хүн бүр тодорхой журам дүрмүүдийг даган баримтлах ёстой байдаг билээ. Энэ нь хүний бүх нүглийг арилган түүнийг бурханлаг оронд буцаан хүргэдэг Путрада гэж нэрлэгдэх энэ экадашид ч мөн хамаардаг болно. Энэ экадашид Бүхний Дээд Бурхан, анхдагч Бодьгал-Шри Нараянад бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн мөргөдөг. Тэр өөрийн цэвэр чин бишрэлтэнгийн бүхий л хүслийг биелүүлдэг бөгөөд түүнд бүрэн төгс төгөлдрийг хайрлан хүртээдэг. Иймээс гурван ертөнцөд, хөдлөгч болон үл хөдлөгч оршнолуудын дунд Бурхан Нараянагаас илүү дээд бодьгал байдаггүй билээ.

Ай хаан минь ээ, Би чамд одоо бүхий л нүглийг арилган зайлуулдаг хийгээд хүнд алдар цуу болон эрдэм мэдлэгийг соёрхон хүртээгч Путрада экадашийн түүхийг айлдъя. Энэ явдал Сукутуман хааны захирдаг Бхадравати улсад болсон юм. Түүний хатан нь эрхэм хүндэтгэлт Шайбья байлаа. Харин эзэн хаан хүүгүй байсан учир тэр байнгад л: “Надад хүү заяахгүй нь ээ, миний удам угсааг хэн залгамжлан үргэлжлүүлэх болж байна вэ?” гэж бодож үргэлж тайван бус, тавгүй байдаг байлаа. Сүсэг бишрэлт ухаан бодолдоо автсан тэрээр: “Хаашаа явж хэн дээр очих вэ? Юу хийх нь зүйтэй вэ? Яаж хүүтэй болох вэ?” гэж удаанаар бодлого болон суудаг байв. Сукутман хаанд түүний улс гүрэн, хаант төр нь ямар ч баяр хөөр авчрахаа больсон бөгөөд цаг хугацаа өнгөрөх тусам тэрээр ордноосоо гадуур, хатнаасаа тусдаа улам бүр их цагийг өнгөрөөж, яаж хүүтэй болох тухай бодолд автан гунихардаг болсон.

Ийнхүү, Сукутман хаан болон түүний хатан Шайбья нар маш их тавгүй байдалд орсон байлаа. Тэднийг *тарпана* буюу өвөг дээдэстээ зориулж ус өргөж байх үед ч тэдний гэр бүлийн энэхүү аз жаргалгүй байдал нь уг өргөлийг өвөг дээдэст нь буцалмал халуун ус мэт таарч тохирохооргүй болгож байв. Тэд, өөрсдийг нь үхсэний дараагаар тэдэнд зориулан *тарпана* өргөх үр удамгүй байгаа тухайгаа л боддог байв. Тэдний өвөг дээдэс нь тун удалгүй тэдэнд *тарпана* өргөх хэн ч байхгүй болох нь гэдгээс болж мөн л түгшин үймэрч байгааг мэдээд бүр ч ихээр гунихардаг болов.

Өөрсдийн өвөг дээдсийн зовуурь түгшүүрийн талаар бодсоноор хаан хатан хоёр улам бүр ихээр зовон шаналах болов. Сайд түшмэд нь ч тэр, найз нөхөд нь ч тэр, тэр ч бүү хэл тэдний хамгийн ихээр хайрладаг ойр дотнын хүмүүс нь ч тэднийг тайтгаруулж, тайвшруулж чадахгүй байлаа. Хаанд заан ч тэр, хүлэг морьд ч тэр, явган цэрэг ч тэр огтхон ч сонирхолгүй болсон бөгөөд эцэстээ тэр ямар ч идэвхгүй болж, бүрмөсөн арчаагүй сул дорой, үхээнц байдалтай болсон. Хаан: “Хүүгүй гэр бүл бол гэр бүл биш гэж ярьдаг. Хүү заяагаагүй гэр бүлтэй хүний зүрх нь хичнээн тансаг, гоё сайхан гэр оронтой байсан ч хөндий хоосон гэр оронтойгоо нэгэн адил хоосон бөгөөд хөөрхийлөлтэй болж үлддэг. Хүүгүй бол тэр өвөг дээдэстээ ч, хагас бурхдад ч, өөр бусад хүмүүст ч өрөө эргүүлэн өгч чадахгүй болдог билээ. Иймээс гэр бүлтэй хүн бүр хүүтэй болох ёстой. Ингэж байж л тэр алдар хүндийг олох бөгөөд хожим нь тэнгэрийн гаригуудад хүрдэг. Хүү бол хүний өнгөрсөн зуу зуун амьдралууддаа үйлдсэн ач тустай үйлсийн гэрчилгээ байдаг бөгөөд ийм хүн эрүүл саруул, элбэг дэлбэг, урт удаан амьдардаг. Хүнд, энэ амьдралд нь хүү болон ач хүү заяаж байгаа нь тэрээр урьд өмнөх амьдралууддаа Бурханы Дээд Бодьгал, Вишну Бурханыг бишрэн шүтэж байсан гэдгийг нь гэрчилж байгаа юм. Хүү болон мөн эд баялаг, хурц ухаантай болох дээдийн дээд адислалыг Бүхний Дээд Бурхан, Шри Кришнад бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн залбирч мөргөснөөр хүртэх болно. Миний бодлоор бол ийм л байдаг билээ.” гэж бодон байсан.

Ийнхүү бодол болсоор хаан өөрийгөө бүр ч тайван бус, тавгүй байдалд оруулж байв. Тэр өдөр шөнөгүй, өглөөнөөс орой болтол тавгүй, тайван бус байдаг байлаа. Унтахаар хэвтэх оройноос өглөө болж нар мандах хүртэл түүний нойр нь түгшүүр зовиураар тасралтгүй дүүрэн байлаа. Тавгүй байдал, түгшүүр зовиураас болж тасралтгүй шаналж байсан Сукутуман хаан амиа

егүүтгэснээр өөрийн зовлон шаналалаа эцэс болгохыг шийдсэн боловч амиа хорлосон хүн дараагийн төрөлдөө тамд унадаг гэдгийг мэдэх учир энэ бодлоо таягдан хаясан.

Өөрийг нь бүрэн эзэмдсэн тайван бус, таагүй байдал түүнийг аажим аажмаар сүйтгэн хөнөөж байгаад цөхөрсөн хаан мориндоо мордон өтгөн ойн зүг ганцаар давхин одсон. Ордон дотор хэн ч, гэгээнтнүүд болоод брахманууд хүртэл түүнийг хаашаа явсныг мэдсэнгүй. Янз бүрийн жигүүртэн шувууд хийгээд амьтан араатангууд дүүрэн хөлхөлдөх ой дундуур хаан тилака, тиндука, саптапарна, бакула, пальм, финик, белын жимс, фич модод болон үр жимсээ дааж ядсан бут сөөгүүд, мөн шала, тала, тамала, сарла, хингота, аржуна, лабхера, бахеда, саллака, каронда, патала, кхайра, шака болон палаша зэрэг моддыг ажиглан ямар ч зорилгогүйгээр хэрэн тэнүүчилж явав. Тэд бүгдээрээ л цэцэгс хийгээд үр жимсээрээ гайхалтай сайхнаар чимэглэгдсэн байлаа. Хаан мөн ойрхон яваа буга, бар, зэрлэг гахай, арслан, сармагчин, аврага том заан, тугалаа дагуулсан эмэгчин заан болон эмэгчинтэйгээ хамт байгаа дөрвөн соёт заануудыг харсан. Тэнд мөн үхэр, чоно, туулай, ирвэс, бегометууд байв. Эмэгчид хийгээд үр зулзагануудаараа хүрээлүүлж дагуулсан эдгээр амьтдыг хараад хаан өөрийн амьтны хүрээлэнгээ, ялангуяа ордныхоо заануудыг дурсан санасан бөгөөд гунигласнаасаа болж тэрээр араатан амьтдад маш ойрхон, бараг хажуу дэргэд нь очсон байлаа.

Хаан гэнэт хажууханд нь цөөвөр чонын улихыг сонссон. Айж цочсон тэр зүг зүгт харангаа цааш үргэлжлүүлэн гэлдрэв. Ингэсээр байтал үд болж хаан ядарч байгаагаа мэдрэв. Түүнийг өлсөж цангах явдал мөн зовоож эхлэв. Тэрээр: “Аагим халуун хийгээд хоолой ам аргаж хатахаас болж ингэж зовж шаналахаар ямар нүгэл би үйлдсэн юм бол доо? Би хагас бурхдад олон удаа галан тахилга үйлдэж өргөл өргөн, бишрэл хүндэтгэлээ маш элбэг дэлбэг байдалтайгаар илэрхийлж байсан билээ. Мөн зохистой брахмануудад олонтаа бэлэг өгч байсан билээ. Би албат иргэддээ өөрийн хүүхдүүд мэт санаа тавьж байсан. Би яагаад ингэж зовж шаналах ёстой гэж? Ямар учир нь үл мэдэгдэх нүгэлт үйл намайг ингэж тамлан зовоогоод байна вэ?” гэж бодсон.

Ийнхүү бодолдоо автсан Сукутуман хаан дэмийрэн урагш явсаар, магадгүй өөрийн сайн үйлийн ач тусаар алдар цуутай Манасаровара нууртай төстэй нэгэн гайхамшигтай цөөрөмд тулж ирсэн. Энэ цөөрөмд амьдарч байгаа матар, янз бүрийн загас жараахайнууд болон хун, тогоруу, нугас зэрэг шувууд бүгд л аз жаргалаар дүүрэн байлаа. Мөн тэр цөөрөм наранд дэлбээгээ дэлгэн байгаа үзэсгэлэнт сайхан бадамлянхуа болон сараана цэцгүүдээр чимэглэгдсэн байв. Цөөрмийн эргэн тойронд олон тооны *ашрамууд* байх бөгөөд тэдгээрт хэн бүхний хүслийг биелүүлэхэд бэлэн байх гэгээнтэн мэргэд амьдарч байв. Тэд, бүгдэд сайн сайхныг хүсэж байлаа.

Хаан энэхүү үзэсгэлэн төгөлдөр газрыг хармагц л баруун гар болоод нүд нь ямар нэгэн таатай зүйл болохын дохио тэмдэг болон чичигнэн татахыг мэдэрсэн. Хаан мориноосоо буугаад, цөөрмийн эрэг дээр суугаад эрхин дээрээ Бурханы ариун гэгээн нэр алдруудыг давтан хэлж байгаа мэргэдэд ойртон очсон. Тэрээр алгаа хавсран, мэргэдийг магтан тэдэнд гүн хүндэтгэлтэйгээр мөргөлөө. Тэдэнтэй уулзсандаа тэр маш их баяртай байв. Хүндэтгэл үзүүлсний дараагаар хаан өөрийгөө тэдэнд танилцуулсан. Мэргэд: “Хаан минь ээ, чамайг ирсэнд бид маш их баяртай байна. Ямар учраас энд ирэв? Хэрэг зорилго юу болохоо хэлээч.” хэмээн хэллээ. Хаан хариулсан нь: “Ай аугаа мэргэд минь ээ, Та нар хэн бэ? Ай гэгээнтэнгүүд минь ээ, Та бүхний алдар нэрсийг хэн гэдэгсэн бол? Энэ үзэсгэлэнт сайхан газар та бүхэн юу хийж байгаа юм бэ? Энэ тухайгаа та бүхэнд надад ярьж өгөөч.”

Мэргэд түүнд хариу болгон өгүүлсэн нь: “Ай хаан минь ээ, Бид бол Вишведева¹ нар билээ. Бид энд, энэ үзэсгэлэнт сайхан цөөрөмд угаал үйлдэхээр ирсэн билээ. Таван өдрийн дараа *Магха* сар эхэлнэ. Харин

өнөөдрийн энэ өдөр бол Путрада экадаши гэж алдаршсан өдөр билээ. Хүүтэй болохыг хүссэн хэн бүхэн энэ экадашийг² нарийн чанд баримтлах хэрэгтэй байдаг.” Хаан: “Би хүүтэй болохыг маш ихээр хүсэж байна. Аугаа мэргэд минь ээ, надад сайн хүү хайрлаж өгөөч.” гэж бахдан дуу алдав.

“Путрадын жинхэнэ учир утга бол— хэмээн эхэлсэнээ, мэргэд цааш нь үргэлжлүүлэн- тэрээр хүү заяахад оршдог. Иймээс, экадашийн энэ өдөр бүтэн мацаг барь. Хэрвээ чи ингэх аваас бидний адислал болон Кешава Бурханы өршөөл нигүүлслээр хүүтэй болох нь эргэлзээгүй.” гэж өгүүлэв.

Вишведевагуудын зөвлөснөөр хаан Путрада экадашийн өршөөл ивээлтэй энэхүү өдөр тогтоогдсон бүхий л дүрэм журмуудын дагуу мацаг барьсан. *Двадашид* мацгаа тайлаад тэрээр мэргэдэд хүндэтгэл бишрэлээ дахин дахин илэрхийлж байлаа.

Сукутуман хааныг ордондоо буцаж ирсний дараагаар тун удалгүй Шайбья хатан жирэмсэлсэн бөгөөд Вишведева нарын урьдчилан хэлсэнчлэн, тэд нар лугаа туяаран гэрэлтэх царайтай үзэсгэлэн төгөлдөр хүүтэй болсон. Хүү өсөж том болоод баатар-хан хүү гэж алдаршсан бөгөөд хаан түүнийг өөрийн залгамжлагчаар баяртайгаар өргөмжилсөн. Сукутуманы хүү үнэнч шудрага бөгөөд албат иргэддээ өөрийн төрсөн хүүхдүүд мэт санаа тавьдаг байлаа.

Ай Юдхиштхира минь ээ, иймд хүслээ биелүүлэхийг хүсэж байгаа хэн бүхэн Путрада экадашийг нарийн чанд баримтлах хэрэгтэй. Энэ гариг дээр оршиж байгаа хэн бүхэн энэхүү экадашийг нарийн чанд баримтлах аваас хүүтэй болох нь гарцаагүй бөгөөд бие махбодио орхисны дараагаар ангижралд хүрэх болно. Путрада экадашийн яруу алдрын тухай уншсан эсвэл сонссон хэн бүхэн мориор тахилга өргөл үйлдсэнтэй адил хэмжээний ач тусыг хүртэх болно. Бүх хүн төрөлхтний тусын тулд Би чамд энэ бүхнийг айлдлаа.

Путрада экадаши буюу Пауша-шукла экадашийн яруу алдрын тухай Бхавишья Пуранаас авсан хүүрнэл ийнхүү өндөрлөлөө.

Тайлбар:

1. Арван Вишведева буюу Вишвагийн хөвгүүд: Васу, Сатья, Краду, Дакша, Кала, Кама, Дхрити, Пурурава, Мадрава болон Куру нар.

2. Хүү гэдэг үгийг санскрит хэл дээр *путра* гэдэг. Тамын нэгэн хэсгийг *Пу* гэж нэрлэдэг, харин *тра* гэдэг үг нь ангижруулах, аврах гэсэн утгатай. Иймээс *путра* гэдэг үг нь “Пу нэртэй тамаас ангижруулагч” гэсэн утгыг илэрхийлдэг. Иймээс эхнэр авсан хүн бүр ядаж нэг хүү төрүүлж түүнийгээ зохих ёсоор хүмүүжүүлэх ёстой байдаг. Тэгсэн цагт тэр эцэг тамд зовохгүй болдог. Гэхдээ энэ журам Вишну буюу Кришна Бурханы цэвэр чин бишрэлтэнгүүдэд үл хамаардаг. Учир нь Бурхан Өөрөө түүний хүү нь, эцэг нь, мөн эх нь болдог билээ.

Чанакья Пандитын хэлсэнчлэн: “Үнэн- энэ бол миний эх, мэдлэг- энэ бол миний эцэг, оноогдсон үүрэг- энэ миний ах, амар амгалан- миний эхнэр, харин бүхнийг өршөөн уучлахуй- энэ бол миний хүү. Энэ бүгд- миний гэр бүлийн гишүүд.” Бурханы чин бишрэлтэнгийн 26 гол шинжүүдийн дунд уучлан хэлтрүүлэх шинж нь хамгийн чухал байдаг. Иймээс чин бишрэлтэнгүүд энэхүү шинжийг өөртөө хөгжүүлэхийг бүхий л хүчээрээ хичээн чармайх хэрэгтэй. Энд Чанакья Пандитын хэлсэнчлэн: “Бүгдийг өршөөн уучлахуй- миний хүү.” бөгөөд иймээс Бурханы чин бишрэлтэн нь гэр бүлгүйн амьдралын хэвшлийн сахилыг баримталж байгаа байсан ч Путрада экадашид мацаг барихдаа бүхнийг уучлан өршөөхүйн- “ийм хүүтэй” болохыг залбиран гуйж болно.

ШАТ-ТИЛА ЭКАДАШИ

Далбья Риши Пуластья Мунид хандан хэлсэн нь: “Материаллаг эрчимтэй шүргэлцэн холбогдсоноор сүнс нь төдөлгүй хулгай хийх, аллага үйлдэх, бэлгийн зөвшөөрөгдөөгүй харьцаанд орох зэрэг нүгэлт үйлүүдийг хийж эхэлдэг. Тэр ч бүү хэл брахманыг хүртэл хөнөөх зэрэг өөр бусад нүгэлт олон үйлүүдийг ч үйлдэж магадгүй. Ай өө сэв, гэм нүгэлгүй минь ээ, эдгээр хувь заяа муутай сүнснүүд тамын гаригуудад унаж, гэсгээл цээрлэл эдлэхээс хэрхэн яаж мултран ангижирч болохыг надад өгүүлээч. Хүн даруухан бага ч гэсэн өглөгийг өгсөнөөр үйлдсэн нүглээ хэрхэн яаж зайлуулж болохыг ярьж өгөөч.”

Пуластья Муни хариулсан нь: “Ай аз жаргалд умбагч минь ээ, чи надаас Брахма, Вишну, Шива болон Индра нар ч хариулахад төвөгтэй маш эрхэм нандин чухал асуултыг асуулаа. Миний ярихыг анхааралтай сайн сонсож ав.

Магха (1-2) сар эхлэх өдөр, угаал үйлдсэнийхээ дараа уур хилэн, бардам сайрхуу зан, атаа жетөө, өө сэв эрэн гоочлох болон шунал тачаал зэргээ дарснаар мэдрэхүйгээ маш сайн хичээнгүйлэн эзэмдэн захиран Бурханы Дээд Бодьгал, Шри Кришнаг бясалгах хэрэгтэй. *Пурвашхадха-накшатра* хос од харагдах өдөр бага зэргийн үхрийн баасыг газар унахаас нь өмнө амжиж тосон аваад түүнийгээ хөвөн болон кунжутын үртэй холин 108 ширхэг үрэл хийх хэрэгтэй.

Экадашид мацаг барихын зэрэгцээ ямар дүрэм журмыг баримтлах хэрэгтэй байдаг талаар одоо сонс. Экадашийг баримтлахыг зорьж буй хүн угаал үйлдсэнийхээ дараа Бүхний Дээд Бурханд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн залбирч мөргөх хэрэгтэй. Бурхан Кришнад залбирч мөргөх болон ариун гэгээн нэр алдруудыг нь давтан хэлж байх үедээ энэхүү экадашийг нарийн чанд баримтлахаа амлах хэрэгтэй. Мацаг баригч хүн бүхий л шөнийн туршид унталгүй сэрүүн байж мөн *хомаг* үйлдэх хэрэгтэй. Дараа нь чин бишрэлтэн Өөрийн мутрууддаа дун, галт хүрд, шийдэм болон бадам лянхуа цэцэг барьсан Бурханд зандан модны оо, хүж, гавар, зул болон гайхамшигтай сайхан идээ зоог өргөж *арати* үйлдэх хэрэгтэй. Үүний дараагаар, чин бишрэлтэн нь Бүхний Дээд Бурхан Кришнагийн ариун гэгээн нэр алдруудыг давтан хэлэнгээ дээр бэлтгэсэн 108 үрлээ ариун галд өргөх ёстой. Бүхэл өдөр, шөнийн туршид үр тариа болон буурцагт ургамал оролцуулан хийж бэлтгэсэн хоол хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэхийг цээрлэн тэвчиж экадашийг нарийн чанд баримтлах ёстой бөгөөд Бурханд хулуу, наргилын самар болон гауваг өргөх хэрэгтэй. Хэрвээ эдгээр зүйлс байхгүй бол бетелийн самар өргөж болно.

Бүх амьд оршнолуудыг ивээгч Бурхан Жанарданад: “Ай Бурхан Кришна минь ээ, Та бол Бурханы хамгийн нигүүлсэнгүй Бодьгал хийгээд уналтанд өртсөн бүхий л сүнснүүдийг авран чөлөөлөгч билээ. Ай Бурхан минь ээ, бид материаллаг оршнолын далайд уначихсан байна. Бидэнд өршөөл нигүүлслээ хайрлаач. Ай бадамлянхуа мэлмийт Бурхан минь ээ, бидний хамгийн хүлцэнгүй бөгөөд гүн хүндэтгэлт бишрэлийг болгоож хайрлана уу. Ай ертөнцийг ивээгч минь ээ, бид Танд дахин дахин хүндэтгэл бишрэлээ илэрхийлье. Ай Дээдийн Дээд Сүнс минь ээ, ай Бүхний Дээд минь ээ, ай бидний бүх өвөг дээдсийн минь Өвөг Дээд минь ээ, Таныг болон Таны мөнхийн амраг хайрт Шримати Лакшми девиг бидний энэхүү эгэл даруухан өргөл бэлгийг таалан болгоохыг гуйж байна.” гэж залбиран мөргөх хэрэгтэй.

Дараа нь чин бишрэлтэн нь зохистой брахманд халуун дотно мэндчилгээний хамт сав дүүрэн ус, шүхэр, гутал хувцас өргөж түүний тав тух, баяр баясгалантай байдлыг хангаж, түүнээс адислал ерөөл хүсэх хэрэгтэй. Үүний ачаар чин бишрэлтэнд Бурханыг хайрлах цэвэр ариун хайр хөгждөг болно. Хэрвээ нөхцөл боломж байх аваас ялангуяа, Ведийн сургаалын бүх чиг салбарт нэвтэрхий сайн брахманд хар зүсмийн үнээ өргөж болно. Түүнд мөн сав дүүрэн кунжутын үр өргөх хэрэгтэй.

Ай аугаа Далбья Муни минь ээ, зааж зөвлөсөн ёсоор хүндэтгэлээ илэрхийлэх болон галан тахилга үйлдэхэд кунжутын үр онцгой таарамж нийцтэй байдаг. Харин кунжутын цагаан болон хүрэн үр нь зохистой брахманыг дайлах идээ зоогонд зориулагддаг. Ариун гэгээн Шат-тила экадашид энэ хоёр төрлийн үрийг өргөл болгох хүн тэнгэрийн гаригуудад дээшлэн очдог бөгөөд өргөл болгосны дайтай тийм хэмжээний үрийг тариад хурааж авах үрийн тоотой тэнцэхүйц тийм олон мянган жилийн туршид тэнд байх болно.

Энэ экадашид, чин бишрэлтэн кунжутын үр хольсон усанд угаал үйлдэж, биедээ кунжутын оо түрхэн, тахилга үйлдэх үедээ кунжутын үр өргөж, кунжутын үр идэж, кунжутын үрийг өглөг хишиг болгон тарааж, кунжутын үрээр өргөл авдаг. Энэ зургаа (*шат*) нь кунжутын үрийг (*тила*) энэ экадашийн үед бурханлаг ариуслын зорилгоор ашигладаг зам байдаг юм. Иймээс түүнийг Шат-тила экадаши гэж нэрлэдэг.

Аугаа Деварши Нарадажи нэгэн удаа Бурханы Дээд Бодьгал, Шри Кришнад: “Ай хүчит мутарт Бурхан минь ээ, ай Өөрийн хайрт чин бишрэлтэндээ өршөөл нигүүлслээ хайрлагч минь ээ, ай Ядава минь ээ, Та Шат-тила экадашийг баримталснаар хүрэх үр дүн, ач тусын тухай надад айлдан соёрхоно уу.” гэж айлтгасан байдаг.

Бурхан Кришна хариу айлдсан нь: “Ай хоёр дахиа төрөгчдөөс хамгийн шилдэг нь минь ээ, Би Өөрөө гэрч нь болсон нэгэн түүхийг чамд айлдъя. Олон жилийн өмнө энд нэгэн настайвтар эмэгтэй-брахман амьдардаг байсан ба тэр өдөр бүр Надад бишрэл хүндэтгэлээ илэрхийлсээр мэдрэхүйгээ эзэмдэн захирч удирдан залж чаддаг болсон. Итгэл дүүрэн тэрээр олон удаа, ялангуяа Намайг бишрэн хүндэтгэдэг тусгай өдрүүдэд мацаг барьдаг байсан ба Надад чин бишрэл дүүрэн, ямар ч шунахайн сэдэлгүйгээр үйлчлэн зүтгэдэг байв. Хүнд хэцүү мацгуудаас болж тэр бүр сульдан, ядарч эцсэн байлаа. Тэрээр брахмануудад, залуу охидуудад өглөг тараадаг байсан ба бүр өөрийн гэр орноо хүртэл өргөл болгон өргөхөөр зэхэж байв. Ай брахмануудын шилдэг нь минь ээ, энэ бурханлаг эмэгтэй зохих хүмүүст өргөлийг энэрэнгүйгээр тараадаг байсан хэдий ч түүний тэвчил наманчлалын хачин жигтэй онцлог нь тэрээр брахманууд болоод хагас бурхдад хэзээ ч идээ зоог өргөдөггүй байсанд оршиж байлаа.

Хэдийгээр тэр ийм хачин жигтэй осол эндэл гаргасан ч, ивээл өршөөлөө хайрлах боломж гарах бүрт мацаг барин өөрийгөө ариусгах болон Надад цөхрөлтгүйгээр, чин бишрэлтэйгээр бишрэл хүндэтгэлээ илэрхийлэх энэхүү гайхамшигтай эмэгтэйг эгэл жирийн хүмүүсийн хувьд огтхон ч хүршгүй, Миний залрах оронд хүрч очиход таарч тэнцэнэ гэдэг нь эргэлзээгүй хэмээн Би таалсан билээ. Гэхдээ Би түүнийг шалгахаар энэ гариг дэлхий дээр морилон бууж ирэн хүзүүндээ яст мэлхийн зүүлт зүүж, гартаа гуйлга гуйх аяга барин Шива бурхны дагалдагчийн дүрд хувирсан.

Намайг түүнд ойртож очиход, тэр эмэгтэй: “Ай эрхэм хүндэт хүн гуай минь ээ, над руу ямар хэрэг зорилгоор ирсэнээ нуулгүй үнэнээр нь хэлээрэй.” гэлээ. “Ай үзэсгэлэнт эмэгтэй минь ээ, Би ариун гэгээн өглөг бага зэргийг л хүртэх гэж ирлээ.” гэж Намайг хариултал, тэрээр Миний аяга руу хатуурч нягтарсан бөөн шавар шидчихлээ. Энэ гайхамшигтай брахман-эмэгтэйд уужим өршөөнгүй болон харамч нарийн зан гайхалтай хосолсон байлаа. Тэгээд Би шууд л эргэн, Өөрийн орон тийш буцан одсон доо, Нарада минь.

Хожим нь энэ тэвчилт эмэгтэй өөрийн биеэрээ бурханлаг ертөнцөд хүрч очсон. Түүний мацаг барих болон тахилга өргөл үйлдэхдээ гаргасан хүчин чармайлт ийм л аугаа байсан билээ. Надад өгсөн хэсэг шаврыг нь Би гайхамшигтай сайхан байшин болгон хувиргасан. Гэхдээ, ай Нарадажи минь ээ, энэ онцгой байшинд идэх будаа тарианы зүйл юу ч байгаагүй. Мөн тэрчлэн ямар ч тавилга, чимэглэлгүй байв. Тэр байшинд орон юу ч үгүй хөндий хоосон байхыг харж мэдээд Над руу хүрч ирэн маш их ууртайгаар: “Би аятай таарамжтай, өршөөл ивээлтэй боломж тохиох бүрт өөрийн бие махбодийг сул

дорой, эцэнхий муу болтол өчнөөн олон удаа мацаг барьж бүхий л орчлонгийн хамгаалагч хийгээд эзэн Танд өч төчнөөн удаа залбирч мөргөсөн билээ. Тэгэхэд, энэ бүгдийг хийсэн байсан ч, ай Жанардана минь ээ, миний шинэ гэрт ямар ч эд баялаг, ямар ч хоол хүнсний зүйл алга байна. Яагаад тэр вэ?¹” гэж асуулаа.

Би түүнд: “Гэртээ буцаж хариад байж бай. Хэсэгхэн хугацааны дараа, шинээр ирэгчийг харах гэсэн сониуч зандаа хөтлөгдсөн хагас бурхдын эхнэрүүд чам дээр айлчлан очих болно. Харин чи тэднийг Шат-тила экадашийн яруу алдрыг тодорхойлон хэлж, магтан дуулахаас нааш хаалгаа битгий нээгээрэй.” гэж хариулсан.

Үүнийг сонсоод тэр гэртээ буцаж харьсан. Удалгүй хагас бурхдын эхнэрүүд ирж, бүгд хамтаараа: “Ай үзэсгэлэн төгөлдөр минь ээ, Бид чамд бараалхахаар ирлээ. Хаалга үүдээ нээж бидэнд өөрийгөө харуулаач.” гэж хэлцгээв. Эмэгтэй: “Ай үнэт эрдэнэсүүд минь ээ, хэрвээ та бүхэн, намайг хаалга үүдээ нээг гэж хүсэж байгаа бол Шат-тила экадашид ариун гэгээн мацаг барьснаар хүртэж болох ач тусын талаар надад хэлж өгцгөөнө үү.” гэж хэллээ. Гэсэн ч тэдний нэг нь ч хариу дуугарсангүй.

Хэсэг хугацааны дараагаар тэд буцаж ирцгээн нэг нь энэхүү ариун гэгээн экадашийн эрхэм дээд мөн чанарыг сайн тайлбарласан. Эмэгтэйг хаалгаа нээхэд тэд ямар ч хагас бурханыг, ямар ч *гандхарваг*, тэр ч бүү хэл *нагапатнаг* ч олж харсангүй. Тэр бол зүгээр л нэг эгэл жирийн эмэгтэй байлаа.

Материаллаг таашаал ханамж болон ангижралыг нэгэн зэрэг хүртээх Шат-тила экадашийг тэрээр өөрт нь тодорхойлон өгүүлсэн тэр л байдлаар баримталсан байлаа. Ингээд хожим нь тэр эмэгтэй өөрийн гэртээ хүссэн тавилга, хогшил хийгээд хоол хүнстэй болсон. Түүнээс гадна түүний жирийн материаллаг бие нь үзэсгэлэн гоо дүр төрх бүхий гайхамшигтай бурханлаг бие болон хувирсан. Ийнхүү Шат-тила экадашийн өршөөл ивээлээр тэр эмэгтэй болон түүний шинэ гэр орон нь бурханлаг ертөнцөд хачин гайхалтайгаар туяаран алт, мөнгө, сувд болон алмааз эрдэнээр гялалзах болсон.

Ай Нарадажи минь ээ, хүн экадашийг шудрага бус замаар үр дүнд хүрэх гэсэн найдлага, чармайлттайгаар, үзүүлбэр байдлаар баримтлах ёсгүй. Хүн өөрийн нөхцөл байдалдаа тохирсон байдлаар зүгээр л, хоол хүнс, хувцас хунар болон кунжутын үрийг харамгүйгээр өргөл болгон өргөх ёстой. Ийнхүү үйлдсэнээр эрүүл саруул бие бялдар болон ариун дээд бурханлаг ухамсартай² болно. Эцэстээ тэр ангижралд хүрч Бурханы дээдийн дээд оронд буцан очдог. Ай хагас бурхдын шилдэг нь минь ээ. Миний таалал ийм байдаг.

Пуластья Риши төгсгөлд нь: “Ай Далбья Муни минь ээ, гайхамшигт Шат-тила экадашийг аугаа их итгэл бишрэлтэйгээр баримтлах хэн бүхэн ямар ч бурханлаг, ухаан бодлын, бие бялдрын, нийгмийн болон оюун ухааны-ядуурал хоосролд үл өртөхийн зэрэгцээ өвчин хийгээд гай зовлонгийн бүхий л хэлбэр, төрөлд үл нэрвэгдэнэ. Экадашид мацаг барьж, өглөг тарааж, тахилга өргөл үйлдэж мөн кунжутын үрийг амтлан хүртэж байгаа хэн бүхэн бүх нүглээсээ салан ангижирдаг нь эргэлзээгүй. Үүнд гайхах хэрэг огтхон ч байхгүй. Ведийн сургаалыг зөв даган баримталж байгаа, чин бишрэлийн зөв шудрага зан байдалтайгаар өглөг тарааж байгаа ховор сүнс л бүхий л нүгэлт үр дагавруудаасаа бүрнээ ангижирч бурханлаг ертөнц тийш, Бурханы зүгт гэртээ буцаж харьдаг.” гэж өгүүллээ.

Шат-тила экадаши буюу Магха-Кришна экадашийн яруу алдрын тухай Бхавишья-уттара Пуранаас авсан хүүрнэл ийнхүү өндөрлөлөө.

Тайлбар:

1. Бурханлаг ертөнцөд уур хилэн болон материаллаг хүсэл сонирхол огтхон байдаггүй ч, Кришна Шат-тила экадашийн яруу алдрыг тайлбарлан таниулахын тулд тэр эмэгтэйд энэхүү шинжүүд илрэн гарахаар зохицуулсан.

2. Вайшнавчуудын хувьд өргөл өргөнө гэдэг нь “Кришнын ухамсарыг өгөх” ялангуяа, Харе Кришна мантраг давтан хэлэх явдал байдаг. Шри Чайтанья Махапрабху: “Ай ах минь ээ, “Харе Кришна”-г бахдан дуулж, давтан хэлээ ч ... Би зөвхөн энэ л хайр хишгийг гуйж байна.” гэж айлдсан билээ. Хэдийгээр ийм байдаг ч гэр бүлтэй-чин бишрэлтэнгүүд нь зохих бодьгалд кунжутын үр, хувцас болон хоол хүнс өргөх чадал чинээтэй байх аваас тэрээр үүнийг сайн дураараа хийж болно.

ЖАЯ ЭКАДАШИ

Юдхиштхира Махаража айлтгасан нь: “Ай бурхдын Бурхан Шри Кришна минь ээ, Таны алдар бадартугай. Ай орчлонгийн эзэн минь ээ, Зөвхөн Та л өндөг, чийг, үрнээс төрөх болон үр хөврөлөөс хөгжин бий болдог амьд оршнолуудын дөрвөн төрлийн эх булаг билээ. Зөвхөн Та л бүгдийн анхдагч учир шалтгаан билээ. Ай Бурхан минь ээ, иймээс Та бол бүтээгч, тогтоон баригч болоод устган сөнөөгч билээ.

Бурхан минь ээ, Та өршөөн нигүүлсэгч учраас л *Магха* (1-2) сарын харанхуй хагаст тохиодог Шат-тила экадашийн адислал ерөөлт өдрийн талаар надад айлдсан билээ. Одоо, энэ сарын гэрэлтэй хоёр долоо хоногийн экадашийн тухай айлдаж соёрхоно уу. Түүнийг юу гэж нэрлэдэг болон хэрхэн яаж баримтлах ёстой вэ? Танд маш эрхэм байдаг энэ өдөрт ямар Бурханд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэх вэ?

Бурхан Шри Кришна хариу айлдсан нь: Ай Юдхиштхира минь ээ, Би чамд *Магха* сарын гэрэлтэй хагаст тохиодог энэ экадашийн тухай баяртайгаар айлдъя. Энэхүү экадаши нь нүглийн бүхий л үр дагаврыг устгадаг хийгээд сүнсэнд үзүүлэх демонлог нөлөөг зайлуулан арилгадаг. Энэ экадашийг Жая гэж нэрлэдэг бөгөөд энэхүү ариун гэгээн өдөр мацаг барих зол завшаантай сүнс нь хий үзэгдэл байдлаар орших оршнолын хүнд хэцүү дарамт тээрийг хөнгөлдөг. Үүнээс илүү сайн өдөр гэж үгүй билээ. Тэрээр төрөлт үхлээс ангижрахуйг хүртээдэг нь үнэн билээ. Энэ экадашийг маш хичээл чармайлттайгаар бишрэн хүндэтгэх хэрэгтэй. Иймд, ай Пандава минь ээ, Би урьд нь Падма Пуранад айлдсан, энэ экадашид хамааралтай нэгэн гайхамшигт түүхийг маш анхааралтайгаар сонсож ав.

Энэ явдал маш эртийн цагт болсон юм. Тэр цагт тэнгэрийн гаригуудад Индра бурхан өөрийн тэнгэрийн хаант төрөө амжилттай захиран байсан бөгөөд тэнд амьдрагч хагас бурхад бүгдээрээ аз жаргалтай, хангалуун сайхан байцгаалаа. Индра хаан хүссэн цагтаа л парижата цэцгээр гайхамшигтай сайхнаар чимэглэгдсэн Нандана ойд амброзия уун, өөрийг нь цэнгүүлэхээр онгод хөөрөлтэйгөөр бүжиглэж байгаа 50 сая тэнгэрийн бүсгүйчүүд, *алсарууын* алба үйлчлэлээр цэнгэн жаргадаг байв. Пушпадантагаар ахлуулсан олон дуучид зүйрлэшгүй яруу тунгалаг хоолойгоор түүнд зориулан ая дуугаа өргөдөг байлаа. Тэдний дунд Индрагийн гол хөгжимчин Читрасена өөрийн эхнэр Малина болон гайхамшигт хөвгүүн Мальяван нарын хамт оролцдог байв.

Пушпавати нэртэй *алсарад* Мальяван маш ихээр таалагдаж, хайрын бурхны хурц сумууд түүний зүрхийг сийчин байлаа. Мөн түүний гоо үзэсгэлэн Мальяванаг ч татаж байлаа. Түүний хөмсөгний гижигдэм шидэт хөдөлгөөн болон үзэсгэлэн төгөлдөр бие бялдар нь дур булаам байв. Ай хаан минь ээ, Пушпаватын харж ханахын аргагүй гуа үзэсгэлэнг намайг хэрхэн тодорхойлохыг сонс: түүний зүйрлэшгүй, гунхалзсан гарын тэврэлт нь гоё сайхан төрсөн цалам мэт, царай нь сар лугаа, бадамлянхуа нүд нь гайхамшигтай уран сайхан ээмгээр гоёж чимсэн үзэсгэлэнт хөөрхөн чихэнд нь бараг хүрсэн байлаа. Лавай

адил нарийн хүзүүтэй, өндөр босоо хөхтэй, хурууны бүдүүнтэй зүйрлэхүйц гэмээр нарийн гуалиг бэлхүүстэй, өргөн ташаатай, бананы модны их бие лугаа шулуун хөлтэй, дэлгэрэн байгаа улаан бадамлянхуаг санагдуулам өлмийтэй байгалаас заяасан гуа сайхан түүний дүр төрхийг гайхамшигт сайхан гоёл болоод хувцас нь улам бүр чимэж байлаа. Нэг үгээр хэлбэл, Пушпаватийн тэнгэрийн гоо сайханд Мальяван дур булаагдан эзэмдэгдэж татагдсан байлаа.

Нэгэн удаа, Индра бурхныг дуу бүжгээрээ цэнгүүлэхээр Мальяван Пушпавати хоёр бусад дуучид бүжигчдийн хамтаар ирлээ. Гэвч хайр дурлалаасаа болсон буюу тачаангуйн биелэл хайрын бурхан тэдний зүрхийг сум мэт нэвтлэн сийчсэн байсан учир тэд хаан эзнийхээ өмнө зөв ч дуулж, сайн ч бүжиглэж чадахгүй байлаа¹. Тэд хэмнэлээ алдан буруу хийж байлаа. Индра бурхан тэдний алдаад байгаагийн учир шалтгааныг шууд ойлгосон. Доромжлогдсон тэрээр маш ихээр уурлаж хилэгнэн: “Ямар ч хэрэггүй тэнэг мунхагууд, бие биедээ татагдсанаас болж байж ядан байгаа та хоёр надад дуулж өгөхөөр ирээ юу? Та хоёр надаар тохуу хийж байх шив. Би одоохон та хоёрыг *пишача* (демон) болгон хувиргачихья. Газар дэлхий дээр очиж өөрсдийн алдаа, басамжлалын үрийг амсаж эдлээрэй.” гэж хашгирав.

Эдгээр хатуу ширүүн үгсийг сонсоод үг дуугарч ч чадахгүй, хөшсөн мэт болсон Мальяван, Пушпавати хоёр тэнгэрийн орон дахь Нанданын гайхамшигт ойгоос агшин зуурт л газар дэлхийн өндөрлөгүүдийн нэг Гималайн оройд шилжин бууж ирсэн байлаа. Тэд байж болохын аргагүй цочирдолд орж, Индрагийн хэлсэн хараалын хахир хатуугийн хирээр тэдний тэнгэрийн ухамсар төдийчинээн хэмжээгээр бүдэгшрэн унтарч амтлах, үнэрлэх, тэр ч бүү хэл хүртэх мэдрэхүйгээ хүртэл бүрмөсөн алдсан байлаа.

Гималайн цас мөсөн цөлд тэд таашаал ханамж эдлэх нь бүү хэл унтаж нойр авч ч чадахааргүй тийм хүйтэн, баргар дүнсгэр байлаа. Уулын оройгоор ямар ч зорилгогүйгээр хэсүүчлэх Мальяван Пушпавати хоёр улам ихээр зовж шаналж байв. Хэдийгээр тэд агуйд хоргодсон боловч цас орж, хүйтэрч байгаагаас болж тэдний шүд нь тасралтгүйгээр тачигнатал дагжин чичирч, айж гайхсанаасаа болж үс нь хүртэл өрвийн боссон байлаа. Ийнхүү цөхрөнгөө барж хэцүүдсэн туйлын хүнд хэцүү байдалд орсон Мальяван Пушпаватид хандан: “Энд ийм аймшигт нөхцөл байдалд, *пишачагийн* ой гутам бие махбодид ингэж зовохоор ямар жигшүүрт, булай муу нүглийг үйлдсэн юм бол. Тамыг байж болохын аргагүй айхавтар хахир хатуу ширүүн гэдэг ч бидний одоогийн амсаж эдэлж буй зовлон шаналал түүнээс ч бүр илүү хатуу ширүүн байна. Иймээс хэзээ ч нүгэл үйлдэхийн хэрэггүй гэдэг нь маргаангүй үнэн юм.” гэж өгүүлэв.

Ийнхүү доош унасан амраг хос цас мөсөн дундуур ихээхэн хүч чармайлт гарган урагшилж байв. Гэхдээ, тэдэнд маш их зол завшаан тохиож, энэ бүхэн Магха сарын гэрэлтэй хагасын Жая экадашийн өдөрт болсон байлаа. Энэхүү гай зовлон шаналал дүүрэн байдалдаа юу ч уугаагүй, энэ өндөр газар дайралдах ямар ч шувуу алаагүй, ямар ч ургамал ногоог олж идээгүй учраас тэд ус хоолгүйгээр бүтэн мацаг барьж экадашийг санамсаргүйгээр баримтлан өнгөрөөсөн хэрэг.

Зовлон зүдгүүртэйгээ тэмцэлдсээр Мальяван Пушпавати хоёр бүр ядарч тамирдаад пипаловын модны дор унацгаан өөр хаа нэгтэй толгой хоргодохыг ч бодсонгүй. Нар жаргав. Шөнө нь бүр ч их хүйтэн болж, өдрийнхөөс бүр илүү их зовлон бэрхшээлтэй байв. Цас орж хүйтрэн, тэд дагжин чичирч, шүд нь хүртэл дуу нийлүүлэн тачигнаж байлаа. Даарч бээрсэн тэд дулаацахын тулд бие биенээ тэврэв. Бие биетэйгээ тас тэврэлдэн байх тэдэнд бэлгийн таашаал ханамж эдлэх хүсэл тачаал төрөх нь бүү хэл бага ч атугаа унтаж нойр авч ч чадахгүй байв. Ийнхүү Индра бурханы хүчтэй хараалын улмаас тэд бүхэл шөнөжингөө зовж тарчлав. Гэсэн ч, ай Юдхиштира минь ээ, тэд ухаарч мэдэлгүй, санамсаргүйгээр Жая-экадашид мацаг барьсны өршөөл нигүүлсэл болон бүхий л шөнийг унталгүй сэрүүн өнгөрөөсний ач тусыг нь хүртлээ. Дараа

өдөр нь юу болсоныг сонс. *Двадаши* болоход Мальяван Пушпавати хоёр демоны дүр төрхөө орхин гялалзан туяарах гоёл чимэглэл, тансаг нарийн хувцас хунар бүхий тэнгэрийн орны үзэсгэлэн гоо оршин суугчид дахин боллоо. Тэд бие биенээ гайхашран ажиглан харж байх тэр үед тэнгэрийн орны нисдэг хөлөг-*виман* гарч ирлээ. Дурлалт хос тэрхүү гайхамшигт хөлөгт ороход хөлөг шууд л тэнгэрийн орныг чиглэн одлоо. Тэнгэрийн орны оршин суугчид хамтдаа тэднийг магтан дуулж байлаа.

Мальяван, Пушпавати хоёр Индра бурханы залрах хот Амараватид ирээд өөрсдийн эзний өмнө очин түүнд гүн хүндэтгэлээ хүлцэнгүйгээр илэрхийлэв. Индра бурхан тэднийг тэнгэрийн орноосоо хөөн, хараасны дараа хуучин дүр төрх байдалдаа ийнхүү хурдан эргэн орсныг хараад гайхсан. Тэгээд Индра тэднээс: “Та нар миний харааснаар авсан *пишачагийн* биеийг ийнхүү хурдан орхиж чадах зохистой шагналыг ямар онцгой үйлийг үйлдэж хүртэвээ? Хэн та нарыг миний давж гаршгүй хараалаас чөлөөлөн ангижруулав аа?” гэж асуув.

Мальяван хариулсан нь: “Ай эзэн минь ээ Бурханы Дээд Бодьгал, Бурхан Васудевагийн өршөөл нигүүлсэл болон Жая экадашийн үзүүлэх хүчтэй нөлөөллөөр л бид *пишачагийн* биед зовж шаналах явдлаас аврагдлаа. Чухамхүү бид, Бурхан Вишнуд хамгийн эрхэм байдаг өдөр Жая экадашийг баримтлан Түүнд чин бишрэлтэйгээр зүтгэсэн учраас л хуучин дүр төрх байдалдаа орсон билээ.”

Индра хэлсэн нь: “Та хоёр экадашийг баримтлан Бүхний Дээд Бурхан Кешавад үйлчлэн зүтгэсэн учраас мөн миний хүндэтгэлийг хүлээх нь зүйн хэрэг. Та хоёрыг нүглээсээ бүрэн ангижирсаныг би харж байна. Бурхан Шри Хари эсвэл Шива бурханд чин бишрэлтэйгээр үйлчлэн зүтгэх хэн бүхнийг магтан алдаршуулах нь зохистой бөгөөд мөн миний хүндэтгэлийг хүлээдэг. Үүнд эргэлзэхийн хэрэг огт байхгүй.” Үүний дараагаар Индра бурхан Мальяван, Пушпавати хоёрт чөлөөтэйгөөр бие биетэйгээ цэнгэн жаргах болон өөрийн тэнгэрийн орноор аялахыг зөвшөөрсөн.

Иймээс ай Юдхитхира минь ээ, Хари Бурханы өдөр, ялангуяа хоёр дахиа төрсөн брахманыг хөнөөсөн нүглээс ч ариусган чөлөөлөх Жая экадашид мацгийг нарийн чанд барих хэрэгтэй.

Энэ мацгийг бүрэн итгэл, чин бишрэлтэйгээр барьж байгаа аугаа сүнснүүд нь бүхий л ариун мөргөлийн газар орнуудад угаал үйлдсэн болон бүхий л хэлбэрийн өглөгүүдийг тараасантай адил тийм л үр дүн, ач тусыг хүртдэг. Жая экадашид мацаг барьсан хүн Вайкунтхад хүрэх боломжтой болж тэнд тэр бум, тэр бум жилийн туршид эцэс төгсгөлгүй аз жаргалаар цэнгэн баясах болно. Ай аугаа хаан минь ээ, Жая экадашийн яруу алдрын тухай зүгээр сонссоноор эсвэл уншсанаар хүн Сама-ведийн дууллуудыг дуулан үйлддэг *Агнистома* тахилгыг үйлдсэнээр хүртдэг ач тусыг хүртдэг билээ.

Жая экадаши буюу Могха-шукла экадашийн яруу алдрын тухай Бхавишья-уттара Пуранаас авсан хүүрнэл ийнхүү өндөрлөлөө.

Тайлбар:

1.Амара-коша толь бичгийн дагуу бол биелсэн шунал тачаал болох *Камадева* нь таван нэртэй: *кандарпа дерпако нанга камахпанча шарайх смарах*- хайрын бурханд таван нэр байдаг.

А) *Кандарпа*-хайрын бурхан, б) *Дерпака*- хэрэг явдлыг үгүй болгогч, в) *Ананга*- физик бие махбодьгүй, г) *Кама*- биелсэн шунал тачаал, д) *Панча-шарайх*- таван сум баригч.

Кандарпа- Бхагавад Гитагийн (10.28)-д Бурхан Кришнагийн айлдсанчлан, *пражанаш часми кандарпах*-үр удмаа төрүүлэхийн учир шалтгаануудаас бол Би- хайрын бурхан, *Кандарпа*. *Кандарпа* гэдэг үг нь мөн “хамгийн үзэсгэлэнт

сайхан” гэсэн утгатай. *Кандарпа* нь Дваракад Кришнын хүү Прадьюмна болон илэрч тодорсон.

Дарпака- Энэ нэр нь хайрын бурханыг үйл явдлыг үгүй болгож арилган зайлуулдаг хийгээд бий болгон гаргадаг гэж ойлгож болохыг заадаг. Ялангуяа тэрээр түүний ухааныг эзэмдэн түүнийг материаллаг мэдрэхүйн таашаал ханамжийг хүчээр эдлүүлснээр цэвэр бурханлаг үйл ажиллагаанд саад тотгор болохыг чармайн оролдож байдаг.

Ананга- Нэгэн удаа хайрын бурхан Шива бурханы бясалгалд саад болон үймүүлсэн учир энэ хүчирхэг хагас бурхан түүнийг үнсэн товрог болгожээ. Гэсэн ч Шива бурхан хайрын бурханд материаллаг ертөнцөд физик бие махбодь авалгүйгээр үйл ажиллагаагаа явуулах боломжийг өгсөн.

Кама- Бхагавад Гитагийн (7.11)-д Кришна Бурхан айлдсан нь: “*дхарма вируддхо бхутешу камо ‘сми*- Би шашин номын зарчмуудад үл зөрчилдсэн бэлгийн амьдрал.”

Панча шарайх- амьд оршнолын ухааныг сүлбэн хатгаж дийлэх хайрын бурханы таван сум бол амт, хүртэхүй, дуу авиа, үнэр болон дүрс хэлбэр билээ.

Бүхий л амьд оршнолуудын дурыг булаан тэдэнтэй хүссэн бүхнээ хийж байдаг хайрын бурхан нь ийм таван нэртэй байдаг. Шри Кришна болон *гуругийн* өршөөл нигүүлсэлгүй л бол хэн ч түүнийг сөрж чадахгүй билээ.

ВИЖАЯ ЭКАДАШИ

Юдхиштира Махаража айлтгасан нь: Ай Васудевагийн алдарт хүү Бурхан Кришна минь ээ, намайг өршөөн соёрхож, *Пхалгуна* (2-3) сарын гэрэлтэй хоёр долоо хоногт тохиодог экадашийг тодорхойлон айлдаж хайрлана уу.

Бурхан Кришна айлдсан нь: Ай Юдхиштира минь ээ, хаадын хаан минь ээ, Вижая экадаши гэж алдаршсан энэхүү аугаа мацгийн тухай чамд Би баяртайгаар айлдъя. Энэхүү экадашийг баримтлах хэн бүхэн энэ амьдралдаа ч тэр, мөн дараагийн амьдралдаа ч тэр амжилтанд хүрэх нь эргэлзээгүй. Энэ экадашид мацаг барьсан болон түүний аугаа яруу алдрын тухай сонсох хэн бүхний бүхий л нүгэл арилан үгүй болдог.

Нэгэн удаа Нарада Муни бадамлянхуа байрлалаар сууж байгаа Брахма бурханд хандан: “Ай хагас бурхдын шилдэг нь минь ээ, Вижая экадашийг итгэл дүүрэн баримтлах хүний хүртэх ач тусын талаар надад өгүүлж хайрлана уу.” гэж хэлсэн.

Нарадын аугаа эцэг Брахма бурхан хариулсан нь: Ай эрхэм хайрт хүү минь ээ, мацгийн энэхүү тэргүүлэх өдөр нь бүх нүглийг устгаж үгүй хийн, ариусгадаг. Өнөөдрийн энэ өдрийг хүртэл би энэ талаар хэнд ч өгүүлээгүй боловч нэрээс нь хүртэл тодорхой байгаа энэ экадашийг ямар үр дүн, ач тусыг хайрлан хүртээдгийг чамайг сайн ойлгох байх гэдэгт эргэлзэхгүй байна. (Вижая гэдэг нь ялалт гэсэн утгатай санскрит үг юм.)

Рама Бурхан, эхнэр Сита охин тэнгэр болон Түүний бурханлаг ах Лакшмана нар 14 жилийн туршид ойд цөлөгдөх үедээ Панчаватид гуйлгачин дүрээр хоргодож байсан. Равана демон Ситаг хулгайлан авч одсоны дараа Рама уй гашуу гунигт автсан байлаа. Өөрийн хайртай гэргийг хайх явцдаа Бурхан, амь тавих гэж байсан аугаа чин бишрэлтэн харцага- Жатайютай тааралдсан бөгөөд тэр Рамад, Түүний амраг хайртай Ситаг нь Равана демон хэрхэн хулгайлан авч одсоныг хэлсэн. Түүний дараагаар Жатаю Вайкунтхын гариг тийш буцан очсон билээ.

Тэгээд Рама Өөрийн дайсан Кабандхаг хөнөөсөн бөгөөд хожим нь сармагчингуудын хаан Сугриватай¹ найз нөхрийн харьцаа тогтоосон билээ. Тэд хамтдаа, сармагчингууд болон баавгайнуудыг эгнээндээ нэгтгэсэн хүчирхэг том армийг бүрдүүлэн зохион байгуулсан. Тэд мөн, ашаквын цэцэрлэгт Сита девиг

олж уулзаж магадгүй гэж Хануманаг Шри Ланк руу илгээсэн. Тэрээр Рамагийн илгээмжийг авч Түүнд дамжуулан, мөн Түүнээс илгээмж аван буцаад Рама дээр хүрч ирэх ёстой байлаа. Бүхний Дээд Бурханы алба үйлэнд тэрээр ийнхүү аугаа хосгүй байдлаар зүтгэсэн билээ.

Рама Бурхан Сугривагийн тусламжтайгаар Ланкад хүрч очихоор бэлтгэсэн. Сармагчингуудын армитайгаа далайн эрэг дээр ирээд түүнийг хязгааргүй өргөн их болохыг харав. Тэгээд Рама Лакшманад хандан: “Ай Сумитрын хүү минь ээ, Варунын эзэмшил орон болох энэхүү маш гүн, хязгааргүй их далайг туулан гарахад шаардлагатай адислалыг Бид хэрхэн яаж олж хүртэх билээ? Могой болон зэрлэг догшин загаснууд дүүрэн сүлжилдэн арзганах энэхүү далайн усыг туулан гарах амар хялбар замыг Би мэдэхгүй байна.” гэж айлдсан.

Лакшмана хариу айлтгасан нь: “Ай амьд оршнолуудын шилдэг нь минь ээ, ай бүх бурхдын эх булаг минь ээ, ай анхдагч Бодьгал минь ээ, эндээс 4 милийн тэртээх нэгэн арал дээр аугаа гэгээнтэн Бакадалбхья амьдардаг. Ай Рагхава минь ээ, тэр олон Брахмын ирж одохыг үзсэн тийм өндөр настай мэргэн билээ. Бид Өөрсдийн зорьсондоо яаж эсэн мэнд хүрч болохыг түүнээс асууцгаая.” Ингээд Рама, Лакшмана хоёр хэнтэй ч зүйрлэшгүй, энгүй Бакадалбхья Мунигийн даруухан *ашрамд* хүрч очсон. Хоёр Бурхан мэргэнд ойртон очоод Вишнуд бишрэл хүндэтгэлээ илэрхийлж байгаатай адилаар түүнд гүн хүндэтгэл бишрэлээ хүлцэнгүйгээр илэрхийлсэн. Гэсэн ч Бакадалбхья Муни, Рама бол үнэн хэрэгтээ Бурханы Дээд Бодьгал бөгөөд Тэр Өөрийн тааллын дагуу газар дэлхий дээр хүний дүрээр морилон бууж ирсэн гэдгийг ойлгож мэдэж байлаа.

Бакадалбхья Муни: Ай Рама минь ээ, ай амьд оршнолуудын дээд нь минь ээ, Таныг юу ингэж миний энэ нам гүм оронд авчраа вэ? гэж асуухад Рама Бурхан: “Ай хоёр дахиа төрсөн аугаа брахман минь ээ, Би наашаа энд, далайг гатлан, демонуудын байрлаж байгаа Ланкыг эзлэн авахаар баавгай болон сармагчингуудаас бүрдсэн цэргийн хүчтэйгээ ирлээ. Ай гэгээнтэнгүүдийн аугаа нь минь ээ, Намайг өршөөн соёрхож энэхүү хязгааргүй их далайг яаж гатлахыг зааж өгнө үү. Үүний төлөө л Би чам руу хүрч ирлээ.” гэж хариу айлдав.

Гэгээнтэн хариу айлтгасан нь: Ай Рама Бурхан минь ээ, Би Танд бүх мацгуудын хамгийн аугаа нь болох мацгийн талаар айлтгая. Та энэ мацгийг барьснаар Раванаг ялах нь гарцаагүй бөгөөд Таны яруу алдар мөнхөд дуурсагдах болно. Та намайг бүрэн анхааралтай сонсох ажаам уу.

Экадашийн өмнөх өдөр алт, мөнгө эсвэл зэсээр усны сав хийж бэлтгэ. Хэрвээ энэ металлууд байхгүй байвал шавраар ч хийж болно. Түүнийгээ цэвэр усаар дүүргээд дараа нь мангоны навчаар сайтар гоён чимэглэ. Саваа таглаад ариун гэгээн шүтээний дэргэд долоон янзын үр² овоолоод дээр нь тавь. Өглөөний угаал үйлдсэний дараагаар саваа цэцгийн хэлхээгээр болон зандан модны оогоор чимэглэ, савны тагны хонхор хэсэгт арвай, анар болон наргилын самар тавь. Үүний дараагаар энэхүү сав-шүтээндээ хайр, чин бишрэлтэйгээр мөргөн, хүж, зандан модны оо, цэцэг, зул болон тансаг идээ зоог өргө. Энэхүү ариун савны дэргэд шөнийг сэрүүн өнгөрүүл. Арвай, анар, наргилын самартай түүний таган дээр Нараяна Бурханы алтан *муртийг* зал.

Экадашийн үүр цайх үед өглөөний угаалаа үйлдээд савыг зандан модны оо болон цэцгийн хэлхээгээр чимэглэ. Дараа нь саванд хүндэтгэлээ илэрхийлэн мөргөж хамгийн сайн хүж, зандан модны оо болон зул өргө. Мөн савны өмнө янз бүрийн идээ зоог, анар болон наргилыг өргө. Шөнийг сэрүүн өнгөрүүл.

Двадашийн үүр цайх үед устай савыг аван ариун дагшин голын эрэг дээр оч эсвэл том биш цөөрөм ч байж болно. Ай хаадын хаан минь ээ. Сав шүтээндээ зөв байдлаар мөргөн хүндэтгэл бишрэлээ илэрхийлээд түүнийг дээр дурьдсан чимэглэлүүдийн хамтаар Ведийг мэдэх цэвэр ариун брахманд өргөн барь. Хэрвээ Та болон Танай цэргийн жанжингууд Вижая экадашийг ийм байдлаар баримтлах аваас Та бүгд эцэстээ ялах болно.

Бурханы Дээд Бодьгал Рамачандра бүгдийг Бакадалбхья Мунигийн заасны дагуу хийж демоны хүчинг ийнхүү ялсан. Вижая экадашийг ийнхүү баримтлах хэн бүхэн энэхүү мөнх бусын ертөнцөд үргэлж ялагч байх бөгөөд түүнийг орхисноор Бурханы оронд мөнхөд амьдрах болно.

Ай Нарада, хүү минь ээ, энэ түүхээс үзэхэд, энэ экадашид зааж тогтоосон дүрэм журмуудыг нарийн чанд баримтлан мацгийг зөв барих хэрэгтэй гэдэг нь тодорхой. Энэ мацгийн хүч нь хамгийн жигшүүртэй, гутамшигт хүний бүхий л нүгэлт үйлүүдийн үр дагаврыг устган зайлуулах болно.

Шри Кришна төгсгөлд нь айлдсан нь: Ай Юдхитхира минь ээ, энэхүү хүүрнэлийг сонссон эсвэл уншсан хэн бүхэн тахилга өргөл үйлдсэнтэй нэгэн адил ач тусыг хүртэх болно.

Вижая экадаши буюу Пхалгеуна-Кришна экадашийн яруу алдрын тухай Сканда Пуранаас авсан хүүрнэл ийнхүү өндөрлөлөө.

Тайлбар:

1. Аугаа сармагчин Сугрива бол Индра Ахилья хоёрын хүү байсан. Ахилья нь Брахма бурханы ухаанаас төрсөн долоон мэргэдийн нэг Гаутамагийн гэргий байв. Индра Гаутамагийн дүрд хувирч 16 наснаасаа хойш хөгшрөхгүй байх адислалыг хүртсэн байсан Ахильягийн толгойг эргүүлэн уруу татсан. Тэр бол газар дэлхий дээрх хамгийн үзэсгэлэнтэй эмэгтэй байсан бөгөөд түүнд Индра, мөн нарны бурхан хоёр хоюул дурласан байлаа. Тэр хоёр Гаутамагийн дүрд ээлжлэн орж түүнтэй ойртож хавьтсан. Сугрива, Вали хоёр ингэж төржээ.

Эхлээд Сугрива, Вали хоёр нь хүний хэлбэр дүртэй байсан. Харин Гаутама эхнэрийнхээ үнэнч бус байдлыг мэдээд, уурандаа: “Хэрвээ энэ хоёр миний хүү биш бол сармагчин бол.” гэж хэлээд хоёр хүүг далайн усанд хаясан. Тэд ингэж сармагчин болсон хэрэг. Сугрива өөрийн найз Рамад Ситагаа олоход нь, харин Рама түүнийг дүү Валигаа дагуулан Өөрийн оронд буцаж очиход нь тусалдаг.

Чанакья Пандит, Гаутамагийн үзэсгэлэнт эхнэртэй холбогдуулан: “Энэ ертөнцөд, хүнд дөрвөн дайсан байдаг: өр ширэндээ баригдсан эцэг, завхай зайдан эх, үзэсгэлэнт гоо эхнэр болон бурханлаг шинжлэх ухааныг үл сонирхох хүү.” гэж хэлсэн байдаг.

2. Долоон үр: арвай, улаан буудай, цагаан будаа, эрдэнэ шиш, шар будаа, кукани, дал (вандуй)

АМАЛАКИ ЭКАДАШИ

Мандхата хаан нэгэн удаа Васиштха Мунид хандан: “Ай аугаа гэгээнтэн минь ээ, намайг өршөөн соёрхож мөнхийн ач тусаа хүртээх ариун гэгээн мацгийн талаар ярьж өгөөч.” гэж хэлсэнд Васиштха Муни хариулт болгон өгүүлэхдээ: “Ай хаантан минь ээ, мацаг барьдаг бүхий л өдрүүдээс шилдэг нь болох Амалаки экадашийн талаар миний ярихыг сонсоно уу. Энэ экадашид мацгийг итгэл бишрэлтэйгээр барих хүн хэмжээ хязгааргүй баялгийг хүртэж, бүхий л нүглээсээ аврагдан ангижралд хүрдэг. Энэ экадашид мацаг барих нь цэвэр ариун брахманд мянга мянган үнээ өргөснөөс илүүтэйгээр ариусдаг. Иймээс гэм зэмгүй олон амьтадыг хөнөөсөн боловч Амалаки экадашид мацаг барьснаар ангижралд хүрсэн нэгэн анчны түүхийг анхааран сонсоно уу.

Эрт урьдын нэгэн цагт Вайдиша-гийн хаант улс гэж нэгэн гүрэн оршин тогтнож байжээ. Энэ гүрний брахман, кшатрия, вайшья болон шудрагууд бүгд ведийн мэдлэгт адил тэнцүү боловсорсоны зэрэгцээ бүгд маш их хүч чадал, эрүүл саруул оюун ухаантай байлаа. Бүх улс гүрэн даяар ведийн дуу аялгуу дүүрэн эшгшиглэдэг байлаа. Энэ гүрнийг сарны буюу Сома удмын Пашабиндука хаан захирдаг байв. Түүнийг мөн Читраратха гэж нэрлэдэг байсан ба тэрээр маш их бишрэл шүтлэгтэй бөгөөд үнэнч шудрага хаан байлаа.

Читраратха хааныг арван мянган заанаас илүү их хүчтэй, маш баян бөгөөд ведийн цэцэн мэргэн мэдлэг ухааны зургаан салбарыг¹ бүгдийг нь төгс төгөлдөр мэддэг байсан гэж ярьдаг.

Түүний хаанчлалын үед бусдын *дхарма* (оноогдсон үүрэг)-д өнгөлзөгч нэг ч нүгэлтэн байдаггүй байв. Бүхий л брахман, кшатрия, вайшья болон шудрагууд өөр өөрсдийн *дхармаг* ийнхүү төгс байдлаар биелүүлцгээдэг байв. Тэр гүрний хаанаас ч ядуурал гуйланчлалыг олж харахааргүй байв. Ган гачиг хийгээд үер ус ч болдоггүй байв. Мэдээж хэрэг тэнд мөн, өвчин зовлон гэж байдаггүй байсан. Хүн бүр л эрүүл саруул, жаргал цэнгэлтэй байдаг байлаа. Хүмүүс Бурханы Дээд Бодьгал, Бурхан Вишнуд хайр чин бишрэлтэйгээр зүтгэдэг байв. Энэ улс гүрний иргэн бүр экадашид сар бүр хоёр удаа мацаг барьдаг байв. Нэг удаа, Пхалунга сарын Амалаки экадашийн ариун гэгээн мацаг двадашид тохиосон. Читраратха хаан ийм онцгой мацаг нь ер бусын ач тустай байдаг гэдгийг ойлгож байсан учраас тэр Вайдишагийн бүх иргэдийн хамтаар энэхүү ариун гэгээн экадашийг бүхий л дүрэм журмуудыг нарийн чанд даган баримталж өнгөрөөсөн. Голын усанд угаал үйлдсэний дараагаар хаан хийгээд түүний бүхий л бараа бологч дагалдагчид Амалака мод ургасан ойд байдаг Бурхан Вишнугийн сүм рүү очихоор явцгаасан. Эхлээд хаан хийгээд түүний гол тэргүүлэх мэргэд модонд усаар дүүргэсэн савууд болон гайхамшигтай сайхан шүхэр, гутал, алт, бриллиант, бадмаараг, сувд, индрианал болон хүж өргөсөн. Дараа нь тэд Бурхан Парашурамад дараахь залбирлыг айлтган бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн мөргөсөн: “Ай Бурхан Парашурама минь ээ, ай Ренукын хүү минь ээ, ай бүхний баясуулагч минь ээ, ай ертөнцийг аврагч минь ээ, биднийг өршөөн соёрхож, энэхүү ариун гэгээн модны доор залран бидний гүн хүндэтгэл бишрэлийг таалан болгооно уу.” Түүний дараагаар тэд Амалаки модонд залбиран: “Ай Амалаки минь ээ, ай Брахма бурханы үр сад минь ээ, Та бүх нүглийн үр дагаврыг устган зайлуулагч байж ч магадгүй билээ. Бидний гүн хүндэтгэл хийгээд энэхүү эгэл даруухан өргөлийг минь таалан болгоох ажаам уу. Ай Амалаки минь ээ, Та бол Брахманы дүр бөгөөд Танд урьд нэгэн цагт Бурхан Рамачандра Өөрөө хүндэтгэлээ илэрхийлэн мөргөж байсан билээ. Таныг тойрон явах хэн бүхэн бүхий л нүглээсээ шууд ангижирдаг билээ.”

Дээрх гайхамшигт залбирлыг хэлэн Читраратха хаан болон түүний албат, дагалдагчид нь ариун гэгээн судруудын дагуу мөргөн залбирсаар бүхий л шөнийг унталгүйгээр сэрүүн өнгөрөөв. Мацгийн хийгээд мөргөл залбирлын энэхүү адислал ерөөлт цагаар өөрийгөө болон гэр бүлийнхнээ хооллож ундлахын тулд ан гөрөө хийж явсан бурхангүй үзэлтэй нэгэн хүн хуран цугларсан тэдэнд ойртон очжээ. Өлсөж цанган, ядарч туйлдсан хийгээд хийсэн нүгэлдээ дарагдсан анчин, олон зулаар гэрэлтүүлсэн үзэсгэлэнт сайхан ойд бүх нийтээрээ унталгүй сэрүүн байж мацаг барин Бурхан Вишнуд залбиран мөргөж байгаа хаан тэргүүтэй Вайдишагийн оршин суугчдыг харсан. Өөрийн нь өмнө харагдаж байгаа ер бусын хачин үзэгдэлд гайхсан анчин нилээд ойртож очсон. Энд юу болж байгаа юм бол? гэж тэр гайхан бодож байлаа. Тэр, энэ ойд ариун гэгээн Амалаки модны доор дүүрэн устай сав- *асана* дээр залсан байх Дамодара Бурханы дүрийг харсан. Тэнд хуран цугларагсад Түүнд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн мөргөх болон Бурхан Кришнагийн дүр хийгээд Түүний трансценденталь зугаа наадмуудыг нь магтсан ариун гэгээн дууллуудыг дуулж байхыг тэр мөн харж, сонсож байлаа. Анчин хэдийгээр, өөрийгөө хамгаалах чадваргүй хөөрхийлөлтэй ан амьтад болон жигүүртэн шувуудыг алж хөнөөдөг засаршгүй бурхангүй үзэлтэй нэгэн байсан ч бүхий л шөнийн туршид Бурханыг магтан дуулахыг сонсон, экадашийн баярыг машид гайхан ажигласаар байв.

Нар мандахын үеэр хаан өөрийн бараа бологч, дагалдагчид болох ариун гэгээн хүмүүс болон Вайдишагийн бүх оршин суугчдын хамтаар бишрэл хүндэтгэлийн үйлээ өндөрлөөд хотын зүгт буцсан. Мөн тэр цагт анчин овоохой руугаа буцаж, хоол ундаа идэж уулаа. Хожим нь, анчин зохих цаг хугацаандаа

нас эцэслэсэн. Харин тэр Амалаки экадашид мацаг барьсан, Бурханы Дээд Бодьгалыг магтан дуулахыг сонссон хийгээд шөнийн туршид сэрүүн байсныхаа төлөө шагнал болгон, дараагийн амьдралдаа маш олон тэрэг, заан, агт морьд болон цэргүүдийг эзэмшиж, захирсан аугаа мундаг хаан болон төрсөн. Тэрээр Видуратха хааны хүү болон төрж Васуратха гэсэн нэрийг авсан бөгөөд тэрээр Жаянта улсыг захирсан хаан байлаа.

Васуратха хаан маш их хүчирхэг бөгөөд аймшиггүй чин зоригтойн дээр нар мэт туяарч гэрэлтсэн, сар мэт үзэсгэлэн төгөлдөр байлаа. Хүч чадлаар бол тэр Вишнутаг, энэрэл нигүүлслээрээ бол газар дэлхийтэй зүйрлэхүйц ажээ. Маш өршөөнгүй хийгээд үргэлжийн шудрага үнэнч Васуратха хаан Бүхний Дээд Бурхан Шри Вишнуд хайр чин бишрэлээр байнгад үйлчлэн зүтгэдэг байв. Үүнийхээ ач тусаар тэр Ведийн мэдлэг ухаанд маш гарамгай, нэвтэрхий болсон. Бардам сайрхуу зан байдал нь хэн хүнийг эвдэн сүйтгэдэг гэдгийг ажиглаж мэдсэн учраас тэр ийм занг үздэггүй байлаа. Тэрээр маш олон удаа тахилга өргөл үйлдэхийн зэрэгцээ өөрийн улс гүрний гачигдал дутагдалтай байх хэн бүхэнд хангалттай хэмжээгээр дэмжлэг туслалцаа болохуйц бүгдийг хийдэг байлаа.

Нэгэн удаа Васуратха хаан ой хөвчид ан хийж яваад замаа олохоо больж төөрсөн. Нилээд удаан төөрч будилж явсаар бүр сүүлдээ ядарч туйлдан нэгэн модны ёроолд буудаллан, түүний үндэсний салааг дэрлэн унтжээ. Унтаж байх үед нь түүний хажуугаар нохойгоор хооллогч зэрлэг хүмүүсийн бүдүүлэг хэрцгий омгийнхон явж өнгөрсөн. Тэдэнд хааныг үзэх ядах аль эртний өшөө хорсол нь сэрж, түүнийг хэрхэн хөнөөх талаар зөвлөлдөж эхэлсэн. “Тэр бидний эцэг эхчүүд болон төрөл төрөгсдийг алж хөнөөснөөс болж бид галзуу солиотой мэт ямар ч зорилгогүйгээр хэрэн тэнүүчлэх болсон билээ.” гэж ярилцаж байснаа жад, сэлэм, нум сум болон шидэт уяа зэргээ оролцуулаад байгаа бүх зэвсгээ хэрэглэн Васуратха хаанаас хариугаа авахыг оролдсон. Гэвч үхэлд хүргэх эдгээр зэвсгүүд нь унтаж байгаа хаанд шүргэж хүрч ч чадахгүй байлаа.

Соёл иргэншилгүй, нохойгоор хооллогч зэрлэгүүд айж эмээснээсээ болж зугатацгаахыг завдсан. Айдас хүйдэс нь тэдний бүх хүч чадлыг авснаас болж тэд дүйнгэтэн манарч, сульдэн доройтсоны улмаас бараг ухаангүй болсон байлаа. Хааны биеэс гэнэт үзэсгэлэн гоо эмэгтэй гарч ирэн зэрлэгүүдийг балмагдуулав. Тэр маш олон чимэг зүүлтээр гоёсон байсны дээр түүнээс тансаг сайхан анхилуун үнэр ханхалж байлаа. Түүний хүзүүг гайхамшигтай сайхан цэцгийн зүүлт чимэглэж байв. Хөмсөг нь маш ууртайгаар зангирч улаан нүд нь хурцаар гялалзаж байлаа. Тэр биелсэн үхэл мэт харагдаж байв. Хааныг хөнөөхийг оролдож буй зэрлэг омгийнхныг тэр эмэгтэй хоромхон зуурт л гал бадруулсан хүрдээрээ даран сөнөөв.

Хаан нойрноос сэрмэгц өөрийн нь хажуугаар зэрлэгүүд үхсэн хэвтэж байхыг хараад хачин ихээр гайхан, “эд нар чинь бүгдээрээ л надад аюултай дайснууд байна шүү дээ. Хэн тэднийг хөнөөгөө вэ? Миний төлөөнөө ийнхүү сайныг үйлдэгч хэн байдаг билээ?” гэж бахдан хашгирлаа. Тэгтэл, тэнгэрээс нэгэн дуу гарч: “Чи, хэн надад туслаа вэ? гэж асууж байна. Гэхдээ, ийм зовлон бэрхшээлтэй учирсан хэн бүхэнд тусалдаг цорын ганц хэн байдаг билээ? Бурханы Дээд Бодьгал, Шри Кришнагаас өөр, Түүнд шунахайн зорилгогүйгээр өөрийгөө даатгаж, аврал ивээл хайгчдыг хэн аврах билээ дээ?” гэж хэлэхийг тэр сонсов. Ийнхүү хэлэхийг сонсоод Васуратха хаан Бурханы Дээд Бодьгалыг хайрлах хайраар дүүрэн бялхав. Тэр нийслэл хотдоо буцан ирж улс гүрнээ хоёр дахь Индра мэт ямар ч үймээн самуунгүйгээр удирдан захирч байлаа.

Иймээс, ай Мандхата хаан минь ээ хэмээснээ эрхэм хүндэтгэлт Васиштва Муни яриагаа өндөрлөн ийнхүү өгүүллээ: Ариун гэгээн Амалаки экадашийг баримтлах хэн бүхэн Бурхан Вишнугийн залрах дээдийн дээд оронд хүрч очих нь эргэлзээгүй. Мацаг барихуйн хамгийн ариун гэгээн энэхүү өдрийг баримтлахын шагнал ийм л аугаа байдаг.

Амалаки экадашийн буюу Пхалгеуна-шукла экадашийн яруу алдрын тухай
Брахмананда Пуранаас авсан хүүрнэл ийнхүү өндөрлөлөө.

Тайлбар:

1. Ведын мэдлэгийн 6 салбар: 1). Жайминагийн карма-мимамса систем. 2).
Девахутын хүү Бурхан Капилагийн санкхья-систем. 3). Гаутама болон Канада
нарын ньяя философи. 4). Аштавакрагийн майявадын философи.
5). Патанжалын йога-сутра. 6). Шрила Вьясадевагийн бхагаватын философи.

ПАПАМОЧАНИ ЭКАДАШИ

Юдхиштхира Махаража айлтгасан нь: Ай Бүхний Дээд Бурхан минь ээ,
Пхалгеуна (2-3) сарын гэрэлтэй хагаст тохиодог Амалаки экадашийн талаар
Таны айлдахыг сонслоо. Одоо Та Чайтра (3-4) сарын харанхуй хоёр долоо
хоногийн экадашийн тухай, юу гэж нэрлэдэг? болон түүнийг баримталснаар
ямар ач тус, үр дүнд хүрдэг талаар айлдаж соёрхоно уу.

Бурханы Дээд Бодьгал, Шри Кришна хариу айлдсан нь: Ай хаадын шилдэг
нь минь ээ, бүх нийтийн ач тус, сайн сайхны төлөө Би Папамочани гэж
нэрлэгддэг энэхүү экадашийн яруу алдрын талаар чамд баяртайгаар
тодорхойлон айлдъя. Энэ экадашийн түүхийг Мандхата хаанд нэгэн удаа
Ломаша Риши өгүүлсэн билээ. Мандхата хаан мэргэнд хандан: “Ай аугаа
гэгээнтэн минь ээ, бүх хүмүүсийн сайн сайхан, болоод ач тусын төлөө Чайтра
сарын харанхуй хагаст тохиодог экадашийг нэрлэж, түүнийг яаж баримталдаг
талаар тайлбарлаж өгнө үү. Мөн тэрчлэн энэхүү экадашийг баримталсны ач
тусыг тодорхойлон өгүүлнэ үү.” гэж хэлсэн.

Ломаша Риши хариулсан нь: Чайтра сарын харанхуй хагаст тохиодог
экадашийг Папамочани экадаши гэж нэрлэдэг бөгөөд итгэл дүүрэн байх чин
бишрэлтэнгүүдэд хий үзэгдэл болоод шулмууд (демонууд)-ын зүгээс үзүүлэх
үйлдэл нөлөөлөлд саад тотгор хийдэг. Энэ экадаши нь мөн амьдралын найман
төгс төгөлдрийг хүртээн соёрхож, бүхий л хүслийг биелүүлж, хүний амьдралыг
бүх нүглийн үр дагавраас нь ангижруулж, хүнийг ач тустай, сайн үйлд
батжуулан бэхжүүлдэг.

Энэ экадашийн түүхийг болон гандхарвануудын (тэнгэрийн орны
хөгжимчид) ахлагч Читраратхын тухай хүүрнэлийг сонсоно уу. Нэгэн хавар,
Читраратха тэнгэрийн орны бүжигчдийн хамтаар ойд зугаацан баясахаар
ирсэн. Ургамал ногоо ид цэцэглэдэг цаг болж байлаа. Тэнд мөн тэдэнтэй өөр
бусад гандхарванууд болон киннарууд нэгдэн нийлсэн. Тэдэнтэй, ойгоор
зугаацаж явсан тэнгэрийн хаан Индра бурхан хүртэл хамт байлаа. Тэд бүгд л
үүнээс илүү сайхан цэцэрлэгт хүрээлэн байхгүй гэдгийг мэдэрч шагшин байлаа.
Тэнд мөн, тэвчил наманчлал үйлдэж байсан цөөнгүй тооны гэгээнтэн мэргэд
байсан. Хагас бурхдууд ялангуяа Чайтра болон Вайшакха саруудад
тэнгэрийн орны цэцэрлэгт хүрээлэнгээр зугаацан явж цэнгэх их дуртай байдаг.

Тэр ойд аугаа гэгээн Медхави амьдардаг байсан бөгөөд үзэсгэлэнт
хөөрхөн бүжигчин охин тэнгэрүүд түүнийг уруу татахыг үргэлж оролддог байв.
Манжугхоша нэртэй нэгэн үзэсгэлэнт хөөрхөн охин тэнгэр аугаа мэргэний
анхаарлыг хэрхэн яаж татах вэ гэж олон янзын төлөвлөгөө боловсруулсан.
Гэсэн ч түүнийг хүндэтгэх үүднээс болон олон жилийн туршид тэвчил
наманчлал үйлдсэний үр дүнд хүртсэн хүч чадлаас нь айгаад тэр түүнд
ойртож төвдөхгүй байлаа. Иймээс тэр өөрийн асар саравчаа гэгээнтэнгээс 2
милийн зайтай газарт босгон, хэнгэрэгээ дэлдэн тоглож, уян нялуунаар дуулж
эхэлсэн.

Хайрын бурхан хүртэл түүнийг хараад, түүний дуулахыг сонсоод, түүний түрхсэн зандан модны тосон оо энгэсэгний анхилуун үнэрийг мэдрээд догдолж байлаа. Тэрээр өөрийнхөө Шива бурхантай холбогдсон бүтэл муутай явдлын талаар санаад Медхавийг уруу татан хариугаа авахаар шийдсэн¹.

Манжугхошагийн нум мэт хөмсөг, хөвч мэт нүд, сум мэт харц, бай мэт хөхийг ашиглан хайрын бурхан Медхавийн дурыг татан, сахил санваарыг нь алдуулан гажуудуулж, трансн байдлаас нь гаргахаар түүнд ойртон дөхөж байлаа. Хайрын бурхан ийнхүү Манжугхошаг туслагчаа болгон ашигласан.

Хүчирхэг, дур булаам хийгээд залуухан гэгээнийг хараад Манжугхоша хүсэл тачаалдаа шатаж эхэлсэн. Үзэсгэлэн төгөлдөр, оюунлаг, эрдэм мэдлэгт нэвтэрхий түүнд брахманы цагаан зангиа болон *саннясийн* ариун бэрээ нь улам чимэг оруулсан байлаа. Чьявана Ришигийн *ашрамд* суугаа түүнээс Манжугхоша нүдээ ч салгаж чадалгүйгээр ойртон дөхлөө. Тэрээр дур булаам сайхнаар дуулж байхад түүний бүс болон шагайндаа зүүсэн жижиг хонхнууд хийгээд гартаа зүүсэн бугуйвчууд нь хөгжмийн шагшин гайхмаар аялгууг эгшиглүүлж байлаа.

Манжугхоша Медхавид алгуурхнаар дөхөж очлоо. Түүний алхаа гишгээ, талимаарсан харц нь Медхавийн анхаарлыг татсан. Манжугхоша гунхалзаж нахилзан байж хэнгэрэгээ тавиад мэргэнийг тэврэн авав. Түүний гар нь аврага том модыг ороон ургасан ороонги ургамалтай адилтгахуйц харагдаж байв. Дур булаагдан татагдсан Медхави бясалгалаа зогсоож орхин түүнтэй зугаацахаар шийдсэн. Тэр даруйдаа л зүрхний хийгээд ухааны нь цэвэр ариун байдал түүнийг орхин алга боллоо. Өдрийг шөнөөс ялгахаа больсноор тэр Манжугхошатай аль болох удаан хугацааны туршид таашаал ханамж эдлэхийн төлөө бүхнийг хийхэд бэлэн болсон байлаа².

Манжугхоша өөрийн зорилгодоо хүрсэн хийгээд залуу иогчийн ариун гэгээн байдлыг үнэхээрийн ганхуулсан байна гэдгээ хараад түүнийг орхин, гэр лүүгээ буцахаар шийдсэн. Тэрээр: “Ай аугаа гэгээнтэн минь ээ, намайг гэртээ буцаж харихыг та болгоох ажаам уу.” гэж хэлэхэд Медхави: “Ай үзэсгэлэн гоо минь ээ, чи дөнгөж үзэгдээд л явах гэж үү, ядаж маргааш болтол надтай хамт байгаа ч дээ.” хэмээн хариулсан. Мэргэний ид шидийн хүчнээс айсаар Манжугхоша Медхавитай 57 жил 9 сар 7 хоногийг хамт өнгөрүүлсэн болов ч Медхавийн хувьд энэ бүх цаг хугацаа ганцхан хором мэт санагдсан. Тэрээр мэргэнээс дахин явуулахыг гуйхад Медхави: “Хайрт минь ээ, энэ шөнийг надтай хамт өнгөрөөгөө ч, тэгээд маргааш өглөө явж болно шүү дээ. Ядаж, намайг өглөөний зан үйлээ үйлдэх хүртэл, ариун гэгээн *гаятри* мантрагаа уншиж дуусах үе хүртэл энд байгаа ч дээ.” гэж хариу гуйсан. Манжугхоша инээсэн царай гаргахыг оролдонгоо: “Та өглөөний зан үйл болон уншлагаа хэзээ нэг үйлдэх юм бэ? Намайг өршөөн соёрхож, надтай хамт өнгөрүүлсэн цаг хугацаанд болсон бүхнээ бодоод нэг үзээ ч.” гэж хэлэв.

Гэгээнтэн, Манжугхошатай хамт өнгөрүүлсэн он жилүүдийнхээ талаар эргэн бодсоноо дараа нь маш их гайхснаа: “Нээрээ би чамтай 57 жил гаруйн хугацааг хамт өнгөрүүлсэн байна шүү дээ.” гэж хэлэв. Түүний нүд улаанаар эргэлдэн түүнээс зэрэг зэрэг цахилгаан цахиж аянга ниргэх шиг болов. Одоо л тэр Манжугхошаг биелсэн үхэл хийгээд бурханлаг амьдралыг нь хөнөөн сүйтгэгч байдлаар харан: “Ай хууран мэхлэгч, чи миний хамаг хүч чармайлтаа зориулсан тэвчил наманчлалын минь бүх үр дүнг юу ч үгүй шатаан үнс нурам болголоо. Ай хахир хатуу чулуун зүрхэт, унаж доройтсон нүгэлтэн минь, чи нүглээс өөр юу ч үл мэддэг юм байна. Чамд бузар, муу хувь тавилан учраг. Хууран мэхлэгч минь, би чамайг хорон муу санаатай *пишача* бол гэж харааж байна.” гэж хэлэв. Уур хилэндээ багтран салганан чичрэх тэр Манжугхошаг харааж байсан ч Манжугхоша хүлцэнгүйгээр: “Ай брахмануудын шилдэг нь минь ээ, намайг өршөөн соёрхож хараалаа буцааж хайрлана уу. Цэвэр чин бишрэлтэнтэй харьцсаны ач тус нь тэр дороо ирдэг, харин түүний хараал нь

долоо хоногийн дараагаар биелдэг гэж ярьдаг билээ. Би тантай хамт 57 жилийн туршид хамт байсан шүү дээ. Ай эзэн минь ээ, надад өршөөл нигүүлслээ хайрлаач дээ.” гэж залбиран гуйв.

Медхави Муни: “Ай номхон даруу царайлагч минь ээ, Чи намайг юуг хий гэж? Чи миний бүхий л тэвчил наманчлалыг юу ч үгүй болтол бусниулан сүйрүүлсэн. Чи энэ нүглийг үйлдсэн ч гэсэн би чамд, миний уур хилэнт хараалаас хэрхэн яаж аврагдан ангижирч болохыг хэлж өгье. *Чайтра* сарын харанхуй хагаст, бүхий л нүглийг зайлуулан арилгах, бүгдэд тустай экадаши тохиодог бөгөөд энэ экадашийг Папамочани гэж нэрлэдэг. Ай үзэсгэлэн гоо минь ээ, энэ ариун гэгээн өдөр мацаг барих хэн бүхэн ямар ч демоны дүр, төрөлд төрөхөөс аврагдан чөлөөлөгддөг.

Энэ үгийн хэлээд гэгээнтэн эцгийнхээ *ашрам* тийш явсан. Гэртээ орж ирж буй хүүгээ хараад Чьявана Муни: “Ай хүү минь ээ, зохисгүй авирлаж, ёс бус үйл үйлдсэнээр чи өөрийн сахил санваар хийгээд тэвчил наманчлалын ач тусыг үгүй хийж, үрэн таран болголоо доо.” гэж халаглан хэлэв. Медхави эцгээсээ: “Ай эцэг минь ээ, Манжугхоша бүжигчинтэй харьцсанаар эдлэх ёстой болсон дур гутан жигшим, булай муухай нүглийг би өөрөөсөө хэрхэн яаж арилган зайлуулж болохыг надад нээн хүртээж соёрхоно уу.” хэмээн гуйлаа. Хариуд нь, Чьявана Муни: “Ай хайрт хүү минь ээ, чи *Чайтра* сарын харанхуй хагаст болох Папамочани экадашид мацаг барих хэрэгтэй. Тэр бүх нүглийг, хичнээн аймшигтай байсан ч ялгаагүй бүгдийг нь устган үгүй болгодог.” гэж хэлсэн.

Медхави, эцгийнхээ зөвлөсний дагуу Папамочани экадашид мацаг барьлаа. Ингэснээр түүний бүх нүгэл устан үгүй болж, тэр өөрийн урьдын гавья зүтгэлээ дахин хүртлээ. Мөн, Манжугхоша энэхүү мацгийг барьж *пишача* болох хараалаас аврагдсан. Тэрээр тэнгэрийн хүрээлэлдээ очиж өөрийн урьдын байр сууриа дахин эзэлсэн.

Ломаши Риши цааш нь үргэлжлүүлэн өгүүлсэн нь: Тэгэхлээр, ай хаан минь ээ, Папамочани экадашид мацаг барьсны аугаа ач тус нь түүнийг итгэл, чин бишрэлтэйгээр баригчийн бүхий л нүглийг устган үгүй болгодогт оршдог юм.

Шри Кришна төгсгөлд нь: “Ай Юдхиштхира хаан минь ээ, Папамочани экадашийн тухай сонсож байгаа, эсвэл уншиж байгаа хэн бүхэн мянган үхрээр өргөл өргөснөөр хүртэх ач тустай дүйхүүц тийм үр дүнд хүрдэг. Энэхүү экадаши нь мөн брахманыг хөнөөсөн, үр хөврөлийг аборт хийн устгасан, согтууруулах ундаа хэрэглэсэн болон *гуру-гийн* ор дэвсгэрийг бузарласны нүглийг арилган зайлуулдаг. Надад маш эрхэм байдаг хийгээд алдаршуулбал зохилтой Папамочани экадашийн энэхүү ариун гэгээн өдрийг зөв баримталснаар ийм хэмжээлшгүй их ач тусыг хүртдэг болой.” гэж айлдсан.

Папамочани буюу Чайтра-Кришна экадашийн яруу алдрын тухай Бхавишья-уттара Пуранаас авсан хүүрнэл ийнхүү өндөрлөлөө.

Тайлбар:

1. Пражапати Дакшийн үйлдсэн тахилга өргөлийн үед өөрийн хайртай эхнэр Ситагаа алдсаны дараагаар Шива бурхан тахилгын газар орныг юу ч үгүй болтол сүйтгэсэн. Дараа нь Шива өөрийн хадам эцэг Дакшид ямааны толгой хүртээн түүнд амьдралыг нь эргүүлэн өгөөд 60 жилийн турш бясалгалд автан умбасан. Брахма бурхан Шивагийн бясалгалыг зогсоон болиулахаар Камадева (хайрын бурхан)-г илгээсэн. Кама өөрийн сумуудаа (дуу авиа, амт, хүртэхүй, үнэр, хэлбэр дүрс) ашиглан Шива руу дайран довтолж түүнийг трансин байдлаас нь гаргасан. Гэвч Шива, өөрийн нь тайван байдлыг нь алдагдууллаа гэж маш ихээр уурлан хилэгнэж Камаг өөрийн гурав дахь мэлмийгээрээ хоромхон зуурт л үнс болгон хувиргасан.

2. Эмэгтэй хүнтэй харьцах нь маш хүчтэй нөлөө үзүүлдэг бөгөөд ингэснээр эрчүүд бүхнийг, цаг хугацаа, алдагдаж буй эрч хүч, хөрөнгө зоорь, тэр ч бүү хэл

өөрийнхөө тухай ч мардтаг. Нити шастирт өгүүлсэнчлэн: “*стриия чаритрам пурушасья бхабьям дайво вижанати кито манушьях* буюу хувь заяагаар нь тодорхойлогдсон байдаг хүний ирээдүйг таньж мэдэж болдоггүйтэй адил эмэгтэйчүүдийн зан байдлыг хагас бурхад хүртэл урьдчилан таньж мэдэж чаддаггүй.” Ягьявалки Муни: “Бурханлаг амьдрал тийш тэмүүлэн байгаа брахмачари нь эмэгтэйчүүдтэй харьцах бүхий л холбоогоо таслан зогсоож, орхих ёстой. Тэр түүний тухай бодох ёсгүй, түүнийг харах ёсгүй, хүнгүй зэлүүд газар түүнтэй ярих ёсгүй, түүнээс алба зүтгэл авах ёсгүй, түүнтэй бэлгийн харьцаанд орох ёсгүй.” гэж сургасан байдаг.

КАМАДА ЭКАДАШИ

Шри Сута Госвами хэлсэн нь: “Ай гэгээнтэн мэргэд минь ээ, Та бүхэн намайг Деваки болон Васудева нарын хүү, Бүхний Дээд Бурхан, Хари, Бхагаван Шри Кришнад гүн бишрэл хүндэтгэлээ илэрхийлэхийг минь зөвшөөрөх ажаам уу. Түүний өршөөл нигүүлслээр л би бүх төрлийн нүглүүдийг арилган зайлуулах, мацаг барих өдрийг тодорхойлон өгүүлж чадах билээ. Бурхан Кришна Юдхиштхира хаанд бүхий л нүглийг устган арилгах 24 үндсэн экадашийн яруу алдрын талаар айлдсан бөгөөд би одоо тэдгээр айлдваруудаас нэгийг нь та бүхэнд дамжуулан хүргэе. Аугаа мэргэд эдгээр 24 айлдваруудыг 18 Пурануудаас түүвэрлэн авсан бөгөөд тэд үнэхээрийн эрхэм дээд бөлгөө.

Юдхиштхира Махаража айлтгасан нь: Ай Бурхан Кришна минь ээ, ай Васудева минь ээ, Та миний гүн бишрэл хүндэтгэлийг таалан болгооно уу. Та надад *Чайтра* (3-4) сарын гэрэлтэй хагаст тохиодог экадашийн тухай тодорхойлон айлдаж хайрлана уу. Энэ экадашийг юу гэж нэрлэдэг хийгээд түүнийг юуны учраас магтан алдаршуулдаг юм бэ?

Бурхан Кришна хариу айлдсан нь: Ай Юдхиштхира минь ээ, энэхүү ариун гэгээн экадаштай холбоотой эртний нэгэн түүхийг анхааралтай сонс доо. Энэ түүхийг нэгэн удаа Васиштха Муни Бурхан Рамачандрын өвөг дээдэс болох Дилипа хаанд өгүүлсэн билээ.

Дилипа хаан аугаа гэгээн Васиштхад хандан: Ай мэргэн брахман минь ээ, *Чайтра* сарын гэрэлтэй хагаст тохиодог экадашийн тухай сонсож мэдэх гэсэн хүсэлтийг минь болгоон энэ талаар тодорхойлон өгүүлж соёрхоно уу.” гэж хэлсэн.

Васиштха Муни хариулсан нь: “Ай хаантан минь ээ, чиний асуултыг магтвал зохистой. Би чамд, чиний мэдэхийг хүсэж байгаа тэр зүйлийн талаар баяртайгаар ярьж өгье. *Чайтра* сарын гэрэлтэй хагаст тохиох экадашийг Камада экадаши гэж нэрлэдэг. Түймэр ойн модыг хэрхэн шатаан үнс нурам болгодгийн адилаар тэр бүх нүглийг устгаж үгүй болгон арилгадаг. Энэ экадашийг чин зүрхнээсээ баримтлах хэн бүхэн дээдийн дээд ач тусыг хүртэн, ариусдаг. Иймээс хаан минь ээ, зүгээр л сонссон хүний бүх нүгэл устан арилдаг тийм таатай, эртний нэгэн түүхийг сонсоно уу.

Эрт урьдын нэгэн цагт, алт болон үнэт эдлэлээр гойд тансаг чимэглэгдсэн Ратнапура гэдэг хот байжээ. Тэр хотод хурц шүдэт могойнууд амьдран согтууруулах ундаа уун хөлчүүрхэн наргиж цэнгэдэг байж. Харин хотын эргэн тойронд олон *гандхарва*, *киннара* болон *апсарууд* амьдардаг байлаа. Улс гүрнийг Пундарика гэдэг хаан захирдаг байв.

Гандхарвачуудын дунд Лалита болон түүний эхнэр, дур булаам гуа үзэсгэлэн бүрдсэн бүжигчин Лалитаа нар амьдардаг байв. Тэд бие биедээ маш ихээр татагдан салж хагацахын аргагүй байдаг байсан бөгөөд тэдний гэр орон нь эд баялаг болон тансаг сайхан хоол хүнсээр элбэг дүүрэн байлаа. Эхнэр Лалитаа нь нөхрөө маш ихээр энхрийлэн хайрладаг байсан бол нөхөр нь эхнэрээ байнгад бодож, түүн рүү үргэлж тэмүүлэн санагалздаг байлаа.

Нэгэн удаа, Пундарика хааны ордонд олон *гандхарванууд* цугларан хааны өмнө бүгдээрээ бүжиглэхэд Лалита эхнэртэйгээ бус ганцаараа дуулсан. Дуулах үедээ ч тэр эхнэрийнхээ тухай бодохгүй байж чадахгүй байсан бөгөөд иймээс тэр ая хэмнэлээ алдсан. Лалита дууныхаа төгсгөлийг буруу хийхэд хааныг дагалдаж явсан нэгэн атаархуу могой түүнд, Лалита улс гүрнийхээ тухай биш, харин эхнэрийнхээ тухай бодолд автаж байна гэж хов хүргэсэн. Үүнийг сонсоод хаан ихэд догшрон, нүдэнд нь уур хилэнгийн оч бадран улаанаар эргэлдэн: “Тэнэг мунхаг, үл бүтэх этгээд минь ээ, чи өөрт оноогдсон үүргээ биелүүл, хүсэл тачаалдаа автсан чи хаан эзнийхээ тухай бодохын оронд эхнэрийнхээ тухай бодно гэнээ. Ингэсний чинь хариуд би чамайг хүн идэгч бол гэж харааж байна.” гэж хашгирав.

Ай хаан минь ээ, ингээд Лалита тэр дороо л, хэн бүхний айдсыг төрүүлсэн, хүнээр хооллогч аврага том демон (шулам), аймшигт махчин болон хувирсан. Түүний гарууд нь 8 миль урт, ам нь аврага том агуй мэт, нүд нь нар сар адил хурцаар гялалзсан, хамрын нүхнүүд нь ёроолгүй гүн худаг мэт, хөл гуя нь 4 милийн бүдүүнтэй, түүний аврага бие нь 64 милийн өндөртэй байлаа. Гайхамшигтай сайн дуучин-*гандхарва* байсан хөөрхий Лалита Пундарика хааны хараалаас болон ийнхүү зовж шаналах болсон.

Өөрийн нөхрөө, хүн идэгч аймшигт махчины дүрд ороод маш ихээр зовж байгааг хараад Лалитаа эхнэр уй гашууд автсан. Тэрээр: “Хайртай нөхөр минь хааны хараалаас болж ингэж зовж байхад, би юу хийх вэ? яах ёстой вэ? гэж бодож байлаа. Ийнхүү Лалитаа өдөр шөнөгүй гашуудан шаналж байв. *Гандхарва* нөхөртэйгээ цэнгэн жаргаж байхын оронд, хааны хараалаас болж бүрнээ уналт доройтолд орж, аймшигт нүгэлт үйлүүдтэй хутгалдан зууралдан, хамгийн бузар муухай газруудаар хэсэх демон нөхрөө даган хүн амьтангүй ой шугуйгаар хэрэн тэнүүчилж явлаа. Урьд нь үзэсгэлэнт сайхан хагас бурхан-*гандхарва* байсан түүний нөхөр нь одоо хүнээр хооллогч махчингийн аймшигт зан авиртай болсон байлаа. Өөрийн хайртай нөхрийнхөө энэхүү зовлонт байдлыг харж байгаа Лалитаа солиотой мэт хэрэн тэнүүчлэхээсээ болж бараг галзуурах шахан, цурхиран уйлав.

Гэвч нэгэн удаа, Лалитаа эхнэрт маш их аз завшаан тохиож Шринга гэгээнтэнтэй учирсан. Гэгээнтэн Виндхьячала гэдэг алдар цуутай толгой дээр сууж байлаа. Лалитаа түүнд ойртон дөхөж очоод гүн хүндэтгэл бишрэлээ илэрхийлсэн. Гэгээнтэн, өөрийнхөө өмнө залбиран байгаа Лалитааг хараад: “Ай үзэсгэлэн гоо минь ээ, чи хэн бэ? Хэний охин бэ? Ямар хэргээр наашаа ирэв? Бүх үнэнээ нууж хаалгүй нээн яриач.” гэв.

Лалитаа хариулсан нь: “Ай аугаа гэгээнтэн минь ээ, Би бол аугаа Вирадханва *гандхарвын* охин билээ. Намайг Лалитаа гэдэг. Би, Пундарика хааны хараалаас болж хүнээр хооллогч шулам болсон өөрийн хайртай нөхрийн хамтаар ой, тайгаар хэрэн тэнүүчилж байна. Ай брахман минь ээ, Би түүний аймшигт нүгэлт үйлүүд болон түүний догшин хэрцгий дүр төрхийг хараад маш их зовж шаналж байна. Ай багш минь ээ, нөхрийнхөө нүглийг наминчлан арилгахын тулд би юу хийх ёстой вэ? гэдгийг надад сургаж зөвлөж хайрлаач. Ай брахмануудын шилдэг нь минь ээ, түүнийг шулмын дүр төрхөөс нь чөлөөлөхийн тулд би юу хийх ёстой вэ?”

Гэгээнтэн хариу өгүүлсэн нь: Ай бурхангүй үзэлт минь ээ, *Чайтра* сарын гэрэлтэй хагаст Камада гэж нэрлэгддэг экадаши тохиодог. Удахгүй энэ экадаши болно. Энэ өдөр мацаг барьсан хэн бүхний хүсэл нь биелэгддэг. Хэрвээ чи энэ экадашийн өдөр заасан дүрэм журмын дагуу мацаг барих хийгээд хүртсэн ач тусаа нөхөртөө дамжуулан шилжүүлж өгөх аваас тэрээр тэр дороо л хараалаас чөлөөлөгдөн аврагдана.

Лалитаа эхнэр Шринга гэгээнтэний сургасны дагуу Камада экадашид итгэл дүүрэн мацаг барьсан бөгөөд, *двадашид* Васудева Бурханы дүрийн өмнө очин: “Би Камада экадашийг итгэлтэйгээр баримтлалаа. Хэрвээ Та намайг энэ

экадашийг баримталсаны ач тусыг хүртэх нь зохистой гэж болгоох аваас хүнээр хооллогч шулам болгон хувиргасан хараалаас миний нөхрийг чөлөөлж соёрхоно уу. Миний хүртэх ач тус түүнийг минь зовлон шаналалаас ангижруулаг.” гэж залбиран гуйсан.

Лалитааг ингэж хэлмэгц, түүний хажууд зогсож байсан түүний нөхөр хааны хараалаас чөлөөлөгдсөн. Тэрээр олон янзын гайхамшигт гоёл чимэглэлээ зүүсэн, тэнгэрийн орны үзэсгэлэн төгөлдөр дуучин-*гандхарва* Лалитын дүрдээ эргэн орсон. Энэ бүхэн нь Камада экадашийн яруу алдар хийгээд сүр хүчээр л болсон хэрэг бөгөөд *гандхарва*-хос нисдэг хөлөгт суун тэнгэрийн орны зүгт хөөрөн одов.

Бурхан Кришна цааш үргэлжлүүлэн айлдахдаа: “Ай Юдхиштхира минь ээ, ай хаадын шилдэг нь минь ээ, энэхүү гайхамшигт хүүрнэлийг сонсох хэн бүхэнд болон Камада экадашийг баримтлахын тулд бүхнийг хийж байгаа жинхэнэ чин бишрэлтэнд энэ экадаши аугаа ач тусыг хайрлан хүртээдэг. Бүх хүн төрөлхтний ач тусын тулд энэ экадашийн яруу алдрыг чамд Би тодорхойлон айлдлаа. Камада экадашаас илүү экадаши гэж үгүй билээ. Энэ экадашийг баримталсны ач тус нь брахманыг хөнөөсөн нүглийг ч арилган зайлуулдаг, мөн түүнээс гадна шулмын хараалыг зайлуулж, ухамсарыг ариусгадаг. Бүхий л гурван ертөнцөд, хөдөлдөг болон үл хөдөлдөг амьд оршнолуудын хувьд түүнээс илүү өдөр гэж үгүй.” хэмээн айлдсан.

Камада экадаши буюу Чайтра-шукла экадашийн яруу алдрын тухай Вараха Пуранаас авсан хүүрнэл ийнхүү өндөрлөлөө.

ВАРУТХИНИ ЭКАДАШИ

Юдхиштхира Махаража айлтгасан нь: Ай Васудева минь ээ, Танд гүн бишрэл хүндэтгэлээ илэрхийлье. Одоо Та надад *Вайсакха* (4-5) сарын харанхуй хагаст тохиодог экадашийн яруу алдрыг хийгээд түүнийг хэрхэн яаж баримталдаг тухай тодорхойлон айлдаж соёрхоно уу.

Бурхан Кришна хариу айлдсан нь: Ай хаан минь ээ, Энэ хийгээд дараа хойтын ертөнцөд хамгийн өршөөл нигүүлсэлтэй болоод өгөөмөр экадаши бол *Вайсакха* сарын харанхуй хагаст тохиодог экадаши байдаг. Энэ ариун гэгээн өдөр бүтэн мацаг барих хэн бүхэн бүх нүглээсээ салан ангижирч үргэлжийн аз жаргалтай болохын зэрэгцээ түүнийг зол завшаан, амжилт бүтээл үргэлж дагалдаж байх болно. Варутхини экадашид барьсан мацаг нь урагш муутайхан эмэгтэйг ч аз жаргалтай болгодог. Энэ экадашийг баримталж байгаа хэн бүхэнд тэр энэ амьдралд нь материаллаг жаргал цэнгэлийг, харин үхсэний нь дараа ангижралыг хүртээдэг. Тэр бүхий л нүглийг арилган зайлуулж, хүнийг шинээр дахин төрөх зовлонгоос ангижруулдаг.

Мандхата хаан энэ экадашийг зөв баримталснаар ангижралд хүрсэн. Мөн өөр олон хаад түүнийг баримталснаар ач тусыг нь хүртсэн билээ. Икшваку удмын Дхундхумара хаан Шива бурханы хараалаас болсон уяман өвчнөөсөө ингэж л салсан. Варутхини экадашид мацаг барьсан хэн бүхэн мянган жилийн туршид тэвчил наманчлал үйлдсэнтэй адил ач тусыг хүртдэг. Энэ экадашид мацаг барих нь нар хиртэх үед Курукшетрад алт түгээсэнтэй адил ач тустай. Энэхүү экадашийг итгэл, чин бишрэлтэйгээр баримталж байгаа хүн энэ амьдралдаа ч тэр, мөн дараагийн амьдралдаа ч тэр зорьж буй зорилгодоо хүрдэг.

Заанаар өргөл өргөх нь мориор өргөл өргөхөөс илүү, харин газрыг өргөл болгон өргөх нь заанаар өргөл өргөхөөс илүү байдаг. Мөн заанаар өргөл өргөхөөс кунжутын үрээр өргөл өргөх нь илүү байдаг бол алтаар өргөл өргөх нь

үүнээс ч илүү. Гэсэн ч, бүхий л өвөг дээдэс, хагас бурхад болон хүмүүс будаа тариа идэн таашаал ханамж авдаг учраас будаа тариа түгээх нь алт түгээн тарааснаас илүү дээр байдаг билээ. Үүнээс илүү өргөл гэж өнгөрсөн цаг үед ч байгаагүй, одоо ч байхгүй, мөн ирээдүйд ч байхгүй байна¹. Гэхдээ зарим номч брахманууд нь, цэвэр ариун залуу бүсгүйг зохистой хүнд нь эхнэр болгон өгөх нь будаа тариа тараан түгээсэнтэй адил байдаг гэж батлан өгүүлдэг. Харин Бурханы Дээд Бодьгал, Шри Кришна, үнээгээр өргөл өргөх нь хоол хүнсэнд зориулан будаа тариагаар өргөл өргөсөнтэй адил байдаг гэж айлдсан. Гэсэн ч энэ бүх өргөлүүдээс харанхуй мунхаг хүмүүст бурханлаг мэдлэгийг хүртээх нь илүү дээр билээ. Тэгвэл Варутхини экадашид мацаг барьж байгаа хүн энэ бүх үйлүүдийг бүгдийг нь үйлдсэнтэй адил ач тусыг хүртдэг.

Өөрийн охидын хөрөнгө баялгаар амьдрах хэн бүхэн, ай Бхарата минь ээ, орчлонг бүхэлдээ усанд автах үе хүртэл тамын нөхцөлд зовж тарчлах болдог. Ийм учраас охидынхоо эд баялгаас ашиглах явдлаас онцгойлон зайлсхийх хэрэгтэй. Ай хаадын шилдэг нь минь ээ, шунахайрал хомхойрлоосоо болж өөрийн охиныхоо буюу хүргэний эд баялгаас авах аливаа *грихастха* (гэрбүлийн амьдралын хэлбэрт амьдрагч) нь дараагийн амьдралдаа муур болон төрдөг. Иймээс олон янзын үнэт зүйлсээр гоёж чимэглэсэн охиноо зохих инжтэйгээр нөхөрт гарган ариун гэгээн өргөл үйлдэж байгаа хэн бүхэн Ямаража бурханы гол туслах Читрагупта өөрөө ч тодорхойлон хэлж чадахын аргагүй тийм ач тусыг хүртдэг гэж ярьцгаадаг. Гэсэн ч энэ ач тусыг Варутхини экадашийг баримталснаар амархан хүртэж болно.

Экадашийн өмнөх өдөр *даша-д* хүрэл сав суулганаас хоол унд идэж уух, бүхий л хэлбэрийн *урад-дал*, улаан чечевиц (зармаг), шар будаа, конго², шпинат, болон бал идэхээс зайлсхийх хэрэгтэй. Мөн өөр бусдын гэрт хооллох, нэгээс илүү удаагаар хооллохгүй байх хэрэгтэй. Мөн тэрчлэн хурьцлыг цээрлэн тэвчих шаардлагатай. Экадашид мөрийтэй тоглоом тоглох, спортоор хичээллэх, өдөр унтах, бетелийн самар болон навчийг нь идэхээс зайлхийн, тэдгээрийг тэвчих хэрэгтэй. Шүдээ сайтар цэвэрлэн, цуурхал тараах, бусдаас өө сэв эрэн гоочлох, бурханлаг хөгжил дэвшлийн хувьд доод түвшинд оршигчидтой болон уур хилэнтэй байгаа, мөн хууран мэхлэгч хүмүүстэй ярилцахын хэрэггүй. Экадашийн дараах өдөр, *двадашид* зэс савнаас хоол идэх, *урад дал*, улаан чечевиц болон балыг хоол хүнсэндээ хэрэглэхээс зайлсхийх хэрэгтэй. Хэвтэж, мөн нэгээс олон удаа хооллож болохгүй. Хүнд ажил хийх, хурьцал үйлдэх, үс сахлаа авах, биеэ тослох болон бусдын гэр оронд очиж хоол унд идэж уухаас зайлсхийх хэрэгтэй.

Бурхан Кришна үргэлжлүүлэн айлдсан нь: Варутхини экадашийг ийнхүү баримтлах хэн бүхэн бүхий л нүглийн үр дагавруудаасаа чөлөөлөгдөн ангижирч, мөнхий бурханлаг орондоо буцаж очно. Шөнийн туршид унталгүй, сэрүүн байж, Жанардана Бурханд бишрэл хүндэтгэлээ илэхийлэн байх хэн бүхэн мөн бүх нүглээсээ ангижран бурханлаг оронд хүрч очно. Иймээс, ай хаан минь ээ, өөрийн үйлдсэн нүгэл хийгээд түүний үр дагавраас, мөн өөрийн үхлээс айж байгаа хэн бүхэн Варутхини экадашид мацгийг маш нарийн чанд барих хэрэгтэй. Ай сурвалжит, ариун шудрага Юдхиштхира минь ээ, ариун гэгээн Варутхини экадашийн яруу алдрын тухай уншиж байгаа эсвэл сонсож байгаа хүн мянган үнээгээр өргөл өргөсөнтэй адил ач тусыг хүртэх бөгөөд хожим нь Вишну Бурханы оронд, гэр лүүгээ буцаж харих болно.

Варутхини экадаши буюу Вайсакха-Кришна экадашийн яруу алдрын тухай Бавишья-уттара Пуранаас авсан хүүрнэл ийнхүү өндөрлөлөө.

Тайлбар:

1. Будаа тариагаар өргөл өргөх нь маш их өршөөл нигүүлсэлтэй. Нэгэн удаа Юдхиштхира Махаража Бурхан Кришнагаас: “Ай Бурхан минь ээ, тахилга

өргөл болон тэвчил наманчлал үйлдэлгүйгээр тэнгэрийн оронд хүрч болох уу?” гэж асуухад Бурхан Кришна хариуд нь: “Ай Бхаратын хөвгүүн минь ээ, талх, ус болон эмийг хэрэгцээтэй байгаа хүнд нь өгч байгаа хэн бүхэн ямар нэгэн тахилга өргөл эсвэл тэвчил наманчлал үйлдэлгүйгээр тэнгэрийн оронд хүрч болно.” (Махабхарата) гэж айлдсан.

Бурхан Кришна Бхагавад Гитагийн (3.14)-д айлдсанчлан: “Бүх амьд биетүүд нь будаа тариагаар хооллодог.” гэж айлдсан байдаг. Иймээс үр тариагаар өргөл өргөхийг хамгийн дээд өргөл гэж үздэг. Түүнээс гадна, хайр чин бишрэлтэйгээр бэлтгэж Бурхан Кришнад өргөсөн зоог-*прасадамыг* хүртсэнээр энэхүү материаллаг ертөнцөөс ангижирдаг.

2. Конго- эрт цагт ядуучуудын иддэг байсан намуу цэцэгтэй төстэй үр тарианы нэгэн зүйл.

МОХИНИ ЭКАДАШИ

Юдхиштхира Махаража айлтгасан нь: Ай Жанардана минь ээ, *Вайсакха* (4-5) сарын гэрэлтэй хоёр долоо хоногт тохиодог экадашийг юу гэж нэрлэдэг вэ? Түүнийг хэрхэн яаж баримтлах ёстой вэ? Намайг өршөөн соёрхож энэ бүхний талаар надад айлдаж хайрлана уу?

Бурхан Шри Кришна хариу айлдсан нь: Ай Дхармын хүү минь ээ, Васиштха Мунигийн нэгэн удаа Рамачандра Бурханд айлтгасныг Би одоо чамд айлдъя.

Рамачандра Бурхан Васиштха Мунид хандан: Ай аугаа гэгээнтэн минь ээ, нүгэл хийгээд гай зовлонгийн бүх хэлбэр, төрлийг арилган зайлуулах мацгийн бүхий л өдрүүдээс хамгийн шилдэг сайн өдрийн тухай өгүүлээч. Би Өөрийн хайртай Ситагаас салж хагацсанаас болоод удаан хугацааны туршид зовж шаналж байна. Энэ зовлон шаналалаасаа хэрхэн яаж ангижрах вэ? гэдгийг чамаас сонсмоор байна.” хэмээн айлдсан.

Васиштха Муни хариу айлтгасан нь: Ай Рама Бурхан минь ээ, ай саруул ухаантан минь ээ, Таны нэр алдрыг дурсан санаснаар л энэхүү материаллаг ертөнцийн далайг гэтлэн туулж болох билээ. Та үүнийг бүх хүн төрөлхтний тусын тулд л надаас асуусан билээ. Иймээс бүгдийн хүслийг биелүүлэх үүднээс бүх ертөнцийг ариусгах чадвартай мацгийн өдрийг би одоо тодорхойлон айлтгая.

Ай Рама минь ээ, энэ өдөр бол *двадашид* тохиодог *Вайсакха-шукла* экадаши юм. Энэ экадаши нь бүх нүглийг арилган зайлуулдаг бөгөөд түүнийг мөн Мохини экадаши гэж алдаршуулдаг. Ай Рама минь ээ, энэхүү экадашийн ач тусаар түүнийг баримталж байгаа зол завшаантай сүнс нь хий хуурмагийн торноос үнэхээрийн чөлөөлөгдөн ангижирдаг. Иймээс Та зовлон шаналалаасаа хагацахыг хүсэж байгаа бол гуниг зовлонгоос ангижруулдаг хийгээд замд тохиолдох бүхий л саад тотгоруудыг арилган зайлуулах энэхүү өршөөл нигүүлсэлт экадашийг төгс байдлаар баримтлах ажаам уу. Түүний аугааг хэрхэн тодорхойлохыг болгоон сонсоно уу. Тэр ч бүү хэл, өршөөл нигүүлсэл дүүрэн энэхүү экадашийн тухай зөвхөн сонссоноор л маш их нүглээсээ салан хагацаж болдог билээ.

Эртийн нэгэн цагт Сарасвати голын эрэг дээр сарны удамд төрсөн Дьютиман хааны захиран суудаг Бхадравата гэдэг гайхамшигт сайхан хот байдаг байлаа. Ай Рама минь ээ, тэр бол хүчирхэг, үнэнч шудрага бөгөөд маш мэргэн ухаантай хаан байв. Түүний эзэнт гүрэнд маш их мөнгө болон үр тариа хураан хуримтлуулсан Дханалала нэртэй нэгэн худалдаачин амьдардаг байлаа. Тэр маш их шүтлэгтэй нэгэн байсан. Бхадраватагийн бүх оршин суугчдын сайн сайхны төлөө тэр нуур байгуулж, тахилга өргөлийн талбар индэр босгож, гоё сайхан цэцэрлэгт хүрээлэнгүүдийг тордон ургуулж байсан. Тэр бол Вишну

Бурханы эрхэм сайн чин бишрэлтэн байсан бөгөөд Суману, Дьютимана, Медхави, Сукрити болон Дхриштабудхи гэсэн таван хөвгүүдтэй байлаа.

Харамсалтай нь түүний хүү Дхриштабудхи нь цаг ямагт л нүгэлт үйлтэй хутгалдан зууралддаг байв. Тэр янхнуудтай унтаж, муу хүмүүстэй нөхөрлөдөг байв. Тэр бэлгийн хорио цээртэй харьцаанд орж, мөрийтэй тоглоом тоглох болон мэдрэхүйн ханамж эдлэх өөр бусад олон зүйлийн хойноос хөөцөлддөг байлаа. Тэр мөн хагас бурхад, брахманууд, өвөг дээдэс, гэр бүлийнхээ ахмад гишүүдийг болон зочдоо үл хүндэтгэдэг байв. Хорлолт Дхриштабудхи эцгийнхээ хөрөнгө зоорийг ямар ч эргэцүүлэн бодох юмгүйгээр үрэн таран хийж, хорио цээртэй хоол хүнс идэж, архи дарс маш их уудаг байлаа.

Нэг удаа, Дхриштабудхи гудамжаар янхантай тэврэлдэн явж байхыг эцэг Дханапала нь хараад түүнийг гэрээсээ хөөсөн. Бүх төрөл төрөгсөд нь түүнийг мш ихээр буруушаан зэмлэж, түүнээс зайлсхийн холдсон. Тэр өөрийн бүх гоёл чимэглэлээ зарсны дараагаар бүрмөсөн хоосорч үгүйрэн ядуурлаа. Түүнээс янхнууд хүртэл нүүр буруулах болсон, тэр ч бүү хэл тэд түүний ядуу зүдүү байдлыг элэг барин шоолж доромжлох болсон. Дхриштабудхи бүр тавгүйтэн улам бүр өлсөж цангах боллоо. Тэрээр: “Би одоо яах вэ? Амьдралаа яаж залгуулах вэ?” гэж бодсон. Тэгээд тэр хулгай хийж эхэллээ. Хааны эргүүлүүд түүнийг барьсан боловч эцэг нь алдар цуутай Дханапала гэдгийг мэдээд суллан тавьсан. Гэвч хожим нь тэд тэд түүнийг барин, зодож занчин гав гинжээр гинжилж хорьсон.

Хааны түшмэлүүд Дхриштабудхид: “Ай хорон муу санаат зальхай минь ээ, чамд энд гишгэх ч газар алга.” гэж хэлсэн. Гэвч эцэг нь түүнийг сулласан бөгөөд Дхриштабудхи шууд л ой руу явсан. Тэр ойгоор тэнэсээр маш их өлсөж цангасан. Эцэстээ тэр хооллож ундлахын тулд арслан, буга, гахай, чоно зэрэг зэрлэг амьтдыг агнаж эхэлсэн. Тэр нумаа гартаа харвахад бэлэн байдалтайгаар үргэлж барьж явдаг байсан ба хурц сумтай саадгаа мөрөндөө эгэлдэргэлсэн байдаг байв. Тэр мөн чакор, тогос, канок, тагтаа зэрэг шувуудыг агнаж байв. Тэрээр шувууд хийгээд амьтдыг ямар ч тээнэгэлзэх юмгүйгээр хөнөөдөг байсан учир түүний нүгэл нь өдрөөс өдөрт улам ихээр нэмэгдэж байлаа. Урьд өмнө үйлдсэн нүгэл хилэнц дээрээ нэмэн тэр одоо бүр нүглийн далайд живсэн байлаа.

Дхриштабудхи цаг ямагт л гунигтай, тавгүй байдалтай байв. Гэсэн ч, тэр нэгэн удаа *Вайсакха* сард, магадгүй өөрийн өнгөрсөн амьдралдаа үйлдсэн сайн үйлийн ачаар, Каундинья Мунигийн *ашрамд* хүрч очсон. Аугаа мэргэн Ганга мөрөнд угаал үйлдээд дөнгөж дуусаж байсан учир түүнээс ус дусалж байлаа. Дхриштабудхид маш их зол завшаан тохиож гэгээнтний хувцаснаас дусах усны дусалд хүрсэн. Тэрээр хоромхон зуурт л мунхагийн харанхуйгаас ангижран чөлөөлөгдөж нүглийн нь үр дагавар багассан. Каундинья Мунид гүн бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн Дхриштабудхи алга хавсран залбирч: “Ай брахман минь ээ, би амьдралдаа маш их нүгэл үйлджээ. Одоо би маш их гунигтай байна. Энэ нүглээс хэрхэн яаж ангижран салж болохыг надад хэлж өгөөч.” гэж гуйсан. Аугаа Риши хариулсан нь: Ай хүү минь ээ, маш анхааралтай сонс, Сумеру уул шиг тийм маш их, хүнд бэрх нүглийг ч устгах хүчийг агуулах ариун гэгээн Мохини экадаши *Вайсакха* сарын гэрэлтэй хагаст болно. Хэрвээ чи миний зөвлөгөөг даган Бурхан Харид маш эрхэм байдаг энэхүү экадашид чин бишрэлтэйгээр мацаг барих аваас өөрийн олон олон амьдралын туршид үйлдсэн бүхий л нүглийн үр дагавруудаас чөлөөлөгдөх болно.

Эдгээр үгсийг маш их баяр хөөртэйгөөр сонсоод Дхриштабудхи Мохини экадашид гэгээнтний зааж зөвлөсний дагуу мацаг барихыг амласан. Ай хаадын шилдэг нь минь ээ, ай Рама минь ээ, Мохини экадашид бүтэн мацаг барьснаар Дханапала худалдаачны замаа алдсан хүү, нүгэлт Дхриштабудхи нүгэлгүй болсон. Үүний үрээр тэр гайхамшигт трансценденталь дүр төрхтэй болж Вишну Бурханы хөлөг Гаруда шувууны нуруун дээр гаран Бурханы дээдийн дээд орон

тийш ямар ч саад тотгоргүйгээр чиглэн одсон билээ. Ай Рама минь ээ, мацгийн өдөр-Мохини экадаши нь материаллаг оршнолд хий хуурмагаар дурлан татагдахуйн харанхуйг сарниулан хөөдөг. Иймээс гурван ертөнцөд үүнээс илүү сайн өдөр гэж үгүй билээ.

Бурхан Кришна: “Иймээс, ай Юдхиштхира минь ээ, ариун дагшин газраар мөргөл хийн явсан ч, өргөл өргөсөн ч, хандив өглөг тараасан байсан ч Мохини экадашийг Миний чин бишрэлтэн баримталснаар хүртэх ач тусын 16-ны нэгд хүрэх тийм ач тусыг ч хүртэж чадахгүй. Мохини экадашийн аугааг ойлгож мэдэж байгаа болон сонсож байгаа хэн бүхэн мянган үнээгээр өргөл болгосонтой адил тийм ач тусыг хүртдэг.” хэмээн айлдвараа өндөрлөв.

Мохини экадаши буюу Вайсакха-шукла экадашийн яруу алдрын тухай Курма Пуранаас авсан хүүрнэл ийнхүү өндөрлөлөө.

Тайлбар:

1. *Двадашид* тохиож байгаа экадашийг Ведийн судруудад мөн экадаши гэж нэрлэдэг. Түүнээс гадна Гаруда Пураны (1.125.6)-д Брахма бурхан Нарادا Мунид: “Ай брахман минь ээ, экадаши нь *двадашитай* давхцах үед энэ экадашийг бүрэн хэмжээгээр баримтлах хэрэгтэй. Харин экадаши нь *даша-д* тохиох аваас түүнийг баримтлах хэрэггүй.

АПАРА ЭКАДАШИ

Юдхиштхира Махаража айлтгасан нь: Ай Жанардана минь ээ, *Жйештха* (5-6) сарын харанхуй хагаст тохиодог экадашийг юу гэж нэрлэдэг вэ? Энэхүү ариун гэгээн өдрийн яруу алдрын талаар надад айлдаж соёрхоно уу.

Бурхан Кришна айлдсан нь: Ай хаан минь ээ, чи үнэхээрийн гайхамшигтай сайхан асуулт тавьлаа. Учир нь, түүний хариу нь бүх хүн төрөлхтөнд ач тус авчрах болно. Энэхүү экадаши бол хамгийн аймшигт нүглийг ч арилгах өршөөл нигүүлсэлтэй хийгээд хүчирхэг бөлгөө. Ай хаан минь ээ, энэхүү хэмжээлэхийн аргагүй ач тусыг хүртээх экадашийг Апара экадаши гэж нэрлэдэг. Энэ ариун гэгээн өдөр мацаг барьж байгаа хэн бүхэн бүхий л орчлон даяар алдарших болно. Тэр ч бүү хэл брахманыг, үнээг эсвэл төрөөгүй хүүхдийг хөнөөсөн, Бурхан шүтээнийг харааж доромжилсон болон бусдын эхнэртэй янаг амрагийн харьцаа тогтоосон зэрэг нүглийг ч Апара экадашийг баримталснаар бүрэн арилган зайлуулж болно.

Ай хаан минь ээ, хуурамч баталгаа өгч байгаа хүмүүс маш их хүнд нүгэлтэн болдог. Хуурамч нялуунаар эсвэл доог тохуутайгаар бусдыг магтах, дутуу жигнэж хэмжих, өөрийн *варна* болон *ашрамын* оноогдсон үүргийг биелүүлж чадахгүй байгаа (Жишээ нь: зохих боловсрол, түвшинд хүрээгүй байж брахманы үүргийг биелүүлэх гэж оролдох болон Ведийг буруу ташаагаар тайлбарлах), өөрийн санаагаар судруудыг зохиох, бусдыг буруу, худлаа зурхайгаар мэхлэх, албан тушаалаа луйврын ажилд ашиглах, Аюрведийн гэсэн нэрээр хуурамч эм тан гаргах гэх зэргийн үйлүүд нь бүгд хуурмаг баталгаа өгч, мэхэлж байгаа учир энэ үйлүүдийг үйлдэж байгаа хэн бүхэн тамд унах болно. Гэсэн ч Апара экадашийг баримталснаар эдгээр нүгэлтэнгүүд нь үйлдсэн нүгэлт үйлүүдийнхээ үр дагавруудаас чөлөөлөгдөн аврагдах болно.

Өөрийн *дхарма* (өөрт оноогдсон үүргээ)-г үл хайхарч, эс тоомсорлон, тулааны талбараас зугатааж байгаа хэн бүхэн тамд унах болно. Гэсэн ч ийнхүү унаж доройтсон кшатрия нь Апара экадашид мацаг барих аваас энэхүү аймшигт нүглээс чөлөөлөгдөн аврагдаж тэнгэрийн гаригуудад дээшлэн хүрдэг.

Номын багшаасаа жинхэнэ бурханлаг мэдлэгийг хүртсэн мөртөө түүнээс нүүр буруулах хийгээд түүнийг муучлах шавь бол хамгийн шившигт бузар

бөгөөд хэврэг болно. Иймээс, энд Бурханы айлдсанчлан, бид Хари-васара-д мацаг барих буюу экадашийг баримтлан Түүнд үйлчлэн зүтгэх хэрэгтэй.

Үүнтэй холбогдуулан, Шримад Бхагаватамын (2.14)-д Шрила Прабхупадын өгүүлсэн үгэнд анхаарлаа хандуулах шаардлагатай: “Цаг хугацааны салхи материаллаг мөн чанарын хязгааргүй их далайн давалгааг бургиулан босгодог бөгөөд амьдралын нөхцөл байдал гэгдэгч зүйл нь бие махбодь, эхнэр хүүхэд, нийгэм, хамтрагчид гэх зэрэг болон биднийг хүрээлэн байгаа эргэн тойрны бусад зүйлийн хэлбэрт байдаг хөөсний цэврүү шиг л юмс байдаг. Сүнсний тухай мэдлэггүй л бол бид өөрсдийн харанхуй мунхагийн золиос болох бөгөөд хүний амьдралын үнэ цэнэтэй эрч хүчийг материаллаг ертөнцөд олж хүртэхийн аргагүй байдаг үхэшгүй мөнхийн хойноос эрж хайхын үргүй зүйлд зориулан үрэн таран хийх болно.”

НИРЖАЛА ЭКАДАШИ

Нэгэн удаа, Юдхиштира Махаражын дүү Бхимасена Пандавчуудын өвөг аугаа мэргэн Шрила Вьясадевагаас экадашийн мацаг барих бүх дүрэм журмуудыг баримтлалгүйгээр бурханлаг ертөнцдөө буцан очиж болох эсэх талаар асуусан. Бхимасена: “Ай аугаа мэргэн өвөг минь ээ, миний ах Юдхиштира, миний хайртай ээж Кунти болон амраг эхнэр Драупади, мөн Аржуна, Накула, Сахадева нар энэ ариун гэгээн өдөр дагаж мөрдөх ёстой бүхий л дүрэм журмуудыг нарийн чанд баримтлан бүтэн мацаг барьдаг. Харин өвөө минь ээ, өлсөнө гэдэг бол миний хувьд тэсвэрлэхийн аргагүй зүйл байдаг учраас би тэдэнд, хоолгүйгээр амьдарч чадахгүй гэж хэлдэг билээ. Мацаг барилгүйгээр тийм үр дүн, ач тусыг яаж хүртэж болохыг надад хэлж өгөөч.” гэж хэлсэн.

Түүний энэ үгийг сонсоод Шрила Вьясадева: “Хэрвээ чи тамын гаригуудад унахаас зайлсхийн тэнгэрийн гаригуудад дээшлэн хүрэхийг хүсэж байвал гэрэлтэй үеийн ч тэр, харанхуй үеийн ч тэр экадашид мацаг барих л хэрэгтэй болно.” гэж хариулсан.

Бхима залбиран: “Ай аугаа мэргэн өвөө минь ээ, *мунигуудын* хамгийн аугаа нь минь ээ, Би өдөрт ядаж нэг удаа хоол идэлгүйгээр амьд байж чадашгүй байна шүү дээ, тэгвэл огт юу ч илдэлгүйгээр мацаг барих аваас би яаж амьд мэнд үлдэх билээ дээ. Миний ходоодыг дотроос нь хоол боловсруулан шингээх *арика* гэж нэрлэгддэг гал¹ дүрэлзэн төөнөж байдаг. Зөвхөн, намайг ханаж цадталаа хоол идсэн цагт л миний ходоодон доторхи гал намждаг билээ. Ай аугаа гэгээн минь ээ, би нэг л удаа мацаг барих чадвартай. Иймээс, бусад бүх экадашуудыг орлох тийм экадашийн тухай надад ярьж өгөөч. Би энэхүү мацгийг ангижралд хүрэхэд таарч зохицуйцаар бат найдлага, чин бишрэлтэйгээр барих болно.” хэмээн хэлсэн.

Шрила Вьясадева хариулсан нь : “Ай хаан минь ээ, чи урьд нь надаас, нарийн чанд судалж бэлтгэсэн ведийн ёслолууд гэх зэрэг биелүүлэх ёстой оноогдсон үүргүүдийн янз бүрийн хэлбэр төрлүүдийн талаар сонссон билээ. Гэхдээ *Кали югад* хэн ч энэ бүх үүрэг, журмуудыг зохих ёсоор нь биелүүлж чадахгүй билээ. Гэсэн хэдий ч би чамд, нэг их хүчин чармайлт гаргалгүйгээр хамгийн бага тэвчлээс хамгийн их ач тусыг олон, эцэстээ аз жаргалд хэрхэн яаж хүрэхийг ярьж өгье. Пурана гэж нэрлэгддэг ведийн судруудад тодорхойлон бичсэн зүйлсийн утга учир нь сарын гэрэлтэй болоод харанхуй хагаст тохиох экадашид хоол унднаас хэрхэн яаж тэвчин татгалзахад оршдог юм. Экадашид мацаг барьснаар тамын гаригуудад унахаас аврагддаг юм².”

Вьясадевагийн үгийг хүчирхэг дайчин баатар эр Бхимасена сонсоод айхын ихээр айж, хүчтэй салхинд ганхан хөдөлж байгаа баньян модны навчис мэт салганан чичирч эхлэв. Айж цочсон тэрээр: “Ай өвөө минь ээ, би яах ёстой

болж байна вэ? Би жилийн туршид сар бүр хоёр удаа мацаг барьж чадахгүй шүү дээ. Мацаг барьснаар хамгийн дээд ач тусыг хүртэж болох нэг өдрийг надад нэрлэж хэлээч.” гэж гуйв.

Вьясадева хариулсан нь: Нар ихрийн болон үхрийн ордод зорчин байгаа үед, *Жйештха* (5-6) сарын гэрэлтэй хагаст тохиодог экадашид ус ч амсалгүйгээр мацаг барих хэрэгтэй. Номч мэргэн хүмүүс, энэ өдөр өөрийгөө цэвэрлэн ариусгахын тулд угаал болон *ачаман* хийхийг л зөвшөөрдөг гэж ярьцгаадаг. Гэхдээ *ачаман* хийхдээ алтны өөдөс эсвэл гичний үр далдлах төдий өчүүхэн бага хэмжээний усыг л залгиж болно. Зөвхөн ийм хэмжээний усыг л гарын алгаа үхрийн чих хэлбэртэй болгон хумбайлгаад дээр нь тогтоон авах хэрэгтэй. Түүнээс илүү их хэмжээтэй ус уух аваас архи дарс уусан мэт согтох болно. Энэ өдөр ерөөсөө юм идэж болохгүй. Энэхүү нарийн чанд мацаг нь экадашид нар мандахаас эхлэн *двадашид* нар мандах үе хүртэл үргэлжилдэг. Хэрвээ энэ экадашийг маш нарийн чанд баримталж чадах аваас бүтэн жилийн туршид бүх 24 экадашийг баримталсантай адил тийм ач тус, үр шимийг хүртэх болно.

Двадашийн өглөө эрт угаал үйлдэх ёстой. Үүний дараагаар тогтоосон дүрэм журмын дагуу, өөрийн боломжоосоо хамааран бага зэргийн алт болон усыг зохистой брахманд өргөх хэрэгтэй. Ай Бхимасена минь ээ, энэхүү экадашийг баримталж байгаа хэн бүхэн жилийн бүх экадашийн үр шим, ач тусыг хүртдэг. Үүнд ямар ч эргэлзээ байхгүй.

Харин одоо, ай Бхишма минь ээ, энэхүү экадашийг баримтлахын ач тусын талаар сонс. Дун, галт хүрд, шийдэм болон бадамлянхуа цэцэг мутартаа барьсан Бүхний Дээд Бурхан: “Хэн бүхэн Надаас өмөг түшиг, аврал ивээл эрэн, Миний айлдвар сургаалыг дагах ёстой.” гэж надад айлдсан билээ. Тэр мөн, энэхүү экадашийг баримтлах хэн бүхэн бүх нүглийнхээ үр дагавраас чөлөөлөгдөн ангижрана гэж айлдсан. *Жйештха-шукла* экадашид Ниржала мацгийг нарийн чанд баримтлах хэн бүхэн бусад бүх экадашуудыг бүгдийг нь баримталсан шиг тийм л ач тусыг үнэхээрийн хүртдэг.

Ай Бхимасена минь ээ, цаг хугацааны явцад Ведийн журам дүрэм хийгээд зан үйл ёслолыг зөв баримтлах болон тахилга өргөлийг зөв өргөх явдал огтын боломжгүй болдог, ведийн зарчмууд хөсөр хаягдан гишгэгддэг, хэрүүл тэмцэл хийгээд бялангач байдлын эрин *Кали югад* тэгээд яаж ариусах болж байна вэ? Иймээс, экадашид мацаг барих- энэхүү тохиромжтой, зохистой бололцоог хүн ер алдаж болохгүй. Тэгснээр тэр өөрийн өнгөрсөн үед үйлдсэн бүх нүглүүдээс чөлөөлөгдөн ангижрана.

Ай Вайюгийн хүү минь ээ, би чамд өөр юу хэлэх билээ дээ. *Жйештха-шукла* экадашийн онцгой өршөөл ивээлт энэхүү өдөр ус ч ууж болохгүй. Ай Врикодара минь ээ, энэхүү экадашийг баримталж байгаа хэн бүхэн ариун мөргөлийн бүхий л газруудад угаал үйлдсэн, бүхий л хэлбэрийн өглөг тараасан болон жилийн бүх харанхуй болоод гэрэлтэй хагаст тохиодог экадашуудыг баримталсантай адил ач тус, үр шимийг хүртдэг. Үүнд ямар ч эргэлзээ байхгүй. Ай хүмүүсийн дундахь бар минь ээ, энэ экадашид мацаг барьсан хэн бүхэн үнэхээрийн аугаа болж эд баялаг, хүч чадал болон эрүүл мэнд зэрэг бүгдийг хүртдэг. Мөн үхлийн аймшигт мөчид, ид шидэт цалам- *паша-гаа* агаарт хий эргэлдүүлэн, бороохойгоо далайн заналхийлж сүрдүүлэх, хар болоод шар өнгийн биетэй *ямадута* нар ч түүнд ойртож чадахгүй. Харин ч ийм чин бишрэлт сүнсийг дөрвөн мутартаа галт хүрд, шийдэм, дун болон бадамлянхуа цэцэг барьцгааж, трансценденталь гоо сайхан биедээ тансаг сайхан шар өнгийн өмсгөл өмссөн *вишнудута* нар Бурхан Вишугийн залрах орон тийш тэр дор нь л бараа болж дагалдан хүргэдэг. Энэхүү маш чухал экадашийг ус ч амсалгүйгээр нарийн чанд баримтлах аваас энэ бүх ач тусыг хүртэх болно.

Жйештха-шукла экадашийг баримталснаар хүртэх ач тусын талаар Пандавчууд сонсоод, түүнийг Шрила Вьясадевагийн Бхимасенад тайлбарласан

шиг тэгж баримтлахаар шийдсэн. Пандавчууд бүгдээрээ түүнийг ус ч амсалгүйгээр баримталсан. Иймээс энэ экадашийг одоо Пандава Ниржала *двадаши*³ гэж нэрлэдэг.

Шрила Вьясадева цааш нь үргэлжлүүлэн хэлсэн нь: Ай Бхима минь ээ, энэ экадашийг баримталснаар чи бүх нүглээсээ салан ангижрах болно. Харин чи Бурханы Дээд Бодьгал, Шри Кришнад: “Ай бүх бурхдын Бурхан минь ээ, ай Бурханы Дээд Бодьгал минь ээ, би энэхүү экадашийг ус ч амсалгүйгээр баримтлах болно. Ай нүгэл үгүй Ананта минь ээ, би энэ мацгаа дараагийн өдөр, *двадашид* тайлах болно.” гэж залбирах хэрэгтэй. Бүх нүглээсээ салан ангижрахын тулд чин бишрэлтэн нь энэ үеэс эхлэн өөрийн мэдрэхүйгээ эзэмдэн захирч Бурханд итгэж бишрэн, экадашийн мацгийг үнэнчээр барих хэрэгтэй. Түүний нүгэл нь Сумеру уул шиг ч байна уу, эсвэл Мендарачала толгой шиг ч байна уу гэдэг нь чухал биш. Хэрвээ тэрээр энэхүү экадашийг баримтлах аваас түүний нүгэл нь багасан үнс нурам болон юу ч үгүй болтлоо шатдаг. Экадашийн хүч ийм аугаа байдаг.

Ай хаадын шилдэг нь минь ээ, мөн тэрчлэн энэ экадашид хүн ус болон үнээг өглөг болгон тараах ёстой байдаг. Ямар нэгэн шалтгаанаас болж үүнийг хийж чадахгүй байх аваас тэр зохистой брахманд ямар нэгэн хувцас эсвэл сав бэлэг болгон өргөх хэрэгтэй. Зөвхөн ус түгээснээр л хүртэх ач тус гэхэд өдөрт 10 сая удаа алт тарааж түгээсэнтэй адил ач тусыг хүртэх болно.

Ай Бхима минь ээ, энэхүү экадашийг баримталж байгаа хүн ариун гэгээн угаал үйлдэж, дорд гуйлгачинд өглөг өгөх, *жала-мала* буюу эрхин дээр Бурханы ариун гэгээн нэр алдруудыг давтан хэлэх болон зөвлөсөн тахилга өргөлүүдээс аль дуртайгаа хийх ёстой гэж Бурхан Кришна айлдсан байдаг. Ийнхүү үйлдсэнээр тэр мөнхийн ач тусыг хүртэх болно. Зөвхөн ганц энэхүү экадашийг баримтлах нь хүнийг Шри Вишнугийн дээдийн дээд оронд хүргэдэг.

Ай Куругийн шилдэг нь минь ээ, хэрвээ хэн нэгэн энэ өдөрт алт, хувцас эсвэл өөр ямар нэгэн зүйл өргөл болгон өргөх аваас түүний хүртэх үр шим, ач тус нь мөнхийн байдаг билээ. Экадашид үр төдийг ч идсэн хүн нүглээр бузартдаг, ямар ч хоол нүгэлтэй болдог гэдгийг санаж ав. Үүний улмаас тэр нохойгоор хооллогч болох бөгөөд үхсэний дараагаар тамын гаригт унаж тэнд зовж тарчлах болно. Харин *Жйештха-шукла* экадашийг баримтлан, өглөг түгээн тарааж байгаа хэн бүхэн төрөлт үхлийн дахин давтагдах хүрднээс ангижран дээдийн дээд оронд заавал хүрэх болно. *Двадашитай* давхцах энэхүү экадашийг баримтлах нь брахманыг хөнөөсөн, согтууруулах ундаа хэрэглэсэн, өөрийн номын багшдаа атаархсан хийгээд түүний сургаал зааврыг эс анхаарсан болон худал хуурмаг үйл үйлдсэн зэрэг бузар муухай нүглүүдээс ангижруулдаг.

Ай амьд оршнолуудын шилдэг нь минь ээ, цааш үргэлжлүүлэн сонс. Бүхний Дээд Бурхан Жалашайи (усан дээр амарч байгаа Бурхан)-д бишрэл хүндэтгэлээ илэрхийлж, дараагийн нь өдөрт зохистой брахманд хамгийн сайн амттан өргөл болгож буй ямар ч хүн, эрэгтэй ч байсан эсвэл эмэгтэй ч байсан ялгаагүй Бүхний Дээд Бурхан Васудевагийн таалалд, тэдний өвөг дээдэс нь муу зан чанартай нүгэлтэн эсвэл бүр өөрийнхөө амийг егүүтгэгч байсан ч Бурханы оронд дээшлэн хүрэхээр тэгж их нийцдэг. Энэхүү экадашийг баримтлах хэн бүхэн Бурханы оронд хачин сайхан, гайхамшигт хөлгөөр үнэхээрийн дээшлэн хүрч очдог.

Энэ өдөр, брахманд домбо, шүхэр эсвэл гутал бэлэглэн өгч байгаа хэн бүхэн тэнгэрийн гаригуудад дээшлэн очиж төрдөг. Энэхүү алдаршил дуурсгалыг зүгээр л сонсож байгаа хүн ч гэсэн мөн Бурхан Вишнугийн залрах трансценденталь оронд үнэхээрийн дээшлэн хүрч очдог. Шинэ сарны өдөр (*амавасья*) өвөг дээдсээ дурсан санаж, *шраддха* зан үйлийг, ялангуяа энэ зан үйлийг нар хиртэх үед үйлдэх хэн бүхэн аугаа их ач тусыг хүртдэг нь эргэлзээгүй. Тэгвэл энэхүү үр шим, ач тусыг энэхүү экадашийн ариун гэгээн

хүүрнэлийг зүгээр л сонссон хүн хүртдэг. Энэхүү экадаши нь ийм л хүчтэй, Бурханд ийм л эрхэм байдаг бөлгөө.

Бүхний Дээд Бурхан, Кешавын таалалд нийцүүлэн, шүдээ сайтар цэвэрлэн, ямар ч хоол, ус хэрэглэлгүйгээр энэхүү экадашийг баримтлах хэрэгтэй. Экадашийн дараа өдөр нь Тривикрамын дүрээр алдаршсан Бурханы Дээд Бодьгалд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн мөргөж Түүнд ус, цэцэг, хүж болон тод гэрэлтэй зул өргөх хэрэгтэй. Дараа нь чин бишрэлтэн нь чин зүрхнээсээ: “Ай Бурхан минь ээ, ай бүхнийг аврагч минь ээ, ай мэдрэхүйн эзэн Хришикеша минь ээ, Танд усаар дүүргэсэн хир тааруу, эгэл даруухан энэхүү аяганаас өөр юу ч өргөж чадахгүй байгаа намайг өршөөн соёрхож надад ангижралыг хайрлаач.” гэж залбиран гуйх хэрэгтэй. Үүний дараагаар чин бишрэлтэн устай аягаа брахманд өргөх ёстой.

Ай Бхимасена минь ээ, экадашийн энэхүү өдөр мацаг барьсны болон өөрийн боломж хирээр өглөг түгээн тараасны дараагаар чин бишрэлтэн нь брахмануудыг хоолоор дайлах хэрэгтэй бөгөөд түүний дараагаар өөрөө *прасадамаа* дуугүй байн хүртэх ёстой.

Төгсгөлд нь Шрила Вьясадева хэлсэн нь: энэхүү өршөөл ивээлт, ариусгагч, нүглийг арилган зайлуулагч *двадашид*, миний өгүүлсний дагуу мацаг барихыг би чамд онцгойлон зөвлөж байна. Ингэж л байж чи бүх нүглээсээ ангижран, дээдийн дээд оронд хүрэх болно.

Жйештха-шукла буюу Бхимасена-ниржала экадашийн яруу алдрын тухай Брахма-вайварта Пуранаас авсан хүүрнэл ийнхүү өндөрлөлөө.

Тайлбар:

1. Галын бурхан Агни-гийн гарал язгуур: Бурхан Вишнугаас Брахма, Брахмагаас Ангираса, Ангирасагаас Брихаспати, Брихаспатигаас Агнигийн эцэг Самья төрсөн. Найрити түүнд зүүн өмнөд хаалгыг хамгаалахыг даалгасан. Тэр бол найман материаллаг элементүүдийн нэг бөгөөд Пракшит хааны нэгэн адил хэрэг явдлын туршилт шалгалтанд маш туршлагатай. Тэр нэгэн удаа тагтаа болон хувирсан Шива Махаражагийн туршилтанд эрсэдсэн билээ. (Шримад Бхагаватам, 1.12.20)

Агни-г гурван ангилалд хуваадаг. Девагни- модны гал, Жатхарагни- ходоодон дахь хоол боловсруулж шингээх гал, Вадавагни- далай дээр хүйтэн халуун хоёр тулгаран манан үүсгэдэг гал. Ходоодны галыг өөрөөр Врика гэж нэрлэдэг бөгөөд энэ бол Бхимасенагийн ходоодон дотор дүрэлзэн байгаа тэр хүчирхэг гал билээ.

2. Шримад Бхагаватамын (12.13.12 болон 12.12.15)-д заасанчлан, Бхагаватам нь Ведантын бүхий л гүн ухааны охь дээж болдог (*сара-веданта-сарам*). Бхагаватамын үндсэн гол сургаал номлол бол- Бурхан Кришнад өөрийгөө бүрнээ даатган, Түүнд хайр, чин бишрэлтэйгээр зүтгэх явдал юм. Экадашийг нарийн чанд баримтлах нь энэ үйл явцад маш их тус нэмэр болдог бөгөөд энд Шрила Вьясадева экадашийн чухлыг онцлон тэмдэглэж байна.

3. Одон зурхайн мацаг *двадашид* тохиосон байсан ч ведийн соёл иргэншилд түүнийг мөн л экадаши гэж нэрлэдэг.

ЙОГИНИ ЭКАДАШИ

Юдхитхира Махаража айлтгасан нь: Ай Бүхний Дээд Бурхан минь ээ, *Жйештха* сарын гэрэлтэй хагаст тохиодог Ниржала экадашийн яруу алдрын

тухай сонсон хүртлээ. Одоо Та надад *Ашадха* (6-7) сарын харанхуй хагаст тохиодог экадашийн тухай нээн хүртээнэ үү. Ай Мадху демоныг хөнөөн дарагч минь ээ, Та намайг өршөөн соёрхож тэр тухай нарийн тодорхой айлдан соёрхоно уу?

Бүхний Дээд Бурхан Кришна айлдсан нь: Ай хаан минь ээ, Би чамд мацаг барих бүх өдрүүдээс шилдэг нь болох *Ашадха* сарын харанхуй хагаст тохиодог экадашийн талаар айлдъя. Йогина экадаши нэрээр алдаршсан энэ экадаши нь бүх хэлбэрийн нүглийн үр дагавруудыг устган зайлуулж дээдийн дээд ангижралыг хүртээдэг билээ.

Ай хаадын шилдэг нь минь ээ, энэхүү экадаши нь материаллаг оршнолын хүрээ хязгааргүй далайд живэн байгаа хүмүүсийг авран, тэднийг бурханлаг ертөнцийн эрэгт хүргэдэг. Энэ экадаши нь бүхий л гурван ертөнцийн хүрээнд мацгийн бүх ариун гэгээн өдрүүдээс гол чухал нь юм. Би чамд Пурануудад бичсэн нэгэн түүхийг айлдан энэхүү үнэнийг нээн хүртээе.

Алакапурын хаан, хагас бурхдын сан хөмрөгийг хариуцагч Кувера нь Шива бурханы гуйвалтгүй чин бишрэлтэн байсан бөгөөд Хемамали нэртэй нэгэн албат түүний хувийн цэцэрлэгчин байв. *Якша* Хемамали нь дур булаам хөөрхөн нүдтэй үзэсгэлэн гоо эхнэр Сварупаватидаа ихэд татагддаг байж. Хемамали өдөр бүр Маносаровара нуурын эрэгт очиж, тэндээс өөрийн эзэн Куверын Шива бурханд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэхэдээ хэрэглэдэг цэцгийг түүж ирдэг байв. Нэгэн удаа тэр цэцгээ түүсний дараагаар эзэндээ шууд хүргэж өгөн үүргээ биелүүлэхийн оронд эхнэр лүүгээ явсан. Эхнэртэйгээ хайр дурлалын зугаа цэнгэлд автсан тэрээр хорвоо дээрх бүхнийг ор тас мартсан байлаа.

Ай хаан минь ээ, Хемамалиг эхнэртэйгээ ийнхүү таашаал ханамж эдэлж байхад Кувера ордондоо Шива бурханд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн мөргөл залбиралаа эхэлсэн бөгөөд үдийн *луца-д* хэрэглэгдэх ёстой цэцгийг нь бэлтгээгүй байгааг олж мэдсэн. Цэцэг бэлэн биш байгаад уурлаж хилэгнэсэн аугаа хагас бурхан зарлага *якшаг*: “Шалиг Хемамали өдөр тутмын өргөлд минь цэцэг яагаад авчраагүй юм бэ? Учир шалтгааныг нь сайтар олж мэдээд надад биечлэн мэдэгд.” гэж хэлээд явуулсан. *Якша* буцаж ирээд Куверад хэлсэн нь: Ай эзэн минь ээ, Хемамали эхнэртэйгээ нууж хаалгүйгээр бэлгийн таашаал ханамж эдэлж байна.

Үүнийг сонсоод Кувера маш ихээр уурлаж хилэгнэн дорд албат Хемамалиг өөр дээрээ дуудан ирүүлсэн. Оноогдсон үүргээ үл тоомсорлосноо мэдсэн Хемамали маш ихээр айж эмээн, уурлаж хилэгнэснээс болж нүд нь улаанаар эргэлдэж, уруул нь татваганан чичигнэх эзнийхээ өмнө ирэн хүндэтгэлээ илэрхийлэв. Галзууртлаа уурлаж дошгирсон Кувера Хемамали руу: “Ай үнэнч бус нүгэлтэн минь ээ, шашин номын зарчмыг зөрчин гажуудуулагч минь ээ, чи хагас бурхдыг басамжлан доромжлов. Иймээс би чамайг амраг хайртай эхнэрээсээ салан хагацаж, цагаан уяман өвчин тусан зовж шанал гэж харааж байна. Чи маш ихээр зовж шаналж байваас зохилтой. Дорд төрөлт мунхаг минь ээ, чи одоо энэ орныг орхин доод гаригууд дээр очсугай.” гэж хашгирав.

Ийнхүү Хемамали нүд ирмэх зуурт л Алакапурагаас доош унан аймшигт цагаан уямангаар өвчилсөн байлаа. Тэрээр ямар ч хоол ундгүйгээр, айдас хүрмээр балар битүү ойд байж байсан. Хемамали өдрийг нь зовж шаналан, шөнө нь өвчнөөсөө болж унтаж ч чадахгүй байлаа. Тэр өвөл зунгүй зовж шаналж байсан ч Шива бурханд үнэн голоосоо үргэлжлүүлэн мөргөн залбирч байсан учраас түүний ухамсар нь цэвэр ариун хийгээд бат тогтвортой байлаа. Өнгөрсөн амьдралдаа зөв, шудрага байсан учраас аймшигт нүгэл болон түүний үр дагаварт ороогдож тушигдсан байсан ч тэр өөрийн өнгөрсөн амьдралаа санаж байв.

Хемамали уул талаар хэрэн тэнүүчилсээр эцэстээ өндөр сүрлэг Гималайн нуруунд тулж ирсэн. Тэнд түүнд маш их зол завшаан тохиож, амьдрал нь Брахмын 7 өдрийн¹ туршид үргэлжилдэг гэж ярьдаг тэвчил наманчлал

үйлдэгчдээс шилдэг нь болох аугаа гэгээнтэн Маркендейя Риши-тай учирсан. *Ашрамдаа* тайван амгалан сууж байсан Маркендейя нь Брахма лугаа туяаран байлаа. Хемамали өөрийгөө маш их нүгэлтэй гэж үзсэн учраас гэгээнтнээс зохистой хол зайнд зогсон түүнд гүн хүндэтгэл үзүүлэн залбирал магтаал хэлэв.

Бусдын төлөө үргэлж санаа тавьж байдаг Маркендейя уяман өвчтэй түүнийг хараад: “Энэ аймшигт зовлон шаналалыг эдлэхээр ямар нүгэлт үйлийг чи үйлдсэн юм бэ?” гэж асуусан. Түүний хэлсэн энэ үгийг сонсоод Хемамали хариулсан нь: Ай эрхэм минь ээ, би бол Кувера бурханы албат, *якша* билээ. Намайг Хемамали гэдэг. Миний өдөр тутмын алба үйл бол өөрийн эзэндээ, Шива бурханд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн залбирал мөргөл үйлдэхэд нь зориулан Маносаровара нуурын дэргэдээс цэцэг түүж авчрах явдал байсан. Гэвч, нэгэн удаа би үзэсгэлэн гоо эхнэртээ дур булаагдан татагдсанаас болж өргөл болгон өргөх цэцгийг нь авчраагүй. Намайг яагаад байхгүй байгааг мэдээд миний эзэн маш ихээр уурлаж хилэгнэн намайг хараасан бөгөөд одоо би гэр орон, эхнэр болон алба үйлээсээ салан энд байж байна. Гэвч зол завшаанаар би тантай учран танаас аугаа их адислалыг хүртэж чадахаар болж байна. Учир нь Бүхний Дээд Бурханы чин бишрэлтэнгүүд нь өөрсдийн зүрхэндээ бусдын төлөө үргэлж санаа тавьж байдаг гэдгийг би мэдэх билээ. Энэ бол тэдний аугаа мөн чанар. Ай гэгээнтнүүдийн шилдэг нь минь ээ, надад туслаж хайрлана уу².

Маркендейя Риши хариулсан нь: Чи надад үнэнээ хэлсэн учир би чамд аугаа ач тус авчрах мацаг барих өдрийн тухай өгүүлье. Хэрвээ чи *Ашадха* сарын харанхуй хагаст тохиох экадашид мацаг барих аваас аймшигт хараалаас ангижран салах нь эргэлзээгүй. Энэ адислалыг сонсоод Хемамали баяр хөөрөөр дүүрэн газар унан гэгээнтнийг алдаршуулан магтан дуулж эхлэв. Харин Маркендейя юутай ч харьцуулшгүй аз жаргалаар бялхан байгаа Хемамалиг зогсоон, газраас өргөн босгов. Хемамали экадашид мацгийг гэгээнтний зааж зөвлөсний дагуу нарийн чанд барьсан. Үүнийхээ ач тусаар тэр урьдын адил *якша* болон гэртээ эргэн очиж, эхнэртэйгээ аз жаргалтайгаар амьдарсан³.

Бурхан Кришна төгсгөлд нь: “Ай Юдхитхира минь ээ, Йогини экадашийн мацаг нь маш хүчирхэг бөгөөд өршөөл ивээлтэй. Энэхүү ариун гэгээн экадашид мацаг барьсан хэн бүхний өнгөрсөн үеийн нүглийн хуримтлагдсан үр дагаврууд нь устан арилах бөгөөд тэрээр ач тустай зөв шудрага болдог. Иймээс л Би чамд Йогини экадашийн цэвэр ариуны тухай тайлбарлаж байна.” гэж айлдав.

Йогини экадашийн буюу Ашадха-Кришна экадашийн яруу алдрын тухай Брахма-вайварта Пуранаас авсан хүүрнэл ийнхүү өндөрлөлөө.

Тайлбар:

1.Брахмын нэг өдөр (12 цаг) нь *Сатья, Трета, Двапара* болон *Кали* гэсэн дөрвөн юга буюу эрингүүдээс бүрдэх 1000 циклээс тогтдог. Энэ дөрвөн юга нь 4 320 000 жил үргэлжилдэг тул Брахмын бүтэн өдөр буюу нэг хоног нь 8 640 000 000 жил үргэлжилдэг. Харин долоон ийм өдөр нь 60 480 000 000 жил үргэлжилдэг.

2.Ведийн сургаалд батлан өгүүлсэнчлэн:

Гол өөрийн усыг уудаггүй ч өөрийн ач тусаа бусдад өгч, үзүүлж байдаг. Үр жимс нь дэлгэрсэн мод өөрийн үр жимсээ иддэггүй ч тэднийг бусдад өгч байдаг. Үүл өөрийн бороог өөртөө шингээдэггүй ч түүнийг бусдын төлөө оруулж байдаг. Үүнтэй адилаар ариун гэгээн хүмүүс зөвхөн бусдын төлөө л амьдарч байдаг.

Чанакья Пандит хэлсэнчлэн:

Кришнын цэвэр чин бишрэлтэнг ажиглаж бясалгах нь мөргөлийн ариун дагшин газраар явснаас илүүтэй ариусгадаг. Учир нь ариун гэгээн газар орон нь тодорхой хугацааны хойно ариусгадаг бол цэвэр чин бишрэлтэнг харсанаар хоромхон зуурт, тэр дороо л ариусдаг.

3.Хемамали нь эхнэр лүүгээ, тэнгэрийн гаригууд тийш буцаж очихыг хүсэж байсан учраас түүний баримталсан экадаши нь түүний хүслийн дагуу материаллаг үр дүн авчирсан. Тэгэхэд Кришнын чин бишрэлтэнгүүд нь Бурханд зүтгэх өөрсдийн чин бишрэлээ нэмэгдүүлэхийг хүсэн экадашийг баримталдаг бөгөөд тэд ингэж л бурханлаг шагналыг хүртдэг.

ПАДМА ЭКАДАШИ

Юдхиштира Махаража айлтгасан нь: Ай Кешава минь ээ, *Ашадха* (6-7) сарын гэрэлтэй хагаст тохиодог экадашийг юу гэж нэрлэдэг вэ? Түүнийг яаж баримталдаг вэ? Энэ ариун гэгээн өдөр ямар Бурханд бишрэл хүндэтгэлээ илэрхийлдэг вэ?

Бурхан Кришна хариу айлдсан нь: Ай газар дэлхийн сахин хамгаалагч минь ээ, Брахма бурханы өөрийн хүү Нарадажид өгүүлсэн нэгэн түүхийг Би чамд айлдъя. Нарада эцэгтээ хандан: “*Ашадха* сарын гэрэлтэй хагаст тохиодог экадашийг юу гэж нэрлэдэг вэ? Бүхний Дээд Бурхан Вишнугийн таалалд нийцүүлэхийн тулд энэхүү экадашийг хэрхэн яаж баримтлах ёстойг та надад өгүүлэх ажаам уу.” гэж хэлсэн.

Брахма бурхан хариулсан нь: Ай аугаа уран яруугаар номлол айлдагч минь ээ, ай бүх гэгээнтэнгүүдийн шилдэг нь минь ээ, ай Бурхан Вишнугийн хамгийн цэвэр ариун чин бишрэлтэн минь ээ, чи маш эрхэм сайн асуултыг надаас асуулаа. Энэ ертөнцөд Хари Бурханы өдөр, экадашаас илүү өөр ямар ч зүйл байдаггүй билээ. Хэрвээ түүнийг зөв баримтлах аваас хамгийн хүнд нүгэл хилэнц хүртэл устаж үгүй болдог. Иймээс би чамд *Ашадха–шукла* экадашийн тухай өгүүлж байна.

Энэхүү экадаши дахь мацаг нь бүх нүглийг арилган зайлуулж, бүх хүслийг биелүүлдэг. Иймээс мацаг барих энэхүү ариун гэгээн өдрийг баримтлахыг эс тоомсорлон, хайхрамжгүй хандах хэн бүхэн тамд унах замаа шулуутгаж байгаа хэрэг. *Ашадха-шукла* экадаши нь мөн Падма экадаши гэдэг нэрээр алдаршсан. Мэдрэхүйн эзэн Хришикешагийн таалалд нийцүүлэхийн тулд энэхүү өдөр мацаг барих хэрэгтэй. Ай Нарада минь ээ, энэхүү экадаштай холбоотой, сударт бичигдсэн байдаг нэгэн гайхамшигт түүхийг анхааралтай сонс. Энэ түүхийг сонссоноор л бүх хэлбэрийн нүгэл устан бурханлаг төгс төгөлдөрийн зам мөр дээрх бүх саад тотгор арилан үгүй болно.

Ай хүү минь ээ, урьдын нэгэн цагт нарны удмынханд Мандхата гэдэг нэртэй нэгэн хаан байжээ. Тэр үргэлж үнэний талд зогсож, албат иргэддээ өөрийн хүүхдүүд мэтээр санаа тавьдаг байлаа. Түүний зөв шудрага зан байдал болон маш их шүтлэг бишрэлийн ачаар улс гүрэнд нь ган гачиг болж, тахал болоод өөр ямар нэгэн өвчин гарч байсангүй. Бүх албат иргэд нь зөвхөн таагүй байдлаас ангид байсан төдийгүй маш их баян чинээлэг байлаа. Хааны сан хөмрөгт буруу замаар олж хураасан мөнгө гэж байгаагүй бөгөөд тэрээр олон жилийн туршид улс гүрнээ аз жаргалтайгаар захирч байлаа.

Тэгсэн хэдий ч, түүний улс гүрэнд ямар нэгэн нүглээс болж гурван жил дараалан үргэлжилсэн маш аюултай ган гачиг болж албат иргэд нь өлсгөлөнд нэрвэгдэх аюул тулгарсан. Үр тариа дууссанаас болоод өвөг дээдэс хийгээд хагас бурхдад тахилга өргөл өргөн, бишрэл хүндэтгэлийн зан үйл үйлдэх, тэр ч бүү хэл Ведийг судлах ч боломжгүй болсон. Эцэстээ албат иргэд нь өөрсдийн эрхэмлэн хүндэтгэж хайрладаг эзэн хаандаа бараалхан гүн хүндэтгэлтэйгээр хэлсэн нь: “Ай хаантан минь ээ, бидний сайн сайхны төлөө та үргэлж санаа тавьж байсан билээ. Бид одоо таны тусламж дэмжлэгийг хүлцэнгүйгээр хүсэн

хүлээж байна. Энэ ертөнцөд, бүгдэд ус хэрэгтэй. Усгүй бол хэн бүхний тамир тэнхээ муудан үхдэг билээ. Ведэд усыг *нара* гэж нэрлэдэг. Бурханы Дээд Бодьгал усан дээр хажуулан байдаг учраас Түүнийг Нараяна гэж нэрлэдэг. Бурхан усан дотор Өөрийн оронг бүтээж тэндээ залардаг билээ¹. Тэнгэрийн оронд ч Бүхний Дээд Бурхан үүлэн дунд залран бороо оруулж байдаг бөгөөд үүний ач тусаар бүхий л амьд оршнолуудыг тэжээн тэтгэдэг үр тариа ургадаг. Ай хаан минь ээ, ган гачиг болсноос талх тариа ихээр дутагдаж байна. Бид бүгдээрээ зовж шаналан, хүн амын тоо цөөрч байна. Газар дэлхий дээрх төр баригчдын шилдэг нь минь ээ, энэ хүндрэл бэрхшээлтэй байдлыг шийдвэрлэн албат иргэд бидэндээ тайван амгалан хийгээд энх мэндийг хайрлаач.

Хаан хариулсан нь: Та нар үнэнийг өгүүлж байна. Талх бол үр тарианд оршин байдаг хийгээд бүх амьд оршнолуудыг тэжээн тэтгэж байдаг Үнэмлэхүй Үнэн- Брахман лугаа юм. Дэлхий даяраа талхаар л хооллон, түүгээр л амьдардаг гэдэг нь эргэлзээгүй хэрэг. Манай улс гүрэнд яагаад ийм айхавтар ган гачиг болоод байна вэ? Ариун гэгээн судруудад өгүүлсэний дагуу бол, улс гүрний хаан нь бурхангүй үзэлтэй байх аваас тэр өөрөө болон түүний албат иргэд нь зовж шаналдаг. Бидэнд тохиолдоод байгаа энэхүү гай гамшгийн учир шалтгааны талаар би удаан хугацаагаар эрэгцүүлэн бодож үзлээ. Би өөрийн өнгөрсөн болоод одоо үеэ хараад ч ямар нэгэн нүгэлт зүйл байгааг олоогүй гэдгээ шударгаар хэлье. Гэсэн ч миний албат иргэд болсон та бүгдийн сайн сайхны төлөө нөхцөл байдлыг залруулан сайжруулахаар би бүх хүч чадлаа зориулах болно.

Ийнхүү хэлээд Мандхата хаан өөрийн цэрэг армия хуралдуулан, надад хүндэтгэлээ илэрхийлээд ойг зүглэн довтолгоцгоолоо. Тэд нилээд их хэрэн явж, аугаа мэргэдийн *ашрамуудаар* очиж улс гүрнээ ядуурал хоосролоос хэрхэн яаж ангижруулах талаар асууж байлаа. Эцэст нь тэр миний хөвгүүдийн нэг Ангира Мунигийн *ашрамд* хүрч очсон. Аглаг зэлүүд газар орших өөрийн оромжиндоо суугаа Ангира Муни нь хоёрдагч Брахма лугаа харагдаж байсан ба түүнээс зүг бүртээ гэрэл цацарч байв.

Мандхата хаан энэхүү аугаа гэгээнтнийг хараад үгээр илэрхийлэхийн аргагүй ихээр баярлаж яаравчлан, Ангира Мунигийн бадамлянхуа өлмийд гүн хүндэтгэл бишрэлээ илэрхийлсэн. Дараа нь хаан алгаа хавсран, гэгээнтнээс адислал хайрлахыг залбиран гуйсан. Муни хааныг ариун гэгээн мантрагаар адислаж ерөөсний дараагаар Мандхата хаанаас хааны гэр бүл болон хаан төрийг бүрдүүлэгч тулгуур долоон баганын нь амар мэндийг лавлан асуусан.

Хаант төрийн долоон тулгуур баганынхаа тухай өгүүлэнгээ Мандхата хаан гэгээнтний өөрийн нь амар амгаланг асуулаа. Дараа нь хаан өөрийн улс гүрэндээ тохиолдоод байгаа ядуурал хоосролын тухай өгүүлсэн. Ийнхүү Ангира Риши, хааныг ой дундуур ийн хүнд бэрх замыг туулан ирсэний учир шалтгааны сонсож мэдлээ. Хаан хэлсэн нь: Ай аугаа гэгээнтэн минь ээ, би өөрийн улс гүрнээ ведийн сургаалын дагуу залан жолоодож байдаг бөгөөд бидэн дээр дарж овоороод байгаа энэ гай зовлонгийн учир шалтгааныг ойлгохгүй байна. Таныг бидэнд тус болно гэдэгт найдаж байна. Албат иргэдээ гай зовлонгоос ангижруулахад минь та надад туслаач.

Ангира Риши хаанд хэлсэн нь: Одоогийн энэ эрин *Сатья юга* нь бүх эрингүүдээс хамгийн шилдэг нь байдгийн учир нь гэвэл түүний *дхарма* нь дөрвөн хөл² дээрээ зогсож байдаг оршдог. Энэ эринд хүн бүр л брахмануудыг нийгмийн ахмад гишүүдийн адилаар хүндэтгэн үздэг. Түүнээс гадна хүн бүр өөрт оноогдсон үүргээ биелүүлж байдаг бөгөөд зөвхөн хоёр дахиа төрсөн брахманууд л ведийн тэвчил наманчлал үйлдэхийг зөвшөөрдөг. Гэвч, танай улс гүрэнд, ай хаадын дундах арслан минь ээ, энэхүү дүрэм журам байсаар байтал ведийн тэвчил наманчлалыг хууль бусаар үйлддэг нэгэн *шудра* байна. Ийм учир шалтгаанаас болж л танай улс орны нутаг дэвсгэрт бороо хур орохгүй байна. Чи түүнд цаазаар авах ял оноох хэрэгтэй. Энэхүү бузардалтыг арилган

зайлуулснаар, чи өөрийн албат иргэддээ тайван амгалан амьдралыг буцаан авчрах болно.

Хаан: “Тэвчил наманчлал үйлдэж байгаа хүнийг би яахин хөнөөж болох билээ? Та надад үүнээс өөр гарц, арга замыг зааж өгөөч.” гэж халаглан хэлэв. Тэгээд аугаа гэгээн Ангира Муни хэлсэн нь: Ай хаан минь ээ, чи *Ашадха* сарын гэрэлтэй хагасын экадашид мацаг барих хэрэгтэй. Энэхүү өршөөл ивээлт өдрийг Падма экадаши гэж нэрлэдэг бөгөөд түүний хүчээр чиний улс гүрэн хангалттай хэмжээний үр тариатай болох нь эргэлзээгүй хэрэг. Энэ экадаши нь түүнийг үнэн голоосоо баримтлах хэн бүхэнд төгс байдлыг хүртээн, муу үйлийн үр дагаврыг устган зайлуулж, төгс төгөлдөрт хүрэх зам мөрийг нь учрах бүх саад тотгоруудаас чөлөөлдөг. Ай хаан минь ээ, чи болон чиний ойр дотнынхон, мөн чиний албат иргэд—бүгдээрээ энэ ариун гэгээн экадашид мацаг барих хэрэгтэй. Тэгсэн цагт чиний улс гүрэнд бүх юм сайн сайхан болж, өршөөл ивээл та бүхэнд буцан эргэж ирэх болно.

Энэ үгүүдийг сонсоод хаан гэгээнтэнд хүндэтгэлээ илэрхийлээд ордныхоо зүгт буцлаа. Падма экадаши болох үед Мандхата хаан өөрийн улс гүрний бүх *брахмана, кшатрия, вайшья* болон *шудра* нарыг цуглуулан мацгийн энэхүү чухал өдрийг баримтлахыг зарлиг болгов. Мацгийн дараагаар, гэгээнтний урьдчилан хэлсэнчлэн, бороо хур орон тариа ногоо сайн ургаж арвин их ургац авсан. Мэдрэхүйн эзэн, Бүхний Дээд Бурхан, Хришикешийн өршөөл нигүүлслээр Мандхата хааны бүх албат иргэд дээдийн дээд аз жаргал хийгээд хөгжил цэцэглэлтэнд хүрсэн. Иймээс, ай Нарада минь ээ, жинхэнэ цэвэр чин бишрэлтэнд бүхий л төрлийн аз жаргал, мөн тэрчлэн дээдийн дээд ангижралыг хайрлан хүртээдэг энэхүү экадашид хүн бүр мацгийг нарийн чанд барих хэрэгтэй.

Бурхан Кришна төгсгөлд нь айлдсан нь: Ай эрхэм Юдхиштхира минь ээ, Падма экадаши нь, зөвхөн түүний яруу алдрын тухай сонссон эсвэл уншсан хэн бүхэн нүглээс бүрнээ ангижирдаг тийм л хүчирхэг билээ. Ай Пандава минь ээ, Намайг цэнгүүлэхийг хүсэж байгаа хүн мөн Дева-шаяни экадаши³ гэж алдаршсан энэхүү экадашийг баримтлах хэрэгтэй. Ай хүмүүсийн дундах арслан минь ээ, ангижралд хүрэхийг хүсэж байгаа хүн, *Чатурмасья* мацгийн эхлэл болдог энэхүү экадашид заавал мацаг барих ёстой байдаг.

Падма экадаши буюу Ашадха-шукла экадашийн яруу алдрын тухай Бхавишья-уттара Пуранаас авсан хүүрнэл ийнхүү өндөрлөлөө.

Тайлбар:

1. Гурван зүйлийг усгүйгээр оршин тогтнож чаддаггүй гэж ярьдаг. Үүнд сувд, хүн болон гурил ордог. Сувдны мөн чанар нь гялалзан байдагт оршдог бөгөөд энэхүү гялалзах байдал нь зөвхөн усны ач тусаар л боломжтой болдог. Мөн хүний мөн чанар нь үрд оршдог бөгөөд үрийн гол бүрэлдхүүн хэсэг нь ус байдаг. Гурил нь усгүйгээр зуурмаг болдоггүй тул хоол хүнс бэлтгэхэд ашиглах боломжгүй байдаг. Заримдаа усыг *жаланараяна* буюу ус дүрд байгаа Бүхний Дээд Бурхан гэж нэрлэдэг.

2. *Дхармын* дөрвөн хөл: үнэнч шудрага зан байдал, тэвчил наманчлал, энэрэл нигүүлсэл болон цэвэр ариун байдал.

3. Дева-шаяни буюу Вишну-шаяни нь Бурхан Вишну бүх хагас бурхдын хамтаар нойрсдог өдрийг заадаг. Энэ өдрөөс хойш *Картика* (10-11) сард тохиодог Деватхани экадаши хүртэл өршөөл ивээл бүхий зан үйлийг үйлдэх хэрэггүй байдаг. Учир нь нойрсож байгаа хагас бурхад тахилга өргөл үйлдэж буй газар оронд хүрч ирдэггүй.

КАМИКА ЭКАДАШИ

Юдхитхира Махаража айлтгасан нь: Ай Бүхний Дээд Бурхан минь ээ, би Танаас *Ашадха* сарын гэрэлтэй хагаст тохиодог Дева-шаяни экадаши дахь мацгийн яруу алдрын тухай сонсож хүртсэн билээ. Харин одоо Та надад *Шравана* (7-8) сарын шинэ сарны хоёр долоо хоногийн экадашийн талаар айлдан соёрхоно уу. Ай Говинда минь ээ, намайг өршөөн соёрхож, түүний яруу алдрын талаар айлдаж хайрлана уу. Ай Васудева минь ээ, Танд би гүн бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн мөргөө.

Бүхний Дээд Бурхан, Шри Кришна хариу айлдсан нь: Ай хаан минь ээ, анхааралтай сонс, Би чамд бүх нүглийг арилган зайлуулагч энэхүү ариун гэгээн өдрийн өршөөл ивээлт үйлчлэл нөлөөний талаар тодорхойлон айлдъя. Энэ талаар нэгэн удаа Нарада Муни Брахма бурханд хандан: “Ай бүхний эзэн минь ээ, ай бадамлянхуа ширээнээ залрагч минь ээ, *Шравана* сарын харанхуй хагасын экадашийг юу гэж нэрлэдэг вэ? Энэ өдөр ямар Бурханд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн мөргөдөг вэ? Ямар дүрэм журмыг баримтлах ёстой вэ? Түүнийг баримталснаар ямар ач тус хүртдэг талаар надад нээн хүртээх ажаам уу.” гэж хэлэхэд Брахма бурхан хариулсан нь: Ай хайртай хүү Нарада минь ээ, бүх хүн төрөлхтний тусын тулд би чиний асуусан бүхэнд чинь баяртайгаар хариулъя. Учир нь Камика экадашийн яруу алдрыг зүгээр л сонссон хүн мориор тахилга өргөл өргөсөнтэй адил ач тусыг хүртдэг билээ. Дун, галт хүрд, шийдэм болон бадамлянхуа цэцэг мутартаа барьсан дөрвөн мутарт Гададхара Бурханы бадамлянхуа өлмийг бясалган, мөн Шридхара, Хари, Вишну, Мадхава болон Мадхусудана гэж нэрлэгддэг Түүнд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн мөргөх хэн бүхэн аугаа их ач тусыг хүртдэг. Бурхан Вишнуд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн мөргөснөөр хүртэх адислал Каши (Варанаси), Наймишаранья ой эсвэл намайг бишрэн мөргөл үйлддэг Пушкара¹ зэрэг газар оронд Ганга мөрний усанд ариун гэгээн угаал үйлдсэнээр хүртэх адислалаас олон дахин илүү байдаг.

Бурхан Кришнад бишрэн мөргөх хүний Камика экадашийг баримталснаар хүртэх ач тус буюу шагнал нь Гималайн ууланд Кедаранатхи Бурханаас *даршан* хүртсэн, эсвэл нар хиртэх үед Курукшетрад угаал үйлдсэн, эсвэл газар дэлхийг ой мод болон далай тэнгистэй нь хамтаар өглөг болгон өгсөн, эсвэл Юпитер арслангийн ордод зорчин байх үед нэг дэх өдөр (даваа гаригт, Орч.) тохиох бүтэн сартай өдөр Гадавари юм уу, эсвэл Гандаки голд угаал үйлдсэнээс илүү байдаг. Камика экадашийг баримтлах нь тугалтай, сүүтэй үнээг тэжээлийн нь хамт өргөл болгон өргөсөнтэй адил ач тустай. Энэхүү өдөр Шридхарадева, Вишну Бурханд бишрэн мөргөж байгаа хэн бүхнийг хагас бурхад, *гандхарванууд, паннагууд* болон *наганууд* хүндэтгэдэг билээ.

Нүгэл хилэнцээр дүүрэн байдаг материаллаг амьдралд бүрнээ төөрөлдөн, өөрийн өнгөрсөн үедээ үйлдсэн нүгэлт үйлүүдийнхээ үр дагавруудтай тэмцэлдэн байгаа хүн экадашийн шилдэг нь болох энэхүү экадашийг өөрийн ач тусын төлөө, өөрийн боломжийн хирээр баримтлах хэрэгтэй бөгөөд тэгснээрээ тэр ангижралд хүрнэ. Нүглийг арилган зайлуулахдаа илүү хүчирхэг энэхүү өдөр бол бүх өдрүүдээс цэвэр ариун нь бөлгөө. Ай Нарада минь ээ, Бурхан Шри Хари Өөрөө энэ экадашийн талаар: “Камика экадашид мацаг барьж байгаа хүн бурханлаг ном судрыг судалж байгаа хүнээс ч илүү ач тусыг хүртдэг.” гэж айлдсан билээ.

Энэхүү онцгой өдөр мацаг барьж шөнийг унталгүй сэрүүн өнгөрөөх хэн бүхэн эрлэгийн хаан- Ямаража бурханы торонд унадаггүй. Камика экадашийг баримталж байгаа хүн дахин төрөхийн зовлонг эдэлдэггүй. Энэ өдөр мацаг барьсан олон иогчид бурханлаг ертөнцөд буцаж очсон болой. Ийм учраас тэдний адислалт өлмийн зам мөрийг даган энэ экадашид мацгийг нарийн чанд барих хэрэгтэй.

Бурхан Харид бишрэн мөргөж, *туласийн* навч өргөж байгаа хэн бүхэн нүглээсээ ангижирдаг. Бадамлянхуа цэцгийн навч усан дотор ургаж байдаг ч

нордоггүйтэй адилаар тэр нүгэлд бузарталгүйгээр амьдардаг. Бурхан Харид *туласийн* навч өргөж байгаа хүн 200 грамм алт, 800 грамм мөнгө өргөл болгож байгаатай адил ач тус, үр шимийг хүртдэг. Бүхний Дээд Бурханд сувд, бадмаараг, молор, алмааз, номин, индранил, гомедха-чулуу, барын нүд болон шүр өргөснөөс *туласийн* ганц навч өргөсөн байсан ч энэ нь Түүний таалалд илүүтэй нийцдэг. Бурхан Кешавад *туласи* модны шинэхэн дэлбээлсэн *манжари* (цэцгийн цоморлиг) өргөн байгаа хүн энэ болоод урьд өмнөх амьдралууддаа үйлдсэн нүгэлт үйлүүдийн хуримтлагдсан үр дагавруудаас салан ангижирдаг. Камика экадаши дахь *туласийн даршан* нь бүх нүглийг арилган зайлуулдаг нь эргэлзээгүй бөгөөд түүнд зөвхөн хүрснээр л материаллаг хүслийн бүх хэлбэрүүд үндсээрээ бүрмөсөн арилан үгүй болдог. *Туласийг* усалж байгаа хүн үхлийн бурхан буюу эрлэгийн хаан Ямаражаас хэзээ ч айхгүй болдог. *Туласийг* тарьж ургуулж байгаа хүн эцэстээ Бурханы оронд Бурхан Кришнатай учран золгодог. Иймээс, чин бишрэл дүүрэн бялхах албаны, ангижрал хүртээгч Шримати-Туласи-девид өдөр бүр гүн бишрэл хүндэтгэлээ илэрхийлж байх хэрэгтэй.

Ямаража бурханы туслах Читрагупта хүртэл Шримати Туласи девид шар тосоор зул өргөж байгаа хүний хүртэх ач тусыг тоолж бардаггүй. Энэхүү ариун гэгээн экадаши нь Бүхний Дээд Бурханд маш эрхэм байдаг бөгөөд Түүнд шар тосоор эсвэл сезамын тосоор зул өргөж байгаа хүний бүх өвөг дээдэс нь тэнгэрийн гаригуудад дээшлэн хүрч тэндхийн рашаанаар ундаалах болно².

Ай Юдхиштира минь ээ, гэснээ Бурхан Кришна: Бүх нүглийг арилган зайлуулагч Камика экадашийн хэмжээлшгүй их алдар цууны тухай энэ хүүрнэлийг Брахма бурхан Нарада Мунид өгүүлсэн билээ. Энэхүү ариун гэгээн өдөр нь, брахманыг эсвэл эхийн хэвлийд байгаа хүүхдийг хөнөөсөн нүглийг ч хүртэл арилган зайлуулдаг бөгөөд хүнийг бурханлаг ертөнцөд хүрэх боломжийг өгдөг³. Камика экадашийн яруу алдрын тухай итгэл, бишрэлтэйгээр сонсож байгаа хэн бүхэн бүх нүглээсээ салан ангижирдаг ба Вишнулока тийш буцаад, гэр лүүгээ эргэн харьдаг.“ хэмээн айлдвараа өндөрлөв.

Камика экадаши буюу Шравана-Кришна экадашийн яруу алдрын тухай Брахма-вайварта Пуранаас авсан хүүрнэл ийнхүү өндөрлөлөө.

Тайлбар:

1.Брахма бурханы мөргөлийн, газар дэлхий дээрх цорын ганц сүм Пушкара-кшетрад байдаг.

2.Энэхүү экадаши нь маш хүчирхэг бөгөөд хүн дээр дурьдсан бүх дүрэм журмуудыг нарийн чанд дагаж мөрдөн мацаг барж чадахгүй байсан ч өөрийн зөв шудрага өвөг дээдсийн хамтаар тэнгэрийн гаригуудад дээшлэн хүрдэг.

3.Брахманыг хөнөөсөн эсвэл өөр бусад хүнд нүглүүдийг үйлдсэн хүн Камика экадашийн яруу алдрын тухай сонссоноор нүглийн үр дагавраасаа ангижирдаг. Гэхдээ энэ нь, энэхүү экадашийн яруу алдрын тухай сонссоноор нүглийн үр дагавар, ял шийтгэлээс мултран гарна гээд брахманыг хөнөөж болно гэсэн үг биш. Ингэж санаатайгаар нүгэлт үйл үйлдэх нь байж болшгүй хэрэг бөгөөд ингэх аваас түүний үр дагавар бүр ч илүү хүндээр тусаж, илүү чанга хатуу ял шийтгэл эдлэх болно.

ПУТРАДА (ПАВИТРОПАНИ) ЭКАДАШИ

Юдхиштира Махаража айлтгасан нь: ай Мадхусудана минь ээ, Та намайг өршөөн соёрхож, *Шравана* (7-8) сарын гэрэлтэй хоёр долоо хоногийн экадашийн тухай тодорхойлон айлдана уу.

Бүхний Дээд Бурхан, Шри Кришна хариу айлдсан нь: Ай хаан минь ээ, энэ ариун гэгээн экадашийн тухай зөвхөн сонссоноор л хүн мориор тахилга өргөл

өргөж байгаатай адил ач тусыг хүртдэг учраас Би түүний яруу алдрын талаар баяртайгаар айлдъя.

Двапара юга-ын эхэнд Махишмати-пуриг захиран суудаг Махижита нэртэй нэгэн хаан байлаа. Тэрээр хүүгүй байсан учир бүх улс гүрэн нь хүртэл түүнд харанхуй юм шиг санагдах болсон. Гэрлэсэн мөртөө хүү төрөхгүй байгаа хүн энэ амьдралдаа ч тэр, мөн дараагийн амьдралдаа ч тэр аз жаргалыг үздэггүй. Он жилүүд нисэх мэт өнгөрөхийг мэдрэхийн хирээр хаан бүр илүүтэйгээр түгшин, санаа нь зовох болсон. Нэгэн удаа, хаан өөрийн зөвлөхүүдээ цуглуулаад тэдэнд хэлсэн нь: Би энэ амьдралдаа нүгэл үл үйлдсэн билээ. Миний сан хөмрөгт шудрага бус арга замаар орсон эд баялаг байхгүй. Би хагас бурхдын болоод брахмануудын аугаа байдалд хэзээ ч халдаж байгаагүй билээ. Өөр хаадтай дайн тулаан хийж байхдаа би цэрэг дайны урлагийн дүрэм журам болон оноосон үүргүүдийг мөрдөн баримталж байсан. Би албат иргэддээ өөрийн хүүхдүүд мэтээр санаа тавьж байсан. Төрөл төрөгсөдөө хүртэл хууль зөрчсөн үед нь цээрлүүлэн шийтгэж, зөв шудрага болон бишрэл шүтлэг бүхий дайсандаа ч сайн сайхнаар хандаж байсан. Ай хоёр дахиа төрсөн брахманууд минь ээ, би Ведийн бүхий л журам, дүрэм, зарчмуудыг мөрддөг боловч надад хүү заяахгүй байна. Үүний учир шалтгааныг надад нээн тайлж өгөөч.

Хааны үгийг сонсоод брахманууд зөвлөлдсөнөө, түүний ач тусын төлөө түүнийг зовоон шаналгаж байгаа хүндрэл бэрхшээлийг тайлан шийдвэрлэхээр аугаа гэгээнтэнгүүдийн *ашрамууд* руу явцгаасан. Эцсийн эцэст тэд тэвчил наманчлал үйлдэгч, цэвэр ариун, өөрөө өөртөө ханамжтай, мацаг барих ёс журмыг хатуу чанд баримтлагч мэргэн дээр хүрч очсон. Тэр бол мэдрэхүйгээ бүрнээ эзэмдэн захирсан, уур хилэнгээ ялан дийлсэн бөгөөд оноогдсон үүргүүдийг биелүүлэхэд туршлагажсан байлаа. Энэ гэгээн ведийн цэцэн мэргэн ухаанд гаргуун байсан бөгөөд түүний амьдралын үргэлжлэх хугацаа нь Брахма бурханы амьдрахтай адил тэнцүү байлаа. Түүнийг Ломаша Риши гэдэг бөгөөд тэрээр өнгөрсөн, одоо болон ирээдүйг мэддэг байв. *Кальп* бүрийн төгсгөлд түүний биеэс нэг ширхэг үс унадаг байлаа.

Хааны зөвлөхүүд болох брахманууд гэгээнд маш их баяр хөөртэйгөөр дөхөн ойртож, түүнд нэг нэгээрээ гүн хүндэтгэл илэрхийлсэн. Түүнд мөргөнгөө тэрхүү аугаа сүнсэнд автагдсан Махижита хааны зөвлөхүүд түүнд хандан: “Ай мэргэн минь ээ, зөвхөн маш их зол завшааны ачаар л бид таныг харж байна.” гэж хэлсэн.

Ломаша Риши тэднийг суухыг уриад дараа нь асуусан нь: Та нарын энд ирсэн хэрэг зориг юу вэ? Юу хүсэж байгаагаа хэлнэ үү. Гэгээнтнүүдэд, бусдад туслах гэсэн зөвхөн ганц зорилго¹ байдаг учраас та бүхний хүндрэл бэрхшээлтэй асуудлыг чинь шийдвэрлэхийн төлөө би бүхнийг хийх ёстой билээ. Үүнд эргэлзэхийн хэрэг огт байхгүй.

Хааны зөвлөхүүд хариу өгүүлсэн нь: Ай аугаа мэргэн минь ээ, бид танаас зөвлөгөө, тусламж авахаар ирлээ. Ай мэргэн минь ээ, та бол Брахма лугаа бөгөөд энэ орчлонд танаас илүү мэргэн үгүй билээ. Манай хаан Махижита биднийг өөрийн төрсөн хүүхдүүд адилаар санаа тавьж тэтгэн, хамгаалж байдаг боловч түүнд нуган үр заяахгүй байна. Хүүгүйн улмаас түүнийг хэрхэн гутаж, аз жаргалгүй байгааг хараад бид маш их гуниглаж, тэвчил наманчлал үйлдэхээр ой руу ирсэн билээ. Харин бидэнд маш их зол завшаан тохиож тантай учирлаа. Танаас хүртсэн *даршаны* ач тусаар бидний хүсэл зорилго биелэгдэж, үйл хэрэг минь бүтэх билээ. Иймээс, манай хаан хэрхэн хүүтэй болж болохыг бидэнд хэлж өгөхийг танаас хүлцэнгүйгээр гуйж байна.

Тэдний өгүүлэхийг сонсоод Ломаша Риши гүн бясалгалд автан умбаж, хааны өнгөрсөн амьдралыг харсан. Дараа нь тэр хэлсэн нь: Танай хаан өнгөрсөн амьдралдаа худалдаачин байсан байна. Өөрийн хөрөнгө баялгаа аривжуулахыг чармайн нүгэлт үйлүүд үйлдэж байжээ. Тэр наймаа арилжаа хийхээр янз бүрийн тосгон суурингуудаар явдаг байж. Нэг удаа замд явж

байхдаа маш ихээр цангаж. Энэ явдал экадашийн дараагийн өдөр, үд дундын үед болжээ. Тосгоны захад орших нэгэн элбэг баян цөөрмийн дэргэд тэр хүрч ирээд ус уухаар ойртлоо. Гэтэл түүний замд саяхан төрсөн тугалаа дагуулсан нэг үнээ хөндөлссөн. Халуунаас болж тэд ч мөн ихээр цангасан байв. Гэвч худалдаачин түрүүлж ус уухаар зүтгэн тэднийг хэрцгийгээр түлхэн өшиглөж хөөн холдуулаад өөрөө ус уусан. Үнээ, тугалд ийнхүү балмадаар хандсаны улмаас танай хаанд одоо нуган үр заяахгүй байна. Гэсэн ч тэр өнгөрсөн амьдралдаа үйлдсэн сайн үйлүүдийнхээ үрээр элбэг дэлбэг улс гүрнийг захирах болжээ.

Үүнийг сонсоод хааны зөвлөхүүд асуусан нь: Ай Риши минь ээ, гэгээнтэнгээс адислал хүртсэнээр өнгөрсөн үеийн нүгэлт үйлүүдийн үйлчлэл нөлөөг арилган зайлуулж болдог гэдгийг бид Ведээс мэдэх билээ. Биднийг өршөөн соёрхож, хааны нүглийг хэрхэн яаж арилган зайлуулах талаар зааж зөвлөнө үү.

Ломаша Риши хариулсан нь: *Шравана* сарын гэрэлтэй хагаст Путрада гэж нэрлэгддэг экадаши тохиодог. Энэ өдөр та бүхэн хааны хамтаар бүгдээрээ мацаг барьж, экадашийн журам дүрмүүдийг нарийн чанд баримтлан бүхий л шөнийг унталгүйгээр сэрүүн өнгөрүүлэх хэрэгтэй. Дараа нь та нар энэхүү экадашийг баримталснаар хүртсэн адислалаа хаандаа зориулан өргөх хэрэгтэй. Хэрвээ та нар миний сургаал зөвлөгөөг дагах аваас хаан удалгүй сайн хүүтэй болно.

Ломаша Ришигийн эдгээр үгсийг сонсоод хааны зөвлөхүүд маш ихээр баярлацгаасан. Тэдний удирдлагын доор Махишмати-пуригийн оршин суугчид болон мөн хаан өөрөө экадашид мацаг барьцгаасан бөгөөд дараагийн өдөр нь буюу *двадашид* тэд хүртсэн адислалаа хаандаа өргөцгөөсөн. Үүний ач тусаар хааны хатан жирэмсэлж, гайхамшигтай хүү төрүүлсэн.

Бурхан Кришна: “Ай Юдхистхира минь ээ, *Шравана* сарын гэрэлтэй хагаст тохиодог экадаши ийнхүү Путрада буюу нуган үр хайрлагч гэж алдаршсан. Энэ болоод дараагийн ертөнцөд аз жаргалыг хүсэж байгаа хэн бүхэн энэ өдөр үр тариа хийгээд буурцагт ургамлыг хоол хүнсэндээ үл хэрэглэн мацаг барих хэрэгтэй. Путрада экадашийн яруу алдрын тухай сонсох хэн бүхэн бүх нүглээсээ бүрнээ ангижран ариусах бөгөөд түүнд нуган үр заяах ба үхсэнийхээ дараа тэнгэрийн гаригуудад дээшлэн хүрэх нь эргэлзээгүй.” хэмээн айлдвараа өндөрлөлөө.

Путрада экадаши буюу Шравана-шукла экадашийн яруу алдрын тухай Бхавишья-уттара Пуранаас авсан хүүрнэл ийнхүү өндөрлөлөө.

Тайлбар:

1. Ломаша Риши нь Бурханы чин бишрэлтэн учраас бүхий л эрхэм дээд шинжүүдийг агуулдаг.

Шримад Бхагаватамын (5.1812)-д өгүүлсэнчлэн: “Шри Кришнад гуйвалтгүй бишрэн зүтгэж байгаа хэн бүхэнд Кришнын болон хагас бурхдын бүхий л сайн шинжүүд бий болдог. Харин тэгэхэд, чин бишрэлийн алба зүтгэлээс ангид гадна байж материаллаг үйлүүдтэй зууралдах хүнд ямар ч сайн шинж огтхон ч байдаггүй. Тэр өөрийн ухаандаа хөтлөгдөн явахаас аргагүй байдаг учраас Бурханы гадаад эрчимд зүтгэх болдог. Ийм хүмүүст хаанаас ч тийм сайн шинжүүд бий болох билээ дээ.

АЖА ЭКАДАШИ

Юдхиштхира Махаража асуусан нь: Ай Жанардана, бүх амьд оршнолуудын хамгаалагч минь ээ, *Бхадрапада* (8-9) сарын харанхуй хагаст тохиодог экадашийг юу гэж нэрлэдэг вэ?

Бүхний Дээд Бурхан, Шри Кришна хариу айлдсан нь: Ай хаан минь ээ, Намайг анхааралтай сонс. Бүхий л нүглийг арилган зайлуулагч энэхүү ариун гэгээн экадашийг Ажа гэж нэрлэдэг. Энэ өдөр бүтэн мацаг барин, мэдрэхүйн эзэн Хришикешад бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн мөргөж байгаа хүн нүгэлт үйлүүдийнхээ бүх үр дагавраас салан ангижирдаг. Тэр бүү хэл энэ экадашийн тухай зүгээр л сонссон хүн өнгөрсөн үедээ үйлдсэн нүглээсээ ангижирдаг. Ай хаан минь ээ, газар дэлхийн болон тэнгэрийн гаригуудад үүнээс илүү сайн өдөр гэж үгүй билээ. Энэ бол ямар ч эргэлзээгүй үнэн болой.

Эртийн нэгэн цагт газар дэлхийг захиран суудаг маш их бишрэл шүтлэгтэй хийгээд үнэнч шудрага, алдар цуутай Харишчандра гэдэг хаан байжээ. Түүний хатныг Чандрамати гэдэг бөгөөд тэд Лохиташва нэртэй нэгэн хүүтэй байлаа. Гэвч хувь заяаны эрхээр Харишчандра хаан улс гүрнээ алдаж, хатан хүү хоёроо худалдахаар тулгагдсан. Эрхэм дээд хаан маань нохойгоор хооллогчийн дорд албат зарц болсон бөгөөд тэд хааныг үхэгсдийн шарилыг шатаадаг газрын манаачаар тавьсан. Тэгсэн хэдий ч, ийм дорд ажил үйл эрхэлж байгаа ч тэр өөрийн итгэл бишрэл хийгээд эрхэм сайн зан төрхөө алдаж орхиогүй. Өөр шингэнтэй холилдсон *сома-раса* нь үхэшгүй мөнхийг хайрлагч өөрийн чадвараа ингэж л хадгалдаг билээ. Энэ байр сууриндаа хаан олон жилийг өнгөрүүлсэн. Гэвч нэгэн удаа тэрээр: “Би энэхүү хүнд хэцүү байдлаасаа салан ангижрахын тулд яах вэ? юу хийх вэ?” гэж гунигтайгаар бодсон. Ийнхүү тэр таагүй байдал, зовлон шаналалын далайд умбасан.

Тэгтэл, тэр газрын хажуугаар аугаа гэгээн Гаутама Муни явж өнгөрсөн бөгөөд хаан түүнийг хараад баяртайгаар: “Ай, Брахма бурхан бусдад тусалж байг гэж брахмануудыг бүтээсэн билээ.” гэж бодсон. Харишчандра, гэгээнтэнд хүндэтгэлээ илэрхийлээд түүний өмнө сөгдөн алгаа хавсран өөрийн гунигт түүхийг ярьсан. Түүний түүхийг сонсоод Гаутама Муни гайхширсанаа: “Одоо энэ хаан үхэгсдийн хувцас хунарыг эмхэлж янзалдаг болтлоо гундан доройтжээ.” гэж бодсон. Тэрээр Харишчандраг маш ихээр өрөвдөн мацгийн тусламжтайгаар хэрхэн ариусах талаар сургаал номлолоо хайрласан.

Гаутама Муни: “Ай хаан минь ээ, *Бхадрапада* сарын харанхуй хагаст, бүх нүглийг арилган зайлуулдаг Ажа гэж нэрлэгддэг онцгой өршөөл ивээл бүхий экадаши тохиодог. Энэ экадашийн өдөр чи тэвчил үйлдэж мацаг барих аваас бүх нүгэл чинь устан үгүй болдог тийм л өршөөл ивээлтэй билээ. Чиний зол завшаан болоход энэ экадаши удахгүй, долоо хоногийн дараа тохионо. Энэ өдөр мацаг барин, шөнийн туршид унталгүйгээр сэрүүн өнгөрүүлэхийг чамд зөвлөө. Хэрвээ чи ийн үйлдэж чадах аваас чиний өнгөрсөн үеийн нүгэлт үйлүүдийн чинь бүх үр дагаврууд устан үгүй болно. Ай Харишчандра минь ээ, би чиний өнгөрсөн үедээ үйлдсэн эрхэм сайн үйлүүдийн чинь ач тус, үр шимээр л энд ирсэн билээ. Чамайг амжилт, зол завшаан дагалдаж байг.” гэж хэлсэн. Гаутама Муни ийнхүү хэлснээ хоромхон зуурт л үзэгдэхгүй боллоо.

Ажа экадашийн ариун гэгээн өдрийг Харишчандра хаан Гаутама Мунигийн зөвлөсний дагуу баримталж өнгөрүүлэв. Ай Юдхиштхира минь ээ, хаан энэ өдөр мацаг барьсан учраас түүний нүгэлт үйлүүдийн үр дагавар нь үгүй болсон. Ай хаадын дундахь арслан минь ээ, экадаши дахь энэ мацгийн гайхамшигтай нөлөөг хар даа. Тэрээр өнгөрсөн үедээ үйлдсэн нүглийн улмаас зовж шаналж байгаа хүний бүх зовлон шаналалыг хоромхон зуурт л ялан дийлж байна

Ийнхүү Харишчандра хаан бүх зовлон шаналалаасаа салан ангижирсан. Энэхүү гайхамшигт экадашийн хүчээр тэр хэдийн нас эцэслэсэн ч одоо дахин амилсан эхнэр, хүүтэйгээ дахин учирсан. Тэнгэрт, хагас бурхад яруу хэнгэрэгээ дэлдэн цохицгоож Харишчандра хаан, түүний хатан болон тэдний хүү дээр цэцэгс цацан мялаав. Экадаши дахь мацгийн адислалаар тэр улс гүрнээ ямар ч

хүндрэл бэрхшээлгүйгээр буцаан эзлэн авсан. Түүнээс гадна Харишчандра хааныг энэ гаригийг орхих үед түүний төрөл төрөгсөд болон бүхий л албатууд нь түүнтэй хамт бурханлаг ертөнц тийш одсон билээ. Энэхүү экадашийн яруу алдрыг сонссон болон ойлгож ухаарсан хэн бүхэн мориор өргөл өргөсөнтэй адил ач тусыг хүртдэг.

Ажа экадаши буюу Бхадрапада-Кришна экадашийн яруу алдрын тухай Брахмавайварта Пуранаас авсан хүүрнэл ийнхүү өндөрлөлөө.

ПАРИВАРТИНИ ЭКАДАШИ

Юдхиштира Махаража Бурхан Кришнад айлтгасан нь: *Бхадрапада* (8-9) сарын гэрэлтэй хагаст тохиодог экадашийг юу гэж нэрлэдэг вэ? Энэ өдөр ямар Бурханд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн мөргөдөг вэ? Түүнийг баримталснаар ямар ач тусыг хүртдэг вэ? Энэ бүгдийн талаар Та надад нээн хүртээнэ үү.

Бүхний Дээд Бурхан, Шри Кришна хариу айлдсан нь: Ай Юдхиштира минь ээ, энэхүү экадашийг Вамана экадаши гэж нэрлэдэг бөгөөд тэрээр аугаа их ач тусыг болон материаллаг боолчлолоос салан ангижрах дээдийн дээд ангижралыг хүртээдэг. Нүгэлт үйлийн бүхий л үр дагавруудыг устган арилгадаг учраас түүнийг мөн Жаянти экадаши гэж нэрлэдэг бөгөөд түүний яруу алдрын тухай зөвхөн сонссоноор л хүн өнгөрсөн үедээ үйлдсэн бүх нүглээсээ чөлөөлөгдөн ангижирдаг. Энэ экадашаас илүү сайн гэж үгүй бөгөөд ангижралд маш амархан хүргэдэг. Материаллаг ертөнцийн хүлээснээс чөлөөлөгдөн ангижрахыг хүсэж байгаа хүн бүр Вамана экадашид мацаг барих хэрэгтэй.

Энэхүү ариун гэгээн мацгийг барингаа *вайшнав* буюу чин бишрэлтэн нь Бүхний Дээд Бурханд Түүний бадамлянхуа цэцгийн дэлбээ мэт мэлмийт оодой-Ваманадева дүрд хайр чин бишрэлтэйгээр мөргөх ёстой. Энэ экадаши нь нойрсож байгаа Бурхан нөгөө тал руугаа эргэдэг өдөрт тохиодог учраас маш их өршөөл ивээлтэй бөгөөд түүнийг мөн Паривартини гэж нэрлэдэг.

Юдхиштира Махаража Бурханаас асуусан нь: Ай Жанардана минь ээ, Бүхний Дээд Бурхан хэзээ нойрсдог болон нөгөө хажуу тал руугаа хэзээ эргэдэг болохыг надад айлдаж соёрхоно уу? Ай Бурхан минь ээ, Таныг нойрсож байх үед бусад амьд оршнолууд юу болдог вэ? Та Бали Махаражаг хэрхэн номхотгосноо, мөн брахмануудыг хэрхэн яаж ханамжтай болгодог тухай болон *Чатурмасья-г*¹ хэрхэн баримталдаг тухай айлдаж соёрхоно уу

Бүхний Дээд Бурхан айлдсан нь: Ай Юдхиштира минь ээ, ай хаадын дундахь арслан минь ээ, зөвхөн сонссон төдийд л нүглийн бүх үр дагавар устан арилдаг нэгэн түүхийг Би чамд баяртайгаар айлдъя. Урьдын нэгэн цагт, *Трета югад* Бали нэртэй нэгэн хаан амьдарч байсан. Демонуудын гэр бүлд төрсөн хэдий ч тэр Надад маш их чин бишрэлтэй байв. Тэр Намайг цэнгүүлэх гэж *хомазан* үйлийг үйлдэж ведийн дууллуудыг дуулдаг байлаа. Мөн тэр брахмануудад хүндэтгэл үзүүлдэг байсны зэрэгцээ тэднийг өдөр тутмын тахилга өргөлүүдээ үйлдэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлдэг байв. Бали Индратай тулалдан, түүнийг ялж бүхий л тэнгэрийн гаригуудыг эзлэн авсан. Тийм учраас хагас бурхад өөрсдийн номын багш Брихаспати болон аугаа мэргэдийн хамтаар Надад бараалхан Бали Махаражын талаар гомдол зарга мэдүүлсэн. Би тэдний хүсэл сонирхлыг хамгаалахаар Өөрийн тав дахь хувилгаан Ваманадева-оодойн дүрээр морилон тодрохыг таалан зөвшөөрсөн.

Юдхиштира хаан асуусан нь: Ай Бурхан минь ээ, Та оодойн дүрээр тийм хүчирхэг демоныг хэрхэн номхотгон дарж чадав аа? Энэ тухайгаа Та, Таны чин бишрэлтэн болох надад тайлбарлан соёрхоно уу.

Бүхний Дээд Бурхан, Шри Кришна хариу айлдсан нь: Хэдийгээр Би оодой ч, брахман байсан бөгөөд Бали Махаражагаас өчүүхэн бага хэмжээний газар

өглөг болгооч гэж гуйсан. Би: “Ай Бали минь ээ, Надад ердөө л гурван алхам газар өгөөч.” гэж айлдсан бөгөөд Бали ч удаан бодолгүйгээр Миний хүсэлтийг биелүүлэхээр зөвшөөрсөн. Гэвч түүнийг Надад газар өгөхөөр амласны дараагаар Би Өөрийн биеэ аврага том болгосон. Газар дэлхийг Би өлмийгөөрөө, Буварлокаг гуяараа, тэнгэрийн Сваргаг бэлхүүсээрээ, Махарлокаг хэвлийгээрээ, Жаналокаг цээжээрээ, Тапарлокаг хүзүүгээрээ, харин Сатьялокаг тэргүүнээрээ буюу нүүрээрээ бүрхсэн. Бүхий л материаллаг бүтээл, бүх гаригууд Миний аврага том дүрд залгигдах мэт шингэн орсон. Үүний дараагаар Би Балигийн гараас татан: “Ай нүгэл үгүй минь ээ, Би эхний алхмаараа газар дэлхийг бүхэлд нь, хоёр дахь алхмаараа бүхий л тэнгэрийн гаригуудыг бүрхчихлээ. Чиний өгөхөөр амалсан газрыг хэмжихийн тулд гурав дахь алхмаа Би одоо хаана хийх вэ?” гэж асуусан. Намайг сонсоод Бали Махаража Миний өмнө хөсөр унан Надад өөрийн толгойгоо тавьж өгсөн. Би түүний толгой дээр Өөрийн өлмийгөө тавьсан. Түүний энэхүү хүлцэнгүй бишрэлтэй байдал Миний таалалд маш ихэд нийцсэн бөгөөд Би түүнд хандан, үүнээс хойш үргэлж, түүний ордонд үлдэн залрах болно гэж айлдсан. Үүний дараа, *Бхадрапада* сарын гэрэлтэй хагас дахь Паривартини экадашид Вирочанагийн хүү Бали өөрийн улс гүрэндээ Миний дүр-*муртиг* залсан.

Ай хаан минь ээ, *Картика* сарын гэрэлтэй хагаст тохиодог Харибодхини экадаши хүртэл Би нойрсохоор сүүн далай дээр хажуулдаг. Энэ цаг үед хүртэх ач тус онцгой аугаа байдаг. Ийм учраас Паривартини экадашийг нарийн чанд, нягт нямбай баримтлах хэрэгтэй. Энэ экадаши нь ариусгах онцгой үйлчлэл нөлөөтэй бөгөөд бүхий л нүгэлт үр дагавруудыг устган зайлуулдаг. Энэ өдөр Би нойрон дундаа нөгөө тал руугаа эргэж хажуулдаг учраас чин бишрэлтэн нь Бурхан Тривикрама-Ваманадевад дээдийн дээд эцэг дүрээр нь бишрэн мөргөх ёстой. Хэрвээ боломжтой бол энэ өдөр зохистой бодьгальд будаатай хольсон йогурт мөн мөнгө (төгрөг мөнгөний мөнгө биш, алт мөнгөний мөнгө. Орч.) өргөн шөнийг унталгүй сэрүүн өнгөрүүлэх хэрэгтэй.

Энэхүү ариун гэгээн Паривартини экадашийг баримталж байгаа хүн энэ ертөнцөд бүх төрлийн аз жаргалыг эдлэх бөгөөд эцэстээ Бурханы оронд хүрч очих болно. Энэ хүүрнэлийг чин бишрэлтэйгээр зүгээр л сонсож байгаа хүн хагас бурхдын оронд хүрч очих бөгөөд сар лугаа гэрэлтэн туяарах болно. Энэ экадаши нь ийм л хүчирхэг бөлгөө. Түүнийг баримталснаар мориор мянгантаа өргөл өргөсөнтэй адил тийм их хүч чадалтай болдог.

Бхадрапада сарын гэрэлтэй хагаст тохиодог Паривартини экадаши буюу Вамана экадашийн яруу алдрын тухай Брахма-вайварта Пуранаас авсан хүүрнэл ийнхүү өндөрлөлөө.

Тайлбар:

1. *Чатурмасья*-гийн мацгийг хэрхэн барьдаг талаар Бхавишья-уттара Пураны “*Чатурмасья-махатмья*” бүлэгт тодорхойлон өгүүлсэн байдаг.

ИНДИРА ЭКАДАШИ

Юдхиштхира Махаража айлтгасан нь: Ай Мадхусудана минь ээ, *Ашвина* (9-10) сарын харанхуй хагаст тохиодог экадашийг юу гэж нэрлэдэг вэ? Та түүний яруу алдрын талаар айлдан соёрхоно уу?

Бүхний Дээд Бурхан, Шри Кришна хариу айлдсан нь: Энэхүү ариун гэгээн өдрийг Индира экадаши гэж нэрлэдэг. Хүн энэхүү өдөр мацаг барих аваас түүний бүх нүгэл нь устан арилахын зэрэгцээ тамд унасан түүний өвөг дээдсүүд нь тэндээс чөлөөлөгдөн ангижрдаг. Ай хаадын шилдэг нь минь ээ, энэхүү

экадашийн тухай зүгээр л сонсож байгаа хүн мориор өргөл өргөсөнтэй адил аугаа их ач тусыг хүртдэг.

Сатья югад, Индрасена нэртэй нэгэн хаан амьдардаг байсан ба тэрээр бүх дайснуудаа ялан дийлсэн тийм хүчирхэг нэгэн байлаа. Түүний улс гүрнийг Махишмати-пури гэдэг байв. Маш их бишрэл шүтлэгтэй байсан учир Индрасена хаан өөрийн албат иргэддээ зохих ёсоор анхаарал халамж, санаа тавьдаг байв. Иймээс ч тэр маш их алт, үр тариа болон хөвгүүд, ач нартай байлаа. Тэр бол Шри Вишнугийн аугаа чин бишрэлтэн байлаа. Тэр Миний нэр алдрыг магтан дуулж, “Говинда, Говинда” гэж бахдан дуудсанаараа онцгой баяр баясгаланг амсаж эдэлдэг байв. Ийнхүү Индрасена хаан өөрийгөө жинхэнэ цэвэр ариун бурханлаг амьдралд байнгад зориулсан байсан бөгөөд Үнэмлэхүй Үнэний бясалгалд автан умбаж маш их хугацааг өнгөрүүлдэг байв.

Нэгэн удаа Индрасена хаан хурал чуулганаа, аз жаргал дүүрэн хийгээд амар тайван тэргүүлэн сууж байх үед нь тэнгэрээс буун ирсэн хосгүй уран яруу номлогч Нарада Муни морилон ирсэн. Хаан хагас бурхдын дундахь гэгээнтэн Нарада мэргэнд маш их хүндэтгэл үзүүлэн, түүнд мөргөн мэндчилж, ордондоо урьж, тав тухтай суудалд залан суулгаж, хөлийг нь угаан чин зүрхний халуун дотно мэндчилгээний үгүүдийг хэлж байлаа.

Нарада Муни Индрасена Махаражагаас: “Ай хаан минь ээ, чиний хаан төрийн долоон тулгуур багана цэцэглэн мандаж байгаа биз дээ? Оноогдсон үүргээ яаж хамгийн сайнаар биелүүлэх вэ? гэж эрэгцүүлэн бодож, шүүн тунгаахад ухаанаа зориулж байна уу? Бүхний Дээд Бурхан, Шри Вишнуд улам бүр ихээр бишрэн зүтгэж байна уу?” гэж асуулаа.

Хаан хариулсан нь: Ай мэргэдийн хамгийн аугаа нь минь ээ, Таны өршөөл нигүүлслээр бүгд сайн байгаа. Өнөөдөр, чухам Таныг морилон ирэх үед, манай улс гүрэн даяар бүх тахилга өргөлөө амжилттай үйлдэж дууслаа. Та өөрийнхөө морилон ирсний учрыг бидэнд болгоон хэлэх ажаам уу.

Тэгээд, хагас бурхдын дундахь мэргэн, Шри Нарада хэлсэн нь: Ай хаадын дундахь алдар цуутан минь ээ, миний гайхалтай яриаг болгоон сонс. Намайг Брахмалокаас Ямалокад бууж ирэхэд, Ямаража бурхан надтай халуун дотноор уулзан гойд тансаг сайхан суудалд урьж суулгасан. Ямаражагийн хурал чуулган дээр би чиний эцгийг харсан. Тэр маш их бишрэл шүтлэгтэй байсан, гэвч тэр экадашид мацгаа хугацаанаас нь өмнө зогсоон тайлсан учраас Ямалокад унасан байна.

Чиний эцэг чамд дараахь үгүүдийг дамжуулж өгөөч гэж хэлсэн. Тэрээр: “Махишматид Индрасена нэртэй нэг хаан байдаг. Түүнд, намайг энд, өөрийн өнгөрсөн нүгэлт үйлийн уршгаар Ямаражагийн оронд унан амьдрахаас өөр аргагүй болсон байна.” гэдгийг түүнд хэлж өгөөч. Мөн түүнд: “Ай хүү минь ээ, Индира экадашийг баримталж аль болох их өглөг тараагаач, тэгвэл би тэнгэрт дээшлэн хүрч очих болно.”¹ гэж дамжуулж өгөөч гэсэн.

Нарада үргэлжлүүлэн хэлсэн нь: Энэ үгийг сонсоод, ай хаан минь ээ, би чамайг зорьж ирлээ. Чи Индира экадашийг баримтлан эцэгтээ туслах ёстой. Хэрвээ чи энэ экадашийг баримтлах аваас ийм сайн үйлийн ач тусаар чиний эцэг тэнгэрт дээшлэн очих болно.

Индрасена хаан асуусан нь: Ай аугаа Нарадажи минь ээ, та намайг өршөөн соёрхож Индира экадашийг яаж баримталдаг болон ямар сарын, ямар өдөрт энэ экадаши тохиодог болохыг хэлж өгөх ажаам уу?

Нарада Муни хариулсан нь: Ай хаан минь ээ, сонс, би чамд Индира экадашийг баримталдаг дүрэм журмыг тодорхойлон хэлж өгье. Энэ экадаши нь *Ашвина* сарын харанхуй хагаст тохиодог. Экадашийн өмнөх өдөр *даша-д* эртлэн босож угаал үйлд, дараа нь Бурханд зориулан ямар нэгэн зүйлийг дүүрэн итгэлтэйгээр хий. Үд дундад урсгал усанд дахин угаал үйлдэж өөрийн өвөг дээдэстээ итгэл, чин бишрэлтэйгээр өргөл бэлэг өргө. Энэ өдөр нэгээс олон удаа бүү хоолло. Шөнө нь шалан дээр унт. Экадашийн өглөө эртлэн босож

ам болон шүдээ сайтар угаан цэвэрлэ. Дараа нь Бурханд гүн бишрэл хүндэтгэлтэйгээр дараахь ам өчгийг өг: Өнөөдөр би бүтэн мацаг барих ба үүний төлөө хүртэх бүх ач тус, үр шимээс татгалзах болно. Ай нүгэл үгүй минь ээ, Та намайг Өөрийн бадамлянхуа өлмийд аврал ивээл эрэхийг болгоон соёрхоно уу.

Үд дундад *Шри Шалагарам-шилагийн*² өмнө очиж, бүх журам дүрмийг даган Түүнд чин зүрхнээсээ мөргөх хэрэгтэй. Дараа нь өөрийн өвөг дээдэстээ өргөл өргө. Тэгээд зохистой брахмануудыг хоолоор дайлан өөрийн боломжоороо тэдэнд өргөл өргө. Түүний дараагаар өвөг дээдэстээ өргөсөн хоолыг авч үнэрлээд үнээнд өргөл болгон өг. Цааш нь, Бурхан Хришикешад хүж, цэцэг өргөн мөргө. Эцэст нь бүхий л шөнийг унталгүйгээр Шри Кешева Бурханы дэргэд өнгөрүүл.

Дараагийн өдрийн буюу *двадашийн* өглөө Шри Харид машид чин бишрэлтэйгээр мөргөн брахмануудыг элбэг тансаг дайллаганд урь. Дараа нь өөрийн ойр дотнынхоо хооллон мөн өөрөө дуугүй хоолло. Ай хаан минь ээ, хэрвээ чи Индира экадашид өөрийн мэдрэхүйгээ эзэмдэн, хянан захирч мацгийг нарийн чанд барих аваас чиний эцэг Бурхан Вишнугийн оронд дээшлэн хүрэх нь эргэлзээгүй. Ийнхүү өгүүлээд Деварши Нарада агшин зуурт л үзэгдэхгүй болов.

Индрасена хаан, аугаа гэгээнтний сургаалыг бүрэн төгс биелүүлсэн ба өөрийн ойр дотнынхон болоод албатуудын хамтаар мацаг барьсан. *Двадашид*, тэднийг мацгаа тайлах үед тэнгэрээс цацсан цэцэгс тэднийг бүрхэн хучиж, сайшаан мялаасан. Индрасена хааны мацаг барьснаар хүртсэн ач тус, үр шимийг Ямаражагийн оронд байсан түүний эцэг авсан. Эцэг нь бүрмөсөн, бурханлаг биеийг авсан ба түүнийг Гаруда шувууны нуруун дээр Бурхан Харигийн залрах орон тийш хэрхэн дээшлэн одохыг Индрасена харсан. Индрасена хаан өөрийн улс гүрнээ ямар ч саад тотгоргүйгээр захирсаар цаг нь болмогц хаан төрөө хүүдээ шилжүүлэн өгч өөрөө мөн л Вайкунтхаг зүглэн одсон.

Ай Юдхитхира минь ээ, *Ашвина* сарын харанхуй хагаст тохиодог Индира экадашийн яруу алдар ийм билээ. Энэхүү хүүрнэлийг сонсож байгаа эсвэл уншиж байгаа хэн бүхэн ямар ч эргэлзээгүйгээр, энэ ертөнцөд амьдралын таашаал ханамжийг эдлэн, өнгөрсөн үеийн бүх нүглээсээ ангижран салах бөгөөд бие махбодио орхисны дараагаар Бурханы зүгт, буцаад гэр лүүгээ харьж тэнд мөнхөд амьдрах болно.

Ашвина-Кришна экадашийн буюу Индира экадашийн яруу алдрын тухай Брахма-вайварта Пуранаас авсан хүүрнэл ийнхүү өндөрлөлөө.

Тайлбар:

1. Амьд оршнол бүр бие даасан өөрийн онцлогтой буюу бодьгал байдалтай байдаг бөгөөд Бурханы зүг буцаж харихын тулд хүн бүр Кришнын ухамсарын зам мөрөөр бие даасан бодьгал байдлаар замнах ёстой. Гаруда Пуранад өгүүлсэнчлэн, Кришнын ухамсарын зам мөрөөр замнан хэрэгжүүлэхийн тулд ухаан нь тодорхой түвшинд, тайван амгалан байх шаардлагатай байдаг учраас тамд унасан хэн бүхэн зовлон тарчлалаас болж энэ зам мөрөөр замнан хэрэгжүүлэх аргагүй байдаг. Тамд зовж тарчлан байгаа нүгэлтний ойр дотнынхон нь түүний өмнөөс өглөг тараах аваас тэр тамыг орхин тэнгэрийн гаригуудад дээшлэн хүрч болно. Харин нүгэлтний ойр дотнынхон нь энэхүү экадашийг өөрийн зовж тарчилж байгаа төрөл төрөгсөдийнхөө төлөө зориулан баримтлах аваас тэд шууд бурханлаг ертөнц тийш одох болно. Энэ тухай л энд ярьсан болой.

2. *Шри Шалагарам-шила* энэ бол Шри Вишнугийн гөлгөр дугуй хар бараан өнгөтэй чулууны хэлбэрт байгаа дүр юм. Чин бишрэлтэнгүүд ангижралд хүрэх

гэж Түүнд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн мөргөдөг. *Шри Шалаграм-шилагийн* тухай Падма Пурана, Уттара Кхандад тодорхойлсон өгүүлсэн байдаг.

ПАШАНКУША ЭКАДАШИ

Юдхиштхира Махаража айлтгасан нь: Ай Мадхусудана минь ээ, *Ашвина* (9-10) сарын гэрэлтэй хоёр долоо хоногийн экадашийг юу гэж нэрлэдэг вэ? Намайг өршөөн соёрхож энэ тухай айлдаж хайрлана уу.

Бүхний Дээд Бурхан, Шри Кришна хариу айлдсан нь: Ай хаан минь ээ, Би чамд бүх нүглийг ариусган зайлуулдаг Пашанкуша экадашийн яруу алдрын талаар айлдъя. Энэ өдөр, хүн бүр бадамлянхуа цэцэг лугаа хүйстэй Бурхан Падманабхад зохих журам дүрмийн дагуу бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн мөргөх ёстой. Тэгснээр тэр тэнгэрийн орны хүссэн бүхий л таашаал ханамждаа хүрэх бөгөөд эцэст нь ангижралыг олно. Гаруда дээр залран байгаа Шри Вишнуд гүн хүндэтгэл бишрэлээ илэрхийлснээр л урт удаан хугацааны туршид тэвчил наманчлал үйлдэх болон мэдрэхүйгээ бүрэн эзэмдэн захирсанаар хүрч болох тийм ач тусыг хүртэж болно. Хүн маш их нүгэлтэй байсан ч бүх нүглийг арилган зайлуулагч Хари Бурханд зүтгэснээр тамд унахаас зайлж чадна.

Тиртхад аялан мөргөл үйлдсэнээр хүрч болох ач тусыг Бурхан Вишнугийн¹ ариун гэгээн нэр алдрыг магтан дуулснаар хүртдэг. Ариун гэгээн нэр алдар- Рама, Вишну, Жанардана болон Кришнаг, ялангуяа экадашид магтан дуулж байгаа хэн бүхэн Ямаража бурханы орныг хэзээ ч үздэггүйтэй адилаар Надад тийн эрхэм Пашанкуша экадашид мацаг барьж байгаа хүн Ямаража бурханы оронд мөн хэзээ ч унахгүй.

Шива бурханд хүндэтгэлтэй бус хандаж байгаа *вайшнав* болон Надад хүндэтгэлтэй бусаар хандаж байгаа *шайв* нь тамд унах нь гарцаагүй хэрэг. Мянган мориор өргөл өргөснөөр болон *Ражасуйя* тахилгыг зуун удаа үйлдсэнээр хүртэх ач тус нь экадашид мацаг барьснаар хүртэх адислалын 16-ны нэгд ч хүрдэггүй.

Экадашид мацаг барьснаар хүртэх ач тусаас илүү ач тус гэж байдаггүй. Бүхий л гурван ертөнцөд нүглээс ангижруулах, бадамлянхуа цэцэг лугаа хүйстэй Падманабха Бурханы өдөр-экадашаас илүү тийм ариун дээд болон түүнээс илүү их хүч чадлыг агуулах зүйл гэж байдаггүй.

Ай хаан минь ээ, Пашанкуша экадаши гэж нэрлэгддэг, Бурхан Падманабхагийн өдөр мацаг үл барих хүн нүгэлтэй хэвээр үлдэх бөгөөд түүнээс өнгөрсөн үедээ үйлдсэн нүгэлт үйлүүдийн нь үр дагавар хэзээ ч салан ангижирдаггүй. Экадашид мацаг барьснаар ч хүрэх боломжгүй тийм ач тус гэж бүхий л гурван ертөнцөд байдаггүй. Мацгийг итгэлтэйгээр барьж байгаа хэн бүхэн биелсэн үхэл-Ямаража бурханыг хэзээ ч харахгүй. Ангижралд хүрэхийг, диваажинд очих, эрүүл саруул сайн бие бялдартай болох, мөн үзэсгэлэн гоо эмэгтэй, эд баялаг болон элбэг дэлбэг үр тариа хүсэж байгаа хүн экадашид мацаг барих хэрэгтэй. Ай хаан минь ээ, Ганга ч, Гайя ч, Каши ч, Пушкари ч, тэр ч бүү хэл ариун дагшин газар орон Курукшетра хүртэл Пашанкуша экадаши шиг тийм ач тусыг өгдөггүй билээ.

Ай Юдхиштхира минь ээ, ай газар дэлхийн хамгаалагч минь ээ, мацаг барьсаны дараагаар, тэр шөнийг чин бишрэлтэн унталгүй, сэрүүн өнгөрүүлэх ёстой. Ийнхүү үйлдсэнээр тэр Бүхний Дээд Бурхан, Шри Вишнугийн залрах оронд хялбархан хүрч очно. Экадашид мацаг барьсан түүний эхийн талын 10 үеийн, эцгийн талын 10 үеийн болон эхнэрийн талын 10 үеийн төрөл төрөгсөд ангижралыг олох болно. Энэ бүх төрөл төрөгсөд нь өөрсдийн анхдагч дөрвөн мутартай, трансценденталь дүр төрхөө авна. Шар өмсгөл өмсөн, гойд тансаг чимэг, зүүлт зүүсэн тэд могойн дайсан Гарудаг хөлөглөн бурханлаг ертөнцөд

хүрч очих болно. Пашанкуша экадашийг зөв баримтлаж байгаа Миний чин бишрэлтэн ийм л адислалыг хүртдэг билээ.

Ай хаадын шилдэг нь минь ээ, Пашанкуша экадашид мацаг барьж буй хүн бүр, хүүхэд ч бай, залуу ч бай, эсвэл хөгшин настан ч бай ялгаагүй бүх нүглээсээ хийгээд тамд төрөх магадгүй байдлаасаа салан ангижрах болно. Тэр Бурхан Харигийн оронд буцаж очно. Энэхүү хамгийн ариун гэгээн өдөр алт, кунжутын үр, үржил шимтэй газар, үнээ, үр тариа, ундны ус, шүхэр эсвэл гутал өргөл болгон өргөж буй хэн бүхэн нүгэлтнүүдийг шийтгэн гэсгээгч Ямаражагийн оронд хэзээ ч унан очихгүй. Харин газар дэлхийн оршин суугчид нь бурханлаг үйлээс хазайн гажиж, ялангуяа экадашид мацаг барихаас зайлсхийх аваас түүний амьсгал нь дарханы хөөрөг уухилахаас ч дээрдэх юмгүй билээ.

Ай хаадын шилдэг нь минь ээ, Пашанкуша экадашид, ядуу хүн ч гэсэн эхлээд угаал үйлдэж, дараа нь өөрийн боломжийн хирээр өглөг өгөн, өршөөл ивээл бүхий өөр бусад үйлүүд үйлдэх хэрэгтэй.

Тахилга өргөл үйлдэж байгаа, нийтийн усан сан барьж байгаа, амрах газар тохижуулж байгаа, цэцэрлэгт хүрээлэн ургуулж тордож байгаа эсвэл байшин барьж байгаа хүнд Ямаражагаас айх юм байдаггүй. Эд баялаг, урт удаан амьдрал, нэр алдар бүхий гэр бүлд төрөх, эрүүл саруул байх- энэ бүгд нь хүний өнгөрсөн амьдралдаа дээрхтэй адил ач тустай, ээнэгтэй үйл эрхэлж, үйлдэж байсны үр шим байдаг юм. Гэхдээ Пашанкуша экадашид мацаг барьж байгаа хүн Бүхний Дээд Бурханы залран байгаа оронд дээшлэн хүрч очдог.

Ай нүгэл үгүй Юдхитхира минь ээ, Ийнхүү Би чамд Пашанкуша экадашийн яруу алдрын тухай айлдлаа. Хэрвээ чи экадашийн талаар илүү ихийг мэдэхийг хүсэж байвал дахиад асуул даа.

Тайлбар:

1.Шримад Бхагаватамын дагуу бол, Вишну-пуруша нь Бурхан Шри Кришнагийн хувилгаан дүрүүдийн нэг билээ.

РАМА ЭКАДАШИ

Юдхитхира Махаража айлтгасан нь: Ай Жанардана, ай бүх оршнолыг хамгаалагч минь ээ, *Картика* (10-11) сарын харанхуй хагаст тохиодог экадашийг юу гэж нэрлэдэг вэ? Энэ тухай эрхэм нандин мэдлэгийг надад нээн хүртээх ажаам уу.

Бүхний Дээд Бурхан, Шри Кришна хариу айлдсан нь: Ай хаадын дундах арслан минь ээ, *Картика* сарын харанхуй хагаст тохиодог экадашийг Рама экадаши гэж нэрлэдэг. Тэрээр хамгийн их нүглийг ч хоромхон зуурт устган зайлуулж, бурханлаг оронд орох зөвшөөрлийг хүртээдэг нэн их өршөөл ивээлтэй билээ. Би чамд түүний түүх хийгээд яруу алдрын талаар айлдъя.

Урьдын нэгэн цагт тэнгэрийн хаан Индра, мөн Ямаража, Варуна болон Равана демоны эрхэм хүндэтгэлт ах Вибхишанатай нөхөрлөж байсан Мучукунда нэртэй нэгэн хаан амьдарч байжээ. Мучукунда үргэлж үнэнийг ярьж, Миний чин бишрэлийн алба үйлэнд байнгад зүтгэж байсан. Тэрээр улс гүрнээ шашин номын зарчмуудын дагуу удирдан залж байсан учир түүний улс гүрэнд таагүй хэрэг явдал гардаггүй, болдоггүй байлаа.

Мучукунда өөрийн охиныг ариун гэгээн голыг хүндэтгэн Чандрабхага гэж нэрлэсэн бөгөөд түүнийг Чандрасенын хүү Шобханад эхнэр болгон өгсөн. Нэгэн удаа Шобхана өршөөл ивээлт экадашийн үеэр хадам эцгийн ордонд айлчлан ирсэн. Шобхана бие султай хийгээд ямар нэгэн тэвчил хатуужил үйлдэхэд хүч тэнхээ нь хүрэхгүй байсан учир түүний эхнэр Чандрабхагын санаа нь ихэд зовж байлаа. Тэрээр нөхөртөө хандан: “Миний эцэг экадашийг маш нарийн чанд

баримталдаг. Экадашийн өмнөх өдөр *даша-д* тэр том хэнгэрэг дэлдэн “Бурхан Харигийн өдөр, экадашид хэн ч юм идэх ёсгүй.” гэж өндөр дуугаар зарлиг буудгадаг.” гэж хэлжээ. Хэнгэрэгийн дууг сонсоод Шобхана эхнэртээ:”Ай үзэсгэлэн гоо минь ээ, би одоо яах вэ? Амьд мэнд үлдэхийн зэрэгцээ чиний эцгийн зарлигийг хэрхэн биелүүлэхийг надад зааж өгөөч.” гэж хэлсэн. Чандрабхага хариулсан нь: Хайрт нөхөр минь ээ, миний эцгийн ордонд экадашийн өдөр хэн ч, тэр ч бүү хэл хүн байтугай, заан, морьд хүртэл юм иддэггүй билээ. Хари Бурханы энэ өдөрт амьтдад үр тариа, навч ногоо сүрэл, тэр ч бүү хэл ус ч өгдөггүй. Тэгэхээр чамд мацаг барихаас зайлсхийх ямар ч арга алга даа. Миний хайрт минь ээ, хэрвээ чи ямар нэгэн зүйл идэх аваас эндээс бүрмөсөн явах болно. Иймээс чи яахаа өөрөө шийд дээ.” гэж хэлсэн.

Ханхүү Шобхана: “Ариун гэгээн өдөр экадашид би мацаг барихаар шийдлээ. Миний хувь тавилан ямар л байнав би түүнийг л дагана.” гэж хариулав. Ийнхүү шийдээд, Шобхана мацаг барьсан боловч маш их өлсөж цангасны улмаас болж тэр тэсвэрлэхийн аргагүйгээр зовж шаналж байлаа. Эцэст нь нар жаргаж, ариун гэгээн шөнө бүх *вайшнавуудыг* гийгүүллээ. Ай Юдхиштира минь ээ, бүх чин бишрэлтэнгүүд Бурхан Хариг магтан дуулж баясацгаан шөнийг огт унталгүйгээр өнгөрүүлсэн. Харин ханхүү Шобханы хувьд энэ шөнө тэсвэрлэхийн аргагүй байсан ба *двадашид* нар мандах үеэр тэр нас эцэслэсэн.

Мучукунда хаан хүргэнээ оршуулах ёслолд оролцон оршуулгын галд асар том тэвэр дүүрэн түлээ нэмж хийлээ. Харин охин Чандрабхагаг нөхрийн нь хамт явуулахаар галд оруулаагүй. Чандрабхага нөхрийнхөө гэгээн дурсгалд зориулсан бүхий л ариусгах зан үйл, ёслолуудыг гүйцэтгэсний дараа эцгийнхээ ордонд амьдрахаар үлдсэн.

Бурхан Кришна үргэлжлүүлэн айлдсан нь: “Ай хаадын шилдэг нь минь ээ, Шобханын экадашийг баримталсанаар хүртсэн ач тус нь үхлийнхээ дараагаар түүнд Мандарачала уулын оройд орших нэгэн улс орныг захиран суух адислалыг хүртээсэн явдал байлаа. Энэ улс орон нь хагас бурхдын хоттой адил төстэй байв. Тэндхийн бүх зүйлс гайхалтай сайхнаар гэрэлтэн туяарч, орд харшуудын ханууд нь хэмжээлэхийн аргагүй үнэт зүйлсээр чимэглэгдсэн, баганууд нь бадмааргаар хийгдсэн байсан бөгөөд алт болон алмааз эрдэнэ хаа сайгүй гялалзан байлаа. Шобхана хаан цагаан шүхэр доор хаан ширээндээ залран зарц албатууд нь түүнийг сарлагийн сүүлээр хийсэн дэвүүрээр сэвэн сэрүүцүүлж байв. Түүний толгой дээрх гойд тансаг титэм гэрэлтэн туяарч, үзэсгэлэнтэй сайхан ээмэг түүний чихийг, хээнцэр чамин гоё зүүлт хүзүүг, үнэт чулуун бугуйвч гарыг нь чимж байлаа. Түүнд *гандхарванууд* (тэнгэрийн орны дуучид) болон *алсарууд* (тэнгэрийн орны бүжигчид) үйлчлэн зугаацуулж байв. Үнэн хэрэгтээ тэр хоёр дахь Индра лугаа харагдаж байлаа.

Нэгэн удаа, Шобханы улс гүрэнд янз бүрий ариун дагшин газар орнуудаар аялан мөргөл хийж яваа Сомашарма нэртэй брахман Мучукундын улсаас ирсэн. Брахман гялалзан гайхуулам яруу алдар бүхий Шобханаг хараад: “Хэрвээ би эндүүрээгүй бол энэхүү гэрэлтэн туяарах хаан чинь манай Мучукунда хааны хүргэн мөн байна.” гэж бодсон. Шобхана брахманыг хараад хаан ширээнээсээ босон түүнийг гүн хүндэтгэлтэйгээр угтан мэндчилсэн. Брахманд мөргөнгөө тэр түүнээс хадам, эхнэр болон хотын бүх оршин суугчдын амар мэнд, сайн сайхны талаар асууж лавласан.

Сомашарма хариулсан нь: Ай хаан минь ээ, Таны хадмын улс гүрэнд бүх зүйлс амар мэнд, элбэг дэлбэг байгаа. Таны эхнэр Чандрабхага болон гэр бүлийн бусад гишүүд чинь бүгд сайн сайхан байгаа. Харин хаан минь ээ, би таныг энд хараад маш их гайхаж байна. Та өөрийнхөө тухай надад ярьж өгнө үү. Энэ хоттой адил тийм сайхан хотыг хэн ч, хаана ч хараагүй билээ. Та энд яаж ирснээ ярьж өгөөч.

Шобхана хаан хариулсан нь: Рама экадашид мацаг барьсны ач тусаар би энэхүү тансаг сайхан хотыг захирах адислалыг хүртсэн. Гэхдээ энэ хотын бүх аугаа сайхан байдал нь зөвхөн цаг зуурын л зүйл билээ. Түүний тансаг сайхан үзэмж хийгээд яруу алдрыг хэрхэн хадгалж хамгаалах, хотыг цаг зуурын оршин тогтнох байдлаас яаж ангижруулах болон түүнийг хэрхэн яаж мөнхийн болгохыг би мэдэхгүй байна. Намайг ухааруулан гэгээрүүлж, энэхүү дутагдалтай байдлыг арилгахад туслаач.

Брахман асуусан нь: Энэ улс орон яагаад тэгж түр зуур оршин тогтнох болсон юм бэ? Юу түүнд мөнх оршнолыг хүртээх вэ? Энэ талаар тайлбарлаж өгнө үү. Би танд туслахыг хичээе.

Шобхана хариулсан нь: Би экадашид мацгийг зохих ёсны итгэлгүйгээр барьсан хэрэг. Иймээс л миний энэ улс гүрэн цаг зуурын оршнох ёстой болсон билээ. Түүнийг хэрхэн мөнхийн болгож болохыг одоо би хэлж өгье, та анхааралтай сонсоорой. Та гэртээ эргэж хариад Мучукунда хааны үзэсгэлэн гоо охин Чандрабхагад надаас сонссон бүхнээ бүгдийг нь ярьж хэлэх аваас миний энэ хот түүний тусламжтайгаар мөнхрөлийг олж чадах болно.

Брахман гэртээ эргэж хариад Чандрабхагад бүгдийг нь ярьж өгсөн. Энэхүү сониныг сонсоод тэр үгээр илэрхийлэхийн аргагүйгээр гайхаж, мөн баярлан: “Ай брахман минь ээ, энэ чинь үнэ явдал уу? эсвэл зүүд байсан уу?” гэж асуусан. Сомашарма хариулсан нь: Ай гүнж минь ээ, хагас бурхдын улс гүрэнтэй адил тийм тансаг орондоо байсан таны нөхрийг би харсан нь ямар ч эргэлзээгүй үнэн билээ. Харин тэр, түүний улс гүрэн нь удаан хугацааны туршид оршин тогтнохгүй бөгөөд хэзээ хэзээгүй сарнин, устан үгүй болно гэж хэлсэн билээ. Тэр өөрийн улс гүрнээ хэрхэн мөнхийн болгох арга замыг таныг мэднэ гэдэгт маш ихээр итгэж найдаж байна.

Чандрабхага хэлсэн нь: Ай брахмануудын дундахь мэргэн минь ээ, та намайг одоохон миний нөхөр дээр хүргэж өгөөч. Би түүнтэй учран золгохыг маш их хүсэж байна. Би түүний улс орныг мөнхийн болгож чадна. Амьдралдаа тохиосон бүх экадашуудыг баримталсан учраас би онцгой адислалыг хүртсэн билээ. Та биднийг аль болох хурдан учруулж өгөөч. Салж хагацсан хүмүүсийг холбон уулзуулсан хэн бүхэн аугаа ач тусыг хүртдэг гэж ярьдаг шүү дээ.

Ингээд Сомашарма брахман Чандрабхагаг Шобханы туяаран гэрэлтэх улс гүрэнд дагуулан очив. Түүн рүү орохын өмнө тэд Мандарачала уулын бэл дэх Вамадевагийн *ашрамд* буудалласан. Вамадева ведийн дуулуудыг магтан дуулан, Чандрабхагын түүхийг сонсонгоо түүнийг ариун усаар цавдсан. Энэхүү аугаа *ришигийн* үйлдэх ариусгах зан үйлийн үйлчлэл нөлөөллийн доор экадашийн бүхий л өдрүүдийг баримталсанаар Чандрабхагын хүртсэн адислалын ач тус нь түүний биеийг трансценденталь болгосон. Дур булааж хайр хүрмээр нүднээсээ гэрэл цацруулсан Чандрабхага урам орон замаа цааш үргэлжлүүлэв.

Мандарачала уулын орой өөд өгсөн ирж яваа эхнэрээ хараад Шобхана баяр хөөрөөр дүүрч, аз жаргалаасаа болж дуу алдан хашгирсан. Чандрабхага түүний дэргэд ирж зүүн талд нь суугаад хэлсэн нь: Ай хайрт минь ээ, би чамд маш тустай нэгэн зүйлийг хэлэхийг сонсоно уу. Би найман настайгаасаа эхлэн тохиосон экадашийн өдөр бүрт бүрэн итгэлтэйгээр үргэлж мацаг барьж ирсэн билээ. Хэрвээ би өөрийн хүртсэн бүхий л ач тусаа чамд шилжүүлэн өгөх аваас чиний улс гүрэн мөнхөд оршин тогтнох бөгөөд хэмжээлшгүй ихээр элбэг дэлбэг болж улам бүр цэцэглэн дэлгэрэх болно.

Бурхан Кришна үргэлжлүүлэн айлдсан нь: Ай Юдхитхира минь ээ, Гоё сайхан чимэглэл нь гэрэлтэн цацарсан трансценденталь биетэй болсон Чандрабхага эцэстээ ийнхүү нөхөртэйгөө хамт амар сайхан жаргасан ажгуу. Рама экадашийн хүчээр Шобхана нь *Кама-дхена* үнээ адил мөнхийн аз жаргал хүртээдэг хийгээд бүхий л хүслийг биелүүлдэг чадвартай, Мандарачала уулын орой дээр орших улс гүрэнтэй болсон.

Ай хаадын хаан минь ээ, Би чамд Рама экадашийн яруу алдрын талаар айлдлаа. Сар бүрийн гэрэлтэй болоод харанхуй хагаст тохиодог экадашийн ариун гэгээн өдрийг баримталдаг хэн бүхэн нүгэлт, тэр ч бүү хэл брахманыг хөнөөсөн зэрэг аймшигт бузар нүгэлт үйлийнхээ үр дагавраас ч салан ангижирах нь эргэлзээгүй. Сарын гэрэлтэй болон харанхуй хагаст тохиодог экадашуудын хооронд ялгаа гаргах хэрэггүй. Хар болон цагаан зүсмийн үнээнүүд нэг л хэмжээний сүү өгдөгтэй адил харанхуй болоод гэрэлтэй хагасын экадаши нь нэг л ач тусыг хүртээдэг бөгөөд эцсийн эцэст төрөлт үхлийн хүрднээс ангижруулдаг. Рама экадашийн энэхүү ариун гэгээн өдрийг магтан дуулахыг зүгээр л сонсож байгаа хэн бүхэн бүхий л нүглээсээ салан ангижрах бөгөөд Бурхан Вишнугийн дээдийн дээд оронд хүрч очдог.

Рама экадаши буюу Картика-Кришна экадашийн яруу алдрын тухай Брахмавайварта Пуранаас авсан хүүрнэл ийнхүү өндөрлөлөө.

ХАΡΙΒΟԁХИНИ ЭКАДАШИ

Брахма бурхан Нарада Мунид хандан хэлсэн нь: Ай хайрт хүү минь ээ, ай мэргэдийн шилдэг нь минь ээ, Бүхний Дээд Бурханд чин бишрэлээр зүтгэдэг мэргэн хүмүүст аугаа их ач тусыг хийгээд дээдийн дээд ангижралыг хайрлан хүртээдэг болон бүхий л нүглийг устган зайлуулдаг Харибодhini экадашийн яруу алдрын тухай би чамд өгүүлье.

Ай брахмануудын шилдэг нь минь ээ, Ганга мөрөнд угаал үйлдсэнээр хүртдэг ач тус нь Харибодhini экадаши гэж бий болох үе хүртэл л ач холбогдолтой байсан. *Картика* сарын гэрэлтэй хагаст тохиодог энэхүү экадаши нь мөргөлийн газар орон болон далайд угаал үйлдэхээс ч хавьгүй илүү хүчтэй. Энэ ариун гэгээн экадаши нь нүглийг устган зайлуулахдаа *Раиасуйя* тахилга өргөлийг 100 удаа болон *Ашвамедха* тахилга өргөлийг 1000 удаа үйлдсэнээс ч илүү хүчирхэг билээ.

Хагас бурхдын дундахь мэргэн Нарада Муни өгүүлсэн нь: Ай эцэг минь ээ, экадашийн өдөр үр тариа болон буурцагт ургамал оруулалгүйгээр үд дундад эсвэл орой нэг удаа хооллох эсвэл бүхий л өдрийн туршид бүтэн мацаг барьснаар ямар шинж чанартай болдог талаар тодорхойлон хэлж өгнө үү.

Брахма бурхан хариулсан нь: Хэрвээ хүн экадашийн өдөрт, зөвхөн нэг удаа үд дундад хоол идэх аваас түүний өмнөх төрөлдөө үйлдсэн нүгэл, хэрвээ зөвхөн орой нэг удаа хооллох аваас түүний өмнөх хоёр төрөлдөө үйлдсэн нүгэл, харин юу ч үл идэх аваас түүний өмнөх долоон төрөлдөө үйлдсэн нүгэл бүгд устан арилдаг.

Ай хүү минь ээ, Харибодhini экадашийг нарийн чанд баримталж байгаа хүн энэ гурван ертөнцөд хүрэхэд хүнд бэрх байдаг тэр л зүйлийг хүртдэг. Хэн нэгний нүгэл нь Сумеру уултай харьцуулахуйц их байсан ч Папахарини буюу Харибодhini экадашид бүтэн мацаг барьснаар тэр их нүгэл нь түүнээс бүрэн арилан зайлдаг. Хэрвээ хүн мацаг барихын зэрэгцээ экадашийн шөнийг унталгүй сэрүүн өнгөрүүлэх аваас түүний өмнөх мянган амьдралын туршид хуримтлагдсан нүгэл нь уул шиг овоолж нуруулдсан хөвөн бялт хүргэх төдийд шатдагийн адил үнс нурам болон үгүй болдог. Энэхүү экадашид мацгийг нарийн чанд барьж байгаа хүн дүрэм журмыг баримтлан их биш ч гэсэн, ач тустай үйл үйлдэх аваас тэр Сумеру уултай дүйхүүц тийм их ач тусыг хүртдэг. Харин ариун гэгээн судруудын зааврыг үл даган баримтлах хүн Сумеру уул мэт ач тустай үйл үйлдэн байсан ч ямар ч ач тусыг эс олно.

Гаятри мантраг өдөр бүр гурван удаа эс магтан дуулж байгаа, ариун гэгээн судруудыг шүүмжлэн, Бурханд үл итгэн, мацаг барихыг үл тоомсорлож

байгаа, Вед нь түүнийг даган мөрдөж байгаа хүнд зөвхөн сүйрэл мөхөл авчирдаг гэж бодож байгаа, бусдын эхнэртэй зугаацаж байгаа, туйлын тэнэг мунхаг бөгөөд шудрага бус байгаа, бусдыг хууран мэхэлж байгаа- ийм хүн, ай хүү минь ээ, шашин номын ямар нэгэн үйлийг хэзээ ч амжилттай хийж үйлдэж чаддаггүй. Бусдын эхнэртэй, ялангуяа хоёрдахиа төрөгчийн эхнэртэй таашаал ханамж эдэлж байгаа хүн хэн ч байсан, брахман ч байна уу, шудра ч байна уу ялгаагүй нохойгоор хооллогчоос дээрдэх юмгүй билээ¹.

Ай мэргэн минь ээ, өөр нэгэн брахманы эхнэртэй эсвэл бэлбэсэн эхнэртэй таашаал ханамж эдлэх ямар ч брахман нь өөрийгөө болон өөрийн гэр бүлдээ сүйрэл учруулж байгаа хэрэг юм. Үл зөвшөөрөгдсөн бэлгийн таашаал ханамж эдэлж буй ямар ч брахманд дараагийн амьдралд нь үр хүүхэд заяадаггүй бөгөөд түүний хүртэж буй бүхий л адислал нь нуран унасан балгас адил ямар ч хэрэггүй болдог. Хоёр дахиа төрсөн брахман болон номын багшдаа хүндэтгэлтэй бусаар хандаж байгаа хүний бурханлаг хөгжил дэвшил нь зогсохын зэрэгцээ үр хүүхдүүдийн нь сайн сайхан байдал үгүй болно.

Зүй бус, журамгүй байгаа, нохойгоор хооллогчийн эхнэртэй бэлгийн таашаал ханамж эдэлж байгаа, үл бүтэх, шившигтэй хүмүүсийн хүрээлэлд байж харьцахдаа ханамжтай байгаа зэрэг энэ гурван төрлийн хүмүүс нь өөрсөддөө хор хөнөөл учруулж байдаг. Нүгэлтнүүдтэй харьцдаг хийгээд тэдний гэр оронд бурханлаг зорилго агуулалгүйгээр очиж байгаа хүн эрлэгийн хаан, Ямаража бурханы оронд унах болно. Энэхүү өдөр тийм айлд хоол идэж байгаа хүний хүртсэн ач тус нь үгүй болж, хувь заяа, амьдралын нь үргэлжлэх хугацаанд муу нөлөө үзүүлэх бөгөөд мөн үр хүүхдүүдэд нь ч тийм тусгал нөлөө үзүүлдэг.

Ариун гэгээн хүнийг басамжлан доромжилж, алдас хийж байгаа үл бүтэх этгээдийн бишрэл шүтлэг, эдийн засгийн элбэг дэлбэг байдал буюу материаллаг талын чинээлэг хангалуун байдал, мэдрэхүйн таашаал ханамж нь маш хурдан барагдан үгүй болж эцэстээ тамын галд шатах болно. Ариун гэгээн хүмүүсийг басамжлан доромжилж байгаа эсвэл тэднийг басамжлан доромжилж алдас хийгчийг зогсоон болиулахгүй байгаа хэн бүхнийг илжигнээс дээрдэх юмгүй гэж үздэг. Ийм тэнэг мунхаг хүн тэр амьдралдаа л өөрийн удам угсаа нь тасран, устаж сүйрэхийг харах болдог.

Цэвэр ариун бус зан төлөвтэй хүн, үл бүтэх шившигийн этгээд болон хууран мэхлэгч, бусдаас үргэлж өө сэв эрэн гоочлогч нь байнгад өглөг хандив тарааж эсвэл эрхэм хүндэтгэлт үйлүүд үйлдэж байсан ч үхлийн дараагаар эрхэм дээд зорилгодоо хүрч чадахгүй. Иймээс хүн бүр таатай бус үйл үйлдэхийг цээрлэн зөвхөн эрхэм хүндэтгэлт үйлүүдийг үйлдэж байх ёстой бөгөөд тэдгээрийн тусламжтайгаар тэр зовлон шаналалаасаа салан ангижирч төгс төгөлдөрт хүрнэ.

Гэхдээ Харибодхини экадашид мацаг барьснаар хүн өөрийн өмнөх 100 амьдралынх нь туршид хуримтлагдсан эдгээр нүглүүдийг угаан арилгадаг. Харин зөвхөн мацаг барьсан төдийгүй мөн экадашийн шөнийг сэрүүн өнгөрүүлж байгаа хүн бие махбодио орхисны дараагаар Вишну Бурханы залрах оронд дээшлэн хүрч очих бөгөөд түүний 10 мянган төрөл төрөгсөд болон ойр дотнынхон нь мөн түүнийг даган тийш зүглэдэг. Түүний өвөг дээдэс нь маш их нүгэл үйлдэн, түүнийхээ төлөө тамд унан зовж тарчилж байсан ч тэд тансаг сайхан гоёл чимэглэл бүхий бурханлаг биеийг авцгаан Вишну Бурханы орон тийш аз жаргалтайгаар даган одоцгоодог.

Ай Нарада минь ээ, брахманыг хөнөөсөн бузар нүгэлд буруутай байгаа хүн ч Харибодхини экадашид мацаг барингаа шөнийг унталгүй сэрүүн байж өнгөрүүлснээр өөрийн зан авирын жигшүүрт байдлаас салан ангижирдаг. Үнээ, алт болон үржил шимтэй газраар өглөг өгөх, мориор тахилга өргөл өргөх, мөргөлийн бүхий л ариун дагшин газар орнуудад угаал үйлдсэнээр ч хүртэхийн аргагүй тийм ач тусыг энэхүү ариун гэгээн өдөрт мацаг барин шөнийн туршид унталгүй сэрүүн байснаар хүртэж болно. Харибодхини экадашийг баримтлан

байгаа хүн бүрийн ухамсар дээшлэхийн зэрэгцээ өөрийн удам угсааг алдаршуулдаг. Үхэл бол зайлшгүй, иймээс эд баялгаа алдан тэднээс салан хагацах нь мөн зайлшгүй хэрэг. Энэ тухай мэдсэнээр, ай мэргэдийн шилдэг нь минь ээ, хүн бүр Бурхан Харид маш эрхэм Шри Харибодхини экадашид мацаг барих ёстой.

Экадашид мацаг барьж байгаа хүний гэр оронд бүхий л гурван ертөнцийн мөргөлийн газар орон ирж хуран цугладаг. Иймээс, мутартаа галт хүрд барин байгаа Бурханыг цэнгүүлэхийн тулд Бурханд чин бишрэлээр зүтгэж байгаа хүн бүр экадашид мацаг барин бүх дүрэм журмуудыг биелүүлэх ёстой. Харибодхини экадашид мацаг барьж байгаа хүнийг мэргэн, жинхэнэ иогч, тэвчил үйлдэгч, өөрийн мэдрэхүйг үргэлж эзэмдэн захирч удирддаг хүн гэж үздэг. Зөвхөн тэр л энэ ертөнцөд төгс төгөлдөр байдлаар цэнгэл жаргалыг эдэлдэг бөгөөд түүний ангижралд хүрдэг нь эргэлзээгүй хэрэг билээ. Энэхүү экадаши нь Бурхан Вишнуд маш эрхэм байдаг бөгөөд иймээс ч тэр бишрэл шүтлэгийн хамгийн гол учир утга болдог. Экадашид мацаг барихуй нь бүхий л гурван ертөнц дэх дээдийн дээд шагнал, соёрхлыг хайрлан хүртээдэг.

Ай Нарадажи минь ээ, экадашид мацаг барьж байгаа хүнд дахин төрөх явдал учирдаггүй. Иймээс энэ экадашид Бүхний Дээд Бурханы итгэл дүүрэн чин бишрэлтэнгүүд нь шашны бүхий л хэлбэрүүдийг орхин, мацаг барихуйд л автдаг билээ. Экадашид мацаг барин, шөнийг сэрүүн өнгөрүүлж байгаа сүнсний буюу хүний үг хэл, бие болон ухааны үйлдлүүдээрээ үйлдсэн нүглийн үр дагаврыг Бүхний Дээд Бурхан, Шри Говинда Өөрөө биечлэн устган арилгадаг билээ.

Ай хүү минь ээ, мөргөлийн газар орнуудад угаал үйлдэж байгаа, өглөг тарааж байгаа, Бүхний Дээд Бурханы ариун гэгээн нэр алдрыг магтан дуулж байгаа, тэвчил наманчлал үйлдэж байгаа болон Харибодхини экадашийн өдөр Бурханд өргөл өргөж буй хүн бүр мөнхийн ач тусыг хүртдэг. Энэ өдөр гойд тансаг чимэглэлээр чимэглэсэн Мадхава Бурханд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн мөргөж байгаа чин бишрэлтэн өмнөх 100 амьдралынхаа хүнд бэрх нүглүүдээс салан ангижирдаг. Энэхүү мацгийг барин Бурхан Вишнуд бишрэл хүндэтгэлээ зөв илэрхийлэн мөргөж байгаа хүн асар их аюул ослоос мултран зайлдаг.

Харибодхини экадаши нь Жанардана Бурханд маш их баяр баяслыг төрүүлдэг бөгөөд энэ өдөрт мацаг барьсан хүнийг Тэр Өөрийн залрах оронд буцаан аваачдаг. Гоо үзэсгэлэн, аз жаргалыг хүсэж байгаа хүн Харибодхини экадашийг, ялангуяа түүнийг *двадашид* тохиох үед нь бишрэн хүндэтгэхийг хичээн чармайх хэрэгтэй. Харибодхини экадашид чин бишрэлтэйгээр мацаг барьж байгаа хүний өмнөх 100 амьдралын нь нүглийг, хүүхэд ахуй, залуу болон нас ахисан үеийн нь нүглийг Бүхний Дээд Бурхан Говинда “нойтон” эсвэл “хуурай” байсан гэдгээс нь үл хамааран устган үгүй болгодог².

Харибодхини экадаши бүх өдрүүдийн шилдэг сайн нь. Экадаши нь элбэг арвин үр тариа, хариу өршөөл ивээл болон дээдийн дээд ач тусыг хүртээдгийн зэрэгцээ ангижралд хүрэх зам мөр дээр үндсэн гол саад тотгор болж байдаг бүх нүглээс ангижруулдаг учир энэ өдөр мацаг барьж байгаа хүний хувьд энэ ертөнцөд хүрэх аргагүй зүйл гэж байдаггүй. Энэхүү экадаши дахь мацаг нь нар эсвэл сар хиртсэн өдөр өглөг хандив тараахаас 1000 дахин илүү сайн, ач тустай байдаг.

Ай Нарадажа минь ээ, ариун мөргөлийн газруудад угаал үйлдэх, өглөг хандив тараах, *жала*-давтан хэлэх, ведийн мантраг иш татан хэлэх, тахилга өргөл үйлдэх болон Ведийг судалсанаар хүртэх ач тус нь Харибодхини экадашид ганцхан удаа мацаг барьсан хүний ач тусын 10 саяны нэгтэй л тэнцэхүйц байдаг гэдгийг чамд дахин хэлье.

Эрхэм хүндэтгэлт үйл үйлдэх замаар амьдралдаа хүртэж болох бүхий л ач тус нь экадашид мацаг барих болон Бурхан Вишнуд *Картика* сард бишрэл

хүндэтгэлээ илэрхийлэн мөргөөгүй л бол ямар ч хэрэггүй байдаг. Иймээс Нарада минь ээ, чи Бүхний Дээд Бурхан Жанарданад бишрэл хүндэтгэлээ үргэлж илэрхийлэн мөргөж, Түүнд үйлчлэн зүтгэж байх хэрэгтэй. Ингэснээр л чи хүссэн зорилго- дээдийн дээд төгс төгөлдөрт хүрэх болно.

Харибодhini экадашид Бурханы чин бишрэлтэн нь бусдын гэрт болон чин бишрэлтэн бусчуудын бэлтгэж хийсэн хоол ундыг идэж ууж болохгүй. Үүнийг эс баримтлах аваас тэр тэргэл сартай өдөрт мацаг барьсанаар хүртэх тийм л ач тусыг хүртэнэ. *Картика* сард ариун гэгээн судруудын гүн ухааны хэлэлцүүлэг хийх нь Шри Вишнугийн таалалд заан, агт морь бэлэглэх эсвэл үнэ цэнэ ихтэй тахилга өргөл үйлдэхээс илүү ихээр нийцдэг. Бурхан Вишнугийн зугаа наадам болон шинж чанарын талаар тодорхойлон өгүүлснээс ядаж хагас шүлэг, бүр ядаж дөрөвний нэг хэсгийг ч давтан хэлж, магтан дуулж эсвэл сонсож байгаа хүн брахманд зуун үнээ бэлэг болгон өргөж байгаатай адил ач тусыг хүртдэг. Ай Нарада минь ээ, *Картика* сард ердийн ажил үйлийнхээ бүхий л хэлбэрийг орхиж, өөрийн бүх цаг, эрч хүчийг бүгдийг нь, ялангуяа мацаг барих үедээ, Бүхний Дээд Бурханы трансценденталь зугаа наадмыг хэлэлцэхэд зориулах хэрэгтэй. Бурханд маш эрхэм байдаг экадашид Шри Хариг ийнхүү магтан алдаршуулсан хүний өмнөх 100 үеийнхэн ангижралыг олдог. Ийнхүү хэлэлцэн цэнгэл жаргалыг эдлэхэд, ялангуяа *Картика* сард, өөрийн цагаа зориулж байгаа хүн бүр 10 мянган тахилга өргөл үйлдсэнтэй дүйхүүц ач тус, үр шимийг хүртэх ба түүний бүх нүгэл нь үнс нурам болтлоо шатан үгүй болно. Бурхан Вишнугийн тухай эрхэм дээд хүүрнэлийг, ялангуяа *Картика* сард сонсож байгаа хүн 100 үнээгээр тахилга өргөл өргөсөнтэй адил ач тусыг аяндаа хүртэх болно. Ай аугаа мэргэн минь ээ, экадашид Хари Бурханы яруу алдрыг магтан дуулж байгаа хүн долоон арлаар өргөл өргөсөнтэй адил ач тусыг хүртдэг.

Нарада Муни алдар цуутай эцгээсээ асуусан нь: Ай бүгдийн бурхан минь ээ, ай хагас бурхдын шилдэг нь минь ээ, энэхүү ариун гэгээн экадашийг хэрхэн яаж баримталдаг тухай надад өгүүлэх ажаам уу, Итгэл дүүрэн баримтлах хүн ямар ач тус, гавьяа шагналыг хүртдэг вэ?

Брахма бурхан хариулсан нь: Ай хүү минь ээ, энэхүү экадашийг баримтлахыг хүсэж байгаа хүн өглөө эрт *брахма-мухурта-ын* үед (нар мандахаас 1 цаг 30 минутаас 50 минутын хооронд) босох ёстой. Шүдээ сайтар цэвэрлэн, боломж нөхцлөөсөө хамааран нуур, гол, усан сан, булаг эсвэл гэртээ угаал үйлдэх хэрэгтэй. Бурхан Шри Кешавад бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн мөргөсний дараагаар Бурханы ариун гэгээн судруудыг маш их анхааралтайгаар сонсох хэрэгтэй. Чин бишрэлтэн Бурханд хандан: “Ай Бурхан Кешава минь ээ, Танд маш эрхэм байдаг энэхүү өдөр би мацаг барина. Харин маргааш би Таны ариун гэгээн *прасадамыг* магтан дуулж алдаршуулах болно. Ай бадамлянхуа мэлмийт Бурхан минь ээ, ай нүгэл үгүй минь ээ, Та бол миний цорын ганц авран ивээгч билээ. Та намайг өмгөөлөн хамгаалж хайрлаач.” гэж залбирах ёстой.

Бурханы өмнө энэхүү цог жавхлантай залбирлыг аугаа их хайр чин бишрэлтэйгээр айлтган мацгийг нарийн чанд барих ёстой. Ай Нарада минь ээ, экадашийн шөнийн туршид унталгүй сэрүүн байх, Бурханыг алдаршуулан магтан дуулах, экстаз буюу онгод хөөрөлтэйгээр бүжиглэх, Бурханы трансценденталь цэнгэлд зориулан эрхэм сайхан аялгуу эгшгүүдийг хөгжмийн зэмсэг дээр тоглох болон төгс төгөлдөр ведийн судруудад тодорхойлон бичсэн байдаг Бурханы зугаа наадмуудын талаар ярьж хүүрнэх хэн бүхэн гурван ертөнцийн хүрээ хязгаарын чанадад орших, Бурханы залрах бурханлаг ертөнцөд дээшлэн хүрч очдог нь эргэлзээгүй.

Харибодhini экадашид Шри Кришнад бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн гавар, анхилуун сайхан үнэртэй жимс болон цэцэг, ялангуяа шар өнгөтэй *агару* цэцэг өргөх хэрэгтэй. Энэ онцгой өдөр өөрийн анхаарлыг олз, ашиг хонжоо харсан зүйлд хандуулахгүй байх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, шунал тачаалыг хөдөлгөх үйлийг тэтгэн туслах үйлээр солих хэрэгтэй. Хорогдол үрэгдлийг ингэж

л хэмжээлшгүй их ач тус болгон хувиргадаг билээ. Бурханд янз бүрийн үр жимсийг өргөн, Түүнийг дун-д хийсэн усаар угаах хэрэгтэй. Харибодхиний экадашид үйлддэг чин бишрэлийн ийм үйл нь өглөг хандив, тэтгэн туслах үйлийн бүхий л хэлбэрүүд болон мөргөлийн ариун дагшин газруудад угаал үйлдэхээс 10 сая дахин илүү өршөөл ивээлтэй байдаг.

Энэхүү өдөр Бурхан Жанарданад шинэ *агастья* цэцэг өргөж бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн мөргөж байгаа чин бишрэлтэнд Индра бурхан хүртэл өөрөө алга хавсран хүндэтгэлээ илэрхийлдэг билээ. Бүхний Дээд Бурхан Хари, Өөрийг нь гоё сайхан *агастья* цэцгээр чимэглэхийг ихэд таашаадаг. Ай Нарада минь ээ, Картика сарын экадашид *бел* модны навчийг Бурхан Кришнад чин бишрэлтэйгээр өргөн бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн мөргөж байгаа хэн бүхэнд би ангижралыг хайрладаг билээ. Бурхан Жанарданад *туласийн* навч болон анхилуун үнэртэй цэцгийг бүхий л сарын турш өргөн бишрэл хүндэтгэлээ илэрхийлж байгаа хэн бүхний 10 мянган амьдралын нь бүхий л нүглийг би өөрөө биечлэн үнсэн товрог болгон шатаадаг.

Туласи Махараниг зүгээр л харж байгаа, түүнд хүрэн шүргэж байгаа, түүнийг бясалгаж байгаа, түүний түүхийг ярьж өгүүлж байгаа, түүнд хүндэтгэлээ илэрхийлж байгаа, түүнээс өршөөл ивээл гуйж байгаа, түүнийг тарьж ургуулж байгаа, түүнд мөргөж байгаа, түүнийг усалж байгаа хүн Хари Бурханы оронд мөнхөд амьдрах болно. Ай Нарада минь ээ, энэ есөн арга янзаар Туласи девид үйлчлэн зүтгэж байгаа хүн ургаж гүйцсэн *туласийн* салаа болон үндэсний тоотой адил тийм олон-мянган *югын* туршид, дээд ертөнцийн аз жаргалаар цэнгэн жаргадаг. *Туласи* нь ургаж гүйцээд үрээ өгч эхлэхэд үрнээс нь мөн олон олон шинэ *туласийн* моднууд ургадаг бөгөөд тэд мөн цэцэглэн олон тооны үр өгдөг билээ. *Туласид* дээрх есөн аргаар үйлчлэн зүтгэж байгаа хүний өвөг дээдсүүд нь Хари Бурханы оронд энэ бүх ургамлуудын өгч байгаа үр шиг тийм олон-мянган *кальпын* туршид амьдрах болно³.

Кешава Бурханы таалалд маш ихээр нийцдэг *кадамба* цэцгийг Түүнд өргөн бишрэл хүндэтгэлээ илэрхийлж байгаа хүн Түүний өршөөл нигүүлслийг хүртэн, биелсэн үхэл Ямаражагийн орныг хэзээ ч үздэггүй. Хари Бурханы таалалд нь нийцүүлэн Түүнийг цэнгүүлснээр бүхий л хүсэл биелэгддэг байхад өөр бусад бишрэл хүндэтгэл ямар хэрэг байх билээ? Түүнд *бакула*, *ашока* болон *патали* цэцгийг өргөн байгаа чин бишрэлтэн орчлонд нар болон сар оршин байсан цагт зовлон гаслангаас чөлөөтэй байх ба эцэст нь тэрээр ангижралд хүрнэ. Ай брахмануудын шилдэг нь минь ээ, Жаганнатха Бурханд *каннера* цэцэг өргөн байгаа чин бишрэлтэн, Кешава Бурханд дөрвөн *югын* туршид бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн мөргөснөөр хүртэх тийм хэмжээний өршөөл нигүүлслийг хүртдэг. *Картика* сард Кришна Бурханд *туласийн* цэцгийн сор булцуу (*манжари*⁴) өргөн байгаа хүн 10 сая үнээ өргөл болгон өргөснөөс илүү их ач тусыг хүртдэг. Тэр ч бүү хэл, өвсний шинэ шилбийг чин бишрэлтэйгээр өргөх нь Бүхний Дээд Бурханд ердийн зан үйлийн хүндэтгэл бишрэл үзүүлснээс 100 дахин илүү адислал хайрладаг.

Бурхан Вишнуд *семика* модны навч өргөн бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн мөргөж байгаа хүн эрлэгийн хаан Ямаражагийн торноос чөлөөлөгддөг. Борооны улиралд Бурхан Вишнуд *чампака* болон жасмина цэцэг өргөн бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн мөргөж байгаа хүн газар дэлхий дээр хэзээ ч дахин буцаж ирдэггүй. Бурханд зөвхөн ганц *кумбхи* цэцэг өргөснөөр *палы* алт (200 грамм) өргөл болгон өргөсөнтэй адил ач тус, үр шимийг хүртдэг. Гарудаг хөлөглөн залрах Вишну Бурханд алимны модны ганц шар цэцэг *кетакиг* өргөж байгаа чин бишрэлтэн 10 сая төрөлтийнхөө нүглээс чөлөөлөгдөн ангижирдаг. Бурхан Жаганнатхад цэцэг өргөн байгаа бол бүр илүү. Мөн тэрчлэн, дээр нь зандан модны шар болон улаан өнгөтэй оо түрхсэн зуун навч өргөж байгаа хэн бүхэн материаллаг ертөнцийн хүрээ хязгаарын чанадад орших Шветадвипад хүрдэг нь эргэлзээгүй билээ.

Цааш нь, ай брахмануудын аугаа нь болох Шри Нарада минь ээ, Харибодхини экадашид материаллаг болоод бурханлаг аз жаргалыг хайрлан хүртээгч Кешава Бурханд бишрэл хүндэтгэлээ илэрхийлсний дараа, дараагийн өдөрт нь өглөө эртлэн босож голын усанд угаал үйлдэж, Кришнын ариун гэгээн нэр алдар, *жалаг*⁵ давтан хэлж, гэртээ Бурханы чин бишрэлийн алба үйлэнд аль болох дээд зэргээр зүтгэх хэрэгтэй.

Мацгаа тайлахын өмнө чин бишрэлтэн нь брахмануудыг *прасадамаар* дайлах хэрэгтэй бөгөөд зөвхөн үүний дараагаар л тэдний зөвшөөрснөөр ямар нэгэн үр тарианы зүйл идэж болно. Тэгээд, Бүхний Дээд Бурханы таалалд нийцүүлэн, Түүнийг цэнгүүлэхийн тулд чин бишрэлтэн нь Бурханы чин бишрэлтэнгүүдээс хамгийн цэвэр ариун нь байдаг өөрийн номын багшдаа бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн мөргөж өөрийн боломж нөхцлөөрөө тансаг сайхан идээ зоог, хамгийн сайн хувцас, алт болон үнээг өргөх хэрэгтэй. Ингэх нь Бүхний Дээд Бурханы таалалд нийцэх нь яриангүй хэрэг.

Дараа нь, бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн байгаа тэрээр брахманд үнээ бэлэглэх хэрэгтэй. Хэрвээ тэр аль нэгэн дүрэм журам болон зохицуулах зарчмыг эс тоомсорлон, үл хайхарсан байх аваас Бурханы чин бишрэлтэн энэ брахманд үнэнээ хэлэн, нүглээ наманчлах хэрэгтэй. Үүний дараагаар брахманд *дакшина* (мөнгөн өргөл) өргөх хэрэгтэй. Ай хүү минь ээ, экадашид оройн хоол идсэн хүн дараа өдөр нь брахманыг хооллох хэрэгтэй. Ингэх нь Бүхний Дээд Бурханы таалалд ихээр нийцдэг.

Ай хүү минь ээ, хэрвээ хүн өөрт нь номлол, сургаал хайрлагч буюу өөрийг нь гэгээрүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр мацаг барьж байгаа эсвэл эхнэр нь нөхрийнхөө зөвшөөрөлгүйгээр мацаг барьж байгаа бол брахманд бух өргөл болгон өргөх хэрэгтэй. Бал болон тараг нь мөн брахманд өргөвөл зохих бэлэг юм. Экадашид зөвхөн жимс идсэн хүн дараа өдөр нь жимсээр өргөл өргөх хэрэгтэй. Шалан дээр унтсан хүн хөвөнтэй хөнжил бүхий ор, навчаар хийсэн тавагнаас хоол идсэн хүн шар тостой сав, юу ч ярилгүй дуугүй байж өнгөрөөсөн хүн хонх, кунжут хэрэглээгүй хүн алтаар өргөл өргөн хоёр брахманыг тансаг сайхан идээ зоогоор дайлах хэрэгтэй. Халзарч байгаагаа зогсоон, үгүй болгохыг хүсэж байгаа хүн брахманд толь, хуучирч элэгдсэн гуталтай хүн брахманд шаахай бэлэглэх хэрэгтэй. Давс хэрэглэлгүйгээр мацаг барьсан хүн брахманд бага зэргийн сахар өргөл болгон өргөх хэрэгтэй. Бүхий л сарын туршид хүн бүр Вишну Бурханы эсвэл Шримати Туласи девигийн сүмд шар тосоор зул байнга, тогтмол өргөж байх хэрэгтэй.

Зохистой брахманд шар тос дүүргэсэн алтан эсвэл зэс сав, эсвэл шар тос шингээсэн зулын голыг алтаар дүүргэж даавуугаар бүтээсэн найман савын хамтаар өргөх аваас экадашид барьсан мацаг төгс төгөлдөр болдог. Ийм бэлэг барих чадваргүй хүн брахманд сайн сайхан үгсийг хэлэх хэрэгтэй. Ийн үйлдэж байгаа хүн экадашид барьсан мацгийн адислалыг бүрэн дүүрэн хүртэх нь эргэлзээгүй⁶. Хүндэтгэлээ илэрхийлээд зөвшөөрөл авсаны дараагаар чин бишрэлтэн хооллох ёстой.

Энэхүү экадаши нь *Чатурмасьяг* өндөрлөн төгсгөдөг бөгөөд *Чатурмасьяд* цээрлэсэн тэр зүйлээ брахманд өргөл болгон өргөх ёстой байдаг. *Чатурмасьяг* баримталж байгаа хүн тоймгүй их ач тусыг хүртдэг бөгөөд бие махбодио орхисны дараагаар Бурхан Васудевагийн оронд дээшлэн хүрдэг. *Чатурмасьяг* ямар ч тасалдалгүйгээр, бүрэн хэмжээгээр баримталж байгаа хэн бүхэн мөнхийн аз жаргалд хүрдэг бөгөөд дахин хэзээ ч төрдөггүй. Харин мацгийг хэн нэгэн нь тасалдуулах аваас тэр сохор эсвэл уяман өвчтэй болдог.

Ийнхүү би чамд Харибодхини экадашийг баримтлах төгс төгөлдөр арга замыг өгүүлээ. Энэхүү экадашийн тухай сонсож байгаа болон уншиж байгаа хэн бүхэн зохистой брахманд үнээгээр өргөл өргөсөнтэй тэнцэхүйц хэмжээний ач тусыг хүртдэг.

Харибодхини экадаши буюу Девоттхани экадаши гэж алдаршсан Картика-шукла экадашийн яруу алдрын тухай Сканда Пуранаас авсан хүүрнэл ийнхүү өндөрлөлөө.

Тайлбар:

1. *Шудрагийн* гэрт хоол идэж байгаа, *шудрагуудын* дунд найз нөхөдтэй болж байгаа, *шудра* эмэгтэйтэй унтаж байгаа хүн энэ амьдралдаа л *шудра* болдог. Тэрээр дараагийн 100 төрөлдөө нохойгоор хооллогчийн гэр бүлд төрдөг гэж Ведэд өгүүлдэг.

2. Падма Пуранад өгүүлсэнчлэн, хэрвээ хүн Бурханы ариун гэгээн нэр алдрыг магтан дуулж давтан хэлэхийн хүчээр ямар ч гэсгээл шийтгэлгүйгээр зүгээр өнгөрнө гэж үзэн санаатайгаар нүгэл үйлдэж байгаа хүний хувьд ариуслын ямар ч арга зам байдаггүй. Санаатайгаар үйлдэж буй нүглийг “нойтон” гэж нэрлэдэг бол санамсаргүйгээр үйлдсэн нүглийг “хуурай” гэж нэрлэдэг. Энд, Брахма бурхан, Харибодхини экадашийг баримталснаар “нойтон” болон “хуурай” бүхий л нүглээс ангижирдаг гэж хэлж байна.

3. Нэг *кальла* нь Брахма бурханы 12 цаг буюу газар дэлхийн тооллоор 4 320 000 000 жилийн туршид үргэлжилдэг.

Бурхан Кришна Бхагавад Гитагийн (8.21)-д: “Хүн тэнд нэг л хүрсэн бол хэзээ ч буцаж ирдэггүй тэр орон бол Миний дээдийн дээд орон билээ.” гэж айлдсан.

Үүнээс үзэхэд миллиард *кальпын* туршид Бурхан Вишнугийн оронд байхдаа тэр Түүний чин бишрэлийн алба үйлэнд зүтгэснээр тэнд мөнхөд үлдэх боломжтой болно.

4. Бурханд өргөж буй *манжари* нь тастан авсан бөгөөд маш зөөлөн байх ёстой. Шинэ биш, хуучин *манжари*г Бурханд өргөдөггүй.

5. Бурхан Кришна Бхагавад Гитагийн (10.25)-д: “Бүх тахилга өргөлүүдээс Би бол ариун гэгээн нэр алдруудыг магтан дуулах (*жала*).” гэж айлдсан байдаг. Калисантарана Упанишадад өгүүлсэнчлэн, 16 үгээс бүрдэх Харе Кришна *махамантра*г бахдан дуулж, давтан хэлэх нь *Кали югад* ангижралд хүрэх хамгийн шилдэг арга болно. Шри Чайтанья Махапрабхугийн бидэнд давтан хэлэхийг номлон уриалсан Харе Кришна махамантра: Харе Кришна, Харе Кришна, Кришна Кришна, Харе Харе/Харе Рама, Харе Рама, Рама Рама, Харе Харе.

6. *Вайшнавүүдын* хувьд ачлал ээнэг, өглөг хандив, тусламж дэмжлэг өгөх үзүүлэх гэдэг нь Кришнын ухамсарыг даган баримтлах, ялангуяа Харе Кришна *махамантра*г давтан хэлэх явдал юм. Бурхан Чайтанья: “Ай ах минь ээ, Харе Кришнаг ядаж нэг удаа ч гэсэн магтан дуулаач. Энэ бол Миний гуйх цорын ганц хайр энэрэл билээ.” гэж айлдсан. Гэхдээ, чин бишрэлтэн нь өглөг хандив, тэтгэмж, тусламж өгөх боломжтой бол ядуучуудад кунжутын үр, хувцас хунар болон хоол унд өгч болно.

ПАДМИНИ ЭКАДАШИ

Сута Госвами өгүүлсэн нь:

Юдхиштрира Махаража айлтгасан нь: Ай Жанардана минь ээ, өндөр жилийн (ведийн тооллоор) илүү сарын гэрэлтэй хагаст тохиодог экадашийг юу гэж нэрлэдэг вэ? Түүнийг яаж зөв баримталдаг вэ? Энэ тухай Та надад айлдаж соёрхоно уу.

Бурханы Дээд Бодьгал, Шри Кришна айлдсан нь: Ай Пандава минь ээ, өндөр жилийн илүү сарын алдаршуулан магтвал зохилтой экадашийг Падмини гэж нэрлэдэг. Тэр бол маш өршөөл ивээлтэй өдөр билээ. Түүнийг итгэлтэй болоод шийдвэр төгс баримтлан байгаа зол завшаантай сүнснүүд Миний оронд эргэн ирдэг. Нүглийг устган зайлуулах энэхүү экадашийн үйлчлэл нөлөөлөл нь

Миний аугаа хүчтэй зүйрлэхүйц. Тэр ч бүү хэл дөрвөн тэргүүнтэй Брахма бурхан хүртэл энэ экадашийг зохих ёсоор нь алдаршуулж чаддаггүй билээ.

Бадамлянхуа мэлмийт Бурхан Кришнын таалалд Юдхиштира хааны асуулт маш их нийцсэн бөгөөд түүнд хандан дараахь таатай сайхан хариуг айлдсан: Ай хаан минь ээ, Намайг анхааралтай сайн сонс, аугаа гэгээнтнүүд хүртэл ховорхон баримталдаг Падмини экадаши дахь мацгийн дэглэм журам, ёс заншлын талаар Би чамд айлдъя.

Экадашийн өмнөх өдөр *даша-д* мацаг барьж эхлэх хэрэгтэй бөгөөд энэ өдөр ураг дал, пинк дал, вандуй, бал, далайн давсыг¹ хоол хүнсэндээ хэрэглэж болохгүй. Мөн бусдын гэрт хооллохгүйн зэрэгцээ хүрэл таваг хэрэглэж үл болно. Энэ найман зүйлийг цээрлэх хэрэгтэй. *Даша-д* зөвхөн нэг удаа л хооллон, шалан дээр унтаж, бэлгийн харьцааг тэвчих хэрэгтэй. Экадашийн өдөр чин бишрэлтэн өглөө эртлэн босож нягт нямбай угаал үйлдэх ёстой. Шүдээ цэвэрлэх хэрэггүй. Боломжтой бол угаалгыг мөргөлийн ариун дагшин газарт үйлдэх хэрэгтэй бөгөөд угаал үйлдсэний дараагаар Ведийн ариун гэгээн дууллуудаас бахдан дуулж, биедээ шавар, кунжутын үрийн оо, *куша* өвс болон *амалакын* үрийн нунтаг хольсон үхрийн баас түрхэх хэрэгтэй. Үүний дараагаар чин бишрэлтэн биеэ дахин нэг удаа сайтар угаан дараахь залбирлыг хэлэх хэрэгтэй: Ай ариун гэгээн шавар минь ээ, чамайг Брахма бурхан бүтээж, Кашьяпа Муни ариусган, Кришна Бурхан Вараха бодонгийн дүрд хувилан өргөсөн билээ. Ай шавар минь ээ, миний толгой, нүд болон хөл гарыг минь ариусгаж хайрлаач. Ай шавар минь ээ, би чиний өмнө хүндэтгэлтэйгээр мэхийн мөргөж байна. Намайг Бүхний Дээд Бурхан Харид бишрэл хүндэтгэлээ илэрхийлж болохуйцаар ариусгаж хайрлаач.

Ай үхрийн баас минь ээ, чи бид бүхний эх болсон үнээний ходоодноос гардаг учраас эмчилгээ болоод үхжил эсэргүүцэх шинж чанартай билээ. Чи газар дэлхийг бүхэлд нь ариусгаж чадах билээ. Миний гүн хүндэтгэлийг хүлээн авч намайг ариусгаж хайрлаач.

Ай *амалакын* үр минь ээ, миний гүн хүндэтгэлийг болгоож хайрла. Та бол Брахма бурханы шүлснээс төрсөн билээ. Таны ургаж байгаа бүх гаригууд бүгд ариусдаг билээ. Та миний биеийн мөчүүдийг ариусгаж хайрлаач.

Ай Бүхний Дээд Бурхан Вишну минь ээ, ай бурхдын Бурхан минь ээ, ай орчлонгийн Эзэн минь ээ, ай дун, галт хүрд, шийдэм болон бадамлянхуа цэцэг мутартаа баригч минь ээ, Та намайг мөргөлийн бүхий л газруудад угаал үйлдэхийг болгоон соёрхоно уу.

Энэхүү эрхэм дээд залбирлыг хэлэн, Варуна Бурханд *мантрануудыг* бахдан дуулж, Ганга мөрний эрэгт орших мөргөлийн бүхий л газар орнуудыг бясалган, байгаа нөхцөл байдал нь бололцоо олгох тэр л усанд угаал үйлдэх шаардлагатай. Тэгээд, ай Юдхиштира минь ээ, биеэ угааж арчсаны дараа чин бишрэлтэн нь бүхий л оршнолуудад цэнгэл жаргалыг хайрлан хүртээгч, нүд гялбам сайхан шар өмсгөл бүхий Бүхний Дээд Бурханд бишрэл хүндэтгэлээ илэрхийлэх хэрэгтэй. Чин бишрэлтэн нь өөрийн бүх нүглээ ингэж л устган зайлуулдаг. Үүний дараагаар тэр ариун гэгээн *гаятри* мантраг давтан хэлж, өвөг дээдэстээ бэлэг өргөл өргөх үйлийг үйлдэн, Лакшми девигийн амраг Нараянад бишрэл хүндэтгэлээ илэрхийлэхээр Вишнугийн сүм рүү очих хэрэгтэй.

Хэрвээ боломжтой бол чин бишрэлтэн нь Радха-Кришна эсвэл Шива-Парватийн *муртийг* алтаар хийгээд Түүнд чин бишрэл дүүрэн бишрэл хүндэтгэлээ илэрхийлэх хэрэгтэй. Тэрээр мөн зэс эсвэл шавар савыг анхилуун үнэрт бодис хольсон цэвэр усаар дүүргэн, эхлээд даавуугаар дараа нь алт эсвэл мөнгөн таглаагаар таглаж *асана* бэлтгэн түүн дээрээ Радха-Кришна эсвэл Шива-Парватийн *муртийг* залах хэрэгтэй.

Үүний дараагаар чин бишрэлтэн өөрийн боломж нөхцөлд тохируулан энэхүү *муртид* анхилуун үнэрт хүж, тод гэрэлтэй зул, зандан модны оо, мөн

тэрчлэн гавар, мускус, кункум болон өөр бусад анхилуун үнэрт бодисууд, шинэ, анхилуун сайхан үнэртэй цэцэг, жишээлбэл цагаан өнгийн бадамлянхуа цэцэг болон улирлын байдлаас хамааран мөн өөр бусад цэцгийг хайр, чин бишрэлтэйгээр бэлтгэсэн идээ зоогийн хамтаар өргөх хэрэгтэй. Энэхүү онцгой экадашид чин бишрэлтэн нь Бурхан шүтээнийхээ өмнө экстаз-д буюу онгод хөөрөлтэйгээр дуулж бүжиглэх хэрэгтэй. Тэрээр *праджалпын* бүх төрлүүдээс зайлсхийх хэрэгтэй, мөн сарын тэмдэг нь ирсэн байгаа эмэгтэйчүүдэд болон доод төрлийн хүмүүст шүргэн хүрж болохгүйгээс гадна тэдэнтэй ярилцах хэрэггүй. Энэ өдөрт тэр зөвхөн үнэнийг ярихын төлөө л чармайн хичээх хэрэгтэй бөгөөд Бурхан шүтээний өмнө хэнийг ч, брахмануудыг ч, вайшнавчуудыг ч, номын багшийг ч шүүмжлэх ёсгүй. Тэр бусад чин бишрэлтэнгүүдийн хамтаар Пурануудад тодорхойлон өгүүлсэн Бурхан Вишнугийн яруу алдарт үйлүүдийн тухай сонсох хэрэгтэй.

Энэ экадашид юм ууж болохгүй, тэр ч бүү хэл уруулдаа ус хүргэж ч болохгүй. Энэ журмыг биелүүлж эс чадах хүн зөвхөн сүү л хэрэглэж болно, эс тэгэх аваас мацгийг зогсоон тайлсан гэж үздэг. Бүхий л шөнийг унталгүй сэрүүн өнгөрүүлэх хэрэгтэй бөгөөд Бурханы Дээд Бодьгалыг цэнгүүлэхийн тулд дуулж, хөгжмийн зэмсгүүд дээр тоглох хэрэгтэй.

Экадашийн шөнийг дөрөв хуваасны эхний буюу нэг дэх хэсэгт чин бишрэлтэн өөрийн залсан *муртид* наргилын самрын бага зэрэг идээ, хоёр дахь хэсэгт белын жимс, гурав дахь хэсэгт апельсин, харин шөнө дуусах үед бетелийн самар бага зэргийг өргөх хэрэгтэй. Экадашийн шөнийн эхний дөрөвний нэгийг сэрүүн өнгөрүүлсэн чин бишрэлтэн *Агништома-ягья* үйлдсэн шиг тийм шагналыг хүртдэг. Хоёр дахь хэсгийг сэрүүн өнгөрүүлсэн чин бишрэлтэн *Важапея-ягья*, гурав дахь хэсгийг сэрүүн өнгөрүүлсэн чин бишрэлтэн *Ашвамедха-ягья* үйлдсэн шиг тийм шагнал, үр шимийг тус тус хүртдэг. Харин бүхий л шөнийн туршид унталгүй сэрүүн байсан чин бишрэлтэн дээр дурьдсан бүх ач тусын зэрэгцээ *Ражасуйя-ягья* үйлдсэнээр хүртдэг аугаа их адислалыг хүртдэг. Жилд, Падмини экадашаас илүү мацаг гэж байдаггүй. Ийм шагналыг түүнээс өөр юу ч, галан тахилга өргөл ч, мэдлэг ч, боловсрол ч, тэвчил наманчлал ч тэр хайрлаж хүртээдэггүй. Экадашид энэхүү ариун гэгээн мацгийг барьж байгаа хүн мөргөлийн бүхий л газар орнуудад угаал үйлдсэнээр хүртдэг бүхий л ач тус, үр шимийг хүртдэг. Шөнийг сэрүүн өнгөрүүлсний дараагаар чин бишрэлтэн үүр цайх үеэр угаал үйлдээд Надад бишрэл хүндэтгэлээ нягт нямбайгаар илэрхийлэх хэрэгтэй. Үүний дараагаар тэр зохистой брахманыг идээ зоогоор дайлж, түүнд Кешава Бурханы *мурти* болон анхилуун үнэртэй болгосон цэвэр усаар дүүргэсэн савыг хүндэтгэлтэйгээр барих хэрэгтэй. Ийм бэлэг нь чин бишрэлтэнд энэ амьдралдаа амжилт, зол завшаантай байхыг болон ирээдүйн амьдралдаа ангижралд хүрэхийг нь баталгаажуулдаг.

Ай нүгэл үгүй Юдхиштхира минь ээ, асуултанд чинь хариу болгон Би чамд өндөр жилийн илүү сарын гэрэлтэй хагаст тохиодог экадашийг баримтлах журам дүрэм болон түүний хүртээх ач тусын талаар тодорхойлон айлдлаа. Энэхүү экадашийг Падмини экадаши гэж нэрлэдэг бөгөөд энэ өдөрт барьсан мацаг нь бусад бүх экадашуудыг баримталснаар хүртдэг ач тусыг хайрлан хүртээдэг. Өндөр жилийн илүү сарын харанхуй хагаст тохиодог Парама гэж нэрлэгддэг экадаши нь Падмини экадашийн нэгэн адил, нүглийг устгах аугаа хүчирхэг байдаг билээ. Одоо харин, Падмини экадашийн ариун гэгээн өдрийн гайхамшигт түүхийг анхааралтай сонсоно уу.

Нэгэн цагт энэхүү түүхийг Пуластья Муни Нарадажид өгүүлсэн билээ. Картавирьяржуна нь Раваныг шоронд хийн хорьсон байсныг Пуластья Муни сулласан гэдгийг Нарада Муни мэдээд асуусан нь: Ай мэргэдийн аугаа нь минь ээ, Равана бүх хагас бурхдыг, мөн түүний дотор Индра бурханыг хүртэл

ялан дийлсэн биш үү. Тулаанд ийм гарамгай чадамгай Раванаг Картавирияржуна хэрхэн яаж ийнхүү эрсдүүлж чадаа вэ?

Пуластья Муни хариулсан нь: Ай аугаа Нарада минь ээ, Картавирияржунын эцэг Картавирия нь *Трета югад* Хайхайгийн удамд угсаанд төрсөн. Түүний улс гүрний нийслэл нь Махишмати гэдэг хот байсан бөгөөд тэрээр маш ихээр хайрладаг 1000 хатадтай байлаа. Гэсэн хэдий ч тэдний хэн нь ч түүнд маш ихээр хүсэн хүлээж байсан хүүг нь төрүүлж өгч чадахгүй байв. Тэрээр тахилга өргөл үйлдэж, хагас бурхдад болон өвөг дээдэстээ бишрэл хүндэтгэл үзүүлж байсан ч хэн нэгэн мэргэний хараалаас болоод тэр хүүтэй болох чадваргүй болсон байлаа. Өлссөн хүнд идэх юмнаас өөр юу ч таашаал ханамж өгдөггүйтэй адил хүүгүй хаанд улс гүрэн нь хүртэл баяр баясал өгөхгүй байлаа.

Картавирия хаан өөрийн байр байдлаа сайтар эрэгцүүлэн бодоод хүссэн зорилгодоо хүрэхийн тулд хүнд хэцүү тэвчил үйлдэхээр шийдсэн. Тэр хаан төрийн удирдлагаа сайд түшмэлдээ шилжүүлэн өгөөд хааны хувцсаа тайлан бэлхүүсээ хатуу холтсон халхавчаар ороож, урт үсээ тайрсан. Хатдын нэг болох Харишчандра хааны охин, эмэгтэйчүүдийн шилдэг нь болох, Икшвакугийн удамд төрсөн Падмини хатан хааныг хэрхэн явж одохыг харсан. Тэр бол үнэнч, цэвэр ариун эмэгтэй байсан бөгөөд амраг хайртай нөхрийнхөө мөрийг нь дагах нь өөрийн нь үүрэг гэж үзсэн. Тэгээд өөрийн гуа сайхан биенээсээ хатны өмсгөл, гоёл чимэглэлээ тайлан орхиод хэсэгхэн даавуугаар биеэ ороогоод нөхрийнхөө араас дагасан.

Удаан хугацааны туршид явсаны эцэст Картавирия Гандхамадана уулын оройд хүрч очин тэндээ арван мянган жилийн туршид хатуу чанга тэвчил наманчлал үйлдэн шийдэм агссан Гададхара Бурханыг бясалган, залбирсан. Гэсэн ч тэр хүүтэй болоогүй. Яс арьс болтлоо турж эцсэн эрхэм хайрт нөхрөө хараад Падмини түүнд туслахаар шийдэн Анасуйя деви² дээр очсон. Падмини түүнд ойртож очоод хүндэтгэлтэйгээр хэлсэн нь: Ай аугаа эмэгтэй минь ээ, миний хайртай нөхөр Картавирия сүүлийн арван мянган жилийн туршид хүнд хэцүү тэвчил наманчлал үйлдэж байна. Гэсэн ч өнгөрсөн үеийн бүх нүглүүд хийгээд эдүгээ үеийн хүндрэл бэрхшээлүүдийн цорын ганц арилган зайлуулагч Кешава Бурхан түүнд өршөөл нигүүлслээ одоо болтол хүртээхгүй л байна. Ай хамгийн аз завшаантай эмэгтэй минь ээ, Та надад, түүнийг бид чин бишрэлтэйгээр баримталснаар Бүхний Дээд Бурханы таалалд нийцэн Түүнийг баясуулан цэнгүүлснээр Тэр бидэнд ертөнцийг хүртэл захирах тийм сайхан хүү хайрлан хүртээх тийм мацгийг нэрлэж зааж өгнө үү.

Өөрийн нөхөртөө үнэнч, цэвэр ариун Падминийн үгийг сонсоод аугаа Анасуйя хэлсэн нь: Ай эрхэм сайхан, бадам лянхуа нүдэт эмэгтэй минь ээ, ердийнхөөрөө бол жил нь 12 сартай байдаг билээ. Гэхдээ 36 сар бүрийн дараа дахин нэг илүү нэмэлт сар байдаг. Энэхүү илүү сард тохиодог хоёр экадашийг Падмини, Парама гэж нэрлэдэг. Тэд сарын гэрэлтэй болон харанхуй хагасын *двадашид* тохиодог. Чи энэ өдрүүдэд мацаг барин бүхий л шөнийг унталгүй сэрүүн өнгөрүүлэх хэрэгтэй. Хэрвээ чи ингэж чадах аваас Бурханы Дээд Бодьгал Хари чамд хүү заяах болно.

Ай Нарада минь ээ, Кардама мэргэний охин Анасуйя эдгээр экадашуудын хүч чадлын талаар ийнхүү өгүүлсэн. Ингээд Падмини заасан дүрэм журмуудыг итгэлтэйгээр даган, ус ч амсалгүйгээр мацаг барьж, Бурханы яруу алдрыг магтан дуулж экстаз-д бүжиглэн бүхий л шөнийг унталгүй, сэрүүн өнгөрүүлсэн. Түүний чин бишрэлт энэхүү байдал нь Кешава Бурханы таалалд маш их нийцсэн учир аугаа Гарудагаа хөлөглөн түүний өмнө морилон ирсэн. Бурхан айлдсан нь: Ай үзэсгэлэн гоо минь ээ, чи илүү сарын экадашид мацаг барьснаар Миний таалалд маш их нийцлээ. Надаас чи ямар адислал хүртэхийг хүсэж байгаагаа хэлнэ үү.

Энэ айлдварыг сонсоод Падмини Бүхний Дээд Бурханд чин зүрхнээсээ залбиран мөргөж, өөрийн нөхрийн эрхэм хүслийг биелүүлж өгөхийг гуйсан. Бурхан, Шри Кришна хариу айлдсан нь: Ай даруухан бүсгүй минь ээ, Миний хувьд энэ сараас илүү эрхэм сар гэж үгүй билээ. Харин энэ сард тохиодог хоёр экадаши бол Надад хамгийн эрхэм байдаг. Анасуйягийн зааж зөвлөснийг чи төгс төгөлдөр байдлаар даган биелүүлсэн. Иймээс чиний санаанд нийцүүлэн тохируулахын тулд Би бүхнийг хийх болно. Чи нөхрийн хамт өөрийн хүсэн хүлээж байгаа тийм хүүтэй болох болно.

Тэгээд, ертөнцийг гаслан зовлонгоос ангижруулагч Бурхан Картаврья хаанд хандан айлдсан нь: Ай хаан минь ээ, чи өөрийн чин зүрхний эрхэм нандин хүслээсээ айлтгаж болно. Чиний эрхэм хайртай хатан чинь Миний таалалд маш их нийцсэн учраас Би түүнийг чинь биелүүлэх болно.

Хаан энэ айлдварыг сонсоод маш их баярласан. Мэдээж хэрэг, тэр ийн удаан хугацаагаар хүсэж байсан хүү заяаж өгөхийг гуйн дараахь айлтгалыг өргөсөн: Ай орчлонгийн эзэн минь ээ, ай Мадху демоныг даран хөнөөгч минь ээ, Та надад, хэн ч хагас бурхад ч, хүмүүс ч, могойнууд ч, демонууд ч, хий үзэгдлүүд ч хөнөөж үл чадах, харин зөвхөн Та л ялж дийлэх тийм хүү заяана уу. Бүхний Дээд Бурхан: “Хүссэн зүйл чинь ёсчлон болог.” гэж айлдаад морилон одсон.

Хатандаа маш ханамжтай байсан хаан түүний хамт ордон луугаа буцсан. Удалгүй Падмини хатан жирэмсэлж хүчит гарт хүү Картавирьяржуна хорвоод мэндэлсэн. Тэр бол гурван ертөнцөд хамгийн хүчтэй нь болсон бөгөөд арван толгойтой Равана хүртэл түүнтэй тулалдаад дийлж чадаагүй. Мутартаа галт хүрд, бороохой болон бусдыг барьсан Нараянагаас өөр хэн ч түүнийг дийлж чадахгүй байв. Тэр энэхүү шинж чанарыг экадашийг нарийн чанд болоод гүн итгэлтэйгээр баримталсан эхийнхээ ач тусаар хүртсэн бөгөөд иймээс ч тэр аймшигт Раванаг ялан дийлсэн хэрэг. Энэ бол гайхалтай зүйл биш билээ, ай Нарадажи минь ээ, учир нь Картавирьяржуна бол Бүхний Дээд Бурханы адислалаар төрсөн юм шүү дээ. Үүнийг өгүүлснийхээ дараа Пуластья Муни холдон одлоо.

Бүхний Дээд Бурхан, Шри Кришна төгсгөлд нь айлдсан нь: Ай нүгэл үгүй Юдхиштрира минь ээ, Би чамд энэхүү онцгой экадашийн сүр хүчийн талаар айлдлаа. Ай хаадын шилдэг нь минь ээ, энэхүү мацгийг барьж байгаа хүн Миний Өөрийн залран байдаг оронд хүрч ирэх нь эргэлзээгүй. Хэрвээ чи өөрийн хүслүүдээ гүйцэлдүүлэхийг хүсэж байгаа бол мөн тэгж л хий.

Өөрийн эрхэм хайртай Кешавын айлдварыг сонсож хүртээд Дхармаража (Юдхиштрира) баяр хөөрөөр дүүрэн бялхсан бөгөөд Падмини экадашийг тохиох үед түүнийг чин бишрэлтэйгээр баримталсан билээ.

Сута Госвами дүгнэж хэлсэн нь: Ай Шаунака мэргэн минь ээ, би чамд энэхүү өршөөл ивээлт экадашийн талаар бүгдийг нь өгүүллээ. Өндөр жилийн илүү сарын экадашид чин бишрэлтэйгээр мацаг барьж, зохицуулах зарчмуудыг сайтар нарийн чанд баримталж байгаа хэн бүхэн алдаршин дуурсагдах бөгөөд Бурханы зүгт аз жаргалтайгаар буцан очдог. Мөн энэхүү экадашийн тухай сонсож байгаа эсвэл уншиж байгаа хүн мөн аугаа их ач тусыг хүртдэг бөгөөд Хари Бурханы оронд гарцаагүй хүрэх болно.

Өндөр жилийн илүү сарын гэрэлтэй хагасын экадаши, Падмини экадашийн яруу алдрын тухай Сканда Пуранаас авсан хүүрнэл ийнхүү өндөрлөлөө.

Тайлбар:

1.Ариун гэгээн судруудад заасны дагуу бол мацгийн өдөр далайн давс хэрэглэхээс зайлсхийх хэрэгтэй байдаг. Учир нь Агастья Муни далайн усыг шавхан уугаад дараа нь түүнийг шээс байдлаар буцаан гаргасан. Зөвхөн хоолны давс хэрэглэхийг зөвшөөрдөг.

2. Анасуйя- аугаа мэргэн Атригийн эхнэр бөгөөд Брахма, Вишну болон Шивагийн гурван тэргүүнтэй хувилгаан Даттатрейгийн эх.

ПАРАМА ЭКАДАШИ

Юдхиштира Махаража асуусан нь: Ай Бүхний Дээд Бурхан минь ээ, өндөр жилийн (ведийн тооллоор) илүү сарын харанхуй хагаст тохиодог экадашийг юу гэж нэрлэдэг вэ? Ай бүх орчлонгуудын эзэн минь ээ, түүнийг ямар байдлаар баримтлан өнгөрүүлэх ёстой вэ? Та энэ бүгдийн талаар айлдаж соёрхоно уу.

Бурханы Дээд Бодьгал, Шри Кришна хариу айлдсан нь: Ай Юдхиштира минь ээ, алдаршуулбал зохилтой энэхүү өдрийг Парамэкадаши гэж нэрлэдэг. Энэ өдөр нь амьдралын баяр баясгаланг хийгээд үхэл төрөлтийн хүрднээс бүрмөсөн ангижрахуйн адислалыг хайрлан хүртээдэг. Түүнийг *Картика* сарын гэрэлтэй хагаст тохиодог экадашитай адил төстэйгээр баримталдаг. Энэ экадашид бүх амьд оршнолуудын дээд нь болох Надад аугаа их хайр болоод чин бишрэлтэйгээр бишрэл хүндэтгэлээ илэрхийлэн мөргөдөг. Би чамд одоо, Кампилья хотноо аугаа их мэргэдээс сонссон нэгэн сайхан түүхийг айлдан соёрхоё.

Урьдын нэгэн цагт Кампильяд Сумедха гэдэг нэртэй нэгэн эрхэм сайн брахман цэвэр ариун бөгөөд нөхөртөө өөрийгөө бүрнээ зориулсан эхнэр Павитрагийн хамт амьдардаг байжээ. Өнгөрсөн амьдралууддаа үйлдсэн нүглүүдээсээ болж Сумедха мөнгө ч үгүй, будаа тариа ч үгүй нэгэн байлаа. Хэдийгээр тэр олон хүмүүсээс хоол хүнсний зүйл гуйдаг байсан ч тэд өлөн зэлмүүн амь зуудаг байлаа. Сүүлдээ түүнд өөрийгөө болон ийм ядуу зүдүү байсан ч өөрт нь үнэнчээр үйлчлэн зүтгэж байдаг гайхамшигтай сайхан зан ааштай, залуу, үзэсгэлэн гоо эхнэрээ хооллон хувцаслах хүнд бэрх болж дөнгөн данган аргацаах болсон. Тэднийд зочин гийчин ирэхэд, хэдийгээр Павитра өөрөө байнгад өл залгах төдий ховор тарчиг байдаг байсан ч тэдэнд хоол унд үргэлж хийж өгдөг байлаа. Тэрээр бадамлянхуа цэцэг адил үзэсгэлэн гоо царайгаа хэзээ ч барайлгадаггүй байв. Өлөн зэлмүүн байдлаас болж тэр турж эцсэн хэдий ч урьдын адил өөрийн нөхөр Сумедхад үйлчлэн зүтгэсээр байв.

Өөрийн зол завшаан муутай хувь заяандаа гуниглан байгаа Сумедха энэ бүгдийг хараад нэгэн удаа Павитрад хэлсэн нь: Ай эрхэм хайрт эхнэр минь ээ, ай гоо үзэсгэлэн төгөлдөр минь ээ, би баян хүмүүсээс өглөг гуйх боловч ердөө л үйрмэг үртэс төдий л зүйл цуглуулах юм. Би одоо яах вэ? Амьдрал ахуйгаа яаж сайжруулан дээш татах вэ? Хаанаас тус дэм эрж хайх вэ? Ай хамгийн дуулгавартай, хайртай эхнэр минь ээ, шаардлагатай хэмжээнд хүрсэн чинээлэг биш л бол гэрийн эзний үйл хэрэг хэзээ ч бүтэмжтэй байдаггүй¹. Ийм учраас, хүрэлцээтэй хангалуун амьдрахуйц хөрөнгө чинээтэй болохын төлөө намайг өөр тийшээ явахыг чи зөвшөөрнө биз дээ. Ингэснээр бид аз жаргалтай сайхан амьдрахад шаардлагатай хэмжээнд хүрнэ гэж би үзэж байна. Хүчин чармайлт гаргалгүйгээр хүн өөрийн хүсэл болоод шаардлагаа хангаж чадахгүй билээ. Урам зоригтойгоор хийх оролдлого чармайлт үргэлж таатай, өршөөл ивээлтэй байдаг² гэж мэргэд ярьдаг шүү дээ.

Нөхрийнхөө үгийг сонсоод Павитра алгаа хавсран, нүд дүүрэн нулимстайгаар, маш их хайр хүндэтгэлтэйгээр хэлсэн нь: Миний эрхэм хайрт нөхөр минь ээ, чамаас илүү аугаа хийгээд ном эрдэмтэй хүн байхгүй гэж би бодож байна. Өөрөө гай зовлонтой, ядуу зүдүү байдалд байхдаа ч бусдын сайн сайхны тухай боддог хүн саяын чинийх шиг ярьдаг. Гэхдээ ариун гэгээн судруудад өгүүлсэнчлэн, хүн энэ амьдралдаа эд баялагтай байх эсэх нь өнгөрсөн амьдралууддаа түүний үйлдсэн үйлийн үрээс хамаардаг. Хүн өнгөрсөн амьдралууддаа өглөг хандив өгч байгаагүй бол тэр Сумеру уул шиг аврага том алтан дээр сууж байсан ч ядуу зүдүү хэвээрээ л байх болно³. Хүн

ямар ч өргөл, мөнгө, номлол сургаал эсвэл үржил шимтэй газар өргөсөн бай ялгаагүй ирээдүйн амьдралд нь түүнд эргэж ирдэг. Бид өгсөн зүйлээ л авдаг. Хэрвээ өмнөх амьдралдаа өглөг хандив өгөөгүй л бол хэн ч элбэг дэлбэг байдаггүй. Ай брахмануудын шилдэг нь минь ээ, бид одоо ядуу зүдүү байна гэдэг бол өнгөрсөн амьдралдаа чи болон би ядуучуудад өглөг тарааж байгаагүйн л тэмдэг. Иймээс, ай өршөөл ивээлт хань нөхөр минь ээ, чи хаашаа ч явалгүй, энд надтай үлдэх ёстой биш үү. Чамгүйгээр би хоромхон зуур ч амьдарч чадахгүй.

Нөхөргүй эхнэртэй, хэн ч эцэг эх нь ч, ах нь ч, хадам эцэг нь ч, гэр бүлийн бусад аль ч гишүүд мэндчилдэггүй. Хүн бүр л: “Чи нөхрөө алдсан, хувь тавилангүй муу заяат.” гэж хэлдэг. Ийм учраас бүгд л намайг харгис хэрцгийгээр буруушаан зэмлэх болно⁴. Надтай хамт байж бидэнд байгаа зүйлдээ ханамжтай бай л даа. Бидэнд заяасан тэр л зүйлийг цаг тухайд нь зохих ёсоор нь хүртэж байх аваас бид дүүрэн жаргалтай байх болно шүү дээ.

Эхнэрийнхээ гунигтай, хөөрхийлөлтэй үгийг сонсоод Сумедха төрсөн тосгоноосоо явахгүйгээр шийдсэн. Ингэж байтал, нэгэн удаа аугаа мэргэн Каундинья тэнд ирсэн. Сумедха брахман эхнэртэйгээ түүний өмнө очин гүн хүндэтгэлээ илэрхийлсэн. Толгойгоо бөхийлгөн Сумедха түүнд: “Ай мэргэдийн дундахь шилдэг нь минь ээ, таныг өнөөдөр энд мэндчилж байгаадаа би маш их баяр жаргалтай байна. Та бидний амьдралыг гийгүүлэн гялайлгасан билээ. Бид бүхэн таны ачыг санаж байх ёстой билээ.” гэж хэлсэн.

Сумедха Каундинья Муниг тав тухтай суудалд урьж суулган түүний тэвчилт хийгээд номч мэргэн байдлыг өндрөөр өргөмжилж байлаа. “Өнөөдөр танаас *даршан* хүртсэнээрээ би маш их зол завшаантай байна.” гэж Сумедху хэлсэн. Брахманы ядуу хос мэргэнийг чадлынхаа хирээр элбэг дэлбэг дайллаа. Түүний дараа Павитра: “Ай номч мэргэн минь ээ, ядуу зүдүүгийн гай зовлонгоос гарахын тулд бид юу хийх ёстой вэ? Өнгөрсөн амьдралдаа өглөг хандив үл өгсөн хүн яаж сайн гэр бүл, амар мэнд, элбэг дэлбэг байдал болон их сайн боловсролтой болж болох вэ? Миний нөхөр өглөг гуйхаар намайг орхин өөр тийшээ явах гээд байна. Би түүнийг хаашаа ч явалгүй, гэртээ үлдээ ч гэж гуйсан. Хэрвээ хэн нэгэн энэ амьдралдаа хүрэлцээтэй чинээлэг биш байх аваас энэ нь тэр өнгөрсөн амьдралууддаа зохих хэмжээний өглөг хандив өгч байгаагүйн илрэл гэдгийг түүнд би хүлцэнгүйгээр хэлсэн билээ. Тэгээд тэр явахаа болон надтай үлдэхээр шийдсэн. Өнөөдөр, таны энд морилон ирсэн явдал миний хувьд аугаа их зол завшаан болж байна. Тэгэхээр удалгүй бидний ядуу зүдүү байдалд төгсгөл ирнэ гэдэг нь эргэлзэхгүй байна.

Ай брахмануудын шилдэг нь минь ээ, бидний ядуу зүдүүгийн учир шалтгаан болсон энэхүү үргэлжийн зовлон шаналалаас бид хэрхэн ангижирч болох вэ? Ай өршөөл ивээлт минь ээ, бидний аз жаргалгүй байдал, гуниг зовлон мөнхөд үгүй болохоор ач тус хүртэх тийм арга замыг зааж өгөө ч. Энэ нь бидний очих ёстой ариун мөргөлийн газар орон уу, эсвэл мацаг барих ёстой өдөр байна уу, эсвэл бидний хийж үйлдэх ёстой тэвчил наманчлал байна уу гэдгийг хэлж өгөөч.

Хүлцэнгүй даруу эмэгтэйн чин зүрхний гуйлтыг сонсоод аугаа мэргэн Каундинья хэсэг зуур дуугаа хураан сууснаа хэлсэн нь: Бурханы Дээд Бодьгал, Харид маш эрхэм мацгийн өдөр байдаг юм. Энэ өдөр барьсан мацаг нь бүх нүглийг устган арилгаж ядуурал үгүйрлийн учруулдаг зовлон шаналалыг бүгдийг нь цааш хөөн зайлуулдаг. Өндөр жилийн илүү сарын харанхуй хагаст тохиодог мацгийн энэ өдрийг Парама экадаши гэж нэрлэдэг. Энэ бол Бурхан Вишнугийн дээдийн дээд өдөр билээ. Энэ экадаши нь амьдралд шаардлагатай бүхнийг- мөнгө, будаа тариаг хүртээн эцэст нь ангижралыг хайрладаг. Энэ өдрийн орой болох үед Бурханы алдар цууг магтан дуулж, бүхий л шөнийн туршид онгод, хөөрөлтэйгөөр (экстазд) бүжиглэх хэрэгтэй.

Энэхүү ариун гэгээн өдрийг Кувера бурхан нэгэн удаа аугаа их итгэлтэйгээр баримталжээ. Шива бурхан түүнийг хэрхэн нарийн чанд мацаг барьж байгааг хараад маш их хангалуун байсан бөгөөд Кувераг тэнгэрийн орны сан хөмрөгийг хариуцагч болгосон. Мөн Харишчандра хаан хатан, хүү хоёр нь худалдагдсан байх үед энэхүү өдөрт мацаг барьсан бөгөөд ингэснээрээ тэр тэднийгээ эргүүлэн авч чадсан билээ. Тэгээд тэр өөрийн улс гүрнээ ямар ч саад тотгор, бэрхшээлгүйгээр залан, захирсан. Иймээс, ай өргөн дэлгэр нүдэт эмэгтэй минь ээ, чи Парама экадаши дахь ариун гэгээн мацгийг бүх журам дүрмийн дагуу барьж бүхий л шөнийг сэрүүн өнгөрүүл.

Бурхан Кришна үргэлжлүүлэн айлдсан нь: Ай Пандугийн хүү Юдхиштхира минь ээ, ийнхүү Каундинья Муни өршөөл нигүүлслээ хайрлаж Павитраг Парама экадаши дахь мацаг барихуйн тухай мэдлэгээр гэгээрүүлэн гийгүүлэв. Дараа нь тэр Сумедхад хэлсэн нь: Экадашийн дараахь өдөр, *двадашид* та нар зохих дүрэм журмын дагуу *Панчаратрика* мацгийг барих хэрэгтэй. Өглөө эрт угаал үйлдээд чи эхнэрийн хамт, мөн тэрчлэн танай төрөл төрөгсөд өөрсдийн боломж нөхцөлд тохируулж нийцүүлэн 5 өдөр мацаг барих ёстой. Тэгсэн цагт та нар Бурхан Вишнугийн орон тийш, буцаад гэр лүүгээ харих болно.

Ядаж нэг удаа ийн үйлдсэн хүн тэнгэрийн гаригуудад дээшлэн хүрдэг. Энэ 5 өдрийн туршид зохистой брахманыг сайтар дайлсан хүн бүхий л хагас бурхад, хүмүүс тэр ч бүү хэл демонуудыг хооллосонтой адил үр шим, ач тусыг хүртдэг. Энэ 5 өдөрт, хоёр дахиа төрсөн брахманд усны хувин өргөл болгосон хүн газар дэлхийг бүхэлд нь өргөсөнтэй адил шагнал, ач тусыг хүртдэг. Номтой мэдлэгтэй хүнд кунжутын үр дүүрэн хийсэн савыг өгч байгаа хүн саванд байгаа үрийн тоотой адил жилүүдийн туршид тэнгэрийн оронд амьдардаг. Алтан шаргал шар тос дүүргэсэн савыг өргөл болгон өргөж байгаа хүн энэ газар дэлхий дээр таашаал ханамж бүрэн эдэлсэнээ дараа нь нарны бурханы орон тийш оддог. Энэ таван өдөрт бэлгийн таашаал ханамж эдлэхийг цээрлэн тэвчиж байгаа хүн тэнгэрийн орны аз жаргалд хүрэн Индралокад тэндхийн хагас бурхадын хамт цэнгэн жаргах болно. Иймээс Сумедха, Павитра та хоёр энэ газар дэлхий дээр үлдэж байгаа амьдралын туршдаа элбэг дэлбэг будаа тариа болон эд баялгийг хүртээ гэвэл *Панчаратрикийн* таван өдөр мацаг барих ёстой. Түүний дараа танай гэр орон бурханлаг ертөнц болно.

Аугаа мэргэний зөвлөгөөг хүлээн авсан брахмануудын хос Сумедха, Павитра хоёр Парама экадашид *Панчаратрика* мацгийг зөв барьсан. Удалгүй тэдний гэрт хааны ордноос үзэсгэлэн төгөлдөр хан хүү айлчлан ирсэн. Брахма бурханы шийдвэрээр хан хүү тэдэнд гайхамшигтай, тансаг сайхан тавилга, засалтай байшинг бэлэглэж тэднийг тэнд амьдрахыг урьсан. Тэдний тэвчил, тэвчээрийг магтаж сайшаан тэр тэдэнд бүхэл сууринг өгөөд ордон руугаа буцсан. Ингээд Сумедха эхнэрийн хамт энэ ертөнцийн сайн сайхан бүхнийг таашаан цэнгээд хожим нь Вишну Бурханы залрах орон тийш одсон.

Парама экадаши дахь мацаг, мөн тэрчлэн *Панчаратрика* мацгийг барьж байгаа хэн бүхэн бүхий л нүглээсээ ангижран, Сумедха брахманы болон түүний үнэнч шудрага эхнэр Павитра нарын адилаар энэ газар дэлхийн амьдралын таашаал цэнгэлийг эдлэсний дараагаар Вишнулока тийш буцаж очих болно. Ай Юдхиштхира минь ээ, Парама экадашид мацаг барьснаар хүртэх ач тусыг тоочих аргагүй билээ. Учир нь, энэхүү мацгийг барих нь Пушкара нуур болон Ганга мөрөн зэрэг мөргөлийн ариун дагшин газар оронд угаал үйлдэх, үнээг өглөг болгон өгөх болон бишрэл шүтлэгийн бусад бүх үйлүүдийг үйлдэхтэй дүйхүүц юм. Энэхүү өдөр мацаг барьж байгаа хүн Гай дахь өвөг дээдэстээ бэлэг өргөл хэдийнээ барьсан хэрэг юм. Тэрээр өршөөл ивээл бүхий бусад бүх өдрүүдэд мацаг барьсаны ач тусыг хүртдэг.

Варна-уудын шилдэг дээд нь брахманы хэвшил, дөрвөн хөлтөнгүүдээс хамгийн сайн нь үнээ, хагас бурхдын шилдэг нь Индра бурхан байдгийн адил саруудаас хамгийн сайн эрхэм нь өндөр жилийн илүү сар байдаг билээ. Илүү

сарын таван өдрийн мацаг- *Панчаратрика* мацаг нь булай, жигшүүрт нүглийн бүх хэлбэрийг арилган зайлуулдаг гэж ярьдаг. Харин *Панчаратрика* мацаг нь Парама болон Падмани экадаши дахь мацгийн хамтаар хүний бүх нүглийг устган арилгадаг. Энэ бүх өдрүүдэд мацаг барьж чадахгүй байх аваас өөрийн боломжийн хирээр л мацаглах хэрэгтэй. Хүний бие махбодийг аван төрсөн мөртөө илүү сард зөв угаал үл үйлдэх болон Бурхан Харид маш эрхэм байдаг энэхүү экадашийг үл баримтлах хэн бүхэн өөрийгөө хөнөөн егүүтгэж байгаа хэрэг бөгөөд 8 400 000 төрлийн амьд амьтадын дунд төрөн зовж шаналах болно. Хүний амьдрал шиг амьдралын ийм ховор нандин хэлбэр л адислал болон сүүлчийн ангижралыг хүртэхэд зориулагдсан байдаг. Иймээс энэхүү өршөөл ивээлт Парама экадашид мацгийг аль болох нарийн чанд барих хэрэгтэй.

Бурхан Кришна төгсгөлд нь айлдсан нь: Ай нүгэл үгүй Юдхиштхира минь ээ, өндөр жилийн илүү сарын харанхуй хоёр долоо хоногт тохиодог Парама экадашид мацаг барьснаар хүртэх аугаа ач тусын талаар Би чамд тодорхойлон айлдлаа. Байгаа боломж чинээгээрээ энэ мацгийг барь.

Юдхиштхира хаан Бурхан Кришнагийн айлдсан бүх сургаалыг нарийн чанд баримталсан. Мөн түүний бүх дүү нар болон тэдний эхнэр Драупади ч түүн лугаа мацаг барьсан. Материаллаг ертөнц дэх ховор чухаг жаргал цэнгэлийг таашаан байснаа тэд Бурханы зүгт, буцаад гэр лүүгээ эргэн харьсан. Илүү сарын энэ хоёр экадашид мацаг барьж байгаа болон зөв угаал үйлдэж байгаа хүн тэнгэрийн орныг зүглэн одох бөгөөд эцэс хожим нь Шри Вишнугийн залрах оронд дээшлэн хүрдэг билээ. Түүнийг тийш чиглэн одох үед бүх хагас бурхад түүнийг магтан, түүнд залбирч мөргөх болно.

Өндөр жилийн илүү сарын харанхуй хоёр долоо хоногт тохиодог Парама экадашийн яруу алдрын тухай Сканда Пуранаас авсан хүүрнэл ийнхүү өндөрлөлөө.

Тайлбар:

1. Чанакья Пандит: "Амьдрал нь чинээлэг бус, хүрэлцэхгүй байгаа гэрийн эзэн бол ямар ч тусгүй." гэж хэлсэн байдаг.

2. Ариун гэгээн судруудад: "Урам зоригтойгоор хийж буй оролдлого, үйл амжилтанд хүрэх нь эргэлзээгүй хэрэг, гэвч "Би бол өөрийн хувь тавилан үйлээ баталдаг." гэж итгэдэг хүн бол ердөө л залхуу хойрго этгээд юм." гэж батлан өгүүлсэн байдаг.

3. Ведийн судруудад өгүүлсэнчлэн, Трансценденталь мэдлэг, бурханлаг боловсрол, гэр бүлийн сайн сайхан болон эд баялгийн чинээлэг хангамж зэргийг өглөг хандивыг арвин ихээр тараасан хүн л хүртдэг. Хүний хийсэн бүх сайн зүйлс нь түүнд хийснээс нь илүү ихээр буцаж ирдэг.

Ману-нитад Ману Махаража: "хувь заяаны бүтээгч, Виддхатын оноосон бүхэн тохиолдож, болох нь эргэлзээгүй хэрэг. Сайн боловсрол, өндөр ур чадвар болон урам зориг гэж нэрлэгдэх зүйлс нь өөрсдөө амжилт бүтээлийг авчирдаггүй билээ." гэж хэлсэн байдаг.

4. *Niti* шастирт: "Эрдэм номтой хүмүүс, эмэгтэйчүүд болон ороонго ургамал нь зөв хамгаалал болон тусламж дэмжлэггүйгээр амьдарч чаддаггүй." гэж өгүүлсэн байдаг. Иймээс эмэгтэйчүүдийн эрх чөлөөний төлөөх орчин үеийн хөдөлгөөн нь үндсээрээ алдаатай юм.

Гаруда Пуранад: "Цэвэр ариун эмэгтэй нь бурханлаг төгс төгөлдөрт хүрэхээр зорьж байгаа эр нөхөртөө үйлчлэн зүтгэх явдал нь түүний хувьд тэнгэрийн цэнгэл жаргал, дээдийн дээд эрхэм үүрэг болоод аугаа их тэвчил наманчлал гэж үргэлж бодож, үзэж байдаг. Хэрвээ нөхөр нь хангалуун байх аваас тэрээр Бүхний Дээд Бурхан хангалуун байдаг гэж үздэг. Бүхний Дээд Бурхан бүх хагас бурхдыг Өөртөө багтаан агуулж байдаг учраас Бүхний Дээд

Бурхан таалалтай байх аваас бүх хагас бурхад мөн л хангалуун байдаг.” гэж өгүүлсэн байдаг.

Экадашийн өдрүүд болон саруудын нэрс
(Ведийн хуанлиар)

д/ д	Экадашийн нэр		Саруудын нэрс		
	Ведийн	Вайшнавын	ведийн	вайшнав ын	Баруун ы хуанлиа р
1 2	Утпанна Мокшада	Утпанна Мокшада	Маргаши рша	Кешава	11-12
3 4	Шапхала Путрада	Шапхала Путрада	Пауша	Нараяна	12-1
5 6	Шат-тила Жая	Трисприша Бхаими	Магха	Мадхава	1-2
7 8	Вижая Амалаки	Вижая Амалаки	Пхалгуна	Говинда	2-3
9 10	Папамоча ни Камада	Папавимочан и Даманакароп ани	Чайтра	Вишну	3-4
11 12	Варутхин и Мохини	Варутхини Мохини	Вайсакха	Мадхусуд ана	4-5
13 14	Апара Ниржала	Апара Пандава- ниржала	Жйештха	Тривикра ма	5-6
15 16	Йогини Падма	Йогини Девашаяни	Ашадха	Вамана	6-7
17 18	Камика Путрада	Камика Павитраропа ни	Шравана	Пурушотт ама	7-8
19 20	Ажа Париварт ини	Аннада Паршва	Бхадрапа да	Хришике ша	8-9
21 22	Индира Пашанку ша	Индира Пашанкуша	Ашвина	Падмана бха	9-10
23 24	Рама Харибодх ини	Рама Девоттхани	Картика	Дамодара	10-11
25 26	Падмини Парама	Вишуддха Шуддха	Ведийн тооллоор өндөр жилийн илүү сарууд		